



Жан Рональд Руэлл
ТОЛКИН

Бяцхан
ХОББИТЫН
адал явдал

Улаанбаатар 2009

Бяцхан Хоббитын адал явдал

Зохиолч: Жон Рональд Рүэл Толкин

Орчуулсан: Ж.Оюунцэцэг

ISBN: 978-99929-65-72-X

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Бяцхан Хоббитын андуудад

Монголын уншигч багачууд аа! Та бүхний өмнө Английн нэрт зохиолч, дэлхийн зөгнөлт зохиолын их мастер, 20-р зууны уран сэтгэмжит уран зохиолын эцэг хэмээн өргөмжлөгддөг Жон Р.Р.Толкины (1892-1973) “Бяцхан Хоббитын адал явдал” (1936 он) гэдэг сайхан ном дэлгэгдэж байна. Энэ номонд эрэлхэг зоригтой, үнэнч анд, сайхан сэтгэлт Хоббитын адал явдлыг хамгийн энгийн хэлээр нэн сонирхолтой бичсэн байна. Уг номонд бяцхан Хоббит найз одойнууддаа үнэнчээр зүтгэж, тэдэнд амласан андгай тангарагаасаа няцаж цуцалгүй явсаар эцсийн эцэст зөв алхам, зөв шийдвэр гарган амжилтанд хүрдэг. Энэ бяцхан баатар та нарын сэтгэлийг хөдөлгөн, өөрийнхөө үлгэр дуурайлаар байлдан дагуулж, үлгэрийн ертөнцөд умбуулж чадна гэж орчуулагч би баттай хэлэх байна.

Нэргүй зохиолч төдийгүй хэл шинжээч, домог зүй судлаач, яруу найрагч, Оксфордын их сургуулийн профессор, алдарт Оксфорд толийг бүтээхэд оролцсон Жон Р.Р.Толкины “Бөгжний эзэн” зохиолыг та бүхэн уншсан бизээ.

“Бяцхан Хоббитын адал явдал” нь “Бөгжний эзэн” зохиолын өмнөх үйл явдлыг өгүүлэх бөгөөд анх яаж хэн бөгж олсон, яаж үлгэр өрнөсөн тухай гүн гүнзгий ойлгох болно.

Хүүхдүүд ээ мянган удаа сонсохоор нэг удаа үз гэдэг мэргэн үгийг та бүхэн мэднэ шүү дээ! Тавтай сууж амтархан уншиж үлгэрийн ид шидийн адал явдлын ертөнцөд хамтдаа аялцагаая!

Орчуулагч

Жамсрандоржийн Оюунцэцэг

Нэгдүгээр бүлэг

Санаандгүй явдал

Хоббит газар доорх нүхэн гэртээ амар амгалан амьдран сууж байлаа. Энэ бол чийгийн улаан өт хөндлөн гулдгүй сүвлэсэн нойтон ханатай өмхий чийг даасан заваан муухай нүх гэж битгий бодоорой. Тэгэхдээ хуурай цэвэрхэн ч суух газаргүй, идэх ч юмгүй үүрүүдтэй адилгүй шүү. Хоббитын гэр онцгой сайхан амьдран суухад аятай тухтай.

Нүхэн гэрт орох хаалга, хөлөг онгоцны цонх шиг дугуй ногоон хаалганаас эхэлнэ. Гялалзтал зүлгэсэн зэс бариулыг эргүүлж аяархан түлхмэгц л урт хоолой мэт хонгилд ороод ирэх нь тэр. Усан онгоцны утаа тортог үнэртсэн хонгил биш шүү, цэвэрхэн хивс дэвссэн тохилог гээч. Ханаа гөлгөр гялгар модоор доторлон, шалан дээгүүрээ хивс дэвсэж энд тэндгүй эвлэг хөөрхөн урт сандлууд тавьжээ. Бүрх болон дугуй малгай өлгөчихөөр дэгээ мэгээ, дах цувнаас өгсүүлээд элдэв дээдэд зориулсан өлгүүр, зөлгүүр, хадаас шуухан тоо тоймшгүй ажээ. Аргагүй л дээ хоббит зочломтгойгоороо нэрд гарсан нэгэн билээ. Хонгил урт цааш сунаан үргэлжлэх боловч зүгээр л Толгод гэж хавийнхан нэрлэдэг толгод уруу нүхлэн ороогүй ажээ. Хонгилын хоёр талаар жижигхэн дугуй хаалга ирийн жирийн харагдана. Хоббит шатаар дээшээ доошоо амьсгаадан алхах дургүй учраас унтлагын, усны, агуулах зоориуд хувцасны болоод хоолны өрөөнүүд бүгд л нэг давхартаа урт хонгилын хоёр талаар байрлах ажээ. Зүүн гар талаар сайхан өрөөнүүд байрлана. Энэ өрөөнүүд хананд нь гүнзгий суулгасан дугуй цонхтой. Эдгээр цонхоор ойрх цэцэрлэг, гол уруу налж орсон алсын ногоон нуга үзэгдэнэ!

Бидний яриад байгаа Хоббит бол нэлээд хөрөнгөтэй бие хаа ч сайтай нэгэн билээ. Нэрийг нь бол Бэггинс гэнэ. Энэ Бэггинсийнхэн Толгодыг тойрон аль дэвин галваас л амьдарч ирсэн бөгөөд тэднийхэн удам судраараа хүндэтгэл хүлээсэн улс байжээ. Тэднийхэн баян тарганаараа ч биш харин амар амгалан аятай тухтай амьдарч элдэв адал явдал дэгдээдэггүй хэрэг төвөгт оролцдог ч үгүй суудгаараа хөрш олноосоо хүндэтгэл хүлээжээ. Бэггинсийнхэн хэний ч гайхлыг төрүүлдэггүй, үүнд нь хэн ч гайхдаггүй байлаа. Тийм ч болохоор манай Бэггинстэй тохиолдсон үүх түүх тун сонирхолтой шүү. Тэрээр гэнэт л түүнээс гарамгүй зүйл хийж эхэлсэн юм. Гэхдээ хүндэтгэлээ алдаагүй л дээ, харин ч түүнийг бүр хүндэтгэх болсон юм.

Гэхдээ яаран гүйж номынхоо төгсгөлийг шагайгаад яах вэ. Эхнээс нь журам ёсоор ярья.

За тэгэхээр хоббитын ээж, байз байз эхлээд энэ хоббитууд гэж ер нь хэн юм, юу юм гэдгийг тайлбарлах нь зүйтэй гэж бодож байна. Одоо манай үед хоббитууд тааралдахаа больсон болохоор ер нь хэн юм гэдгийг мэдэх хүн ховорджээ. Тэгээд ч хоббитууд том хөлт гэж хүмүүс биднийг нэрлэх агаад биднээс дайжин зугтдаг. Хоббитууд тун намхан навтгар улсууд. Тэд одойнуудаас ч намхан хүний бол бүсэлхий хүрэхтэй үгүйтэй. Одойнуудаас ялгаатай нь ерөөсөө сахалгүй. Том хөлтийн хүчирхэг алхааг сонсонгуутаа л чимээ анир ч үгүй үтэр түргэн зайлан оддог шидэт чадварыг нь тооцохгүй юм бол тэдэнд ид шидийн онцлог хялгасын төдий ч байхгүй. Чимээ ихтэй, эв дүүгүй бидэн шиг амьтдыг хоббитууд милийн цаанаас л мэдэрнэ гээч. Гэхдээ тэдний янзлаг эвлэг байдалд тохирмооргүй тарган басхүү гүзээ нь суначихсан байдаг. Хувцаслахдаа ногоон юмуу шарыг сонгон тод өнгөнд дурлана.

Харин хөл нь бөх гэгчийн ширэн туурайтай төрдөг болохоор тэд ерөөсөө гутал өмсөхгүй. Хоббитын хөлийнх нь шилбэ гуя тэр чигээрээ урт хүрэн үсээр бүрхэгдсэн агаад толгой дээрх өтгөн буржгар үс нь малгай гэмээр. Хоббитууд нарийхан чадварлаг хуруутай, нүүрэнд нь инээд тодорсон сайхан сэтгэлтэй амьтад. Хоббитууд хоолойныхоо гүнээс өнгө солин хөхрөх аж. Ялангуяа, хоол идсэнийхээ дараа тас тас хөхөрнө гээч.

За ингээд та нар хоббитын тухай жаахан мэдээд авлаа, одоо цааш нь ярья. Бүтэн нэр нь Бильбо Бэггинс гэдэг Хоббит болон түүний ээжийн тухай бид ярьж эхэлсэн шүү дээ. Бильбо Бэггинсийн ээж нь Голын цаагуур амьдардаг буюу Голын Цаадах хоббитуудын толгойлогч байсан Хөгшин Тукийн гурван охины нэг алдартай Белладонна Тук гэгч байлаа. Гол гэвэл дэндээд байна. Зүгээр л Толгодын хормойд хоржигносон жижигхэн горхи, горхихон гэвэл болно. Тукийн элэнц эцэг нь шидэт бүсгүйтэй гэрлэн сууж байсан гэдэг яриа хоббитуудын дунд байдаг. Зохиосон яриа байх л даа гэхдээ л, Тукуудын ааш араншинд хоббитынх гэмээргүй зүйл ажиглагджээ. Яагаа ч үгүй зүв зүгээр байж байгаад л Тукийн удам судрынхан адал явдал эрэлхийлэн аян замд гардаг байжээ. Энэ шившгээ хөршүүдээсээ хурдхан л нууж, хурдхан л мартахыг хичээдэг байлаа. Нуугаад ч яах юм билээ. Тэглээ гээд Тукийнхныг хүндлэх нь нэмэгдэх юм биш. Харин Бэггинсийн удам тийм их баян биш ч дандаа л буурь суурьтай хүндэтгэл хүлээсэн хоббитууд байлаа.

Белладонна Тук ямар нэг адал явдлын тухай санаашраагүйгээс гадна Банго Беггинстэй сууснаас хойш бүр ч тансаг Бэггинс хатагтай болсон гэдгийг урьдчилан хэлье. Бильбогийн эцэг Банго эхнэртээ зориулж Толгодын хормойн, Толгодын цаадах тэр тусмаа голын цаадах хоббитуудын үзэж хараагүй асар гоёмсог нүхэн гэр барьсан бөгөөд тэд энэ тансаг оромжиндоо насаа дуустал энх амар, эвтэй найртай амьдарсан бөлгөө. Тэдний ганц хүү Бильбо ааваасаа Бэггинсийнхний буурь суурьтай нүдэнд тусам сайхан чанарыг авсан хэдий ч дотор талд нь хаа нэг газар нь Тукийнхнаас уламжлагдан үлдсэн сониуч сонин зан илэрч гарах хүртлээ хадгалагдсаар байсан ажгуу. Бильбо тавь хүртлээ эцэг эхээсээ хүртсэн гоёмсог тансаг нүхэн гэртээ өөр амьдралын тухай төсөөлөх ч үгүй амар амарлингуй амьдран сууж байлаа.

Энэ дэлхий төвшин намуун эргэн тойронд цэцэг ногоо дэлгэрсэн хоббитын жаргалаа эдэлсэн нэг нойрмог дөлгөөн өглөө бүх юм эхэлсэн юм. Бильбо Бэггинс өглөөнийхөө цайг ууж цадчихаад нүхэн гэрийнхээ үүдэнд эвтэйхэн нь аргагүй буйдан дээр сууж байлаа. Тэрээр үсийг нь нямбайлан самнасан саглагар хөлөн дээрээ урт гэгчийн модон гаансаа тавьчихаад л тамхиа татдаг байлаа. Тэгтэл ийм ч юм болох гэж, яг тэр үед Гэндальф хажуугаар нь өнгөрч явж таарчээ.

Гэндальф. Хэрвээ та түүний тухай миний сонссоноос жаахныг ч гэсэн илүү сонссон болов уу, би ч түүний тухай маш бага мэднэ л дээ, гэхдээ та ямар ч хамаагүй итгэмээргүй түүхэнд итгэх болно. Үнэмшмээргүй үүх түүх, байж боломгүй адал явдал түүний очсон газар болгонд дэгдэн гардаг байлаа. Түүний эртний найз Хөгшин Тук өнгөрснөөс хойш Гэндальф олон жил энэ нутгаар яваагүй билээ. Толгодын болон голын цаадах хязгаараар ч яваагүй юм байна. Урьд нь хүүхэд байсан одоогийн нас бие гүйцсэн хоббитууд Гэндальф ямархуу харагддаг байсныг мартаж орхисонд нь гайхах юу байх вэ.

Тиймээс ч Бильбогийн хувьд Гэндальф тэр өглөө бүсэлхий шүргэсэн буурал сахал нь мөнгөн

өнгөт ороолтынх нь доороос намирсан хэлхгэр саарал цувтай шовгор оройтой цэнхэр малгайтай бөгтөр өвгөн харагдаж байлаа. Өвгөн таяг тулсан байх агаад хүнд хар гуталтай хөлөө аажуухан гэгч зөөж тавина.

- Өглөөний мэнд гэж Бильбо эелдэгхэн мэндлэв. Далимд хэлэхэд үнэхээр мэнд амар өглөө байлаа. Нар гийсэн өвс ногоо халиуран дуниартана.



Гэндалф малгайных нь өргөн хормой нууж үл чадсан өтгөн хөмсөгнийхөө доороос Бильбог харснаа,

- Өглөөний мэнд, гэснээрээ чи юу хэлэх гэж байна. Мэнд амрыг л надад ерөөв үү, эсвэл намайг хэлээгүй байхад энэ өглөө мэнд сайхан гэх гээ юу, эсвэл чамд сайхан байна уу? Ер нь чи өөрөө энэ өглөө амархан мэнд аятай тухтай байна уу?

- Бүгдийг нь хэлж байна гэж Бильбо сандран шулганаад,

- Нэг сайхан гаанс тамхи татаад авмаар нээрэн л сайхан өглөө байна. Хэрвээ танд гаанс байгаа бол хажууд суу, хоёулаа тамхилъя. Яарах юу байх вэ, одоо дөнгөж өглөө болж байна. Орой болтол хаа байсан юм.

Бильбо буйдангаа арагш налан суугаад тамхиа сорон мөнгөлөг дугариг утаа цагираглуулан гаргахад тэр нь Толгодын цаагуур өнхрөн нуугдав.

- Хөөх гэж Гэндалф уулга алдсанаа, энэ сайхан өглөө ингэж утаа цагираглуулан суух зав надад алга. Одоо миний бодож төлөвлөөд байгаа нэгэн адал явдалд оролцож, надад хань болох эр зоригтон хэрэгтэй байна. Тийм хүн олох үнэндээ амаргүй л дээ гэлээ.

- Тийм шүү. Тэр тусмаа манай эндээс. Бид дөлгөөн даруухан улсууд. Адал явдлыг ашигтай, хэрэгтэй гэж үздэг ч үгүй. Адал явдал чинь амар заяа үзүүлэхгүй дээр нь аягүй эвгүй, арга барагдсан учир нь олдохгүй зүйлээр дүүрэн шүү дээ. Өлсөж цангах энүүхэнд. Тэр адал явдал

чинь хэнд хэрэгтэй юм.

Бильбо Бэггинс эрхий хуруугаараа мөрөвчин татуургаа татан нэг тасхийлгэснээ түрүүчийнхээсээ арай том цагираган утаа гаргав. Дараа нь өглөөний сонингоо дэлгэн уншиж эхлэх нь дахиад ярих юмгүй гэж өвгөнд ойлгуулах гэснийх биз.

Харин өвгөн явсангүйгээр үл барам таягаа тулан хоббитыг нүд салгалгүй ширтэж эхлэв. Удалгүй Бильбод эвгүй санагдаж тэссэнгүй,

- Өглөөний мэнд. Уучлаарай бидэнд ямар ч адал явдал хэрэггүй. Тэнэгүүдийг, үгүй ээ эрэлхэг зоригтонгуудыг өөр газраас эр. Толгодын эсвэл голын цаагуур эр дээ гэж хэлээд яриа дууссан гэдгээ ойлгуулах гэж буруу харан суув.

- Өө хө. Хоёрхон үгээр ямар олон юм хэлдэг хүн бэ гэж Гэндальф мушилзсанаа, энэ удаа чиний өглөөний мэнд намайг эндээс зайл эсвэл юун мэндтэй мантай гэсэн утгатай боллоо гэв.

- Өө үгүй үгүй, эрхэм таныг хэн гэдэг вэ?

- Чамайг Бильбо Бэггинс гэдгийг би мэдэж байна. Чи ч гэсэн миний нэрийг мэднэ гэхдээ тэр хүн чинь би гэдгийг бодох ч үгүй суугаа болохоос. Би Гэндальф өдий хүрэх гэж. Белладонна Тукийн хүү ганзагын наймаачинд хоёр зоос шидэх шиг чамтай хоёр гуравхан үг солих төдий болж дээ.

- Гэндальф! Ээ бурхан тэнгэр минь. Энэ чинь та юу. Эзнийхээ тушаалаар өөрөө товчлогддог, өөрөө тайлагддаг шидэт алмаазан чагтага хөгшин Тукад бэлэглэсэн аялан явагч алдарт тэр идтэн шидтэн. Та юу? Амралтын орой болгон луу, махчин гоблинууд, асар том амьтад, аврагдсан гүнж болон аз эзийн эзэн болсон бэлбэсэн эмийн хөвгүүдийн тухай ярьдаг байсан тэр Гэндальф. Зуны нар эргэх баярын өмнө гайхалтай сайхан галын наадам хийдэг байсан Гэндальф. Ямар гоё байсан гээч. Тэнгэрт томоос том галан цэцэг ургаж барын ам ангайх мэт болоход үй түмэн цэцгэн очис гялалздаг сан. Цэцгэн одод харанхуй болтол цэцэглэн улалздаг сан.

- Ээ, эх газар минь гэж Бильбо Бэггинс гайхан шагшин нүд нь тэртээ цагийн тэнгэрийн цэцгийн өнгөөр гялалзаж байлаа. Таны үгний үзүүрээр өвснөөс намхан уснаас чимээгүйхэн амьдарч асан охид хөвгүүд адал явдал эрэлхийлэн есөн уул, найман голыг зүглэн оддог шүү дээ. Залуус ухаан санаанд оромгүй аяглаж модонд авирч эльфүүдийн газар нутагт нэвтрэн орж үл үзэгдэх эрэг эрэлхийлэн хөлөг онгоц хөлөглөн их далайд гардаг. Үнэхээр онцгой сонирхолтой байсан шүү. Та онцгой сонирхолтой явдлыг оргилуулж чаддаг байсан шүү гэж би хэлж байна. Уучлаарай, та одоо өөр ажил явдал эрхэлж байгаа биз дээ.

- Үгүй ээ үгүй, өөр ажил надад байхгүй гэж шидтэн мөрөө хавчсанаа, хамгийн гол нь чи арай бүгдийг мартаагүй байна. Миний наадмыг мартаагүй байна тэгэхээр найдваргүй ч биш юмаа. Чиний өвөө хөгшин Тукийг бодож Белладонна хатагтайг өрөвдөж чиний гуйлтыг биелүүлье.

- Би юу ч гуйгаагүй шүү дээ. Уучлаарай.

- За тэр хоёр дахь удаагаа боллоо. Уучлал гуйгаад байгаа биз дээ. Уучилъя, уучилъя, энэ ч багадана би чамайг жинхэнэ адал явдалд оролцуулъя. Надад сонирхолтой, хэрвээ сайнаар дуусах юм бол чамд ч азтай болно.

-Үгүй шүү, би ямар ч адал явдалд оролцохгүй. Учирлан хэлэхэд надад хэрэггүй. Баярлалаа. Өглөөний мэндээрээ л дуусъя. Харин одоо манайд орж аяга цай уухгүй юу, эсвэл маргааш ирэх үү? За тэгвэл маргааш маргааш, баяртай. Ингэж хэлээд хоббит бүдүүлэг харагдахгүйг хичээн дугуй ногоон хаалга уруугаа гүйн орж аяархандуу хаалаа. Ямар ч гэсэн ид шидтэй хүн ямар нэг ганзагын наймаачин биш дээ.

Яагаад би түүнийг цай уу гэж урив аа гэж идэх юм хадгалдаг агуулах уруугаа явж байхдаа тэрээр гайхан бодов. Тэр саяхан өглөөний цайгаа уусан хэдий ч ингэж догдолсны дараа хоёр жижигхэн боов, сэрүүцүүлэх ундаа уухад илүүдэхгүй бизээ.

Гэндальф гадаа зогссоор чимээгүйхэн инээмсэглэж байв. Дараа нь хоббитын өрх уруу ойртон гөлгөр ногоон хаалган дээр таягныхаа хурц үзүүрээр ямар нэг хачин янзын тэмдэг зурчихаад алга болж өгөв. Яг энэ үед Бильбо хоёр дахь боовоо идэж дуусаад ямар эвтэйхнээр адал явдалд оролцохоос сугарч үлдэв ээ гэж баярлаж суулаа.

Маргааш нь Бильбо Гэндальфийг бараг мартчихсан байлаа. Ерөнхийдөө ой той муутай учраас тогтоох юмаа бичдэг зантай. Жишээ нь: Гэндальф, Лхагва, цай. Харин өчигдөр бүгдийг мартталаа сандран догдолжээ.

Бильбо цайгаа уухаар суутал гэнэт хаалганы хонх чангаар дуугарав. Яг энэ мөчид тэрээр бүгдийг саналаа. Гал зуух уруугаа гүйхээрээ орж плиткэн дээрээ данхаа тавиад нэг аяга таваг, бас хоёр чиг боов гаргачихаад үүд уруугаа харайв.

Гэндальфийг гэж бодоод, хүлээлгэсэнд уучлаарай гэж хэлэх гэтэл түүний өмнө шидэт Гэндальф биш цэнхэр сахлаа алтан бүснийхээ цаагуур хийсэн хар ногоон өнгөтэй малгайтай цамцныхаа доороос цоо ширтсэн нэгэн одой зогсож байлаа. Үүд онгойнгуут л одой зөвхөн түүнийг л хүлээж байсан юм шиг годхийн орчихов.

Тэрээр цамцат малгайгаа тайлж дэгээнд өлгөөд шал шүргэтэл бөхийн,

- Двалин, таны мэдэлд гэлээ.

-Бильбо Бэггинс, басхүү таны мэдэлд гэж гайхаж хоцорсон хоббит гөвтнөв. Тэрээр юу ч асуусангүй учраас мэдээж ямар ч хариулт сонсолгүй сууж байлаа. Чимээгүй удааширмагц Бильбо дэмий л,

-Би яг цайгаа уух гэж байсан юм. Хоёулаа цуг цай уух уу? гэж хоббит эелдэгхэн байхыг хичээсэн боловч хуурай ёсорхуу хэлчихэв.

Таны гэрт урилгагүй одой давхин орж ирээд гэртээ юм шиг хувцсаа шидчихвэл та юу гэж хэлэхсэн бол. Удаж төдөлгүй тэд гурав дахь боовондоо хүрээгүй байтал үүдний хонх дахин дуугарлаа.

- Уучлаарай гэж зочиндоо хэлээд хоббит хаалга чиглэв.

- Одоо л ... нэг гэж оройтсон зочиндоо хэлэх гэтэл тэр нь бас Гэндальф биш байлаа.

Шидэт Гэндальфийн оронд үүдэн дээр улаан өнгөтэй малгайтай цамц өмссөн цагаан сахалтай хөгшин одой зогсож байлаа. Тэрээр түрүүчийн одойн адилаар хаалга онгоймогц л ёс төр ч үгүй ороод ирэв.

- Аа ха, манайхан цуглацгааж байна гэж Двалины ногоон цамцыг харангаа тэрээр хэлээд өөрийнхөө улааныг хажууд нь өлгөв.

- Балин. Таны мэдэлд гэж цээжээ даран танилцлаа.

- Гялайлаа гэж Бильбо утгагүй хариу хэлэв. Манайхан цугларч байна гэдэг үг түүний гайхшралыг төрүүлж тэрээр юу хэлэхээ мэдэхгүй болжээ. Гэнэт боовны тухай муухай бодол толгой уруу нь ороод ирлээ. Зочломтгой эзний хувьд бүх боовоо тавиад өөрт юу ч үлдэхгүй нь ээ.

- За ороорой. Та, яг цай ууж байхад таарлаа гэж хүчлэн хэлээд санаа алдав.

- Би ч аяга шар айраг уучихмаар байна. Мэдээж дургүйцэхгүй бол шүү гэж цагаан сахалт Балин хэлээд хэрвээ танайд байгаа бол гоньдтой боовноос татгалзахгүй гэж нэмлээ.

- Зөндөө байгаа. Бильбо өөрийнхөө дэндүү өглөгч болсонд гайхаад аяга шар айраг тунгаахаар агуулах уруугаа гүйж дараа нь орой иднэ гэж саяхан жигнэсэн боовоо авахаар идэх юм хадгалдаг өрөө өөдөө харайв. Түүнийг эргэж ирэхэд Балин, Двалин хоёр ширээний ард суун найзархагаар, үгүй ээ ах дүүгийн ёсоор үнэндээ ах дүү хоёр ч юмуу ам хамхилгүй ярьж суулаа. Бильбо дайлах юмаа дөнгөж ширээн дээр тавингуут дахин хонх дуугарлаа. Дахин дахин дуугарав. Одоо ч яг Гэндальф гэж бодоод Бильбо үүд чиглэв. Тэгтэл бас л андуурчээ.

Түүний өмнө мөнгөн бүс бүсэлсэн цэнхэр цувтай шар сахалтай хоёр одой зогсож байлаа. Хоёулаа багаж хэрэгсэлтэй цүнх үүрсэн агаад гартаа жоотуу барьцгаажээ. Хаалга онгоймогц л годхийн орж ирдэг одойнуудыг хараад Бильбо одоо бол гайхсан ч үгүй.

- Та нарт би юугаар туслах вэ? Хүндэт одойнуудаа гэж хоббит эелдэгхэн асуув.

- Кили. Таны мэдэлд гэж эхнийх нь хэлэв.

- Фили. Таныг хүндэтгэе гэж нөгөөх нь нэмэв. Тэд малгайтай цамцаа өлгөцгөөгөөд мэхэсхийв.

- Танд болон танайханд туслахад бэлэн хэмээн Бильбо зөв үгийг гэнэтхэн санаж хэллээ.

- Аа ха, Двалин, Балин ирчихэж гэж Кили баярлаад,

- Бид ч ороод ирлээ манай хороо бүрдэнэ гээд бодчих гэх нь тэр.

- Хороо гэнэ үү. Бильбо айсандаа тэднийг тоолж гарав. Хэрвээ бүгд цуглавал яана аа. Ай яа, яа, аяга цай балгаатахъя, амьсгаагаа нэг дараатахъя. Тэрээр буланд чимээгүйхэн суулаа.

Дөрвөн одой ширээ тойрон сууж алт мөнгөний сан, хорлонт махчин гоблинууд, дээрэмчин луу гэх зэргээр Бильбогийн мэдэхгүй, мэдэхийг ч хүсээгүй олон янзын юм ярьцгаана. Эдний ярианаас элдэв адал явдал мэдрэгдэж байлаа. Бильбо цайнаасаа дөнгөж балгатал үүдний хонх хэн нэг нь сахилгагүйтэн таслах гэж байгаа мэт дуугарав. Дон. Дон. Дон. Дон, донгодох нь тэр.

-Дахиад нэг зочин гэж Бильбо бувтнав.

-Хонхдохыг нь сонсвол дөрвүүлээ бололтой гэж Фили сэтгэв. Яг дөрвүүлээ бидний ард явж байсан юм.

Хөөрхий хоббит толгойгоо барин, юу болж байна аа. Юу хүлээх, хэнийг хүлээх гэж шогшров. Хэрвээ эд нар хороогоороо оройн хоол идэхээр үлдвэл яана.

Хонх тэсгэл алдан дуугарна. Хаалга уруу харайхаас. Тэд дөрвүүлээ биш ТАВУУЛАА. аж. Бильбог хаалгаа онгойлгомогц тэд дараа дараалан бөхөлзөн орж ирээд,

-Таны мэдэлд. Таны мэдэлд. Таны мэдэлд. Таны мэдэлд. Таны мэдэлд гэж шулганацгаав. Дори, Нори, Ори, Ойн, Глойн. Пөөх нэрс ч гэж нэрс юм. Хоббит нүдээ ч ирмэж амжаагүй байтал саарал, хүрэн, цагаан, хоёр алаг цамцнууд өлгөгдөж одойнууд алтан мөнгөн бүсээ гялалзуулан гараа хол хол хаялан зочны өрөө уруу цувран оров.

Зочны өрөөнд бараг хороо гэж болохоор одойнууд шуугилдаж байлаа. Нэг нь цайвар өнгөтэй нөгөө нь өтгөндүү шар айраг нэхнэ. Гурав дахь нь кофе уумаар, бүгдээрээ боов идэхийг хүснэ. Хоббит ядраад унах шахаж байлаа. Плиткэн дээр томоо гэгчийн кофены сав зогсоо чөлөөгүй буцална. Гоньдтой боов хормын дотор дуусаж байлаа. Одойнууд зузаан маслотай бин уруу гараа сунгацгааж байтал хонх биш хаалга чангаар нүдэх чимээ гарав.

Хоббитын цэвэрхэн ногоон хаалга чичигнэж байлаа. Хэн нэг нь таягаараа нүдэж байв. Бильбо үүд өөдөө гал мэт дүрэлзэн очив. Самгардаж балмагдсан тэрээр юу ч сэтгэхгүй байлаа. Ийм лхагва гараг урьд өмнө байсан гэж үү? Хоббит уурлан үүдээ дэлгэтэл тэд яг цэргүүд шиг шил шилээ даран орцгоов. Дахиад дөрвөн одой. Тэдний ард Гэндалф таягаа тулан инээвхийлэн зогсож байв. Гэндалф хаалгыг нь таягаараа нүдэж өчигдрийнхөө тавьсан тэмдгийг арилгажээ.

- Болгоомжтой, Бильбо болгоомжтой. Чамайг чинь ингэнэ гэж бодсонгүй. Эхлээд нөхдөө хаалганы цаана хүлээлгээд дараа нь хаалгаа мултартал татдаг чинь юу билээ. За энэ Бифур, Бофур, Бомбур ялангуяа энэ Торин танилцацгаа гэлээ,

-Таны мэдэлд гэж Бифур, Бофур, Бомбур шилээ даран зогссон гурав нэгэн зэрэг хэлэв. Дараа нь тэд нар яг тушаал авсан юм шиг цамцат малгайнуудаа тайлан хоёр шар нэг цайвар, ногоон бас нэг онцгой урт мөнгөн цацагтай тэнгэрийн цэнхэр өнгөт хувцсаа өлгөцгөөв. Мэдээж тэр онцгой гоё нь Ториных байлаа. Энэ хүндэт одой бол аугаа их Торин Оукеншильд дүрээрээ

мөн байлаа. Торин босго алхангуутаа л Бифур, Бофур, Бомбур гуравт шахагдан гутлын улны алчуур дээр зогссондоо их л дургүйцлээ. Тарган Бомбур ганцаараа хэнийг ч бяц дарж чадахаар билээ. Ихэмсэг Торин голдоо ортол доромжлогдсон байв. Хэрвээ түмэн уучлал, мянган харамслаа илэрхийлээгүй бол Бильбо зочноосоо таны мэдэлд гэсэн жижүүрийн үг байтугай эвтэйхэн хэдэн үг ч сонсохгүй байх байлаа. Эцсийн эцэст Торин,

- Боллоо, боллоо нөхөр минь! гэж уруулаа унжуулан хөмсгөө зангидан хайнгадуухан хэллээ. Гэндальф түүний малгайн хажууд өлгөөтэй байгаа бүх арван гурван одойн цамцыг гүйлгэж хараад хөгжилтэйгөөр,

-За ингээд бүгд цуглажээ. Гайгүй улсууд цугласан байна шүү. Бидэнд идэх уух юм үлдсэн биз дээ. Би улаан дарс уумаар байна даа гэв.

- Би ч гэсэн гэж Торин хэлэв.

- Надад улаан бөөрөлзгөний чанамал, алимтай боов гэж Бифур захиалав.

- Бас амтат боов, бяслаг гэж Бофур нэмлээ.

- Гахайн махтай боов, салат гэж Бомбур уруулаа долооход,

- Боов боов, шар айраг, кофе гэж бусад одойнууд нь хашхиралдав.

- Хөөе найз минь, арван хоёр өндөг аваад ирээрэй гэж Гэндальф идэх юм хадгалах өрөө өөдөө дуулгавартай явж байгаа хоббитын араас хашхирлаа. Түүгээр ч барахгүй,

- Утсан тахиа, давсалсан өргөст хэмх мартав аа, гэж нэмэв.

- Гэрт юу хадгалж байгааг надаас илүү мэдэж байх шив гэж Бильбо амандаа гөвтнөв. Түүнийг жинхэнэ адал явдалд уруу татаж байна гэдэгт бараг эргэлзсэнгүй. Хоббит янз бүрийн идэх уух юм, банк, шилтэй ундаа, халбага сэрээ, таваг аяга бүгдийг том том тавиур дээр тавин зөөсөөр бүр халууцаж ядарч амьсгаадлаа.

- Энэ муусайн цадаж ханадаггүй одойнууд хагарч дэлбэрвэл таарна гэж үглээд, ажилгүй юмнууд алхайж ялхайгаад сууж байгаагий нь туслах ч үгүй шүү. Идэх юм хадгалдаг өрөөний үүдэнд чихцэлдэн байгаа Балин, Двалин, Фили, Кили нарыг гэнэтхэн хараад Бильбо үг ч хэлж амжаагүй байтал тэд зочдын өрөөнд том ширээ оруулж идэх юмтай тавиуруудыг тосон авч ширээн дээр яах ийхийн зуургүй өрцгөөв. Гэндальф ширээний дээд талд бусад арван гурав түүнийг тойрон сууцгаав. Бильбо мухар сандал дээр хамгийн захад шомбойн суув. Тэрээр юм ч идэх дургүй дэмий л жижигхэн хатсан боовхон мэрг суулаа. Хөөрхий Бильбо юу ч болоогүй ямар ч адал явдалд яасан ч оролцохгүй дээ гэж өөрийгөө ятгах аядана. Харин одойнууд идэж, ууж, зажилж, мэрг зөвхөн үүний төлөө л ирсэн юм шиг чалчицгаана. Эцэст нь тэд цадацгааж ширээнээс холдлоо. Бильбо хоосон таваг, аяга, шилнүүдийг хураахаар босон харайхдаа тэднийг татгалзана гэж бодоод,

- Оройн хоол идэхээр үлдэцгээнэ биз дээ гэж хэлээд тавьчихлаа.

-Мэдээж үлдэнэ гэж Торин хариулаад,

- Оройн хоолны дараа ч бас жаахан сууцгаана. Одоо ажил хэрэг ярилцах зуураа дуулъя, бүжиглэе. Алив нөхөд өө, цэвэрлээд гэлээ. Торин өөрөө суудлаасаа ч боссонгүй. Гэндалфтай чухалчлан ярилцан суух хооронд бусад арван хоёр одойнууд ширээн дээрээс сав суулгыг нүд ирмэхийн зуур хураачихав. Одойнууд тавагнуудыг нэг гар дээрээ овоолцгоож дээр нь хоосон шил тавиад сул гараа хол хол хаялан галын өрөө тийш цуврахад Бильбо тэдний араас гүйн айсандаа хашхиран алдан,

- Болгоомжтой болгоомжтой. Алив би өөрөө угаая гэхэд одойнууд сонсоогүй царайлан ийнхүү дуулцгаав.

Халбигар таваг тавагханыг хагалцгаа

Халбагаа нуга дарцгаа. Хутгаа хугалцгаа

Цайны аяга сайхан хагарна даа

Цартай нь шалан дээр шидэцгээ

Асгацгаа соусаа. Хивсийг хайрлах хэрэггүй

Алив бүгдийг нь дээш доош нь хаялцгаа.

Шалаа хэмхэрхийгээр дүүргэцгээе.

Шар дарстай шилийг хана уруу шид.

Бүтээлгийг урцгаа. Амны алчуурыг тасалцгаа.

Бүтэн сандал ширээ уруу сэрээ шаацгаа

Хазсан талх, үлдэгдэл хоолыг хөнжил доогуур.

Харласан муухай хайруулыг дэвсгэр даавуун доогуур.

Бильбод ингэж тусалсан усалсан

Бидэнд бүгдээрэнд маань баярлана даа.

Үнэн хэрэгтээ бүх юм өөрөөр буюу эсрэгээр байлаа. Бильбог сандран гүйж тэдний урьд хойно нь орох хооронд одойнууд аймаар дуугаа дуулсаар аяга тавгийг хурдан түргэн угааж бүгдийг нь байр байранд нь эмх цэгцтэйхэн өрж тавьцгаалаа.

Дараа нь одойнууд Торин камин зуухны төмөр дээр хөлөө тавиад хэнэггүйхэн тамхилж байгаа зочны өрөөнд орцгоолоо. Торин тэрэгний дугуйн чинээ асар том угаан цагирагийг

дээш нь утааны нүх уруу эсвээс камин зуухан дээр байгаа цаг уруу эсвэл ширээн доогуур эсвэл зүгээр л таазаар нэг тархаан сарниаж суулаа. Харин Гэндальф богинохон шавар гаансандаа байн байн тамхи чихэн арай багахан шиг утаан цагираг гаргахад түүний утаа эргэлдэн Торины утаан цагираганд тулж очоод нэвтрэн гарч тасалгаан дотуур эргэлдсэнээ эргэж Гэндальфийн толгой дээр зөндөө олон утаан цагираг цуглаж түүнийг мөнгөлөг үүл болон хучиж байлаа. Оройн бүрэнхий шидэт гэрэлд утаан малгай доор Гэндальф нууцлаг хүчирхэг харагдана. Бильбо шидэт утаан цагирагуудын эргэлдэхийг харан мэлрэн зогсож байлаа. Тэрээр өглөөхөн түүний тамхины өчүүхэн жижиг утаан цагирагуудыг салхи хийсгэн Толгодын цаагуур оруулсныг ярьж гайхуулж байснаа санаад ичих шиг болов.

- За, одоо тоглоцгооё. Хөгжмүүдээ аваад ирцгээ гэж Торин санал болгов. Кили, Фили хоёр цүнх өөдөө гүйн очиж жижигхэн хийл гаргаж ирлээ. Дори, Нори, Ори гурав цуван доороосоо гэнэтхэн лимбэ гаргацгаав. Бифур, Бофур хоёрын гарт бялар хөгжим бий болов. Тэд таягтайгаа цуг тавьсан байжээ.

- Бид нар хөгжмөө үүдний гадаа тавьсан гэж Балин, Двалин хоёрыг хэлэхэд,

- Минийхийг бас аваад ирээрэй гэж Торин тэдэнд хандан хашхирлаа.

Удалгүй одойнууд эргэж ирэв. Тэр хоёр хоёулаа өөрсөдтэйгөө өндрөөрөө адилхан виола барьжээ. Тэд мөнхүү Торины нарийн хийцтэй алтан босоо ятгыг ч авчирлаа. Торины босоо ятгыг ногоон даавуунд нямбайлан боосон байв. Торин хөгжмөндөө хүрмэгц эелдэг намуухан сайхан аялгуу урсан гарч, Бильбо орчлон хорвоо дээрх бүхнийг мартан хөгжмийн аялгуугаар нисэн хоббитынхоо өрхнөөс алсын алсад дэвж явлаа. Голын тэртээ, Толгодын цаана, хэд хэдэн сар тэнгэрт гялалзсан үл мэдэх газарт нисч явлаа. Үдшийн харанхуй жижигхэн цонхыг халхалж Толгодын орой, гүвээ давааг далдлан нуужээ.

Алсын алсад дөрвөн сарын гал хорхойн өчүүхэн гэрлүүд үсчинэ. Одойнууд хөгжимдсөөр хөгжимдсөөр Гэндальфийн сахлын сүүдэр ханан дээгүүр удаан гэгч гулсан бүжиглэнэ. Зочны өрөөг харанхуй бүрхэв. Камин зуухны гал ч унтрав. Сүүдэр уусан алга боллоо. Гэнэтхэн одойнуудын нэг нь дуу эхэллээ. Хоёр дахь гурав дахь нь дэмжин дуулж эхэллээ. Олон өнгийн хоолой хөгжимтэй хосолно. Эртний нутаг орон нууцат агуй одойнуудын домог туульсын дуу Бильбогийн гэрийг дүүргэлээ.

Одойнууд дуулахад Бильбогийн зүрх энэ газар доор амьдрагчдын чадварлаг гараар бүтсэн гайхамшигт зүйлийг хайрлах хайраар бялхаж байлаа. Эдний ид шид хоббитын сэтгэлийг урвуулж чадлаа. Агуу их Тукийн үр удам бүрийн сэтгэлийн гүнд нуугдан байдаг тэр зүйл Бильбогийн дотор сэргээд ирлээ. Түүнд алсын алсад орших тэнгэрт тулсан уулсыг харж, нарсны бүдэг шуугих чимээ, усны хүрхрээ шаагин буухыг сонсон, гүнзгий агуйд орж гартаа бадарчингийн таяг биш хурц сэлэм барьж үзэхсэн гэсэн хүсэл оргиллоо.

Бильбо цонхонд наалдан гадагш харлаа. Харанхуй тэнгэрт моддын дээгүүр том том одод гялалзана. Түүнд агуйн гүнд үнэт эрдэнийн чулуу овоолттой гялалзаж харагдав. Голын тэртээх ойд түүдгийн гал дүрэлзэх шиг болов. Хэн нэг нь түүдэг асаасан байж магадгүй гэтэл Бильбод догшин луунууд улаан галаар амьсгалан эргэн тойрныхоо амьд бүхнийг шатааж байх шиг санагдлаа. Тэрээр толгой сэгсрэн толгодын хормойн бэл эдлэн газрын энгийн нэг

оршин суугч Бильбо гэгч даруухан төлөв хоббитдоо эргэж хувирах гэж яарав. Тэрээр айсандаа чичрэн босов. Гэрэл авах гэж байгаа хүн болоод зоорь уруу орж шар айрагны боошигны ард нуугдчихдаг юм билүү? Тэгээд одойнууд манай гэрээс явтал үзэгдэхгүй суугаад байх уу? Яг тэр үед дуу дуусаж бүгдээрээ түүнийг харанхуйд нүдээ гялалзуулан ширтэв.

- За чи хаачих нь вэ? гэж Торин асуух нь тэр. Түүний дууны өнгө хоббитын санааг уншчихсан юм шиг байв.

-Гэрэл авчиръя. Харанхуй болчихлоо гэж Бильбо гөвтнөв.

- Аан ха, бид харанхуйд дуртай. Хар хэрэг харанхуйд гээд л одойнууд шуугилдан үүр цайтал өдий байна аа гэгцгээв.

- За за гээд Бильбо мухар сандал дээрээ дахин суух гэснээ ичингүйрсэндээ сууж чадалгүй галын хайч, үнсний сэтгүүр хөлөөрөө түлхэн өнхрүүлж тас хийтэл унаад өгөв.

- Чимээгүй. Торин үг хэлнэ гэж Гэндальф хөмсөг зангидан зарлалаа. Торин ийнхүү ярьж эхлэв.

- Гэндальф! Одойнууд! Ноён Бэггинс! Бид, бидний найз итгэлт нөхөр энэ ер бусын эрэлхэг зоригт хоббитынд ирээд байна. Түүний толгойноос нэг ширхэг үс, хөлнөөс нь нэг ч туг үс бүү унах болтугай. Хоол цайгаар дайлж, дарс ундаагаар зочилсон энэ гэрийн эзэнд гүн талархлаа илэрхийлж байна. Бильбо хариу талархал илэрхийлнэ гэж бодоод тэрээр дуугүй болов. Хөөрхий сандарч тэвдсэн Бильбо зөвхөн түүнийг эрэлхэг зоригт гэсэн бас итгэлт нөхөр гэж нэрлэхийг л сонсож амжжээ. Энэ бол сайн юм амлаж байгаа хэрэг биш дэг ээ. Тэрээр нам цохиулсан мэт хөдөлгөөнгүй зогсон уруул нь дуугүй шомболзоно. Торин жаахан хүлээзнэснээ цааш нь ярьж гарлаа.

- Бид яаж, хаашаа, хэнтэй, юунд, хэдийд, яагаад явах болсноо хэлэлцэн тохирох гэж цугласан. Энэ адал явдалт аян замаас манай ид шидэт Гэндальфаас бусад нь буцаж ирэхгүй ч байж магадгүй. Гэвч бид сэтгэлээр унахгүй. Хаашаа, юунд, яагаад явах гэж байгааг бид бүгд мэдэж байгаа. Харин хүндэт, зочломтгой ноён Бэггинс мөн хамгийн залуу Кили, Фили хоёрт нэмэлт тайлбар хэрэгтэй байхаа... Торин дэмий сул үг чалчигч биш. Тэрээр чухал, хүндтэй одой шүү дээ. Хэрвээ түүнийг зогсоохгүй бол гоё үгээр булж хаях байлаа. Түүний урсгал яриа гэнэтхэн тасрав.

Буцаж ирэхгүй ч байж магадгүй гэдэг үгийн дараа айж тэвдсэн Бильбо тэсвэр алдлаа. Хоббит айсандаа хонгилын гүнээс гарч ирсэн галт тэрэг орилох шиг чих янгинуулам хашхирлаа. Одойнууд сандал ширээгээ өнхрүүлэн босож ирцгээлээ. Зочдын өрөөний харанхуйг Гэндальфийн шидэт таяг ногоон өнгөөр гэрэлтүүлэхэд анивчих гэрэлд камин зуухны өмнө хөшчихөөд жимсний чанамал шиг үл мэдэг бэлбэлзэн зогсоо хоббитыг бүгд харлаа. Тэрээр гэнэт,

-Цахилгаан цохилоо, аянга намайг ниргэг гэж утга учиргүй хашхирав. Одойнууд түүнээс олигтой юм сонсож чадсангүй зүгээр л өргөж хажуугийн өрөөний буйдан дээр аваачиж, сэргээх аяга ус тавиад буцаж өөрсдийнхөө үл мэдэгдэх хэргийг ярилцаж эхэллээ.

-Мэдрэлтэй залуу байна гэж Гэндалф тайван хэлээд хачирхалтай боловч ажил хэрэг дээр бол буланд шахагдсан луу мэт догшин доо гэх нь тэр. Хэрвээ та буланд шахагдсан лууг харсан болов уу, хоббитын тухайд тийм үг таарахгүй гэдгийг ойлгоно. Хөгшин Тукийн элэнц өвөг эцгийн тухайд ч ингэж зүйрлэж болохгүй. Хэдийгээр тэр элэнц өвөг эцэг нь өөрийнхөө өндөр болоод хүчтэй харьцуулахад морь унах төдий биш морь сургаж байсан гэж байгаа юм шүү. Түүгээрээ ч Догшин Бух гэдэг хоч авсан гэдэг. Ногоон тал дахь тулалдаанд тэрээр махчин гоблинуудын үүрийг үндсээр нь эргүүлж тэдний хаан Гольфимбулын толгойг ганцхан бороохойдоод унагааж байсан гэж ярьдаг. Тулалдаан ялалтаар дуусч түүнээс хойш гольф гэдэг нэрт тоглоом үүссэн гэнэ билээ.

Энэ үед Догшин Бухын энхрийхэн удам буйдан дээр ухаан орж байлаа. Тэрээр уснаас хоёр балгачихаад чимээ гаргахгүйг хичээн үүд өөдөө гэтэж очоод Глойны үзэн ядсан гэмээр хайхрамжгүйхэн яриаг сонсов.

-Хм. Энэ хоббит таарна гэж үү. Үүнийг ширүүн догшин хоббит гэж Гэндалф бидэнд хэлсэн. Хэрвээ саяных шигээ орилох юм бол зөвхөн лууг биш лууны бүхий л төрөл саданг сэрээчих шинжтэй. Тэгвэл ч бид сайнаа үзэхгүй нь мэдээж. Мэдрэлтэй гэнэ ээ, зүгээр л хулчгар нөхөр байна. Энэ сандарч гүйсэн, ааглаж амьсгаадсан бүдүүн надад шууд л таалагдаагүй. Хэн ч байж болно, талхчин ч байсан яах вэ, гагцхүү Түлхүүр-Чимхүүр ямар ч байсан бишээ.

Бильбо тэсвэр алдан хаалгаа хуу татан зочдын өрөө өөд гүйхээрээ орлоо. Түүний дотор Тукуудын халуун цус буцалж байв. Өөрийнхөө догшин ширүүнийг харуулахын тулд дулаан хөнжил, хоол ундгүйгээр хаашаа ч явахад бэлэн байлаа. Ааглаж амьсгаадсан бүдүүн гэдэг үг бүр зэвүүгий нь хүргэжээ. Үнэндээ дараа нь хэд хэдэн удаа Бэггинсийнхний юмыг ул суурьтай тунгааж бодох чанар илэрч ирэх үед, ээ мангараа гэж ийм холион бантанд хутгалдах ч гэж дээ гэж бодсон нь бий,

-Уучлаарай. Би таны яриаг санамсаргүйгээр сонсчихлоо. Юу ярилцаж байгааг чинь ойлгосон болж би маяглахгүй. Ямар тэмдэг, түлхүүр тааруулагч, хаалга онгойлгогч ч гэх шиг, гэхдээ та нар намайг юунд ч хэрэггүй хулчгар амьтан гэж бодоцгоож байгааг би ойлголоо гэж Бильбо буурь суурьтайхан хэлээд тавьчихлаа. Буйр суурь хаанаас ч зээлмээргүй хангалттай байлаа. Би үзүүлээд өгнө. Хаалган дээрх ямар тэмдэг яриад байгааг би ойлгохгүй байна. Хаалгаа би долоохон хоногийн өмнө будсан даа. Үнэндээ та нар хаалга андуурсан юм биш биз. Би та нарын хачин царай зүсийг хараад л ойлгосон юм аа. Шууд л буцаад гар гэхийн оронд жаахан хүлээхээр шийдсэн юм. Надаас та нарт юу хэрэгтэйг шууд хэлээтэх, тэнгэрийн хаяа хүртэл алхаж, элсэн цөлд ороолон шидлүүдтэй үхэх сэхэхээ үзэлцэн тэмцэхэд би бэлэн байна. Миний элэнц өвөг эцэг Догшин Бух Тук нэг удаа...

- За, тийм тийм, гэхдээ энэ бол аль эрт болсон явдал гэж Глойн түүний үгийг таслаад,

- Би чиний тухай ярьсан юм. Итгэ, хаалган дээр тэмдэг байсан. Эрт дээр үеэс ганцхан утга илэрхийлдэг, шинийг нээгч Түлхүүр-Чимхүүр тохирсон үнээр аюултай ажил хийхэд бэлэн байна гэсэн тэмдэг л дээ. Алт мөнгөний лут Эрэлч гэж өөрийгөө нэрлэсэн ч болно. Бидэнд хамаагүй. Лхагва гарагт таван цагт аяга цай уунгаа уулзаж ярилцацгаана гэж Гэндалф бидэнд хэлсэн юм.

-Тэмдэг байсан гэж Гэндальф оролцоод, би өөрөө зурсан юм. Яагаад гэвэл та нар арван дөрөв дэхийг олооч гэж надаас гуйсан биз дээ. Би ноён Бэггинсийг сонгосон хэрэг. Хэрвээ би алдаж, та нарыг буруу хаалга цохиулсан бол та нар арван гурвуулаа үлдэнэ. Азгүй тоо. Яваад аз эзээ үзвэл үз л дээ. Эсвэл газар доор орцгоож нүүрсээ гаргацгаа. Тэрээр ингэж хэлээд хөмсгөө зангидан Глойн уруу харахад, Глойны нуруу зарсхийх шиг болов.

Бильбо юм асуух гэснээ Гэндальфийн өтгөн хөмсгөн доорх түлэх мэт харцанд өртөгдөн амаа хамхив.

- За ингээд гүйцээ гэж шидэт Гэндальф хэлээд одоо маргахаа больцгооё. Би ноён Бэггинсийг сонгосон, түүнийг Түлхүүр-Чимхүүр гэж нэрлэе, тэгээд л боллоо. Цаг нь болохоор тэр өөрийгөө үзүүлнэ ээ. Та нар мэдэхгүй байна, тэр өөрөө ч мэдэхгүй л сууж байна. Миний энэ сонголтонд баярлалаа гэж хэлэх цаг ирнэ. Хэрвээ амьд буцаж ирцгээх юм бол? Бильбо алив хүү минь гэрлээ асаа.

Улаан дөрвөлжин чийдэнгээс ширээн дээр тусаж байгаа гэрэлд Гэндальф газрын зурагтай төстэй пергамент цаасны хэсгийг дэлгэв.

- Торин, үүнийг чиний өвөө хөгшин Трор зурсан юм гэхэд одойнууд дуу алдан шагшрав.

- Уулын зураг гэж Гэндальфийг хэлэхэд Торин,

- Ямар хэрэгтэй юм бэ? Би газрын зурагтай зураггүй уул түүний орчмыг цээжээр мэднэ. Хар ой, луу, луунууд амьдардаг хөндийг ч эрж олно.

- Энэ Уулан дээр луу зурсан байна. Хэрвээ бид тийшээгээ хүрч чаддаг л юм бол зураггүй байсан ч олж харах болно доо гэж Балин нэмэрлэлээ.

- Анхааралтай харцгаа гэж шидэт Гэндальф хэлээд,

- Харж байна уу? Нууц нүх үү дээ? Баруун талын хэц дээрх энэ бичгийг хараач? Бичгийн доор чиг заасан тэмдэг байна. Яг энд доод агуй уруу орох нууц зам бий дээ.

-Хэзээ ч юм нууц байсан л байх. Одоо нууц хэвээрээ үлдсэн гэж хэн хэлэх вэ. Хөгшин Тортог аль хэзээнээс тэнд амьдарч байгаа болохоор бүхий л нүх сүвийг шиншчихээ биз гэж Торин өгүүлэв.

- Шиншээ л биз, түүнд үүнээс ямар ашиг байгаа аж.

- Яагаад?

- Яагаад гэвэл нүх түүнд дэндүү нарийхан. Эртний номонд үүгээр гурван одой зогсоогоороо зэрэгцэн орж болно гэж бичсэн байдаг юм. Ийм жижигхэн нүхэнд Тортог луу яаж ч зүтгээд орж чадахгүй. Хөгшин Тортог залуудаа ч таргандуу байсан одоо Дейл хотын хүмүүс, одойнуудыг залгисаар бүр дэлбэрэх шахсан байх.

-Надад дэндүү өргөн л юм гэж амьдралдаа амьд луу, лууны нүх үзээгүй Бильбо дуугарчихав

аа. Тэрээр яриаг улайран сонирхож түүнд бол дуугүй байсан дээр нь гэдгийг таг мартчихжээ. Гол нь Бильбо янз бүрийн газрын зураг үзэх их дуртай аж. Түүний үүдний өрөөнд зугаалж алхах дуртай зөрөг замуудыг нь улаан харандаагаар тэмдэглэсэн, ойр орчны томоо гэгч газрын зураг өлгөөтэй бий. Ийм том хаалгыг яаж нууж болдог байна аа? гэж хоббитын гэрийн эвлэгхэн үүд жижигхэн санагдахгүй байгаад хоббит гайхаж байлаа.

- Өө, арга чарга зөндөө. Яаж хийснийг тэнд очоод л үзнэ дээ. Газрын зураг дээрээс харвал чанга хааж түгжээд Уулын хормойд айхтар эвлэг нууцалсан байна. Одойнуудын энгийн л нэг заль даа, тиймээ? гэж Гэндальфийг хэлэхэд,

- Тийм, тийм гэж Торин дэмжлээ.

- Өө, бүр мартчихаж газрын зурагтай хамт нэг түлхүүр байсан гэж Гэндальф хэлээд олон шүдтэй мөнгөн түлхүүр Торинд өгөөд, хаячихав гэж сануулав.

- Бид юм хаядаггүй ээ гэж Торин амлав. Тэрээр хүзүүндээ байсан нарийхан гинжинд түлхүүрийг зүүгээд хүрэмнийхээ цаагуур хийчихэв.

-Одоо л бүх юмны учир олдлоо. Түрүүн бид нар юу юугүй л Дорно зүг уруу явж Урт нуур уруу сэмхэн гэтэж ойртохоор шийдсэн. Тэнд биднийг аюул осол хүлээж байгаа... Аюул осол биднийг арай эрт хүлээж байгаа шүү. Дорнын зам дээр юу юу болдгийг би сайн мэднэ гэж Гэндальфийг оролцоход Торин тоосон ч үгүй яриагаа үргэлжлүүлэв.

-Нуураас цааш зам Түргэн гол уруу зална. Аа, тэндээс Уулын хормой дахь хөндийн голын дэргэд байсан Дейл хотын балгас дээр очих юу байх вэ. Үнэнээ хэлэхэд, их Үүдийг дайран шууд явмааргүй байна. Гол Уулын Өмнөд нурууны хадан дундуур яг Уулынхаа хормойгоор урсаж байгаа шүү дээ. Тэндээс луу нисэж гардаг шүү дээ. Идэх юм эрж хайх аяг зангаа л өөрчлөөгүй бол.

Энд ч ёстой хүчирхэг арми эсвэл эрэлхэг баатрууд үгүйгээр давахгүй байх даа гэж Гэндальф яриад,

-Одоо цагт тэднийг хаанаас ч олох билээ дээ? Хязгаар нутгаас дуудаад ирэхгүй. Тэд хоорондоо л дайтахаас өөр юм мэдэхгүй улс даа. Ойрх нутгаар баатар эрс үзэгдэж харагдахаа болиод удаж байна. Энд хурц сэлэм мөхөж, дайны цавчуур модны мөчир хугагалах төдийхөн болж төмөр илд, хүүхдийн эргэдэг ор эсвэл савны таглаа болжээ. Энэ нутагт луу амьдардаггүй болохоор лууг зөвхөн үлгэр домогт л гардаг гэж бодоцгооно.

Тэгээд би баруун хэц дээрх нууц нүхийг санангуутаа алдагдсан зүйлийг эрж олох тухай бодсон юм. Цоож онгойлгодог юмуу эвдэлж чаддаг уран гартангүйгээр энэ хэрэг бүтэхгүйг ойлголоо. Манай бага жаахан Бильбо Бэггинсээс өөр цоож онгойлгох мастер байхгүй, хаанаас ч олохгүй шүү. За тэгэхээр цаг үрээд яах вэ, манай цаашдын ажлын талаар ярилцъя.

-Гайхамшигтай, Түлхүүр-Чимхүүр бидэнд яаж, хаашаа ямар аргаар, юу хийхийг хэлж сургаж зөв зам заагаад өгөг гэж Торин хэлээд Бильбо уруу тохуутай харлаа.

-Бид ер нь юу хийх гээд байгааг би эхлээд мэдмээр байна гэж хоббит хэлэхдээ нуруу уруу нь хүйт оргин өр өөд нь нэг юм өгсөөд ирэх шиг болохыг мэдрэв. Гэвч түүний судсаар ухарч няцаж сураагүй Тукийн цус урсаж байгаа болохоор цааш нь зоригтойгоор ярьж гарлаа.

-Алдагдсан алт мөнгөний тухай, луу бүгдийг залгисан гэх мэт... тэр алт мөнгө ер нь хэнийх юм бэ? Яагаад тэнд орчихсон юм?

-За тэр. Чи газрын зураг хараагүй гэж үү? Бидний дуулсныг сонсоогүй гэж үү? Энэ тухай бид нар өдрийн хагас л ярьж байна шүү дээ гэж Торин уулга алдав.

-Ямар ч гэсэн тодорхой, хэсэг хэсгээр нь мэдмээр байна гэж Бильбо ихэмсэгээр толгой өргөв. Түүнээс мөнгө зээлэх гэхэд тэрээр ийнхүү ихэмсэг болдог бөгөөд энэ удаа жаал зуул юм ойлгодог Гэндалф түүнийг зүгээр ч нэг сонгоогүй гэдгийг үзүүлэх гэжээ.

-Түүнээс гадна, бидэнд тохиолдох аюул ослын тухай, энэ аян хэр удаан үргэлжлэх, гарлага орлого, хэрэгтэй олон юмны тухай мэдмээр байна гэлээ. Хэрэгтэй олон юм гэдэг үгэндээ хэрвээ амьд мэнд эргэж ирвэл олзны хэдэн хувь түүнд оногдохыг мэдэх гэжээ.

-За, сонсож бай. Эрт урьд цагт миний өвгийн үед манайхныг хойд нутгаас хөөж туухад манайхан эд хогшлоо аван дайжин зугтсаар одоо энэ газрын зураг дээр байгаа Уулын хормойд ирцгээсэн байна.

Энэ Уулын хормойг урьд манай дээд өвөг Ахмад Трайн газар доорх нутаг оронтой эзэмшин тохижуулж иржээ. Уурхай ухаж, хонгил хөндий гаргаж, агуйг том том заал болгож, түүнээс гадна нэлээд алт мөнгө, үнэт эрдэнийн чулуу олборложээ. Ингэж хөдөлмөрлөсөөр баяжиж нэр хүнд, хүндэтгэлийг олжээ. Миний өвөөг Уулын доорх одойнуудын Хаан гэж өргөмжилжээ. Түүнийг хаа сайгүй хүндэтгэж, өмнө зүгээс ирсэн хүмүүс Түргэн голын дагуу гэр орноо барих болжээ.

Ингээд их уулын хөндийд Дейл гэдэг сайхан хот цэцэглэн босжээ. Тэр хотын удардагчид манайхан уруу, манай дархчуулд юм юмыг захиалж муу сайнгүй их үнээр авдаг байжээ. Эцгүүд хөвгүүдээ сургахаар манайхан уруу явуулж төлбөр төлөөсөн дээр гар татдаггүй байж. Идэх уух юмаар ч төлдөг байж. Иймээс бид талх тариа, мах тос дарс ундаагаар дутдаггүй байлаа. Хэдийгээр Уулын хормойд бид тариа ногоо тарьдаггүй байсан боловч, гайхамшигтай сайхан цаг байжээ. Ядуу зүдүү гэдгийг мэдэхгүй зүгээр л сэтгэлийн ханамж авахын тулд ажилладаг байлаа. Манай уран гартангууд одоо хаанаас ч эрээд олохгүй тийм ид шидтэй хөөрхөн тоглоом хийдэг байсан юм. Манай өвөөгийн зоорь агуулах алт мөнгөн чимэглэл, үнэт эрдэнийн чулуу, цэргийн илд бамбай, цомог саваар дүүрч байж л дээ. Дейл хотын зах зээл хойд нутагтаа алдаршжээ.

Энэ тухай муу луунууд мэдсэнд гайхах юу байх вэ. Тэд нисэн ирж хүмүүсийг, эльфүүдийг, одойнуудыг аль алиныг нь үл ялган цөлмөн дээрэмдэх боллоо. Олз омгоо тэд үүрэндээ аваачин нууж, нүдний цөцгий мэт хамгаална. Лууг алахгүй л бол өөрөө үхдэггүй мөнх амьдардаг амьтан. Луу зөвхөн алт, үнэт чулуу, тэр ч байтугай гарамгай уран дархан хийсэн зэс бөгж ч хамаагүй хуу хаман дээрэмддэг байлаа,

Энэ бүдүүлэг зэрлэгчүүд гайхмашигтай сайн хийц гайхмаар муухай дуураймал алийг ч үл ялгах мөртлөө алтны үнэ цэнийг сайн мэддэг амьтад. Тэднээс авах юм байхгүй, тэд чинь дуулган дээрх дугуй төмрийг тэгшилчихэж чадахгүй улс шүү дээ. Сүүлдээ бүр алтнаас луу илүү олон болоод иржээ.

Одойнууд үхлээс зугтан өмнө зүг дайжихад луунууд газар доорх хоосорсон хот, агуулах зоорь, дархны газруудыг эвдэн сүйтгэжээ. Ялангуяа, Тортог нэртэй зэвүүн, шуналт, догшин луу сүйтгэн түйвээсээр нутаг хоосроход, тэр өмнө зүг давхижээ. Хойд зүгээс хүчтэй шуурга эхлэх гэж байгаа юм шиг шунгинан шүнгэнэж байснаа Уулын хэц дэх зуу зуун настай нарс моддыг их салхи хуга хуга даран унагааж эхэлжээ. Би, бас өөр хэдэн одойнууд азаар хөндийд байж луу яаж Уул уруу нисэн ирж Уул газар тэнгэр нийлсэн гал утаанд дарагдахыг харсан юм. Дейл хот орилоон хашхираанаар дүүрч энд тэндгүй хонх цохиж цэргүүд зэр зэвсгээ шүүрэн авч гүйн гарч байлаа. Хэн ч амиа аварч чадаагүй. Улаан галаар буцалсан гол эргээсээ хальж өтгөн халуун манан Дейл хотыг нөмөрсөн билээ. Манангаар халхавч хийн Тортог луу хотыг хамгаалагчдыг дайран нэгд нэгэнгүй устгасан даа.

Энэ нь гунигт түүх боловч тэр цагт энгийн зүйл байлаа. Луу хүмүүсийг алж хядчихаад Уул уруу эргэсэн. Луу их Үүдээр чихэн шургаж бүхий л хонгил, зоорь, агуулах өрөөнүүдээр шагайн нэгжиж, замдаа дайралдсан бүхнийг алж байлаа. Ууланд амьд амьсгаа нэг ч үлдсэнгүй. Луу хамаг үнэт баялагийг хаман авч одсон юм.

Луугийн жаяг заншлаар бол Тортог тэр баялагийг Уулын хамгийн гүний агуйд нуучихаад одоо болтол нүд цавчихгүй дээр нь хэвтэж байгаа даа. Урьд нь луу агуйнаасаа шөнөөр мөлхөн гарч Дейл хот уруу дайжин орж залуу охидыг хулгайлан агуйдаа аваачиж иддэг байсан. Хотоос хүмүүс амь дайжин зугтсаар хот бүр мөхөн сөнөх хүртэл ингэж түйвээсээр байсан. Одоо тэр газар амьд амьтан байгаа юу, үгүй юу мэдэхгүй. Урт нуурын эрэг дээр хэн нэгэнтэй таарвал сайн л байна.

Тэр үед амьд үлдсэн атгахан хэдэн одойнууд шатаж байгаа Уулыг нууц оромжноосоо харан нулимс унагахаас өөр яаж ч чадахгүй, догширч галзуурсан лууг хараан зүхэж байсан даа. Гэнэт бидний өмнө аав, өвөө хоёр гараад ирэх нь тэр. Сахал үс нь шатсан хувцас хунар нь түлэгдсэн байлаа. Тэд баргар царайлан угтсан намайг та нар яаж амь гарч ирэв гэхэд амаа тат, цаг нь болохоор аяндаа мэдэх болно гэж ойлгуулсан даа. Тэр цагаас хойш бид төрөлх газраа орхин одож хүний газар юу тааралдсаныг хийн амь зууж явна.

Дарханы газар туслагч эсвэл уурхайд нүүрс ухацгаасан. Харин лууд дээрэмдүүлсэн үнэт эрдэнэсийнхээ тухай хэзээ ч мартаагүй. Тэр ч байтугай, одоо бид жаахан хөлжсөн /Торин хүзүүн дэх хүнд алтан гинжээ харав/ боловч боломж олдвол Тортогоос өшөөгөө авч үнэт эрдэнэсээ буцааж авах бодлоосоо няцаагүй шүү.

Аав, өвөө хоёр луунаас яаж зугтааж гарсан тухай би олон удаа бодсон. Лууны хэц дээр зөвхөн тэр хоёр л мэддэг нууц үүд байсан байхаа гэж сүүлд нь таамагласан. Энэ газрын зургийг тэр хоёр л зурсан байх. Гагцхүү энэ газрын зургийг яагаад Гэндальф эзэмшихээд жинхэнэ өв залгамжлагч надад байхгүй байгааг мэдэхгүй байна.

-Эзэмшихээд ээ хэмээн Гэндальф хөмсгөө зангидсанаа,

- Надад өгсөн юм аа. Чиний өвөө Трорыг Морий агуйд махчин гоблин Азог алсныг чи санаж байгаа биз дээ?

-Энэ нэр хараал зүхэл идэг! гэж Торин уулгалав.

-Чиний эцэг Трайн яг зуун жилийн өмнө дөрөвдүгээр сарын хорин нэгэнд гэрээсээ гарч яваад эргэж ирээгүй. Түүнийг тэр өдрөөс хойш хэн ч хараагүй билээ.

-Тиймээ тийм, би санаж байна гэж Торин толгой дохив.

-За, тэгэхээр чиний эцэг хэзээ нэгэн цагт чамд өгөөрэй гэж надад энэ зургийг өгсөн юм. Яагаад урьд нь өгөөгүйн учрыг чамд хэлье. Би буруугүй. Чиний эцэг энэ зургийг надад өгөхдөө дэндүү хөгшин болчихсон өөрийнхөө нэрийг тэр тусмаа чиний нэрийг санахгүй байсан. Чамайг эрж олно гэдэг тийм амар ажил биш байлаа. Үглэхийн оронд үүнийгээ ав гээд Гэндальф Торинд газрын зургийг өглөө.

- Гэхдээ л энэ бүхэн нэг л учир начиртай гэж одой бувгнав.

Бильбо ч гэсэн юу ч ойлгосонгүй. Бильбо энд ямар холбоотой билээ? Гэндальф баргар царайлан удаан гэгч ингэж ярив.

- Чиний өвөө Морий агуй уруу явахдаа газрын зургийг хүүдээ буюу чиний аавд хадгалуулахаар үлдээжээ. Гэтэл өвөө чинь амь үрэгджээ. Тэгэхэд чиний эцэг газрын зургаа авч өвөртлөөд, аавынхаа замаар аз эзээ үзэхээр аян замд гарчээ. Тэр аюул осол, адал явдал олныг давсан боловч Уул хүрч чадсангүй. Харин Некромантад олзлогдсон байлаа. Энэ хар хараалчийн хорих гэрт би танай эцгийг сүүлчийн удаа харсан юм. Яаж яваад тэнд орсныг бүү мэд!

- Чи өөрөө тэр хараалчийн гэрт юу хийж явсан юм бэ? гэж Торин тэвдчин асуув. Түүний бүхий л биений шар үс өрвөгнөх шиг болов.

- Чамд энийг мэдэх хэрэг байхгүй ээ. Маш аюултай хэрэг байсныг л хэлье. Тэр ч байтугай Гэндальф би арай гэж амь гарсан. Чиний эцгийг аврах гэсэн боловч дэндүү оройтсон байлаа. Ухаан нь самуурч дэмий ярьж юу ч сэтгэхгүй байсан даа. Гэхдээ газрын зураг түлхүүр хоёрын тухай мартаагүй байсан.

- Морий агуйн хараалч хар хилэнт гоблинд хариуг нь ёстой сайн өгсөн дөө. Одоо Некроманттай тооцоо хийнэ ээ гээд Торин нүүрээ барайлгав,

- Өө, санашгүй ажил шүү. Хойд, Өмнийн бүх одойнууд цуглаад ч та нар тэр дайсныг дийлэхгүй. Газрын зураг, түлхүүр хоёроо л ашигла. Эцэг чинь үүнийг л хүсэж байсан шүү. Уул, луу гээд дарагдашгүй ажил их байна.

- Хөөе, хөөе, сонсоцгоо гэж Бильбо өөрийн эрхгүй хашхирлаа.

- Юу, юу сонсох юм бэ? гэж одойнууд сандралдаад бүгд хоббитын зүг харлаа.

- Би нэг юм хэлье гээд Бильбог эвгүйрхэхэд,

- Хэл, хэл гэж түүнийг тайвшруулав.

- Бид нар одоо Дорно зүг уруу явж бүх юмыг тагнах хэрэгтэй. Уулан дээр нууц хаалга байна. Луу, луунууд дандаа сэрүүн байхгүй шүү дээ. Заримдаа унтдаг биз. Орох үүд хаалга өөд нь чимээгүйхэн гэтэж очоод босгоны өмнө сууж сайн гэгч тунгаавал толгой уруу нэг бодол орж ирнэ ээ дээ. Би хэнийг ч гомдоох гээгүй шүү, гэхдээ л хоосон яриа хоол болохгүй. Одоо удахгүй үүр цайх нь. Жаахан дугхийцгээгээд үүрийн гэгээнээр аян замдаа хөдөлвөл яасан юм бэ? Замд гарахын өмнө би та нарыг сайн хооллоно.

- Биднийг хооллох оо? гэж Торин яаран асуугаад,

- Чи чинь, Хаалганы Хаан биш юмуу? Хаалга үүдийг онгойлгохын өмнө чи тэнд сууж бодох хэрэгтэй биз дээ? Тэр хаалгаар хамгийн түрүүлж чи орох ёстой биш билүү? Харин одоо унтаад өглөө аян замын өмнө сайхан хооллоход дуртай байлгүй яах вэ. Өглөө надад хиамтай зургаан өндөг шарж өгөөрэй. Өндөгний шар нь бүтнээрээ байна шүү.

Бусад одойнууд ч захиалгаа өгцгөөв. Гэхдээ тэдний хэн нь ч,

- Болох уу? гэдэг үгийг хэлэхгүй шууд л захиалаад байхаар нь Бильбо ихэд гомдов. Гэлээ гээд яах вэ дээ, гомдох зав ч байхгүй одой болгонд ор дэр зассаар гүйж ойчих шахаж байлаа. Одойнуудыг урт сандал, буйдан дээр, сандлууд зэрэгцүүлж байгаад хүртэл унтуулав. Зочдоо унтуулчихаад өөрөө жижигхэн орон дээрээ унаад өглөө. Энэ ичих нүүргүй арзгаруудад өглөөний хоол бэлдэх гэж үүр цүүрээр босож би л чадахгүй дэг. Аян замд цуг явна гэвэл ёстой гонжийн жоо. Энэ гэрийн хамгийн сайхан өрөөнд унтаж байгаа Торин хамар доороо нэгэн дуу гуншганахыг Бильбо зүүрмэглэж эхлэхдээ сонслоо.

Алсын уулс мананд умбана

Агуйн харанхуйд нууц хадгалагдана

Аяныхаа бэлтгэлийг шөнөдөө дуусгана

Алдсан эрдэнэсээ эрж заавал олно...

Энэ дууны аянд бүүвэйлэгдэн Бильбо унтаад өглөө. Элдэв аймшиг зүүдлэгдэв. Өглөө нэлээд оройтож сэрлээ.

Хоёрдугаар бүлэг

Шарсан хонины мах

Бильбо орноосоо гулган буугаад халаадаа нөмрөн хоолны өрөө уруу яарлаа. Хэн ч алга. Харин яаран сандран цай унд уусны ул мөр энд тэндгүй. Гал зууханд угаагаагүй аяга таваг овоолоотой өрөө аймаар эмх замбараагүй хөглөрнө. Муухай сав суулгыг хараад хөөрхий Бильбо өчигдрийн зочид зүүдлэгдсэн биш, (хичнээн горьдсон гээч) жинхэнээрээ тэднийд ирсэн байсан юм байна гэдэгт итгэв. Тэд түүнийг сэрээлгүйгээр яваад өгчээ гэж бодонгуутаа жаал уужирлаа. Баярлалаа ч, гэхгүй шүү гэж Бильбо дургүйцэн бодов. Гэхдээ сэтгэл нь нэг л хачин байлаа.

- Ингээд эхлэлгүйгээр дууслаа гэж үү? Бильбо Бэггинс. Битгий мангарт. Чиний насанд луу муу элдэв долоон юманд итгэх чинь дутаа юу гэж тэр өөрийгөө ятгав. Тэгээд тэрээр юу ч болоогүй юм шиг хормогчоо уячихаад, галаа түлэн ус халааж, сав суулгаа угааж эхлэв. Дараа нь гал зуухандаа суун амттай өглөөний цайгаа уучихаад хоолны өрөөндөө орлоо. Нар нэлээн өндөрт гарчээ. Дэлгэж орхисон гадаа хаалгаар хаврын дулаахан салхи үлээнэ. Шөнийн хачин сонин ярианууд толгойноос нь арилан одож, Бильбо хөгжилтэйхөн исгэрсээр дахиад цай уудаг ч юм билүү гэж байтал Гэндалф дахин ороод ирлээ.

- За, найз минь, яагаад саатаад байна? Өглөө эрт босно гэж өндөр өндөр дуугарсан чинь чи биш үү? Түүний оронд цай унд болоод л сууна уу? Хоёр дахь, гурав дахь удаагаа юм идэж байна уу? Харахгүй юу, арав хагас болчихож. Тэд чамайг хүлээж цөхөөд бичиг үлдээсэн.

- Ямар бичиг мичиг? гэж хөөрхий хоббит дуу нь гарахтай үгүйтэй асуув.

- Өөх, хө. Чи чинь сэрээч, сэрээч. Камин зуухныхаа тоосыг ч арчаагүй суугаа юм уу? гэж Гэндалфийг асуухад Бильбо,

- Камин зуух ямар хамаатай юм? Би сав суулгаа угааж арайхийж л дууслаа. Энд арван дөрвөн зочин биш, бүхэл бүтэн хороо цэрэг байсан юм шиг л байна.

- Хэрвээ чи камин зуухныхаа шороог арчсан бол цагны доороос энэ бичгийг олох байсан гээд Гэндалф нэгэн бичиг сугалж түүнд сарвайлаа.

-Энэ зэрлэгчүүд миний цаасыг ичгүүргүй ашигласан байна шүү. Тэр цаасан дээр ингэж бичжээ.

“Торин болон хамсаатангууд Түлхүүр-Чимхүүр Бильбод өглөөний мэнд хүргэж байна. Цайлж дайлсанд болон ялангуяа адал явдалт аян замд гарахад бэлэн байгаад нь онцгойлон талархлаа илэрхийлье.

Тохиролцоогоо тохиръё. Олз омгоо тэв тэгш хуваана, нэг үгээр хэлбэл, хэрвээ ямар нэг юм олвол Түлхүүр-Чимхүүрийн хувь арван дөрөв хуваасны нэг шүү. Аян замын зардал танаас гарахгүй, өөрөө л өөр маягаар хүсэхгүй бол оршуулгын зардал ч мөн адил.

Чиний амгалан нойрыг үргээж зүрхлэлгүй аян замынхаа бэлтгэлийг хангалттай хийхээр үүр цүүрээр бид явлаа. Хүндэт Түлхүүр-Чимхүүр Бильбог усны ойролцоох Ногоон Луу хоолны газар яг арван нэгэн цагт хүлээх болно. Чи тогтсон газар товлосон цагтаа ирэх биз ээ. Чин сэтгэлээсээ хүндэтгэн ёсолсон Торин ба түүний хамсаатнууд “

- Чамд арван минут байна гүйх болж дээ гэж Гэндальф хэллээ.

- Үгүй ээ... гэж Бильбог ээрэхэд Гэндальф,

- Цаг алга, цаг алга гэлээ.

Нэг л мэдэхэд гадаа гудамжинд малгай ч үгүй, таяг ч үгүй хармаандаа ганц мөнгө ч үгүй, ер нь гадаа гарах болгондоо авч явдаг юм юмгүй гүйж явсныгаа Бильбо дараа нь өөрийнхөө амьдралын сүүлчийнхээ өдрийг хүртэл ойлгож чадаагүй билээ. Яагаад, ямар учраас хоёр дахь удаагаа тав тухтай цайлсан ч үгүй, гэр орноо цэвэрлэсэн ч үгүй, дээр нь бас бүх түлхүүрээ Гэндальфт атгуулчихаад гүйдэг билээ? Түүний сагсгар үстэй хөл нэг л мэдэхэд зам уруу гаргаж, дараа нь том гэгчийн тээрмийн хажуугаар, дараа нь гол хөндлөн, сүүлд нь түүнээс ч илүү газар гүйхээрээ авч явлаа.

Цаг яг арван нэг дэхээ цохихоос хормын өмнө тэр хоолны газрын хаалгаар амьсгаадан харайж орлоо. Бусад юмныхаа хамт хамгийн гол юм болох нусныхаа алчуурыг мартсанаа тэр үед мэджээ.

- Өө, зүйтэй гэж хоолны газрын үүдэнд хүлээж байсан Балин хашхирав.

Энэ үед тосгон уруу явдаг замын уулзвар дээр бусад нь зогсож байх нь харагдлаа. Шуудайлсан, ууталсан, боож багласан хөнжил гудас, сагс үүргэвчинд хийсэн юмаа дүүрэн ганзагалсан жижигхэн пони мориндоо тэд морьдоцгоож байлаа. Тэдний хажууд Бильбод яг таарсан бас нэг бяцхан пони бөнжигнөн зогсоно.

- За, бушуухан морд, замд гарцгаая гэж Торин хоббитод хэллээ.

- Ёстой уучлаарай, би малгайгүй тэгээд ч гэрээсээ мөнгөгүй, нусны алчуур ч үгүй гарчээ. Тодорхой хэлбэл би, та нарын бичгийг дөнгөж сая арав дөчин тавд л олж уншлаа шүү дээ.

- За, тэр яах вэ. Тодорхой цаг зэргийн цамаан үг хэрэггүй гэж Двалин түүний яриаг таслаад,

- Аян замд нусны алчуур мэтийн жижиг зүйл ч хэрэггүй шүү. Малгайн хувьд бол зоволтгүй. Надад илүү цув, малгайтай цамц байгаа гэлээ.

Ингэж энэ их аялал хаврын нэгэн сайхан өглөө эхэлсэн юм. Усны ойролцоох Ногоон Луу гэдэг хоолны газрын гаднаас хүнд ачаатай пони морьдын цуваа хөдөллөө. Двалины томдсон, гандаж хуучирсан хар ногоон цамцыг өмссөн Бильбо шууд хэлэхэд, инээдтэй харагдаж байлаа. Хүндэт эцэг Банго нь үүнийг харсан бол юу хэлэх байсан бол, бодохоос аймаар юм. Аз болоход хоббитууд сахалгүй нь сайн болжээ. Бильбог сахалтай одой гэж хэлэхгүй л дээ.

Тэднийг хөдлөөд удаагүй байтал ганган цагаан морьтой Гэндальф давхин ирэхдээ Бильбод

багц нусны алчуур, гаанс тамхийг нь авчирлаа.

Шидтэн Гэндалфтай ганзага нийлснээс хойш тэдний сэтгэл санаа сэргэж замын турш дуулж эсвэл элдэв сонин хачин үүх түүх ам хамхилгүй ярьж явлаа. Ам нь идэх юмаар дүүрэн байх юм уу амрахаар буудалласан үедээ л дуугүй байцгаана. Харамсалтай нь Бильбогийн бодсоноос тун цөөхөн буудаллана. Гэхдээ энэ хөгжилтэй, ямар ч аюул осолгүй аялал түүнд таалагдаж эхэллээ.

Эхлээд тэд сайн замтай, сайхан сайхан буудлуудтай, даруухан эрхэмсэг ард олонтой энх амгалан, тэнүүн цэлгэр, хоббитуудын нутгийг туулан гарлаа. Замд хааяа нэг ажил хэргээ гүйцэлдүүлж яваа хоббит юмуу одой яаран зөрнө. Дараа нь Бильбо амьдралдаа сонсоогүй дуу, үл ойлголцох хэл яриатай хачин танихгүй нутгаар явцгаалаа.

Явсаар явсаар, юун буудал байтугай дардан зам ч үгүй, оршин суугч ч үгүй үржилгүй газар хүрээд ирцгээв. Ой тайгаар бүрхэгдсэн нэг нь нэгнээсээ өндөр уулс өмнүүр харанхуйлна. Зарим уулын оройд эртний цайзын эвдэрч сүйрсэн балгас мэдэгдэх төдий харагдана. Бас дээр нь тэнгэр муухайрч эхэллээ. Саяхан л тун сайхан бараг үлгэрийн гэмээр таван сарын өдрүүд налайж байснаа одоо хүйтрээд тэнгэр уйлагнаад эхлэв. Энэ үржилгүй газар зүсрэн цутгах борооноос дайжин амарч буудаллах аятай газар эрж хайхад хүрнэ.

Цувааны сүүлд пони нь өвдгөө тулсан шавар шалбааг туучин яваа Бильбо, таван сар дуусах дөхөөд цэцгийн сар гарах гэж байхад ийм байна гэж хэн бодох вэ? Энэ үед чинь би халуухан цай оочлон дулаахан суудагсан. Гэтэл энд өглөөнөөс бороо цутгаж малгайн ирмэгээс нүд уруу нь ус дусалж цув нь нэвт норчихсон зүдэрсэн морь нь байсхийгээд л бүдрэхийг яана. Бүгд унтууцан дуугаа хураацгааж хоёр үг солих ч үгүй гэлдэрцгээнэ.

Ууттай хувцас, нойтон цүнхтэй идэх юм бантан болсон байх. Энэ мангар явдалд орооцолдоогүй бол өдийд тохитойхон гэртээ камин зуухны өмнө галын дэргэд цай сорсон шигээ сууж байхгүй юу.

Өөх, хөөрхий дараа нь нэг биш удаа жаргалтай амьдралаа санасан даа.

Одойнууд өмнө нь эргэж харах ч үгүй хоббитыг анхаарах ч үгүй гэлдэрцгээнэ. Зузаан саарал үүлэн цаанах нар жаргасан байлгүй дээ. Тэднийг голын хөндийд бууж ирэхэд бараг харанхуй боллоо. Салхи дэгдэж эргийн дагуух модод ганхан өрөвдөлтэйгөөр шүнгэнэн дуугарна. Уулнаас буух оволзсон шар ус болон борооноос болж гол үерлэжээ. Аз болоход хуучны чулуун гүүр бүтнээрээ байлаа.

Тэднийг гүүрээр голын цаана гарахад хав харанхуй боллоо. Хүчтэй салхинд үүл тасрах мэт хөөгдөн туугдахад, нисэж байгаа саарал үүлсийн завсраар цайвар сар үзэгдэнэ. Морьтонгууд амрахаар зогсоход хоол унд, унтах хуурай газрын талаар Торин нэг юм үглээд л байв.

Гэндалф алга болсныг тэд сая л мэдэцгээв. Саяхан болтол тэрээр тэдэнтэй хамт яваад л байсан хэдий ч ер нь энэ аялалд, гол хэрэгт оролцох эсэх нь мэдэгдэхгүй хоцорсон байв. Эсвэл зүгээр эхний үед зам нийлэн явж байсан юм уу? Гэндалф бусдаас их идэж бусдаас чанга инээж, ярьж хөөрч байснаа гэнэтхэн ууссан мэт алга болжээ.

-Хэн тэгээд одоо идэх юм илбэдэн гаргаж өгөх юм бэ? гэж хоббиттой адилаар ойр ойрхон их идэх ёстой гэж үздэг Дори, Нори хоёр гонгинов.

Тэд тэр буудалласан газраа хоноглохоор даруйхан шийдэв. Модны доор хуурай газар олжээ. Жаахан салхи сэвэлзэхэд л навчнаас том том дуслууд бороо мэт асарна. Ингэж зогсоо чөлөөгүй под под дуслах нь уйтгартай. Дээр нь бас гал нь асаж өгөхгүй зовоолоо. Одойнууд уг нь галыг хаана ч, хэзээ ч, юугаар ч асаадаг билээ. Харин энэ шөнө түүдэг үлээдгээрээ хэнийг ч урдаа гаргадаггүй Ойн, Глойн хоёр ч асааж дийлсэнгүй. Дараа нь нэг пони юунаас ч юм үргэж гол тйиш давхиж оров. Фили, Кили хоёр өөрсдөө живэх шахан байж хөөрхий понийг уснаас гаргаж харин ачааг нь аварч чадсангүй. Ганзагануудыг нь хурдан урсгал аван одов. Аймаар хохирол. Тэр ганзаганд идэх уух юм байсан аж. Одоо орой идэх жаахан юм үлдсэн, өглөө хүрэлцэхтэй үгүйтэй. Тэд чөмгөндөө хүртэл норчихоод одоо болтол гал асаах гэж зууралдах Ойн, Глойн хоёрыг загнан баргар царайлан суув. Адал явдал гэдэг бол хаврын налгар наран доор пони унан галгиулж явахыг хэлдэггүй юм байна гэж Бильбо гуниглан бодож, гансрахын дээдээр гансран сууж байтал харуулд зогсож байсан Балин гэнэт,

- Гал. Тэнд гал гэж хашхирлаа. Үнэхээр ойролцоох толгодын орой дээр өтгөн шугуйг нэвтлэн түүдэг юм уу бамбарын улаан шаргал толбо дуудах мэт харагдана.

Аянчид хэдэн хором тэр галыг харан яахаа мэдэхгүй зогсоцгоов. Дараа нь улайран маргалдаж эхлэв. Зарим нь зөв, зөв гэнэ, зарим нь үгүй, буруу гэнэ. Түүдгийн дэргэд дулаацаж халуун хоол ундтай залгах нь юу нь буруу байгаа юм бэ? гэж нэг хэсэг нь хэлж байхад зарим нь,

- Бид энэ газрыг мэдэхгүй. Уул ч ойрхон байна. Бидэн шиг энгийн хоргүй аянчид ийшээ ирэх нь ховор. Хуучин газрын зурагт итгэж болохгүй, одоо цаг өөр шүү. Зам харгуй хамгаалалтгүй, дэг журам гэж байхгүй. Хэрэггүй юманд хошуу дүрвэл хэрэггүй л юманд орооцолдоно шүү гэнэ.

- Бид ямар ч гэсэн арван дөрвүүлээ.

- Гэндальфгүйгээр бид юу юм. Ингэж маргалдаж байснаа ер нь Гэндальф хаачсан талаар зөрөлдөж эхлэв. Гэтэл Глойн, Ойн хоёр нударга зөрүүлж энэ нь тэднийг эвлэрүүллээ.

-За, за бидэнтэй хамт Түлхүүр-Чимхүүр байгаа юм чинь гээд тэд удаан эргэлзсэнгүй,тэр шарлан байгаа үл таних галын зүг явцгаав. Пони морьдоо хөтлөн аяархан гишгэлсээр тэд удалгүй толгодод дөхөж ой уруу орлоо. Явж болмоор замтай төстэй ч юм алга байлаа. Бэх шиг харанхуй толгодын эгц өөд өгсөж яваад тэд чимээ гаргачихав. Хуурай мөчир хугарах хөлийн аясаар чулуу хайрга түн тан хийн доош унах, дээр нь бас аахилж, уухилах нэмэрлэн орчныг доргиох шиг боллоо. Гэнэт гэрэл нүд гялбуулан туслаа.

- Одоо чи яв! гэж одойнууд Бильбог урагш түлхэв.

-Энэ юун гэрэл вэ? Аюул осол байна уу, үгүй юу? мэдээд ир гэж Торин даалгалаа. Хэрвээ байдал бишдвэл хурдхан эргээрэй. Буцаж чадахгүй болбол бидэнд мэдэгд. Шар шувуу шиг хоёр удаа, ууль шиг нэг удаа дуугараарай. Бид нэг арга бодно.

Хөөрхий Бильбо аюулын өөдөөс дуулгавартай алхлаа. Тэр шар шувуу шиг нэг ч удаа дуугарч тэр ч байтугай ууль шиг дуугарч бүр ч чадахгүй. Харин ой тайгаар хоббитууд шиг чимээ аниргүй явдаг амьтан байхгүй. Хоббитууд үүгээрээ ихэд бахархдаг билээ. (Та бидэн шиг хүмүүс одойнуудын арми жагсаж явсан ч сонсохгүй л байсан даа.) Гэхдээ бид бол бид, одойнууд бол одойнууд. Бильбогийн аниргүй алхаа ямар ч соргог амьтныг үргээхгүй байсан даа. Хоббит галын зүг ойрхон гэгч гэтэж очоод мэлэрч орхив.

Бүтэн, бүтэн гуалин давхарлан тавьж асаасан том түүдгийг тойрон гурван аварга биетэн сууж байлаа. Галын дээр хонины тууш мах эргэлдэн шарагдана. Аваргууд шүлсээ залгин тостой хуруунуудаа долооно. Толгой эргэм сайхан үнэртэнэ. Түүдгийн дэргэд боошигтой ямар нэг амттай ундаа байх агаад аваргууд тэндээс аяга аягаар ууна.

Энэ чинь Троллууд байна. Хэдийгээр Бильбо өөрийнхөө тохилог гэрээс ийм хол явж байгаагүй ч энэ зэвүүн амьтдын хаднаас цавччихсан мэт том хөл, өгөр царай, гол нь хоббитын чихэнд дэндүү хатуу сонсогдох хэл ярианаас нь Троллууд байна гэж шууд танилаа.

-Өчигдөр хонины мах, өнөөдөр хонины мах. Хэрвээ маргааш дахиад энэ хонины мах нүдэнд харагдах юм бол би газар цөмөрч орно гэж нэг Тролл үглэж байлаа.

-Яг үнэн. Би хүний махны амтыг бараг мартчихсан. Энэ усан толгой Вильям биднийг нааш нь авчрахдаа юугаа бодсон юм бүү мэд. Уух юм ч дуусаж байна гэж хоёр дахь нь өлгөн авч шазалзсанаа аягатайгаа ам уруугаа ойртуулж байсан Вильямыг тохойгоороо ёвроод авав.

Вильям хахаж цацав.

- Дуугаа тат гэж хашхираад,

-Чинийхээр бол хүний мах Берттэй цуг өөрөө хүрээд ирэх үү? За, сайн уу? Намайг идэцгээ, зулгаацгаа гээд л хүрээд ирэх үү? Бид уулнаас бууснаас хойш чи тосгоны бараг хагасыг залгисан биз дээ. Ханаж цаддаггүй хэнхэг минь. Хонины хэсэг мах олдвол баярлалаа. Билл минь баярлалаа гэдэг цаг ирээд байна шүү. Тэрээр хониныхоо гуянаас нэг том хазаад ханцуйгаараа уруулаа арчив.

-Аа яа яа, энэ Троллууд чинь хонь биш байна. Бильбо ийм яриа сонсоод яарахгүй бол болохгүй гэдгийг ойлголоо. Нөхдөдөө хэлэхийн тулд хурдхан эргэх хэрэгтэй байлаа. Одойнууд болон пони морьдоор нь шорлог хийхээс буцахгүй энэ гурван хорлонт Троллын тухай нөхөд нь мэдээгүй байгаа. Эсвэл жаахан азнаж, аятай мөч гарвал энэ Троллуудын хармааг ухдаг юм билүү? Намайг зүгээр нэг Түлхүүр-Чимхүүр гээгүй биз дээ. Аах түүний оронд байсан болов уу? Хонины махыг нь шорлуур дээрээс нь торхтой ундаагийг нь өнхрүүлээд аваад явчих байсан даа.

Тэгээд Троллуудыг бүгдийг нь нам цохичихоод шөнөжин найрлахгүй юу. Жинхэнэ эрэлхэг зоригтонгуудын тухай Бильбо сонссон байжээ. Бас ч уншсан.

Бильбо хэдийгээр үзээгүй, хийгээгүй боловч олон зүйлийг мэддэг байлаа. Олон бодол дотор нь оволзож сэтгэл нь хачин эвгүйрхээд орхив. Эндээс холоо гүйгээд ч явчихмаар санагдав.

Гэхдээ л Торин болон нөгөөдүүл дээрээ гар хоосон буцаж чадсангүй. Тэрээр модны сүүдэрт нуугдан санаа сэтгэл нь хэдэн арван тийшээ бутрах мэт чичрэн зогсож байлаа. Эвлэг гартай эрэлхэгчүүдийн хийдгээс хамгийн амархан нь Троллуудын хармааг ухах байлаа.

Бильбо мод уруу мөлхсөөр Вильямын нурууны яг ард нь очлоо.

Берт, Том хоёр нь дахиад торх авчрахаар явлаа. Вильям байдгаараа тонгойн аяганыхаа ёроолыг шавхан ууж байлаа. Бильбо, Троллын халаасанд гараа шургуулж өөрийнх нь цүнх шиг том түрүүвчийг атгаад авав.

Аах аан гэж Бильбо өөрийнхөө хөнгөн дадмаг болоод шинэ ажлын амархныг гайхасхийн зогтустал гэнэт хачин юм болох нь тэр. Хоббит Троллын түрүүвч нууцтай гэдгийг сэжиглэсэн ч үгүй билээ.

-Хөөе чи хэн бэ? гэж хармаанаас гарсан түрүүвч орилох нь тэр. Вильям хормын дотор эргэн Бильбог хөдөлж ч амжаагүй байхад шилэн хүзүүн дээрээс нь шүүрээд авлаа.

- Ээ чөтгөр гэж. Хөөш Берт , чи хараач би юу бариад авав аа гэж Вильям хашхирав.

- Юу вэ? гэж нөгөө Тролл нь ойртож ирээд гайхан харлаа.

- Би яаж мэдэх вэ. Хөөш, чи юу вэ?

- Бильбо Бэггинс. Түлхүүр-Чимхүүр гэдэг хоббит гэж хөөрхий чичрэн дагжин хэлэхдээ алагдахаасаа өмнө шар шувуу яаж дуугардаг билээ гэж бодож ядан байв.

- Иш чааваас, мистер хоббит гэж. Аварга Троллууд түүнийг ойлгож ядан ширтэнэ. Троллууд ер нь муухан сэтгэдэг бөгөөд тиймээс ч шинэ юм сэддэггүй бөлгөө.

- Энэ мистер хоббитод миний хармаанаас юу хэрэгтэй юм болоо? гэж Вильям духаа үрчийлгэв.

- Энэ ер нь ямар амттай болоо? гэж Том уруулаа долоов.

- За, энэ ч дээ арьс яс. Ганц үмх мах байгаа юм уу, үгүй юу? гэж хонины шорлогонд цадсан Вильям хямсганав.

- Иймэрхүү амьтад үүгээр дүүрэн байдаг байхаа! Том боовны шанз болчихоор олон байгаа ч юм билүү? Хөөш, чам шиг сэгсгэрүүд энэ ойд олон байна уу? Хэлээтэх. Тролл хоббитын үСТЭЙ хөлнөөс нь агаарт өргөн ийнхүү ориллоо.

- Тоо тоймшгүй. Бильбо ингэж чарласнаа нөхдөө илчилж болохгүйг ойлгомгоцгоо,

- Би нэгийг ч хараагүй гэлээ.

- За тэгээд тоотой юм уу, тоогүй юм уу? Би нэг л ойлгохгүй байна шүү. Берт Бильбог эргүүлж үснээс нь шүүрч аваад ийнхүү асуув.

-Би хэлээд байна шүү дээ. Эрхэм ноёд оо. Надаар юу ч битгий хийгээч дээ. Би та нарт надаар бэлдсэнээс илүүтэй сайхан хоол хийхэд бэлэн байна. Өнөөдөр надаар оройн хоол хийхгүй бол маргааш та нарт маягтай сайхан өглөөний хоол хийж өгье. Цүндийтлээ цадсан Вильям,

-Ээх муу яс арьс. Берт хая хая гэлээ.

-Аа, үгүй шүү, эхлээд эд нар тоотой юм уу, тоогүй юм уу гэдгийг хэлэг. Энэ тоо тоймшгүй амьтад унтаж байхад минь хоолойгий минь огтолчихвол яах билээ. Үүнийг би хүсэхгүй байна шүү. Сэгсгэр хөлийг нь гал дээр шараад өгөхөөр энэ муу ярихгүй яах вэ дээ.

-Өө, шал дэмий. Ер нь би барьсан юм чинь би яахыгаа мэднэ гэж Вильям толгой сэгсрэв.

-Чи муу, тэнтгэр тэнэг. Би чамд өнөө оройжингоо хэлж байна шүү дээ, дахиад хэлэхэд чиг бэлэн байна гэж Берт язалзав.

-Аах, чи мал юу гэнэ ээ? Май чи! гээд Берт Вильямын нүд өөд нударгалаад авлаа. Тэгснээ тэр хоёр барилцаж аван зодолдож эхлэв. Хоббитыг мартагнахад Бильбо зодолдож байгаа хоёрын хөл доогуур шурган хурдхан шиг холдов. Троллууд нохой мэт архиралдан харааж зүхэн гал тойрон өнхрөн бие биеэ өшиглөн нүдэлдэж гарлаа. Зодолдож байгаа хоёрыг салгах аядан Том бүдүүн модоор хоёуланг нь цохиж гарсан нь тэр хоёрын уур уцаарыг бүр ч нэмлээ.

Яг л зугтаадаг цаг боллоо. Гэвч Тролл аварга гараараа Бильбог базаад хаясан болохоор Бильбо гар хөлөө хөдөлгөж ч чадахгүй дөнгөж амьсгаатай юм хэвтэж байлаа. Зодоон, нүдээн өрнөж байх энэ үед гэнэт харанхуйгаас Балин гараад ирлээ. Зодооны их чимээг сонсоод одойнууд Бильбог одоохон эргээд ирнэ эсвэл шар шувуу шиг дуугарна гэж хүлээн хөшин зогсож байжээ. Гэтэл Бильбо ч байдаггүй шар шувуу шиг ч дуугарсангүй. Одойнууд гэрлийн зүг ихэд болгоомжтойгоор цувран гэтжээ. Гэтэл Балинг галын гэрэлд үзэгдмэгц аварга Том аймаар муухай орилжээ. Троллууд амьд одойнуудыг үзэж чаддаггүй бөгөөд тэд зөвхөн шарсан одой л иддэг юм чинь. Берт, Билл хоёр хормын дотор зодолдохоо зогсон хоёулаа зэрэг зэрэг,

- Хөөе Том! шуудай гэж хашхирлаа. Балин аан гэж дуугарч ч чадсангүй шуудайлагдлаа.

- Энэ анхных нь одоохон бусад нь гараад ирнэ дээ, би яг мэдэж байна. Тоо тоймшгүй гэдгийн учрыг одоо л би ойлголоо. Мистер хоббит тоотой, одойнууд тоогүй их юм байна.

- Чи ч бас тийм ч их тэнэг биш юм байна, алив галаас холхон нуугдчихъя гэж Берт зөвшөөрөв.

Троллууд хонь хийж байсан элдэв дээдийн дээрэмдсэн юмтай шуудайгаа бэлэн бариад модны доор харанхуйд нуугдан хүлээв. Ээлжит одой гал уруу дөхөж ирээд хонины яс, өвсөн дээр хэвтээ аяга савыг гайхан хармагц тап гээд л шуудайндаа хийгээд байлаа. Удалгүй галын дэргэд оволзож хөдөлсөн хэдэн шуудай овоорон бий боллоо. Двалин, Балин дээр, Фили, Кили зэрэгцэн, Дори, Нори, Ори гурав дээр дээрээсээ давхарладан хэвтэж байлаа. Ойн, Глойн, Бифур бас Бомбур хамаа намбаагүй чихэгджээ.

Эд ингэж байвал таарна гэж Том уурлан гүвтгэнэ. Эцэстээ тултал хазаж, урж, маажиж байсан Бифур, Бомбур хоёроос тэрээр нэлээд хүнд цохилт хүртсэн билээ. Одойнууд бүгдээрээ л

аюулын үед солиотой юм шиг зодолдсон билээ.

Торин галын дэргэд хамгийн сүүлд дөхөж ирсэн бөгөөд Троллууд түүнийг гэнэдүүлж чадсангүй. Торин орилоон хашхираанаас болгоомж, сэрэмж авсан байлаа. Энд иймэрхүү эвгүй явдал болж байгааг ойлгохын тулд овоолттой шуудайнаас өрөвдөлтэйгөөр цухуйж байгаа нөхдийнхөө хөлийг харах хэрэг Торинд байсан ч үгүй, тэртэй тэргүй ойлгомжтой байлаа. Тэрээр модны ард нуугдаад,

- Юу болоод байна аа? Хэн манайхныг цохичихов?

- Троллууд гэж Бильбо хажуудах модны араас шивнэлээ.

-Урагшаа. Торин өөртөө ингэж хамаанд өгөөд галын зүг ухасхийхэд Троллууд аан гэж дуугарч амжсангүй. Торин галтай мөчир шүүрэн авч Бертийн нүд өөд шаалаа. Нүд нь сохорсон Тролл өнхрөн хөрвөөж орилно. Бильбо одойд туслахаар ухасхийн Томын хөлнөөс барьж авах гэж оролдов. Бильбод Томын хөлийг барих гэдэг зуун настай царс модыг тэврэх гэж оролдохтой адил зүйл байлаа. Тролл хөлөө тийрэн сэгсрэхэд хоббит шидэгдэн бутанд шигдэхэд Торины нүүр өөд Троллын хөлөөр үсэрсэн халуун галын цогнууд цацагдлаа. Торин мөчөөгөө өгсөнгүй. Томыг бүдүүн модоор шүдэн дундуур нь цохив. Нэг шүд нь шажигнаад явчихад Тролл өвдсөндөө орилж гарлаа. Яг энэ үед Вильям Торины араас гэтэж байгаад шуудайгаа нөмөргөөд авлаа. Ингэж энэ хүч тэнцүү биш тулалдаан дууслаа.

Одойнууд бүгдээрээ амыг нь боосон шуудайн дотор овооролдон хажууд нь нүд ам нь хөхөрч түлэгдсэн гурван хилэнт Тролл сууж байлаа. Тэр гурав одойнуудаар яаж сайхан амттай оройн хоол хийх тухай халуухан шиг маргаж байлаа. Нэг нь болохоор бүхлээр нь шорлогдон шарж идье гэхэд нөгөөх нь мөчилж салгаад шөл чаная гэнэ. Гурав дахь нь шуудайн дээр дарж суугаад одойнуудыг хэмхэлж няцлаад түүхийгээр нь сорцгооё гэлээ. Бильбо хувцас хунар нь урагдчихсан модны өргөсөнд цусаа гартал шалбарчихсан амьтай голтой юм бутан дунд хөдлөхөөсөө ч айн хэвтэж байлаа.

Яг энэ үед Гэндальф иржээ. Харин түүнийг хэн ч харсангүй. Троллууд маргалдаж маргалдаж ядраад эцэст нь одойнуудыг шарж идье гэдэг Бертийн саналыг зөвшөөрцгөөв.

- За даа, өглөө болтол зууралдаад идэж ч амжихгүй л дээ гэх дуу хаанаас ч юм гарав. Үл үзэгдэх Гэндальф ингэж хэлсэн нь Бертэд, Вильям хэлэх шиг санагдав.

- Чи дахиад үглээд унав уу? Юу гэж өглөө болтол зууралддаг юм. Гэтэл Бертийг үглэж байна гэж бодсон Вильям уурлан,

- Хэн ундууцсан юм? Харин чи л.

- Чи л гонгиноод байна шүү дээ.

- Худалч минь би гонгиноогүй. Вильям дахиад л хилэгнэж эхлэв. Эцэст нь одойнуудыг мөчилж, шөл чанахаар шийдэцгээлээ. Том том тогоо, хурц хутганууд бэлдлээ.

- Чанана гэдэг тэнэг хэрэг. Ус байхгүй, худаг хүртэл хичнээн хол. Дахиад л ийнхүү дуу гарав. Берт, Вильям хоёрт үүнийг Том хэлэх шиг санагдав.
- Дуугаа тат. Хушуу дүрээд байх юм бол өөрөө усанд яваарай. Тэр хоёр түүн өөд ийнхүү дайрахад Вильям гонгинолоо гэж бодсон Том,
- Өөрөө дуугаа тат. Мангар гэлээ.
- Хэн, мангар гэнэ ээ? Вильям хашхирлаа.
- Чи гэж Том язалзав. Маргаан дахин дэгдлээ. Троллууд бие биенээ тас татах шахлаа. Тэгээд сүүлд нь тайвширцгааж одойнуудыг шуудай дээр нь сууж дэвсээд, сайн гэгч нь үйрүүлж идэхээр болов.
- Хэн эхэлж, аль шуудайнаас эхэлж идэх вэ? Дахиад л нөгөөх дуу гарав.
- Би эхэлье. Тэр сүүлчийнхийг няц дарна. Торинд нүдээ түлүүлсэн Берт ингэж хэллээ. Берт Томд хариулж байна гэж боджээ.
- Юу гээд өөрөө өөртэйгөө маргаад байгаа юм бэ? Эхнийх дээр хамгийн сүүлд сууна уу, сүүлчийнхийг хамгийн түрүүнд бяц дарна уу, чиний хэрэг шүү дээ. Тэгээд тэр эхнийх чинь аль нь вэ? Том ийнхүү уурлахад Берт,
- Тэр чинь шар оймстой байсан гэлээ.
- Шал худлаа. Тэр чинь саарал оймстой байсан гэх дуу хоолой Вильямын дуугаар хэлэв.
- Шар, шар. Би яг санаж байна. Берт ийнхүү маргав.
- Хэн маргасан юм. Тийм шар оймстой байсан гэж Вильям дэмжлээ.
- Чи л саарал гээд байна шүү дээ гэж Берт түүнийг шоолоход Вильям,
- Би тэгж хэлээгүй шүү дээ. Том л хэлсэн гэлээ.
- Би юу? Өөрөө бүгдийг нь андуураад байх юм. Том уурлалаа.
- Тийм. Том ч баталж байна. Одоо маргахаа боль, дуугаа тат. Берт ийнхүү Вильям уруу дайрлаа.
- Чи над уруу юу гээд байгаа юм? гээд Вильям нударгаа зангидав.
- Чимээгүй болцгоо. Яарахгүй бол болохгүй. Шөнө өнгөрч удахгүй үүр цайх нь.
- Үүрийн гэгээ хайрлахгүй үхмэл чулуу болгоно. Үл мэдэгдэх дуу хоолой Вильямын дуугаар ийнхүү хэллээ.

Жинхэнэ Вильям юу ч хэлж амжаагүй байтал тэрхэн толгодын дээгүүр үүр манхайн цайлаа. Шувууд шулганан жиргэлдэв. Вильям яг зогссон хэвээрээ чулуу боллоо. Берт, Том хоёр бас л хөдөлгөөнгүй бул хар чулуу болон хувирав. Тэд өнөөдөр болтол тэндээ зогссоор байгаа ба энэ болхи хийцийн ганцаардмал чулуун хийц дээр хааяа нэгхэн шувуу суух авай. Троллууд өглөөнөөс урьтаж газар доор нуугдахгүй бол хад чулуу болон хувирдаг гэдгийг бид мэдэх билээ. Берт, Том, Вильям гурав ингэж хад чулуу болсон билээ.

- Ёстой гоё доо. Гэндальф гэрэлд гарч Бильбод өргөснөөс гарахад нь туслах зуураа ингэж уулга алдлаа. Энэ үед л Бильбо Гэндальфийн дуу хоолой Троллуудыг үүр цайтал маргаж мэтгэлцүүлэн тэднийг хад чулуу болгон хувиргасныг ойлголоо.



Одоо зөвхөн шуудайнуудын амыг тайлан одойнуудыг чөлөөлөх л үлдээд байлаа. Хөөрхий одойнууд бөглөрч үхэхээ шахсан агаад уур уцаар нь буцалж байлаа. Шуудайнд чихэгдчихээд чамайг шарах эсвэл чанах, эсвэл бүр няц дарахаар хэлэлцэхийг сонсох хэнд таатай байх билээ дээ? Троллуудын уур уцаарыг яаж дэгдээсэн, тэднийг яагаад зодолдуулсныг Бильбогоос одойнууд дахин дахин асууж яриулж байлаа.

-Бидэнд галын дэргэд дулаацаж жаал зуул юм идэх л хэрэгтэй байтал чи яах гэж хармаа ухдаг билээ? Бомбур хоббитыг ингэж загнав.

-Зодоон нүдээнгүйгээр жаал зуул юм олдохгүй байсан байхаа. За, одоо цаг үрээд яах вэ? Троллуудад нарнаас нуугдан орогнодог ямар нэг агуй, гүнзгий хавцал ангал энэ хавьд байгаа байхаа. Тийшээ орж үзэх юмсан гэж Гэндальф хэллээ.

Тэд эрсээр яваад удалгүй моддын дундуур асар том чулуун гутлын мөр оллоо. Мөр тэднийг гүвээ дээгүүр дээш хөтлөн ургасан бутанд нуугдмал нэгэн том чулуун хаалганд авчирлаа. Тэд хаалгыг татаж чангааж бүгдээрээ нэгэн зэрэг дарж түлхсэн боловч хаалга онгойсонгүй. Тэр ч байтугай Гэндальфийн шидэт үг хэллэг ч тус болсонгүй. Бүгд хүч тамираа барсны дараа Бильбо,

- Энүүгээр оролдоод үзэх үү? Зодолдож байх үед би газраас олсон юм гээд Вильямд бол жижигхэн санагдаж байсан байх гэмээр томоо гэгчийн түлхүүр гаргаж ирлээ. Троллууд чулуужихийнхаа өмнө газарт унагаасан бололтой.

- Чи яагаад түрүүн хэлээгүй юм бэ? гэж одойнууд хашхиралдав.

Гэндалф түлхүүрийг шүүрэн авч хаалганы нүхэнд шургууллаа. Хүнд чулуун хаалга нэг түлхэхэд л амархан онгойчихов. Зэвүүн муухай үнэр хамар цоргив. Тэд агуйд ороод шалан дээгүүр хаялсан яс, тавиур дээгүүр эмх замбараагүй овоолсон янз бүрийн зэвсэгнүүд байхыг харлаа. Нэгэн буланд хог новшин дотор хулгайлж олсон элдэв дээдийн зүйлс харагдана. Төмөр товчнууд, алтан мөнгөн тэмдэгтээр дүүрэн ваар сав, хана даган өнгө өнгийн хувцас хадаасанд өлгөөстэй байлаа. Энэ өмд цамцнууд мэдээжээр Троллуудад багадах бөгөөд тэгэхээр тэдний хөөрхий болсон дээрэмдүүлэгчдийнх бололтой. Мөнхүү өөр өөр уран дархчуул урласан бололтой урт богино, өргөн нарийн хутга сэлэмнүүд өлгөөтэй байлаа. Иш болон хуйн дээрээ баялаг гоёмсог эрдэнийн чулуун чимэглэлтэй хоёр сэлэм онцгой сайхан харагдана. Энэ сэлэмнүүдийг Гэндалф, Торин хоёр авлаа. Бильбод ширэн хуйтай кинжал хутга таалагдав. Троллуудад энэ хутга жижигхэн, хармааны хутга байсан биз ээ. Шидэт Гэндалф сэлмээ хуйнаас нь талд нь гартал суга татан их л сэтгэл хангалуунаар,

- Онцгой сайн эд байна. Үүнийг Троллууд дархлаагүй, эндхийн дархчуул ч биш, манай үед ч хийгээгүй эд байна. Алив, дээр нь бичсэн тангарагийг уншаад мэдээдхээ гэлээ.

- Эндээс гарцгаая. Амьсгалах аргагүй байна гэж Фили үрчилзэв. Тэд мөнгөтэй ваарууд, тэдэнд санагдсан хэтэрхий муудаагүй жаал идэх юм, боошиг шар айраг аваад гадагшаа гарахаар яарцгаав, Эрүүл агаарт тэд өлссөнөө хурц мэдэрч Троллуудын идэх юмыг дайран идэцгээв. Аваргуудын агуулахад хураасан хоол бага байлаа. Тэд одоо талх, бяслаг, ам нь цангасан үед уух шар айраг, түүгээр ч барахгүй нүүрсэн дээр шараад идэхэд бэлэн томоо гэгчийн давсалсан гахайн махтай боллоо.

Түйвээнтэй шөнийн дараа тэд үд болтол үхсэн мэт унтацгаав. Дараа нь голоос холгүйхэн тэмдэгтэй газарт алт, мөнгөнүүдтэй вааруудаа булаад, пони морьдоо олж аваад, Дорно зүгийг чиглэн зам даган одоцгоов.

- Чи түрүүн хаачсан бэ? Мэдэж болох уу? Торин шидэт Гэндалфаас ийнхүү асуухад цаадах нь,

- Нөгөө талд гарсан. Юу байгааг тагнах гэсэн юм гэж их нууцлаг хариулав.

- Чи эргэж ирэхгүй бол болохгүй гэдгийг яаж мэдсэн юм бэ?

- Наашаа эргээд харсан юм.

- Аан ха, тодорхойхон шиг тайлбарлаж болохгүй юу?

- Би замаа тагнахаар явсан юм. Бидний зам амар биш ээ. Аюул осол амдаж байж ч мэднэ. Идэх юмны нөөц тун бага болохоор нэмэх арга хайсан юм. Азаар Ривендейлийн хуучин

нөхөдтэйгөө дайралдлаа шүү.

- Хаана? гэж Бильбог яаран асуухад Гэндалф,

- Битгий яриа таслаад бай, гэж зандраад,

- Хэрвээ аз таарвал хэдэн өдрийн дараа тэнд очно. Тэр үед мэдэж аваарай. Би юу гэл ээ? Аа, тийм. Элрондын хоёр найзтайгаа таардаг байна шүү. Тэд Троллуудаас болгоомжлон энэ нутгаас зугтаж явсан. Тэд нараас би ууланд гурван Тролл буугаад ойн замын хажууд орогноод орчин тойрныхныг айлган гэнэгүй зорчигчдыг отож байгаа гэж дуулсан юм.

Би ч та нар уруугаа буцахгүй бол болохгүй гэдгийг ойлгосон. Бусдыг нь та нар мэдэж байгаа шүү дээ. Орчин тойрныг нэгжин хартал алсад утаа үзэгдсэн тэгээд яарлаа л даа. Дараа дараачийн удаа тун болгоомжтой байцгаагаарай даа. Тэгэхгүй бол бид хэзээ ч, хаашаа ч хүрэхгүй шүү.

- Энэ бүхэнд чинь машид гялайлаа гэж Торин эрхэмсэгээр хэллээ.

Гуравдугаар бүлэг

Багахан амралт

Энэ өдөр ч, дараагийн өдөр ч, тэд дуулсангүй, хөгжилтэй үүх түүх ярьж чалчицгаасан ч үгүй. Гурав дахь өдрөө бас л чимээгүй явцгаалаа. Агаар тэнгэр сайжран цэлмэсэн ч тэдэнд толгой дээр нь хар үүл бөөгнөрөн хурж байгаа мэт санагдсаар байлаа. Тэд задгай газар унтацгааж явлаа. Троллын агуйгаас олсон идэх юм даруйхан дууслаа, харин шүүслэг өвс зулгаасан пони морьд цатгалан сэргэлэн байв. Дөрөв дэх өдрийн өглөө тэдний замд чулуун дээгүүр хөөсрөн шуугин урсах гол тааралдлаа. Тэд гүехэн газраар голыг гаталж, эгц гулгамхай эрэг өөд нь морьдоо хөтлөн арайхийн мацаж гарлаа. Өмнө нь өндөр уулс дүнхийж байлаа. Өндөр уулсын орой тэнгэр шүргэм харагдах агаад уулсын хормойд хүрэхэд, ганцхан өдөр алхаад хүрчихмээр санагдана. Уулсын саарал гүвээ дээгүүр нарны гэрэл гулгаж байвч бүрзгэр харанхуй харагдах агаад шингэрч байгаа манан дээгүүр хурц оргилууд нь гялалзан цайран харагдана.

- Энэ, нөгөө Уул чинь үү? гэж Бильбо гайхан алмайрав. Тэр урьд өмнө нь ийм том уул үзээгүй ажээ.

- Биш ээ, биш. Манант уулын эхний тасалбар байхгүй юу. Бид энэ уулыг давах юмуу хэрвээ арга нь олдвол сүвлээд гарах хэрэгтэй. Тэндээс л ёстой зэрлэг хязгаар эхэлнэ дээ. Тэндээсээ тэгээд их явна аа. Явсаар явсаар Дорно зүгийг барин алхсаар Тортог луу бидний эрдэнэсийг хадгалж байгаа Ганцаардмал ууланд хүрнэ. Балинг ийнхүү ярихад Бильбо,

- Өөх хө, ийм учиртай байжээ гээд урьд өмнө нь хэзээ ч байгаагүйгээр их ядарснаа мэдэрлээ. Дахиад л түүнд голомтонд нь улалзан асах галын дэргэдэх тохилог буйдан, буцалж байгаа данхны шүнгэнэн дуугарах санагдаад явчихлаа. Хэзээ нэгэн цагт энэ гайхамшигтай, амарлингуй амьдрал эргэж ирэх болов уу? Одоо Гэндалф урд нь орон манлайлж явлаа.

-Сайн харж явцгаагаарай, замаа алдав аа. Эхлээд идэх юм олж аваад нэг аюулгүй чимээгүй газар сайн гэгч амарч авах хэрэгтэй байна. Хамгийн гол нь замаа л зөв барих ёстой. Тэгэхгүй бол Манант уул хүрч чадалгүй төөрчих амархан шүү.

-Тэр гол зөв зам чинь хаана байна? Энэ зам биднийг хааш нь аваачих юм? гэх мэтийн олон асуулт цуврав.

-Бид Зэрлэг хязгаарын хил дээр ирчихээд байгааг та нар ойлгож байгаа биз дээ? Энүүхэнд, урд талд Ривендейлийн гайхамшигт хөндий байгаа. Тэнд Тохилог Өрхөндөө Элронд амьдран сууж байгаа. Би найзуудаараа түүнд хэл мэдээ өгсөн, тэр биднийг хүлээж байгаа.

Энэ яриа тэднийг тайвшруулж тэдэнд таатай байсан хэдий ч Тохилог Өрхөнд хүрэх замаа олох хэрэгтэй байлаа. Гэхдээ ягааран байгаа манан дунд хэсэг бусаг хаг, өвс ногоотой цуу цуу үсэрсэн хад чулуу ер нь замын эцэст ус, амьдралтай золгоно гэдэг найдвар төрүүлж байлаа.

Үд дунд боллоо. Нөгөө л хуучин хэвээрээ тэднийг амь амьдрал ч үгүй цөвүүн цөл хүлээсээр байлаа. Тэд урагш шаргуухан тэмүүлсээр явтал уулын хормойн өгсүүр дээр орон гэр,

амьдралын үл мэдэгдэх төдий шинж тэмдэг мэдрэгдэж эхэллээ.

Гэтэл гэнэт тэдний өмнө цэцэглэн байгаа хөндий цэлийгээд ирэх нь тэр. Эрэг хавцалд нь бут модод ургасан хөндийгөө өгсөөд цул модтой хөөсрөн урсах түргэн голтой ажээ. Тэдний замд ганц үсрээд гарчихмаар санагдах харанхуй ангал тааралдах боловч тэр ангалууд зүйрлэшгүй гүнзгий агаад чулуун дундаас нь хүрхрээ шаагин урсана. Заримдаа ёроолгүй хавцал зам хаан ангайх агаад түүнийг тойрон явж урт зам туулж байлаа. Заримдаа цэцэг алагласан ногоон үзэсгэлэнтэй нуга гэмээр балчиг намаг тааралдна. Хэрвээ ачаа тэгнэсэн пони морьд тэрхүү хуурмаг нугад хөл тавих л юм бол ховдог соруул намаг шимээд авах байлаа.

Голын гүехнээр гараад уулын доод хормой хүрэхэд эхлээд санагдаж байсныг бодвол хэцүү урт зам тууллаа. Тэд үзэгдэх төдий ганцхан зөргөөр аажуухан урагшилж байв. Бут сөөг хагданд дарагдсан жижигхэн цагаан хайргаар үл мэдэг тэмдэг тавьжээ. Эндхийн газар нутгийг сайн мэддэг Гэндалф хүртэл энэ замыг арай ядан олж байлаа. Чулуунаас чулуунд хүрэх гэж морин дээрээсээ тонголзон сахал нь бараг газар шүргэнэ.

Хэдийгээр ийнхүү хичээнгүйлсэн боловч орой болоход зорьсон зорилгодоо ойртож ч чадаагүй байлаа. Сар гараагүй боловч үдийн цайны цаг аль хэдийнэ өнгөрч, тэд цай цүүгээ уугаагүй явлаа. Тэр ч бүү хэл Бильбогийн пони морь нь модны үндэс, чулуунд тээглэн бүдрэх нь олширч байлаа.

-Өө, хүрээд ирлээ гэж шидэт Гэндалф уулга алдав. Одойнууд шидэт Гэндалфийг тойрон зогсож эгц эргийн дээгүүр болгоомжтой харцгаав. Тэр доор өргөн хөндий цэлийнэ.

Тэндээс чулуун дээгүүр шаагин шуугих голын урсгал сонсогдоно. Цэцэглэж байгаа моддын ааглаг сайхан үнэр үнэртэнэ. Голын цаадтаа гэрэл гэгээ дуудах мэт анивчна.

Өтгөрөх харанхуйн дунд Ривендейл хөндийн эгц муригар замаар яажшуухан өнхөрч гулсаж явснаа Бильбо хэзээ ч мартаггүй ажээ. Доошлох тутам агаар таатай дулаахан болж шилмүүст модны ааглаг үнэр бүүвэйлэх мэт болно.

Хоббит хором тутамд мориноосоо унан алдан зүүрмэглэж, толгой нь тонголзож эсвэл мориныхоо дэлэнд шигдэн байлаа. Гэхдээ хөндий уруу буух алхам бүрд тэдний сэтгэл сэргэж байлаа. Нарсан ой, царсан болон навчит модот ойгоор солигдон, бүрэнхий намууханд таатайхан зүүрмэглэмээр санагдана. Тэднийг голын дэргэдэх толгод уруу тулж ирэхэд харанхуй, өвс ногоо цэцэгсээс сүүлчийнх нь өнгийг нөмрөн авлаа.

-Хм, эльфүүдэд таарсан газар байна даа гэж Бильбо бодлоо. Тэрээр толгойгоо өргөн тэнгэрт түгсэн оддыг ширтэв. Цэнхэрлэн гялалзах одод анивчин, анивчин цайрна. Гэнэт моддын цаанаас инээд алдах мэт дуу дуулах сонсогдов.

Өө, та нар юу хийцгээж байна?

Хаашаа яарцгааж байна?

Пони морьдын

Тах нь бэлэнгүй.

Энэ гол шар шур

Эргээ дагаад шаагина, ха ха.

Өө, та нар юу эрж байна?

Юу хийцгээж байна?

Түүдэг галын утаа үнэртэнэ

Тогоон дээр уур савсана

Хөхрөн инээлдэнэ

Хө хө, ха ха

Өө, сахлаа намируулан хаачих нь вэ?

Хаачих нь вэ?

Мистер Бэггинс

Мэдэгдэхгүй, харагдахгүй

Балин Двалин энэ зун

Байдгаараа алхана, ха,ха

Өө, та нар бүү яарцгаа

Тавтай амарцгаа

Бүдэрч эхэллээ, морьд чинь

Бүрэнхий ч боллоо, нөхөд минь

Хө хө үүр цайтал

Хөгжилдөн дуулья

Моддын гүнд нуугдсан энэ хөгжилтэй дууг зугаатай тоглоом гэж хэлж болох байлаа. Эльфүүд огтхон ч санаа зовсон шинжгүй бөгөөд тэдний дууг утгагүй дэмийрэл гэвэл зүгээр л нүүрэн дээр инээд алдах бизээ. Энэ дуучид мэдээж эльфүүд шүү дээ. Удалгүй Бильбо түнэр харанхуйд сүүдэр олж харлаа. Бильбод эльфүүд зайнаас таалагдаж байлаа. Харин нүүр тулж учрахаас нэлээд цэрэвхийнэ. Харин одойнууд эльфүүдтэй нийлдэггүй агаад Торин мэтийн ухаантай одойнууд тэднийг тэнэгүүд гэнэ. Энэ бол хамгийн тэнэг зүйл, үүнээс илүү

тэнэглэлийг зохиож ч болохгүй билээ. Одойнууд дооглохыг тэвчдэггүй бөгөөд харин эльфүүд тэднийг сахлаар нь дооглох дуртай ажээ.

- Ха ха. Хөгжилтэй дуу цангинав.

- Хараач, хараач Бильбо найз. Хоббит морь уначихсан явж байна. Гайхалтай. Тэд түрүүчийн таны сонссоноос илүү зугаатай шинэ дуу зохиож дууллаа. Сүүлд нь моддын дундаас өндөр залуухан эльф гарч ирээд Гэндалф, Торин хоёрт бөхийн мэндчилэв.

- Манай хөндийд тавтай морилогтун гэж хэллээ.

- Гялайлаа гэж Торин хурдхан гэвтнөв. Харин Гэндалф мориноосоо буучихсан эльфүүдээр хүрээлүүлэн тэдэнтэй хөгжилтэй нь аргагүй ярьж байлаа.

Хэрвээ та нар голын цаадах өрх уруу очиж яваа бол замаасаа жаахан хазгайрчээ гэж эльф хэллээ. Бид та нарыг гүүр хүртэл хүргэж өгье, харин цаашаага та нар явган явсан нь дээр дээ гэлээ. Харин одоо жаахан саатаж бидэнтэй дуулахгүй юу? Эсвэл яарч байна уу? Та нарт оройн хоол бэлдсэн байхаа. Галын утаа үнэртэж байна гэж залуухан эльф хэллээ.

Бильбо хэдий их ядарсан ч жаахан саатаж эльфүүдтэй ярилцаж тэдний дуулахыг сонсохоос татгалзмааргүй байлаа. Зургаан сарын одтой шөнөөр хангинах эльфүүдийн дуу, хэрвээ та нар жаахан юм ойлгодог бол сонсох, бодох л ёстой зүйлийн нэг дээ.

Хэдийгээр Бильбо тэднийг урьд өмнө нь үзэж хараагүй ч түүний нэрийг төдийгүй хэн гэдгийг нь мэдэж байгаа эдгээр эльфүүдтэй хэд гурван үг соливол сонирхолтой санагдлаа. Түүнийг уруу татан оролцуулсан энэ аялалын тухай жаахан юм мэдэж авах ч юм билүү. Энэ дэлхий дээр болж байгаа үйл явдлын ихэнхийг эльфүүд мэдэх агаад тэдэнд мэдээ гэдэг салхинаас хурдан ирдэг ажгуу.

Харин одойнууд хоол унд идэх гэж яарч байлаа. Одойнууд нэг ч хором сааталгүйгээр морьдоо хөтлөн цааш хөдөлж, удалгүй голын эрэгт тулж очлоо. Цасан оргилоос хайлан урсах шавартай ус нь шаагин шуугин, хөөсрөн урсаж байлаа. Голын хоёр эргийг холбон нарийхан чулуун гүүр тавьсан байв. Гүүр хэтэрхий нарийхан болохоор морьдоо хөтлөн нэг нэгээрээ цувран явахаас аргагүй боллоо. Эльфүүд гэрэл гарган замыг гэрэлтүүлж, хөгжилтэйхөн дуугаараа сэтгэл сэргээнэ. Тэд урт сахалт Торинд хандан,

- Ах аа! Сахлаа норгочихов оо! гээд инээлдэнэ. Торин энэ аюумшигтай гүүрэн дээгүүр арай л дөрвөн хөллөн мөлхсөнгүй гарсан билээ.

- Бильбо хамаг боовыг чинь идчихнэ шүү, сайн харж яваарай. Бүх боовыг идчихээд энэ бүдүүн гэдэст удахгүй хаалгаар багтахaa байна шүү гээд л эльфүүд хөхрөлдөнө. Хамгийн сүүлд явсан Гэндалф тэдэнд,

- Сайхан нойрсоорой, гайхалтай сайн нөхөд минь. Болгоомжтой байцгаа. Дуугаа намсга. Хөндий нуга ч гэсэн хөдлөх, сонсох чихтэй шүү гэлээ.

Тэд явсаар зочидоо угтан хаалгаа дэлгэсэн Тохилог Өрхийн гадаа ирлээ. Юм ер хачин шүү. Ямар нэг сайхан, сайн юмны тухай ярихад бүгдээрээ дороо л уйдчихдаг биз дээ. Харин янз бүрийн гай зовлон, аюултай адал явдлыг ярих юм бол таныг амаа ангайгаад л сонсоод байна. Тиймээс адал явдлын баатрууд маань энэ зочломтгой сайхан өрхөд арван дөрвөн өдрийг аятай тавтай өнгөрөөсөн тухай олон юм нурших хэрэггүй болов уу. Тэд дахиад хэдэн өдөр ч үлдмээр байсан билээ. Бильбо бол бүр энд амьдрахыг ч хүсэж магадгүй. Шидэт аргаар түүний тохилог гэрийг энд авчирна гэвэл тэр үлдэхээр болж ч мэдэхээр байлаа.

Өрхийн эзэн Элронд, эльфүүдийн анд бөгөөд эльфүүдийн гоблинуудтай хийсэн дайнд оролцсон, хойд нутгийг эхлэн эзэмшсэн хүмүүсийн толгойлогч билээ.

Элронд эльфүүдийн удирдагч байхад яг таарсан сурвалжит сай-хан царай зүстэй, хүчирхэг дайчин, шидтэн мэт ухаалаг, одойнуудын хаан шиг ихэмсэг эрхэм, дэлгэр зун шиг өгөөмөр ажээ. Элрондын тухай олон үүх түүх байх агаад харин тэрээр Бильбогийн түүхэнд их биш ч чухал нэгэн үүрэг гүйцэтгэжээ. Тэсвэрлээд манай түүхийг дуустал уншвал энэ тухай бүгдийг мэдэх болно.

Элрондын гэр одой бүрт таатай сайхан байлаа. Хоол идэх нь идэж, ууж унтах дуртай нь унтаж, ажил хийж үлгэр домог сонсох нь сонсож дуу хуур болох нь болж аль эсвэл чимээгүй тайван сууж бодох нь бодож жаргалын оронд байгаа мэт байцгаажээ. Энэ өгөөжит хөндийд хар хор л алга байлаа.

Аян замд ядарсан одойнууд өөрсдөө ч морьд нь ч амарч тэнхэрч авлаа. Хувцас хунарыг нь өөж, шидэж хөхөрсөн улайсан нүүр амыг нь эмчилж, сэтгэл санаагий нь сэргээн хөгжөөж өглөө. Аяны богцнуудыг идэх юмаар дүүргэж, тэд өөрсдөө цатгалан хүч сэлбэсэн болохоор ямар ч уулыг даван туулахад бэлэн боллоо. Дээр нь бас үй түмэн чухал чухал захиас зангаа хэлж өгөв. Яг энэ үед зуны нар буцах өдөр ойртож байлаа. Нар буцах өдрийн өглөө тэд аяныхаа замыг үргэлжлүүлэх билээ.

Элронд хамгийн эртний бичгийн хэл мэддэг байлаа. Салж явахын өмнө тэрээр тэдний Троллуудын агуйгаас олж авсан сэлэмнүүдийг үзээд Троллууд энэ сэлэмнүүдийг хийгээгүй. Энэ бол Барууны эльфүүд буюу миний их удам судрынхны хуучин сэлэм байна. Гоблинуудтай хийсэн тулалдааны үед Гондолинд дархалсан байхаа. Ямар нэг гоблин юмуу луу үүнийг дээрэмдэж эзэмшиж байсан биз. Луу, гоблинууд эртний хотыг сөнөөсөн юм чинь. Торин чиний сэлэм энгийн нэг сэлэм биш. Оркрест гэж нэрлэгддэг. Гондолинчуудын хэлээр бол Гоблинуудыг Номхотгогч гэсэн утгатай. Гэндальф чиний гарт Гондолины хааны сэлэм байна. Дайснаа Дарагч гэсэн утгатай Глемдринг гэж нэрлэгддэг юм. Сэлэмнүүдээ нүдний цөцгий мэт хайрлаж хамгаалж яваарай гэлээ.

Торин өөрийнхөө сэлмийг сонирхон харж,

- Троллууд эднийг хаанаас авсан байх нь вэ?

- Хэлж мэдэхгүй байна. Троллууд дээрэмчдийг дээрэмдсэн юм уу, эсвэл бусдын ууланд нуусан олзыг олсон байх. Одой гоблины хоорондох дайны үеэс Морийн агуйнуудад багагүй юм үлдсэн гэж би дуулсан юм байна. Торин Элрондыг ихэд анхааралтай сонсож байлаа.

- Энэ сэлмийг би өөрийнхөө нэр төр шиг хайрлах болно. Удахгүй энэ сэлэм дахиад Гоблинуудыг Номхотгогч болох ч юм билүү гэж тангараглах мэт хэлэв.

- Та нарыг ууланд гарахад сэлэм чинь чамайг аврах болтугай гэж Элронд хэлээд,

- Алив газрын зургаа үзүүлээч гэлээ.



Тэрээр газрын зургийг дэлгэн удаан гэгч нарийвчлан хараад хөмсөг зангидан толгой сэгсэрнэ. Элронд одойнуудын алт мөнгөнд тэмүүлж байгааг дэмжихгүй байгаа билээ. Гэхдээ хорт зэрлэг шуналт лууг үзэн ядна. Дейл хотын хана нурсан тухай дурсамж буюу одоо үүрд дуугарахгүй болсон тэр нэгэн цагт баяр жаргалаар цангинаж байсан хотын хонхнуудыг дурсан санахдаа шаналалд автдаг байлаа.

Том сарны мөнгөн гэрэл орчныг гийгүүлнэ. Элронд газрын зургийг өргөн гэрэлд барин харлаа.

- Энэ юу вэ? гэж тэрээр дуу алдаад, энүүгээр гурван одой зогсоогоороо орж болно гэсэн тодхон бичгийг нэвглэн сарны үсгүүд харагдаж байна.

- Ямар, ямар сарны үсгүүд вэ? Хоббитын сонирхол ооволзов. Бильбо газрын зурагт дуртай гэж би та нарт хэлсэн байхаа. Түүнд бас эртний бичиг үсгүүд таалагддаг байлаа. Ер нь Бильбо маягтайхан дурайлгасан үсгүүд болон гар бичмэлийг ихэд сонирхон гайхан шагшдаг байсан бөгөөд өөрөө аалз шиг арвагар үсэгнүүд бичдэг юм.

- Сарны үсгүүд жирийн нүдэнд харагдахгүй. Энэ үсэгнүүд сарны гэрэлд л тодрон үзэгддэг юм. Зарим нь бүр нууцлаг байна гээч! Түүнийг уншихын тулд хэдний, сарны ямар дүрстэй үед бичсэн байна тэр үеийг хүлээх хэрэгтэй. Одойнууд үүнийг мөнгөн өдөөр бичсэнийг чи мэдэх үү? Энэ зурган дээрх бичгийг яг энэ шөнө шиг сартай шөнө бичсэн байна. Зуны нар буцахын өмнөхөн бичжээ.

- Тэгээд юу гэж бичсэн байна? Гэндальф Торин хоёр ухасхийн ийнхүү асуулаа. Бичгийн нууцыг тэр хоёр биш Элронд тайлсанд тэр хоёр дурамжхан байлаа. Үнэндээ, тэр хоёрт газрын зургийг үзээд суух тав тух ч гараагүй билээ.

- Турлиах дуугарахад саарал чулууны дэргэд зогс. Жаргаж байгаа нарны цацраг цоожны нүхийг онож буудна. Энэ бол Дюрин өдөр эхэллээ гэсэн үг. Элронд ингэж уншихад Торин,

- Дюрин гэнэ ээ гэж лавлан асуугаад,

-Дюрин бол Урт сахалт одойнуудын эртний төрлийн дээд овог. Тэгэхээр миний өвөг дээд. Би Дюрины үр удам гэлээ.

- Тэгвэл Дюрин өдөр гэдгийг тайлбарлаатах гэж Элронд сонирхоход,

- Одойнуудын шинэ оны эхний өдөр. Намрын сар, өвлийн нар хоёр тэнгэрт зэрэг гарсан өдөр. Одоо энэ Дюрин өдрийг хэдийд эхлэхийг яг тооцоолж хэн ч чадахгүй байхаа. Энэ мэдлэг олон зуун жилд мартагджээ.

-Харамсаад суух цаг алга. Өөр юу бичсэн байна? Гэндальф Элрондыг тайвшруулаад ийнхүү асуулаа.

-Өнөөдрийн сарны гэрэлд өөр юм уншигдахгүй боллоо гээд Элронд Торинд зургийг буцааж өгөв.

Дараа нь тэд бүжиглэн дэгдэж байгаа эльфүүдийг харахаар гол уруу бууж иржээ. Маргааш өглөө нь мөрөөдлийн дээд гэмээр шинэхэн, сэрүүхэн агаар сэнгэнэсэн гайхамшигтай сайхан байлаа. Цэнхэр тэнгэрт нэг ч үүлгүй. Нарны цацраг долгиотон бүжиглэнэ. Эльфүүдийн үдэлтийн дуу, аян замын ерөөл тэднийг үдэн цуурайтна. Тэд ч шинэ адал явдал тааралдахад, угтахад бэлэн бөгөөд зүрх нь баатарлагаар цохилж тус бүрдээ л Манант уулсыг даван туулж түүний цаанатаа орших газар нутагт хүрнэ гэдэгт итгэл төгс байлаа.



Дөрөвдүгээр бүлэг

Уулын дээгүүр, уулын доогуур

Манант уулыг зүглэх тоймгүй олон зам байлаа. Зарим нь бүр уулын гүнийг нэвтрэх гүнзгий хавцлаар зурайж байлаа. Зарим нь хөтөл гүвээн дээгүүр зурайна. Мушгирч тахиралдсан мухарт тулгах хуурамч зам зөрөг ч байх. Энд элдвийн муу юм ихтэй гэх агаад төөрвөл үхлийн аюул тосох байлаа. Гэхдээ тэд Элрондын мэргэн зөвлөгөөгөөр бас эндхийн замаа таньж мэдэж байлаа. Гэндальфийн ачаар одоохондоо замаасаа төөрөхгүй явсаар байв.

Манай адал явдлын эрэлчид Тохилог Өрхийг орхин одсоноос хойш олон өдөр өнгөрлөө. Багагүй газрыг хороосон хэдий ч тэд улам л дээшээ өгсөн явсаар. Бартаатай зам. Аюултай зам. Махиралдсан хязгааргүй цөлийн зам. Одоо, хэрвээ эргээд харах юм бол асганы завсар тэртээ доогуур цэлийх ард үлдсэн газар нутгийг нэгэн харцаар тойруулан харж болох байлаа. Алсын алс баруун зүгт цэнхэр манангийн цаана аюул осол үгүй амарлингуй цэцэглэх сайхан нутаг, Бильбогийн төрсөн нутаг бий. Бильбо тэртээ алсад түүний сэтгэл дулаацм гэр нь байгаа даа гэж санагалзав.

Гэнэтхэн хүйтэрлээ. Салхи хад асганы завсар сүвлэн сүнгэнэнэ. Эгц дээрээс хайлсан цас мөснөөс хагарсан том том булууд доошоо хар эрчээрээ өнхрөн унаж байв. Нэг том бул цас авралаар хажуугаар өнхрөн өнгөрлөө. Өөр нэг бул тэдний толгой дээгүүр бутран уналаа. Шөнөдөө хүйтэн чийглэг болно. Хэн ч чанга ярихгүй тэр тусмаа дуулж зүрхлэхгүй байлаа. Яагаад гэвэл, унагасан үг болгон цуурай татан уулаар нэг тарах юм чинь. Зөвхөн усны урсгал, чулуу хагарах бутрах, салхи шуугихаас өөр чимээ анир үл гарна.

Тэртээ доор зуны дэлгэр цаг налайгаад л. Өвс хадлан, хээрийн зугаалга... Бид уулнаас бууж амжаагүй байхад тариа ногоогоо хурааж, бор бөөрөлзгөнөд явцгаах байх даа гэж Бильбо бодов.

Бусад одойнууд ч гэсэн уйтгарт бодолд дарагдан байлаа. Саяхан л Элрондоос салж явахдаа тэд уулыг давж, хязгааргүй өргөн тэгш талыг хурдхан туулчих юм шиг л бодож байсан даа. Тэд бүгдээрээ намар гэхэд л Ганцаардмал уулын нууц хаалганд хүрэх байх аа. Яг Дюрин өдөрт амжих байх гэх мэт ганц хоёрхон үг хэлэлцэж явлаа.

Энэ бүхнийг сонсоод Гэндальф зөвхөн толгой сэгсрэх агаад юу ч хэлсэнгүй. Одойнууд энэ замаар өчнөөн олон жил яваагүй билээ. Харин Гэндальф үүгээр нэлээд явсан тэгээд ч Зэрлэг хязгаарт аюул осол алхам тутам амдаж байдгийг мэдэх ажээ. Луу болон гоблинууд энэ газрыг эзэгнэж эндхийн агуй, Морийн агуйд суурьшсан цагаас эхлэн хор хөнөөл ил задгай болсон ажээ. Хэрвээ чамд Зэрлэг хязгаараар явах хэрэг гарсан бол Гэндальф мэтийн шидтэнгүүдийн мэргэн арга, Элронд шиг найзын үнэт зөвлөгөө аль аль нь дандаа гай зовлонгоос авраад байж чадахгүй гэдгийг санах хэрэгтэй. Хэзээ ч, юу ч тохиолдож болох байлаа.

Тэнгэрт тулсан цасан оргилтой энэ уулуудыг даван, шударга ёст хаант улсын оронд олон жилээр эмх замбараагүй хорон санаатнууд эзэгнэн байгаа газар нутгийг онцгой аюулгүй шиг гатлан туулаад өнгөрчихнө гэж Гэндальф дэмий л найдахаас өөр аргагүй байлаа.

Харин одойнууд, хоббит энэ тухай бодох ч үгүй явлаа. Тэднийг ийнхүү амар тайван явж байтал гэнэт хуй салхи салхилж дуутай бороо асгарлаа. Юун бороо, жинхэнэ бороо салхины тулалдаан боллоо. Замдаа дайралдсан бүхнийг хуу хаман шидэлдэг шуургыг эсвэл хоёр хилэнт хүч нэгдсэн далайн шуургыг та бүхэн мэдэж байгаа шүү дээ. Тэр тусмаа уулын шөнийн салхитай бороо ямар аймаар гээч. Гэрэл гялалзаад, дуу чимээний ихийг. Зэвүүн гуаглах, үхтэл эргүүлж хаях хуй салхи. Аянгын дуунд уулс чичирнэ. Цахилгаан, хадыг сүвлэх мэт мөргөнө. Агаар тэнгэр хагарч бутарна. Аянгын дуу цуурайтан агуйд дэлбэрэх мэт болсноо ангал хавцлаар шуугин шургана. Харанхуй чих дүлийрэм чимээгээр дүүрч байснаа гэв гэнэтхэн аянга цахилгаанаар гялалзана.

Ийм аймшгийг Бильбо амьдралдаа үзээгүй бөгөөд тэр ч байтугай ийм юм байдаг гэж төсөөлж бодож чадахгүй билээ. Мананд бүрхэгдсэн хавцлын эгц эрэг дээрх нарийхан чулуун хавтгай дээр тэднийг байхад ийнхүү шуурсан билээ. Бильбо хадны нөмөрт шигдэн толгой дээгүүрээ хөнжлөө нөмрөөд хамаг бие нь дагжин чичрэн суулаа. Хааяа нэг зориглон хөнжлөө сөхөн хамраа цухуйлган харахад, аянга харанхуйд өргөн хөндийгөөс өм цөм таслан эсвэл уулын бидэртэх энгэрээс уран тасдан авч байх шиг санагдана. Үүнийг харсан хоббитод үлгэрийн чулуун аваргууд хадны хэлтэрхийнүүдийг бие бие өөдөө шидэлцэн тоглож харанхуй уруу хаяж байх шиг санагдана. Дараа нь аадар асгарч шавхуурдах мэт салхи мөндөртэй бороо цутгалаа.

Өрвөлзөн эргэлдэх аадраас хадны нөмөр ч аварч чадахгүй боллоо. Удалгүй тэд голдоо ортол норцгоов. Пони морьд нь толгойгоо гудайлган нойтон сүүлээ хавчин айсандаа аяар аяархан тургина. Харин аварга биетэнгүүд ууланд хүрхрэн хархиран тургиж байлаа.

-Энэ ч баларсан юм болох нь дээ. Салхинд хийсээд унадаггүй юм гэхэд, борооны усанд урсаад, аянга цахилгаанд ниргүүлдэггүй юм гэхэд энэ уулын аварга хайрхнууд чинь дарж алах юмуу, ангал уруу өшиглөчих юм байна гэж Торин үглэлээ.

-Тэгээд чи аятайхан газар мэдэх юм бол биднийг тийш нь аваачаатахаач. Уулын аваргуудад дургүй нь хүрсэн Гэндальф бас л хариу үглэв.

Эцэст нь Фили, Кили хоёрыг найдвартай нөмөр газар ол гэж явуулахаар болов. Тэр хоёр бусдаасаа тавиад насаар дүү, тэгээд ч үргэлж л тагнах чагнах ажилд илгээгдсээр нүд нь хурц, чих нь соргог болжээ. Бильбо бол ийм ажилд таарахгүй. Харна гэдэг олж үзнэ гэсэн үг биш гэж Торин өгүүлдэг. Энэ удаа ч тиймэрхүү юм боллоо. Эрж байгаа юм болгон харагдахгүй, харагдаж байгаа юм болгон эрж байсан юм нь биш байдаг билээ.

Хадны нөмөр дагасаар Фили, Кили хоёр удалгүй буцаж ирлээ.

- Бид хоёр хуурай агуй оллоо. Энүүхэнд, тэнд морьд маань ч багтана гэцгээв.

- Та хоёр агуйг сайн харсан уу? Уулын агуйнууд эзэнгүй байх нь бараг үгүйг мэдэх үү? гэж Гэндальф ширүүхэн асуулаа.

- Харсан, харсан гэж тэр хоёр яаран хашхичаад, зайтай цэлгэр юм гэхдээ тийм ч их том биш гэлээ.

- Агуй гэдэг аюултай. Цаашаагаа хичнээн ч гүнзгий юм билээ, хаана очиж мухардах ч юм билээ, хэн, юу ч байж байх юм билээ? Гэхдээ Кили, Фили хоёрын үг тэднийг одоохондоо тайвшруулж байлаа. Даарч чичирсэн тэд нар юм хумаа хурдхан эмхэлж ойрхон шиг нүүхэд бэлтгэж эхэллээ. Аянга дуугарч, салхи улин шуугисаар байлаа.

Тэр агуйд хүрэх гэж тэд нэлээд тэвдэцгээв. Бас морьдоо хөтөлцгөөчихсөнийг хэлэх үү. Уг нь нэг их явсангүй. Тэд удалгүй зөрөг замын нь хажууд нэгэн нүх байхыг харлаа. Тэр нүх уруу ортол үнэхээр пони морьд нь элбэгхэн багтах цэлгэр агуй байлаа. Найдвартай нөмөр газар ийнхүү суугаад гадаа шуугих салхи, аадар асгарах чимээг сонсоход таатай бөгөөд уулын галзуурсан аваргуудын нүргэлэх чимээ аймшигтай биш байлаа. Харин Гэндальф сонор соргог хэвээрээ. Тэрээр дээр нэг удаа Бильбогийн хоолны өрөөнд мартаад орхиж байсан тэр шидэт саваагаа гэрэлтүүлэн хоббиттой цуг агуйг хөндлөн гулдгүй нэгжлээ.

Агуй хэтэрхий том биш боловч сайхан цэлгэр ажээ. Харанхуй боловч нууц гэхээр юм алга байв. Агуй дээр нь бас тохитой хүнхэрүүд-тэй ажээ. Нэлээд гүний нэг буланд пони морьдоо байрлуулах хонхордуу газар оллоо. Одоо морьд аманд нь уяж өлгөсөн шуудайтай өвснөөс тааламжтайхан шир шир хийтэл хивэн дэргэд нь зогсоцгооно. Нойтон хувцсаа хатаахаар Ойн, Глойн хоёр гал асаах гэсэн боловч Гэндальф зөвшөөрсөнгүй. Нойтон хувцсаа газраар дэлгэж тавиад ганзаганаасаа хуурайг гаргаж ирэн эвтэйхэн дэвсгэр болгон засаад, гаансаа тамхиар дүүргэн таазанд тултал утаан цагирагууд уугиулж гарлаа. Гэндальф өнгө өнгийн утаан цагираг гарган, тэр утаан цагирагаа өнхрүүлж бөмбөрүүлэн бүжиглүүлж нөхдөө зугаацуулав. Тэд дэмий яриандаа гадаах салхи шуургыг мартан, заавал олж авах үнэт эрдэнэсийнхээ хувь хүртээлээр юу хийх тухай бүгд л ам булаацалдан ярьж суулаа. Удалгүй алт эрдэнэсээ олж авна гэдэгт хэн ч эргэлзэхгүй байлаа. Харин энэ удаа удсан ч үгүй өөр юм болсон билээ. Тэд ядарсандаа таг унтацгаажээ.

Энэ шөнө тэд нар Бильбог дэмий ч нэг авч яваагүй гэдгийг нотолсон билээ. Бильбо удаан эргэж, хөрвөж унтаж чадахгүй байснаа аймаар муухай зүүд зүүдэлжээ. Агуйн цаад нэг хананд байгаа цуурсан газар улам өргөн болсоор байна гэнэ. Хоббит дуугүй орилж хашхирч эхлэв. Тэрээр хөдөлж чадахгүй дуугүй харсаар байв. Аймшигт зүүд үргэлжилсээр. Агуйн шал хага үсэрч хөөрхий Бильбо хаашаа ч юм нисээд л, нисээд л байв.

Яг энэ үед хоббит чичрэн сэрмэгцээ зүүд нь зүүд биш байсныг харлаа. Агуйн хана үнэхээр цуурч өргөн гэгч зай гарсан байлаа. Тэр өргөн нүх уруу сүүлчийн морины сүүл гялсхийн алга болохыг Бильбо харав. Намхан биендээ баймааргүй муухай чангаар хашхирлаа. Зөвхөн хоббитууд л ингэж орилж чадах билээ.

Яг энэ үед ангайсан хананаас гоблинууд үсрэн гарч ирлээ. Асар том гоблинууд, аймаар муухай гоблинууд, сүргээрээ гарч ирэх нь тэр. Хэн ч юу ч хэлж чадсангүй, амжсангүй. Одой болгон уруу зургаан гоблин, хоббит уруу хоёр гоблин дайран дарж авлаа. Гоблинууд тэднийг хамж аваад ангайж байгаа ангал уруу чирэн орцгоолоо. Харин Гэндальфийг барьж чадсангүй. Бильбогийн хашхирахыг сонсмогцоо Гэндальф дорхноо сэржээ. Гоблинууд ойртмогц тэдний нүд өөд цахилгаан цахих мэт гэрэл гялбаж, дэлбэрэх чимээ, шатсан үнэр үнэртэж, хэдэн дайсан газар дээр үхэтхийн унажээ.

Хананы ангал тасхийн хаагдав. Бильбо, одойнууд хананы нөгөө талд хашигдах нь тэр.

Гэндальф хаана байна аа? Хаашаа орчихов? Гоблинууд ч гоблинуудын баривчлагсад ч, хэн ч мэдэхгүй байлаа. Гоблинууд түүнийг эрж хайхыг ч хүссэнгүй. Тэд Бильбог, одойнуудыг агуйн бүр цаад мухар уруу хөөж аваачлаа. Тэсвэрлэшгүй бүгчим хав харанхуй болж байлаа. Энэ бүдүүлэг гоблинууд баривчлагсадыг хайр найргүй зулгааж, доромжлон тохуурхаж, сөөнгөтөн хөхөрч байлаа. Бильбо бусдаасаа илүү энэ доромжлолд өртөж байв. Хөөрхий Бильбо өөрийнхөө гэгээ гийсэн сайхан гэрээ дахин санагалзаад авлаа. Сүүлчийн удаа биш байгаасай даа, бурхан минь.

Арайхийн, өмнө талд нь улаан гэрэл анивчин харагдав. Гоблинууд дуу хадааж эхлэв. Тэдний хоолойноос зэвүүн хархираа мэт дуу гарав. Өргөн хатуу туурайгаараа зэрэг зэрэг гишгэлэн муухай дууныхаа аясаар баривчлагсдаа нүдэж явлаа.

Топ. Топ, Хар хад

Хаз ур. Нүд зод

Гоблины идэш бол, бол

Гол зогоо, чигчий, чигчий

Хахир, хэхэр. Хадар, хэдэр

Ал хяд. Алх бахь

Газрын доор бяцал няцал

Гол зогоо. Чигчий чигчий

Ташуур тас. Яс мах тас

Таатай дуу. Ёох,ёох

Гоблинууд ууна иднэ

Гоблинууд уухилна, дуулна

Гол зогоо, чигчий, чигчий

Энэ дууг сонсоход дотор харанхуйлна. Чулуун хана энэ Хахир-Хэхэр, Хадар-Хэдэр гэдгийг давтаж байх шиг санагдана. Хаз-Ур, Нүд, Зод гэх нь хэдэн арав болон цуурайтна. Энэ заналт дууны утга дэндүү ойлгомжтой байлаа. Ташуур тас, Яс мах тасар. Гоблинууд ийнхүү хашхиран баривчлагдсан одойнуудаа тас тас гуядан хөөж явлаа. Одойнууд ёолон уйлан хашхиралдан гүйцгээнэ. Гэнэт тэд бүгдээрээ асар том агуй уруу өнхрөн орцгоочихов.

Агуйн голд асаж байгаа түүдэг гал, хананд өлгөөтэй бамбарууд, ховдог шунахай гоблинуудыг гэрэлтүүлнэ. Одойнууд бас жижигхэн хоббитыг хараад, тэд зэрлэгээр орилолдон, хөлөө дэвслэн алга ташицгаав. Гоблинууд тэднийг хөөж туухдаа хайр найргүй гуядаж байсан

болохоор хамгийн сүүлд явж байсан Бильбо хамгийн их өртжээ. Энэ агуйд тэдний пони морьд буланд хураагдсан байлаа. Хажууд нь одойнуудын ганзага шуудайнууд харагдана. Гоблинууд тэднийг ухаж, хэрэгтэйг нь авцгааж тэр ч байтугай олзон дээрээ хэрэлдэж зодолдоод амжжээ.

Хэлэхэд тун харамсалтай нь одойнууд өөрсдийнхөө гайхамшигтай хөөрхөн пони морьдоо дахин харж чадахгүй болжээ. Элронд Гэн-дальфт зээлдүүлсэн сайхан цагаан морь хадтай уулын эгц зөрөг замыг туулж чадалгүй өнгөрчээ. Гоблинууд дандаа өлсгөлөн байдаг бөгөөд морь, пони, илжиг юу л бол юу гударна. Хөөрхий баривчлагсад одоо бол юун пони морьд мантай. Тэднийг ч гэсэн одоохон иднэ. Гоблинууд тэдний гарыг ард нь хүлж шил шилийг нь харуулж зогсоогоод, урт гинжээр холбон агуйн гүн уруу чирч аваачлаа. Бильбо мэдээжээр хамгийн сүүлд чирэгдэв.

Том гэгч хавтгай чулуун дээр том толгойтой аварга гоблин сууж байлаа. Түүнийг тойрон махир сэлэмтэй, бас сүх барьсан жижгэвтэр гоблинууд зогсоно. Гоблинууд зэрлэг хорлонтой ер нь зэвүүцмээр муухай амьтад билээ. Тэд сайн үйлдэл хэзээ ч хийдэггүй. Хэрвээ хүсвэл тэд газрын хонгил, уурхай ухах ажилд одойнуудаас дутахгүй боловч хайнга, хам хум бүдүүлэг, заваан ажилладаг байна. Нүдүүр алх, сэлэм жад, хангинуур сүх, чичлүүр хутга болон тамлах зэвсгийг тэд өөрсдөө муугүй хийх боловч тэд олзлогсод юм уу боолуудыг бүгчим харанхуй агуйн гүнд хөгцөрч унатал нь энэ бүх зэвсгийг хийлгэн тамладаг байна.

Олон хүнийг бөөнөөр нь устгадаг үхлийн машиныг гоблинууд зохиосон байх магадлалтай. Гоблинууд гараараа ажиллах дургүй учраас янз бүрийн тэсрэх дэлбэрэх, зальтай төхөөрөмжүүдийг ихэд сонирхоно. Гэхдээ бидний ярьж байгаа хуучны тэр цагт гоблинууд зэрлэг бүдүүлэг байсан юм. Гоблинууд үнэнч шударгаар ажиллаж дээшилж байгаа бүхнийг үзэн ядна. Харин одойнууд бол ажил хөдөлмөрт дуртай дэг журамтай бүгдийг дэмжинэ. Үнэнийг хэлэхэд одойнууд дунд гоблинуудтай адилхан байхаас ичдэггүй залхуу, хорон санаатай одой тааралдах боловч тэдний тухай яриад ч хэрэггүй юм. Харин гоблинууд урьд нь миний дурдсан дайнаас болж Торин мэтийн одойг онцгой ихээр үзэн ядна.

Ер нь бол гоблинуудад юуг, хэнийг барих ялгаагүй юм. Хамгийн гол нь сэхээрээгүй байхад нь гэнэт дайрч, барьж аваад, алж идэх л гол билээ.

- Энэ муусайн нуснууд хэн бэ? гэж Гоблинуудын Толгойлогч асуув.

- Одойнууд бас энэ юу билээ гээд нэг туугч гоблин гинжийг хүчтэй татахад Бильбо сөхөрч унав.

- Эд нар манай үүдний агуйд нуугдаж байсан байна гэж нэмж хэллээ.

- Та нар яах гэж тийшээ оров? Лав зүгээр ороогүй дэг. Тагнаж эсвэл хулгай хийх гээ биз. Эсвэл бүр алуурчид уу, эсвэл эльфүүдийн хамсаатан уу? Бушуу хэлээтэх. Гоблинуудын Толгойлогч Торинд хандан зандчив.

- Одой Торин таны өмнө гэж Торин дадал болсон зангаараа эелдэгхэн хэлснээ.,

- Биднийг муу юманд хардаж байгаа нь та нарын буруу. Бид тэр агуйг хоосон гэж бодоод салхи борооноос зугтан тийшээ орсон юм. Бид нар гоблинуудад түвэг болохыг огтхон ч бодоогүй. Та нартай уулзана гэж ерөөсөө төлөвлөөгүй. Энэ үг яг үнэн үг байлаа.

- Хм. Аа ха. Та нар ууланд юу хийж тэнэж яваа юм бэ? Хаанаас хаашаа явж байгаа юм? Үнэнээ хэлцгээ. Тэгээд ч нэмэргүй биз дээ. Яагаад гэвэл Торин Оукеншильд чиний тухай, танай ардуудын тухай багагүй мэднэ. Гэсэн ч үнэнээ хэл, эсвэл та нарыг бүгдийг чинь сөнөөнө.

- Бид нар хамаатан садангуудтайгаа уулзахаар явж байгаа юм. Нэгдүгээрт ах эгчийнхээ хүүхдүүдтэй уулзахаар. Хоёрдугаарт авга, нагацынхаа хүүхдүүдтэй уулзахаар. Гуравдугаарт авга нагацынхаа зээ нартай уулзахаар. Дөрөвдүгээрт энэ зочломтгой уулын нөгөө талд Дорно зүгт амьдарч байгаа бидний өвөг дээдсийн үр удам, бүхий л хамаатан садангуудтайгаа уулзахаар явж байна гэж Торин их л үнэмшилтэйгээр хэлэхдээ илүү юм чалчихгүй байхыг байдгаараа хичээн өгүүлэв.

- Энэ муу худлаа ярьж байна. Их эзэнтэн минь гэж нэг туугч гоблин уулга алдаад,

- Энэ урилгагүй зочдыг бидний араас яв гэхэд тэр агуйд манай гоблинуудаас нэлээн хэд алагдсан байсан. Үүнийг муу нус юу гэж цагаатгах бол? Ингэж хэлээд гоблин Торины сэлмийг үзүүлэв. Энэ сэлмийг одойнууд Троллуудын үүрнээс авсан билээ.

Сэлмийг хармагцаа Гоблинуудын Толгойлогч айдас хүйдэс, уур хилэн хослуулан чарлаж гарлаа. Бусад гоблинууд энэ гуугчааг шүдээ хавиран зэр зэвсгээ харшилдуулан хөлөө дэвслэн дэмжлээ. Тэд энэ сэлэм ямар сэлэм болохыг хормын дотор мэдэрцгээлээ.

Дээр нэгэн цагт Гондолинуудыг хамгаалан гялалзуур шалмаг эльфүүд энэ сэлмээр зуу зуун гоблинуудыг алсан байжээ. Эльфүүд энэ сэлмийг Гоблинуудыг Номхотгогч буюу Оркрисст гэх бөгөөд харин гоблинууд болохоор зүгээр л Цавчигч гэдэг ажээ. Гоблинууд энэ сэлмийг ихэд үзэн ядах бөгөөд түүнийг барьж байгаа эзнийг бүр аймаар үзэн ядна.

- Гоблинуудыг алан хядагч, эльфүүдийн андууд. Эднийг хаз, ур, хага цавч, гуяд, гудар. Могойтой хар нүхэнд хая. Энэ гэрэлт дэлхийг эргэж бүү хараг. Гоблинуудын Толгойлогч ийнхүү хашхираад уур хилэндээ багтаж ядан чулуун дээрээсээ үсрэн босч Торин уруу шүдээ хавиран дайрлаа.

Ят тэр хоромд агуйн ханан дахь бүх бамбарын гэрэл унтран түүдгийн галаас бөөн гал тааз уруу шидэгдэн түүний очис тал тал уруу үсчин гоблинуудын биед шигдэн орж байлаа.

Тэгээд юу болсон гэж санана. Орилоон чарлаан, хараал ерөөл, хашхирах гүйлдэх, аймаар дэвслэх, аахилж зугтаах, гуаглах гудчих гээд л. Хэрвээ зуу зуун зэрлэг чоно, муур нохойг амьдаар нь халуун гал дээр шарвал гарах дуу чимээ үүний дэргэд юу ч биш. Улаан галтай очис гоблинуудыг хайр найргүй түлж байлаа. Агуйд битүү утаа дүүрч гоблинууд хүртэл юм харж чадахаа байлаа. Тэгээд ч гоблинууд бие биенээсээ зууралдан агуйн шалан дээгүүр яг л солиотой юм шиг өшигчин түлхэлцэн өнхрөлдөв,

Гэнэт сэлэм гялалзан Гоблинуудын Толгойлогч уруу дүрэн орж, Толгойлогч үхэтхийн унахыг Бильбо харж амжлаа. Гоблинууд сэлэмний үхлийн цохилтоос амь зулбан зугтаж, зэвүүн муухай чарлан харанхуйд алга болцгоов. Сэлэм өөрөө хуйндаа эргэн оров.

- Миний хойноос гэх итгэлтэй тайван дуу хамаандаллаа.

Бильбо юу болсныг сайн ойлгосон ч үгүй. Сүүлэн дэх гинжээ чирсээр өмнөө гүйж байгаа одойнуудыг даган харанхуйг тэмтчин ухасхийв. Ард нь гоблинуудын ёолон орилох дуу холдон хоцров. Харин өмнө нь үл мэдэг гэгээ сүүмэлзэн харагдах нь тэр.

-Хурдал, хурдал. Одоо бамбарууд дахиад асчихна гэж тэднийг нөгөө дуу яаруулж байлаа.

-Алив, жаахан хүлээж бай. Өөрийнх нь ард Бильбо бондгонон гүйхийг өрөвдсөн Дори ингэж хэлээд хүлээстэй гараараа эв хавгүйхэн хөдөлж хоббитыг нуруун дээрээ суулгаад цаашаа гүйлээ. Одойнууд гинжээ хангинуулан унаж босон гүйсээр байлаа. Одойнууд уруудан, уруудан гүйсээр байлаа. Лав уулын голд хүрсэн буй заа.

Зөвхөн сая л Гэндальф таягныхаа үзүүрийг гэрэлтүүлэв. Нөгөө гоблинуудаас аварсан дуу хоолой бол мэдээж Гэндальфийнх байлаа. Тэр яаж ингэж чадав аа. Гэхдээ одоохондоо юун асуух хариулах. Шидэт Гэндальф сэлмээ хуйнаас нь дахин сугалахуйяа харанхуйд хурц гэрэл гялсхийнэ. Сэлэм гоблинуудыг цавчихдаа улайрлын гал цацаж байсан бол одоо Гоблинуудын Толгойлогчийг алсандаа тайвширсан мэт зөөлөн цэнхэр өнгөөр гэрэлтэж байлаа. Энэ сэлмээр гинжийг амархан тас тас цавчин хаяж одойнууд даруйхнаа чөлөөтэй боллоо.

Энэ сэлмийн нэрийг мартаагүй биз? Глемдринг буюу Дайснаа Дарагч. Гоблинууд энэ сэлмийг Цавчигчаас илүү үзэн ядах агаад Бутлагч гэж нэрлэх ажээ. Гэндальф андуудаа аварч сэлмээ аварчээ. Гэндальф бас Оркрест сэлмийг солиот гоблиноос булааж авсан байна. Гэндальф юуг ч орхигдуулсангүй, юуг ч мартсангүй. Гэндальф бүгдийг чаддаг шидтэн биш ч гэсэн хэзээ ч нөхдөө гай зовлонд ганд нь хаяж орхидоггүй билээ.

- За бүгд бүрэн байна уу? Гэндальф Торинд сэлмийг нь өгөнгөө ийнхүү асуугаад,

- Алив, тоол нэг, хоёр, гурав, дөрөв, тав, зургаа, долоо, найм, ес, арав, арван нэг ...

-Хөөш Фили, Кили хоёр хаа байна? Өө, энэ байна. Арван хоёр, арван гурав, ... арван дөрөв дэх нь ноён Бильбо. Бид чинь одоо морьд үгүй, идэх юм үгүй, хаана байгаагаа ч мэдэх юм алга. Араас галзуурсан гоблинууд сүргээрээ хөөж яваа. Алив, бүгдээрээ урагшаа.

Одойнууд урагш гүйцгээлээ. Гэндальф зөв хэлжээ, Тэдний дөнгөж сая гарч ирсэн харанхуй хонгилоос гоблинуудын дэвслэх хөлийн чимээ, орилох гуагчих сонсогдлоо. Одойнууд байдгаараа гүйцгээв. Хөөрхий Бильбо тийм хурдан гүйж чадахгүй учраас одойнууд түүнийг ээлжээр үүрч явахаар болов.

Харин гоблинууд одойнуудаас хурдан гүйнэ. Дээр нь бас тэд өөрсдөө энэ ууланд орох гарах нүх хонгил бүрийг ухсан болохоор хаагуур гүйхээ цээжээр мэдэж байлаа. Гоблинууд уур хилэндээ гуядуулан улайрсан болохоор хөөрхий одойнууд хичнээн хичээсэн ч гоблинуудын

гуугчин хашхичих дуу ойртсоор байлаа. Удалгүй гоблинууд булангийн цаана байгаа мэт хүнд хөлийнх нь дэвслээ, хахиран сөөнгөтөх амьсгаа нь архан талд сонсогдоод ирлээ. Хонгилд тэдний ард бамбарын улаан хэл өрвөлзөн харагдаж эхлэв. Одойнууд гүйж зугтаах хүч тамираа алджээ. Үхтэлээ ядарсан хөл нь сөхрөн, сөхрөн уналаа.

- Яах гэж би гэр орноо орхив доо? Яах ч гэж? Бильбо Бомбурын нуруун дээр сэгсчүүлэн байхдаа ийнхүү халаглан бодож амжлаа.

- Яах гэж би энэ чигчийн чинээ болхи амьтныг цуг явъя гэвээ? Яах ч гэж? хэмээн Хоббитын хүндэд дарагдах шахсан, хөлс нь нүд рүү нь асгарсан, ар нуруунд нь айдас хүйдэс гүйсэн хөөрхий Бомбур аахилж уухилна. Энэ хоромд Гэндалф эргэж гүйлээ. Торин ч түүнийг дагалдав. Тэд хоёулаа булан тойров.

- Дайраад. Сэлмээ сугалаач, Торин гэж Гэндалф хашхирлаа. Өөр аргагүй байлаа. Гоблинууд орилолдон тэдэн уруу давшилснаа зогтусацгаав. Гоблинуудыг Номхотгогч, Дайснаа Дарагч хоёр сэлэм нүдийг гялбуулж тэд сохорцгоов. Түрүүнд нь гүйцэж ирсэн гоблинууд бамбараа унагаан сүүлчийн удаа орилон унацгаалаа. Ард нь гүйцэж ирсэн гоблинууд муухай чарлан эргэж гүйхдээ харанхуйгаас гарч ирж байгаагаа түлхэж унаган гүйцгээнэ.

Цавчигч бас Бутлагч сэлмийг харсан гоблинууд үймэлдэн нэг нэгийгээ унаган гишгэлж эргэж зугтаав.

Гоблинууд тэр булангийн тойруу уруу нэлээн удаан ойртож чадахгүй байлаа. Энэ хооронд одойнууд цаг алдалгүй цааш зугтаалаа. Тэд нар гоблинуудын баргар харанхуй эзэмшилд улам улам нэвтрэн харанхуй хонгилын нүх сүвээр махиралдан тахиралдан гүйсээр байлаа. Гоблинууд бамбараа дахин асааж, зөөлөн гутал өмсөцгөөж, хамгийн хурдан, хамгийн сонорыгоо урдаа оруулан тэдний хойноос элдэн хөөцгөөв. Гоблинууд махиралдан, тахиралдах хонгилоос хонгил уруу могой мэт гулсаж хуй салхи мэт хурдлана.

Бильбо, одойнууд тэр ч байтугай Гэндалф тэдний ойртон ирснийг сонссонгүй. Харин гоблинууд Гэндалфийн таяг гэрэлтэхийг сайн харж байв. Гэндалф өмнөө яваа одойнуудад зам гэрэлтүүлж байлаа. Хамгийн сүүлд Дори Бильбог үүрэн гүйж ядан явлаа.

Гэнэт Дорийн хөлнөөс шүүрээд авав. Ори хашхираад газар элэгдэн уналаа. Хоббит Доригийн дээгүүр шидэгдэн чулуу мөргөн харанхуй уруу ойчив. Бильбо түүнээс хойш юу ч сонссонгүй, юу ч харсангүй.

Тавдугаар бүлэг

Харанхуй дахь оньсого

Бильбо нүдээ нээлээ. Түүнийг түнэр харанхуй нөмрөх агаад эхний үед тэрээр үнэхээр нүдээ нээсэн үү? Эсвэл түүнд нүдээ нээсэн гэж санагдаж байгаа юм уу ойлгосонгүй. Хажууд нь амьд амьсгаа алга байлаа. Хэлж болшгүй аймшиг түүнийг нөмрөв. Тэрээр юу ч сонссонгүй, юу ч харсангүй. Хүйтэн чулуун шалнаас өөр юу ч мэдэрсэнгүй.

Бильбо удаан, маш удаан аяархан гэгч өндийж дөрвөн хөллөж аваад тун болгоомжтойгоор мөлхтөл, хонгилын хананд тулчихав. Өөр юу ч алга байв. Гоблин юм уу одой байгаа шинж ч алга. Толгой нь эргэж байлаа. Ойчихоосоо өмнө тэд аль зүгт гүйж явснаа мэдээгүй Хоббит дөрвөн хөллөсөөр таамгаар мөлхөв. Тэгээд мөлхөөд л, мөлхөөд л байлаа. Гэнэт түүний гарт хонгилын чулуун шалан дээр жижигхэн металл бөгж тэмтрэгдэв. Удалгүй энэ олз түүний хувь заяанд эргэлт хийж амьдралыг нь огцом эргүүлж хаях билээ. Харин одоо жижигхэн хоббит энэ тухай таамаглах ч үгүй явна. Бильбо бөгжийг хармаандаа хийгээд л дэмий шахуу олзоо мартчихав. Одоо бол юун бөгж. Тэрээр урагш мөлхөхийн оронд хүйтэн шалан дээр хэвтээд бодолд автлаа. Гал зуухныхаа өрөөнд хиамтай өндөг шарж байна гэж нүдэндээ харагдтал шаналан бодлоо. Тэрээр амандаа идэх юмны үртэс ч хийлгүй удсан болохоор өлссөндөө аргаа барж байв.

Цаашаа яахыгаа ч мэдэхгүй болов. Юу болоод өнгөрснийг ч ойлгосонгүй. Яагаад бүгдээрээ түүнийг орхичихов? Яагаад гоблинууд түүнийг олж аваагүй юм бэ? Яахаараа толгой өвддөг билээ? Үнэндээ бол ойлгож ядаад байх юм байхгүй. Бильбо харанхуй булан уруу өнхөрч ороод амьд ч биш... азаар үхсэн ч биш хэвтэж байсан юм байхгүй юу.

Бильбо жаахан ухаан ормогцоо хармаанаасаа гаансаа тэмтэрч оллоо. Гаанс нь хугарсангүй, ямар аштай юм бэ! Тамхиных нь уутанд ганц нэрчих тамхи үлджээ. Юутай сайн юм бэ. Хоббит шүдэнз эрээд нэгийг ч олсонгүй. Ахиад л шаналав. Жаахан бодсоноо бас тийм ч их шаналаад байх юм алга шүү дээ гэж бодлоо. Шүдэнз асахыг хараад тамхины утаа үнэртээд харанхуйгаас ямар ч амьтан гараад ирэх юм билээ. Бильбо хармаануудаа ухаж тэмтэрч байгаад бүсэндээ хавчуулсан кинжал хутганыхаа ишинд санамсаргүй хүрчихлээ. Тэр энэ хутгыг Троллуудын агуйгаас олсноос хойш нэг ч удаа хүрээгүй юм. Гоблинууд хараагүй нь сайн болжээ.

Бильбо хутгаа хуйнаас нь сугалав. Хутга харанхуйд бүдэгхэн гэрэлтэнэ. Үүнийг бас эльфүүд дархалсан байх нь ээ гэж хоббит бодлоо. Гэрэлтэж байгаагийн учир нь гоблинууд ойрхон биш ч гэсэн тийм хол биш байна гэсэн утга ажээ.

Хутгатай байхад арай тайван боллоо. Гоблинуудын эсрэг Гондолинуудын хийсэн, үлгэр домог болсон дайнаас үлдсэн, хэт хутганы эзэн байна гэдэг юутай таатай билээ. Эльфүүдийн зэвсгийг хараад гоблинууд яаж чичирч байсныг Бильбо санав.

Хаашаа явах вэ? Эргээд явах уу? Тэнэг хэрэг, хажуу тийшээ явах уу? Үгүй болохгүй. Тэгэхээр урагшаа юу? За, урагшаа явъя. Бильбо ингэж шийдлээ.

Бильбо босч нэг гараараа хана түшин нөгөө гартаа хутгаа бариад хонгилоор урагшлав. Зүрх нь түг түг цохилно. Арга ч үгүй биз ээ. Бильбо хэцүүхэн байдалд байгаа юм чинь.

Гэхдээ хүнд байдалд орсон амьтан хүзүү хүчтэй гэж хэлж болно биз дээ. Яагаад гэвэл, хоббитууд хүмүүс бидэнтэй адилгүй. Тэд гоблинуудын заваан агуй шиг биш, цэвэрхэн арчилж тордсон тохилог нүхэн гэрт амьдардаг. Тэхдээ л нүхэн гэрт амьдарч сурсан Хоббитод энэ агуй тийм ч аймшигтай биш байлаа. Тэд толгойгоороо чулуу хүчтэй гэгч мөргөсөн ч энд лав төөрөхгүй. Хоббитууд гэмтэж бэртсэнийхээ дараа хурдан засардаг амьтад. Чимээгүйхэн гишгэж явдаг бас хурдан нуугдаж чаддаг. Сэтгэлээ засахын тулд онч мэргэн үгс, хөгжилтэй хэллэг, зүйр цэцэн үгс заавал олж хэлж чаддаг. Харамсалтай нь, бидэнд уламжлагдан үлдсэнгүй.

Бильбо хэцүү байдалд байгаа гэж би хэлсэн, тиймээ. Тэр хонгил хязгааргүй юм шиг санагдана. Зарим газраа салаалсан байх аж. Хэт хутганы туяхан гэрэл хажуу хаяаны гүнд нэвтэрч чадахгүй бөгөөд яг тэнд гоблинууд болон өөр газар доор амьдардаг амьтад нуугдаж болзошгүй учраас Бильбо энэ газрыг хурдхан явж өнгөрөхөөр яарч доошлон доошлон урагшаа явсаар байлаа. Үхмэл анирыг толгой шүргэх шахан нисэх сарьсан багваахайн далавчны чимээ л эвдэнэ. Эхлээд Бильбо сарьсан багваахайнуудаас айдаг байснаа сүүлдээ дасаж хайхрахаа болив. Хэдий ядарсан ч нэг ч хором зогсохгүй хичнээн удаан явсныг хэлэхэд хэцүү. Түүнд аль хэдийнээ маргааш болчихсон, энэ насаа дуустал дахиад олон олон өдөр алхах юм шиг санагдана.

Гэтэл гэнэтхэн аан ч гэж хэлж амжилгүй ус уруу уначихав. Аах, мөс шиг хүйтэн ус түүнийг цочроож толгойг нь сэргээв. Сэртэсхийн, хаашаа унаснаа мэдэх гэж хичээв.

Усаар дүүрсэн нүхэнд үү? Хонгилыг огтлон урсах ширүүн урсгалд орчихов уу? Эсвэл газар доорх нууц нуур уу? Хутга гэрэлтэхээ байчихав. Бильбо чимээ чагнав.

- Под-под-под... Дээрээс унах усны хүнд дуслын чимээ. Өөр ямар ч аниргүй байлаа. Энэ их усны урсгал ч биш, гол ч биш байна. Гүнзгий устай хонхор юм уу, нуур бололтой гэж Бильбо бодлоо. Гэхдээ цаашаа хөдлөхөөс айгаад байв.

Хоббит сэлж чадахгүй тэгээд ч бүлтийсэн, сохолзсон нүдтэй ямар нэг гөлгөр, өнгөгүй муухай амьтантай тулчих вий гэж нүгэлтэй айж байлаа. Газар доор хачин аймаар юмнууд байвал яана. Энэ харанхуй усанд эрт цагт ороод ирчихсэн загасны дээд өвөг гэрэлтэй усанд гарч чадалгүй энд хоригдохдоо нүд нь түнэр харанхуй дундаас цэгийн төдий ч хамаагүй гэрэл олж харахаар бүлтийсээр бүлтийсээр бүлтрэх шахсан хачин амьтад болсон буй заа. Энд гоблинуудаас ч өмнө агуйнуудын хонгил хавцал, нүх сүв болгонд дурлан шигдсэн үнэхээр зэвүүн муухай амьтад байдаг аж. Энэ муухай амьтад булан тохойн завсар зай болгонд шигдэн үнэр шиншлэн олзоо тэсвэртэй хүлээж хэвтдэг байна.

Энэ усанд нялцгар том Голлум гэдэг амьтан амьдардаг ажээ. Хаанаас гаралтай ямар гээчийн амьтан гэдгийг хэн ч хэлж чадахгүй. Ганцхан нэр нь Голлум. Түнэр харанхуй шиг хар амьтан.

Нарийхан нүүрэн дээр нь хоёр бөөрөнхий нүд цэхэр толбо шиг тодорно. Голлум жижигхэн завин дээр суугаад нуураар чимээгүй гулсана. Хоббит өргөн, гүнзгий, мөс шиг хүйтэн

нууранд унасан байв. Голлум урт, нахилзуур гараараа ус самардан завиа залж явлаа.

Тэр мах идэх дуртай ажээ.Эргүүтэж төөрсөн гоблинг гэтэж байгаад бариад авах юм бол жигтэйхэн баярладаг байна. Харин шууд ил дайрч чаддаггүй, эвгүйтвэл өөрөө тэдний хоол болж ч магад. Хэрвээ ямар нэг гоблин ганцаараа нуурын эрэг дээр зогсож байвал Голлум араас нь гэтэж очоод хоолойг нь шахдаг байна. Нуурын ёроолд нуугдсан тодорхойгүй аюул ослыг мэдрээд гоблинууд ийшээ бараг ирэхгүй.

Гоблинууд нэг удаа уулын гүн уруу хонгил ухаж байгаад нууранд тулжээ. Цаашаа явах газар байхгүй болохоор энэхүү мухар замыг гоблинууд зөнд нь орхижээ. Заримдаа Гоблинуудын Толгойлогч загас идмээр санагдсан үедээ өөрийнхөө гоблинуудаас нэг хоёрыг нь ийш нь явуулдаг байсан агаад загас болоод явуулсан загасчнаа хэзээ ч харахгүй хоцрох тохиолдол байдаг байлаа.

Голлум нуурын дунд гулгамтгай чулуун аралхан дээр оромж барьжээ. Тэр нуугдаж байгаад томруулагч шил шиг цэхэр бүлтрэх шахсан нүдээрээ Бильбог аль түрүүнээс хойш хараад байжээ. Гоблинтой адилгүй энэ амьтныг амсаж үзэх дур нь аль хэзээнээс хүрээд байсан байна.

Голлумын шуухитнан шивнэх сонсогдов.

- Сайхаан сайхан. Хонгор минь, гял...гялайлаа. Одоохон амттай сайхан хоол аманд уусах болно. Сайхаан сайхан. Голл-голл.

Энэ голл-голл гэдэг үгийг хэлэхдээ тэрээр олзоо бүтнээр нь залгичихсан юм шиг л түүний хоолой нь хоржигнох шиг боллоо. Энэ нялцгай муухай амьтныг Голлум гэдэг боловч тэр өөрийгөө “хонгор минь” гэж энхрийлэн нэрлэнэ,

Энэ зэвүүн муухай шуухитнахыг, харанхуйд өөрийг нь нэвт ширтэх нүдийг хараад хоббит зогтусав.

- Чи хэн бэ? гэж Бильбо хутгаа өмнөө бариад хашхирав.

-Хэн гэж? Хонгор минь л байна. Голлум чимээгүй ертөнцөд ярих хань байхгүй, ганцаараа өөрөө өөртэйгөө ярьж сурсан зангаараа шивгэнэлээ. Голлум саяхан хоолоо идээд цатгалан байсан учраас энэ үл мэдэх амьтантай ярьж хэн гэдгийг нь мэдэж аваад идэж болох юм уу, үгүй юу гэдгийг тогтоохоор иржээ.

- Намайг Бильбо Бэггинс гэдэг. Би одойнуудаасаа төөрчихөөд шидэт Гэндальфаа алдчихаад байна. Би хаана байна? Эндээс яаж гарахыг хэлж өгнө үү? Бильбо ийнхүү хэлэхэд хутгыг хараад зэвүүцсэн Голлум болгоомжлон,

- Бильбо чи, гартаа юу барьж байна? гэж асуулаа.



- Гондолинуудын эртний хэт хутга.

- Хурц уу? Хонгор минь яараад хэрэггүй. Жаахан сууя, жаахан харзная. Энэ оньсого шиг амьтны ярих хэлэхийг сонсьё. Бид оньсогонд ямар их дуртай гээч. Чи бас дуртай биз дээ. Алив оньсого таалцах уу? Надтай тэмцэлдээд үзэг.

Голлум заль гаргаж байлаа. Түүний эзэмшилд юу гээчийн амьтан ороод ирэв, шууд идэж болох уу эсвэл жаахан хүлээх үү? Таньж мэдэхийн тулд оньсого таалгах нь цаг авах сайн арга юм. Голлумд янз янзын амьтадтай оньсого таалцах шаардлага зөндөө гарч байжээ. Тэгэхдээ ингэж оньсого таалцаж байсан цаг аль дээр үед найз нөхдөөсөө салаагүй энэ уулын гүнд харанхуй уруу туугдаж хашигдаагүй байхад болж өнгөрсөн билээ.

- За, за. Бильбо бас л болгоомжлон түүний өмнө ямар амьтан байгааг, гоблинуудтай анд юмуу үгүй юу гэдгийг мэдэхийг хүсэж даруйхнаа зөвшөөрөв. Тэгээд толгойд нь юу ч орж ирэхгүй байсан тул,

- Эхлээрэй гэж хэллээ.

- Газраас ургадаг, модноос өндөр, үүлэнд тулсан, үлэмж аварга.

- Амархнаас амархан. Уул, тийм үү? гэж Бильбо баярлан хэллээ.

- Дэндүү хур-рр-дан таачихлаа. Хонгор минь ахиад тэмц-цц-цэ. Хэрвээ таахгүй бол би чамайг иднэ. Хэрвээ хонгор би хариулж чадахгүй бол чи эндээс явж болно. Бид бүр за-за-замыг нь заагаад өгнө. Тийм ээ, хонгор минь?

Бильбо татгалзахаасаа айн за, за гэж зөвшөөрөөд хамгийн түрүүнд толгойд орсон нэг оньсогыг хэллээ.

Улаан уулан дээр

Цагаан морьд

Зажилна, хивнэ

Зам мөр гаргана

Цөм дуугүй зогсоно.

-Ямар амархан оньсого вэ, чамайг идэх гэж байхад олигтойхон оньсого хэлэх ёстой биш үү?
Өө, зөөлхөн самар байна. Шүд. Шүд Голлум зургаан шүдтэй гэж дуугүй инээдэндээ чичрэн хэллээ. Тэгээд Голлум хоёр дахь оньсогоо таалгав.

Хоолойгүй ч дуулдаг

Хос далавчгүй ч нисдэг

Шүдгүй ч хаздаг

Амгүй ч ярьдаг

- Одоохон, одоохон гэж Бильбо хашхирав. Тэр Голлумын зургаан шүдтэй заваан амнаас нүдээ салгаж чадахгүй байлаа. Энэ заваан ам бодлыг нь сарниулаад байлаа. Аз болоход урьд нь иймэрхүү оньсого сонсож байсан санагдаад,

- Салхи, салхи гэж орилов.

Бильбо баярлан өөрийнхөө хүчинд итгээд, дараагийн оньсогыг өөрөө зохиохоор шийдлээ. Муухай зэвүүн амьтан тарчлаг гэж хорсон бодоод ингэж хэлэв.

Номин тэнгэрийн нүд

Ногоон газрын нүдтэй учрав

Энэ хоёр ижил гэж

Эхнийх нь хэлэхэд нөгөөх нь

Өндөр тэнгэрийнх биш ээ

Өргөн талынхаа, би гэжээ.

-Ш-шшш гэж Голлум могой мэт дуугарав. Тэр газар доор олон жил амьдарсан болохоор номин тэнгэр, ногоон газрыг таг мартжээ. Бильбо хожлоо гэж найдаж эхлэв. Харин Голлум он жилийг, ой тойндoo эргүүлэн эргүүлсээр голын эрэг дэх нүхэнд эмээтэйгээ амьдарч байсан үеэ саналаа.

- Анютагийн нүд гэдэг өдөр дэлбээгээ дэлгэдэг цэцэг, нар хоёр гэж хэллээ. Урьдын

амьдралын тухай дурсамж нь Голлумын толгойд эргэлдсээр байлаа. Энэ үедээ тэрээр тийм их ганцаардсан, дургүй хүргэм зэвүүн биш, бүгдээс нуугдан гүйх хэрэггүй байсан билээ. Гэнэт түүний санаа сэтгэл үймрэн өлсөж эхлэв. Голлум ээдрээтэй хэцүү оньсого таалгахаар шийдлээ.

Уулын гүнд, агуйд, гэрт

Урилгагүй зочин ирнэ

Хөндий, нуга ой тайгыг

Хөмрөн бүрхэн авна

Харагдахгүй, баригдахгүй, хөөгдөхгүй

Харин биднийг унтацгаа гэнэ.

Голлум дахиад л азгүйтэв. Бильбо бас иймэрхүү оньсого мэддэг байжээ. Тэр тусмаа оньсогын таавар түүнийг одоо ороон хүрээлж байгаа билээ.

Харанхуй гэж тэрээр бодох ч үгүй хэлээд тавьчихав. Тэгээд Голлумд сэхээ өгөлгүй шууд өөрийнхөө оньсогыг хэллээ.

Цутгамал авдранд хаалга ч үгүй, цоож ч үгүй

Цул алтан бөмбөлөг дотор нь нуугдана

Бильбо энэ оньсогыг тун амархан, зүгээр л хэцүү оньсого бодож олтлоо цаг хожих гэж хэлжээ. Харин Голлум бодоод байхаар нь тэрээр ихэд гайхжээ. Голлум тавгүйхэн шуухитнаж уурлан исгэрч, хоолой нь хоржигнон дуугарч байлаа.

Бильбо баярлан, яаруулан,

- За, хариул . Шуухитнаад, хоржигноод? Буцалж байгаа данх гэх гээ юу?

- Жаахан байз-зз-зз-на. Хонгор минь бодож байна аа.

- Боллоо, боллоо. За таагаарай.

Голлум аль дээр үед нэг шувууны үүр ухаж эмээдээ түүхий өндөг сорохыг зааж өгч байснаа саналаа.

- Өндөг, өндөг гэж Голлум шуухитнав. Тэгээд өөрийнхөө оньсогыг хэллээ.

Амьсгалахгүй ч амьд

Амьгүй юм шиг хүйтэн

Ус уухгүй ч цангахгүй

Үг хэлэхгүй ч нүд цавчихгүй

Голлум яарсандаа маш хөнгөхөн оньсого хэлчихлээ гэж хэлсэн хойноо харамсав. Хариуг нь өөрөө мэдэж байгаа болохоор түүнд амархан санагдана. Тэгээд ч өндгийг таах гэж зовсондоо түүний толгойд хэцүүхэн оньсого орж ирсэнгүй. Харин хөөрхий Бильбод үүнийг таах амаргүй байлаа. Хоббит уснаас айдаг, зайлсхийдэг. Мэдээжээр, гэртээ тохитойхон буйдан дээрээ суугаад хэн ч чамайг идэх гэж заналхийхгүй үед ийм оньсогыг нүд ирмэхийн зуур таачихна шүү дээ. Бильбо хоолойгоо засаж ханиалгаж хүртэл үзсэн ч толгойд нь юу ч орж ирсэнгүй. Голлум сэргэж сэтгэл хангалуун исгэрч,

- Хонгор минь, мөн сайхан аа. Энэ амьтан ямар амттай бол? Шим шүүс-сс-тэй? Эсвэл шаржигнасан сайхан амттай болов уу?

Түүний нүд нь харанхуйд гялалзана.

- Жаахан, жаахан хүлээ. Би чамд бодох хугацаа өгсөн шүү дээ гэж Бильбо шулганав.

- Түргэл, түргэл. За боллоо, боллоо гэж Голлум бүр завинаасаа бууж эрэг дээр Бильбогийн хажууд ойртохоор завдан аалзных шиг урт гараа сунгатал уснаас айж цочсон загас үсрэн гарч Бильбогийн яг хөлийн хажууд унав.

-Өө, амьгүй юм шиг хүйтэн. Хариу толгой уруу нь гялсхийн орлоо.

- Загас, загас. Бильбо баярлан хашхирав.

Голлум урвайн эргээд завь уруугаа сунав. Харин Бильбо бас л хугацаа алдахгүйг хичээн шууд зохион дараах оньсогыг хэллээ.

Хөлгүй нь хэвтэнэ

Хоёр хөлтэй нь сууна

Дөрвөн хөлтэй нь

Яс мэрдэ.

Сайн оньсого болсонгүй. Голлум сая хөлгүй загасны тухай оньсого таалгасан болохоор шууд,

- Хөлгүй нь загас, хоёр хөлтэй нь хүн, дөрвөн хөлтэй нь муур загасны яс мэрдэ байна гэлээ.

Одоо Голлумын ээлж боллоо. Тэр үнэхээр хэцүү оньсого таалгахаар,

Оргүй алга болно, юм бүхэн

Орон гэр, хот тосгодыг ч залгина

Цэцэг, навч, мод, чулуу

Цэнгэг ус, зам гүүрийг ч устгана

Дэлхийн эзэд түүнд сөгдөнө

Дээд хаан, доод ардыг ч захирна.

Хөөрхий Бильбо харанхуйд бөртийн суугаад, үлгэрийн аварга амьтад, хүн иддэг махчин бүгдийг санаандаа дүрслэн бодоод, тэдний аль нь ч нэг дор тийм аймаар үйлдэл хийж түйвээж чадахгүй дээ, гэсэн шүү юм бодож байв. Энэ ер нь аймшигтай амьтны тухай биш болов уу? Хариу нь нэг ойрхон санагдаад байвч айдас хүйдэс бодох, сэтгэхэд нь саад болоод байлаа. Голлум дахиад завинаасаа гарахаар завдав. Голлум ус уруу үсэрч эрэг өөд бэдрэх нь тэр. Нүд нь бүлтийн ойртоод ирлээ. Бильбо хэл нь хөшиж, хатан хоолойдоо наалдчихав. Хөөрхий Бильбо орилж эхлэв.

- Надад цаг хугацаа өгөөч. Цаг, цаг ...

- Цаг, цаг.

Ингэж Бильбог тохиолдол аварлаа. Энэ үг оньсогын таавар байлаа.

Энэ удаа Голлум бүр гонсойчихов. Түүний тэсвэр алдагдан тоглоом хэтэрч, уур уцаарыг нь хөдөлгөж эхэллээ. Голлум өлсөж байсан учраас завь уруугаа ч буцсангүй Бильбогийн хажууд суучихав. Хоббит айж чичрүүдэс нь хүрч юм сэтгэхээ ч болив.

- Одоохон, одоохон. Хонгор минь. Сүүлчийн удаа таалга, сүүлчийн удаа шүү гэж Голлум чихран хэллээ.

Харин Бильбо ховдоглон тэмтрэх хүйтэн муухай амьтан хажууд сууж байхад юун юм бодох. Хоббит өөрийгөө чимхэж, маажиж арьсаа татаж, чангааж хүртэл үзэв. Толгойд нь юу ч орж ирсэнгүй.

- Сүүлчийн удаа асуу, асуу гэж Голлум шавдуулав.

Бильбо өөрийгөө чимхээд зогссонгүй, цээжээ дэлдэн, хажуу хавиргаа нүдтэл гэнэт гарт нь хэт хутга дайралдав. Нөгөө гарт нь хармаандаа шургуулаад мартаж орхисон бөгж тэмтрэгдэв.

- Миний хармаанд юу байна? Бильбо өөрөө өөрөөсөө ийнхүү асуув. Харин Голлум үүнийг нь дараачийн оньсого гэж бодоод,

- Өө заль, зальдаж байна. Хонгор минь хэл дээ, түүний хармаанд юу байгааг асууна гэдэг заль, намайг залилж байна?

Бильбо түүнд аз таарсныг ойлгомогцоо,

- Миний хармаанд юу байна? гэж чанга тод хэллээ.

- За, за. Хонгор минь гурван удаа азаа үзэг, гурав дахь удаадаа таах байлгүй гэж Голлум мушгиралдав.

- За, за таа, таа гэж Бильбо зөвшөөрөв.

- Гар.

- Үгүй ээ. Бильбо гараа хармаанаасаа суга татаж аваад,

- За хоёр дахиа хэл.

- За, за. Голлум өөрийнхөө хармаанд юу байдгийг санаж эхлэв. Загасны яс, гоблины шүд, нойтон хавч, сарьсан багваахайн далавчны тасархай, соёо ирлэх чулууны хэлтэрхий гээд л элдэв дээдийн хог новш байдаг. Тэгээд бусад амьтад хармаандаа юу чихэж явдгийг бодож эхэллээ.

- Хутга.

- Биш ээ, биш. За, сүүлчийн удаа хэл. Бильбо баярлана.

Санаандгүй энэ асуулт өндөгний тухай оньсогоноос хэцүү байлаа. Голлум шуухитнан шүлсээ хаян, хойшоо урагшаа савчин эвхрэлдэн мунгинав. Сүүлчийн удаа таавраа хэлэх юм чинь тэрээр шийдэж чадахгүй байлаа.

- За, за хурдал. Бильбо түүнийг яаруулна. Хоббит зориг орж сэргэлэн шийдэмгий царай гаргасан боловч энэ оньсого таалгах тоглоом юугаар төгсөхийг мэдэхгүй болохоор дотроо жаахан айж байлаа. Голлум таах уу, үгүй юу мэдэхгүй, гэхдээ л тэр яаж ч магадгүй.

- За, цаг дууслаа.

- Олс, эсвэл юу ч байхгүй гэж хоёр хариу буруу боловч Голлум дэмий гонгинов.

- Үгүй, үгүй. Бильбо тайвширсхийн уулга алдаад үсрэн босож хананд нуруугаа наан өмнөө хутгаа бэлэн барин зогсов. Оньсого таалцах тоглоом бол эртний үеэс ариун шударга байхын үлгэр жишээ, хамгийн зальт муу амьтан ч хэлэлцсэн хэлцээ, товлосон товллоогоо эвддэггүйг Бильбо хэдий мэдэх боловч энэ улцгар амьтнаас болгоомжлохгүй бол болохгүй байлаа. Голлум дараачийн хоромд юу ч хийж мэдэх байлаа. Тэгээд ч сүүлчийн асуулт хуучны дүрмээр бол жинхэнэ оньсого биш юм чинь.

Ямар ч гэсэн Голлум дайрах гэсэнгүй. Голлум Бильбогийн гарт байгаа хутгыг хараад чимээгүй чичрэн сууж байлаа. Бильбо хүлээж ядаад хашхирав.

- Амласнаа биелүүлээч. Зам зааж өгөөч.

- Юу амлалаа? Хонгор минь. Энэ муу Бэггинсэд зам зааж өгөх үү? Магад-гүй, ма- га- гад-гүй.

- Хонгор минь түүний хармаанд юу байгаа юм бэ? Олс биш? Биш ээ. Юу ч байхгүй юм уу?

Үгүй ээ? Ямар нэг юм байна? Юу байж таарах вэ? Голл-голл.

- Чамд хамаагүй. Амласнаа л биелүүл. Бильбо үгийг нь таслан ийнхүү хашхирав.

- Өө, ямар ууртай амьтан бэ? Тэвчээргүй нөхөр байх нь, хонгор минь. Хүлээж байг. Бид яарахгүй, тийм ээ хонгор минь. Эхлээд хамгийн чухал юмаа авъя. Тэр чухал юм маань бидэнд тусална.

- За хурдан, хурдан. Бильбо Голлумаас салж амрах нь гэж бодоод түргэхэн зөвшөөрөв.

Бильбо түүнийг эргэж ирэхгүй зугтааж байна гэж боджээ. Энэ Голлум юу яриад байна аа? Энэ заваан нуурын ёроолд ямар юмных нь чухал юм байдаг билээ? Хоббитын энэ бодол буруу байлаа. Голлум харин чиг яг буцаж ирэхээр товлосон. Бас тэгээд Голлум аймаар өлсгөлөн нүгэлтэй ууртай байгаа юм чинь өөдгүй өрөвдмөөр боловч хорлонт амьтны толгойд аймшигт төлөвлөгөө төрсөн байлаа.

Эндээс тун ч холгүйхэн Бильбо мэдэхгүй болохоос нэгэн жижигхэн арал оршиж байлаа. Тэнд нууц нүхэндээ Голлум идэх юмныхаа хаягдал мэрэгдлээс гадна хамгийн сайхан, хамгийн шилдэг нэгэн зүйлийг хадгалдаг байлаа. Энэ бол бөгж, алтан бөгж, үнэт бөгж юм.

Голлум бөгжөө авахаар зүгээр ч нэг ухасхийгээгүй юм. Энэ бөгж энгийн биш, шидэт бөгж байлаа. Тэр бөгжийг зүүсэн хэн боловч үзэгдэхгүй болдог байлаа. Зөвхөн дэндүү хурц нарны гэрэлд үл мэдэгдэм сүүдэр харагдах төдий болдог байв.

- Төрсөн өдрийн бэлэг. Хонгор минь. Голлум ийнхүү үглэнэ.

Энэ бөгж үнэхээр бэлэг байсан уу? Эрт дээр үед хийсэн бөгжийг Голлум яаж олж авсан бол? Энэ асуултанд магадгүй бөгжний эзэн ч хариулж чадахгүй байх аа. Эхний үед сонирхоод Голлум бөгжийг тайлахгүй зүүдэг байжээ. Дараа нь жижигхэн уутанд хийн хүзүүндээ зүүж яваад хүзүүгээ урчихжээ.

Одоо Голлум бөгжөө арал дээрээ чулууны завсар хадгалдаг болсон бөгөөд үнэт зүйлээ байсан газартаа байна уу, үгүй юу гэж зогсолтгүй эргэж очиж үздэг болжээ. Голлум бөгжнөөсөө удаан салах дургүй байжээ. Хааяа хааяахан бөгжөө зүүж үзнэ. Ялангуяа, загас идсээр уйдаад, мах идмээр санагдсан үедээ бөгжөө зүүнэ. Бөгжөө зүүгээд хэнд ч харагдахгүй болж аваад газрын харанхуй хонгилоор өгсөн, гоблингийн анд явдаг байжээ. Заримдаа бүр бамбар хурц тод гэрэлтсэн агуй уруу ч шагайдаг байна. Гэрэл нүдийг нь хорсгож Голлум өвдөхдөө нүдээ аньдаг боловч, айхгүй тайван байдаг байлаа. Юундаа ч айх билээ дээ. Нэг ч гоблин түүнийг харж чадахгүй бөгөөд хэрцгий хуруунууд хоолойг нь шахаж эхэлтэл мэдрэх ч үгүй юм чинь. Хэдхэн цагийн өмнө Голлум нэг жижигхэн гоблинг ингэж барьсан билээ. Хөөрхий ямар их орилсон гээч. Харамсалтай нь түүнээс хоёрхон яс үлдсэн. Голлум зөөлхөн амттай мах идмээр байлаа.

- Ямар ч аюулгүй болно. Тийм ээ, хонгор минь. Энэ муу амьтан биднийг харж чадахгүй. Харж чадахгүй ээ. Үүний хорсолт хутга биднийг ялгаж чадахгүй. Ёстой аюулгүй болно доо. Голлум ийнхүү үглэнэ. Голлум Бильбог ганцааранг нь орхиод завь уруугаа явж байхдаа ийнхүү

заналхийлэн бодож явлаа. Бильбо энэ улцгар амьтныг дахиад хэзээ ч харахгүй гэж итгэж хоцров. Гэхдээ жаахан хүлээзнэсхийлээ. Энэ хөнөөлт газраас өөрөө бол яагаад ч гарч чадахгүй юм чинь.

Гэнэт хамаг бие арзасхийлгэсэн, хатгуулсан мэт аймаар муухай чарлах сонсогдов. Харанхуйд Голлум орилж хараал зүхэл болж байлаа. Тэр бөгжөө эрэн жижигхэн арлынхаа хавцал, завсар болгоныг ухаж төнхөж арай л эргүүлж сэгсэрсэнгүй.

- Хаашаа орчихов оо? Хаана, хаана? Алга болчихож, хонгор минь. Алга болчихож. Ямар гай дайрах нь энэ вэ? Голлум ийнхүү орилоход Бильбо,

- Юу болов оо? Юугаа гээчихээ вэ гэж хашхирав.

- Битгий асуугаад бай. Миний хэрэгт бүү оролц. Алга болчихож. Гээгдчихэж, голл-голл.

- Би ч гэсэн гээгдчихсэн. Бильбо уурлан,

- Би тэглээ гээд бүр алга болохыг хүсэхгүй л байна шүү дээ. Би хожсон шүү дээ. Амласнаа биелүүлээч. Нааш ир. Намайг эндээс гаргаж өгчихөөд дараа нь юу дуртайгаа эрээч.

Голлум юмаа гээчихээд орилж чарлан гашуудаж байхад Бильбо түүнийг хумсын чинээ ч өрөвдсөнгүй. Тэгээд Голлум гээгдсэн юмаа олчихвол түүнд аюултай ч юм билүү?

- Нааш ир. Бильбо шаардав.

- Үгүй ээ, үгүй, хүлээж байг, тийм ээ хонгор минь. Голл-голл. Дахиад жаахан эрье, нэг тийшээ өнхөрчихсөн байх. Голл-голл.

- Чи хожигдсон шүү дээ, сүүлчийн асуултанд хариулаагүй. Хуурвал тоглоомын дүрэм зөрчлөө гэсэн үг шүү дээ. Бильбо бууж өгөлгүй ийнхүү шаардлаа.

- Асуулт аа? Чи өөрөө дүрэм зөрчсөн гэж Голлум өрвөсхийснээ,

- Чиний хармаанд ер нь юу байгаа юм? Чи эхлээд хэлээтэх гэв.

Бильбо Голлумд хэлчих байсан байж магадгүй. Голлум яагаад ингэж сандарч эрэл болж заль зохиогоод байгаа юм бол. Голлумын энэ сандчаан Бильбогийн уур уцаарыг хүргэж байлаа. Ямар ч гэсэн тэр хожсон шүү дээ. Жаахан төөрөгдүүлсэн нь үнэн, тэгэлгүй ч яах вэ дээ. Амь наана там цаана болж байхад чинь.

- Би асуусан, чи хариулсан гэж Бильбо зөрүүдлэв.

- Шударга биш байна. Асуултыг таалгадаггүй, асуудаг шүү дээ, хонгор минь. Голлум бууж өгсөнгүй.

- Зүйтэй. Би чамаас асууж байна шүү дээ. Чи юугаа гээчихсэн юм бэ? Хариулаач.

- Хармаанд чинь юу байгааг хэлээч. Бильбогийн яг чихэн дээр түүний дуу хадав.

Бильбо сэртэсхийн харснаа хөшиж орхив. Түүнийг гэрэл цацарсан хоёр цэг цоо ширтэж байлаа. Тэр хоёр цэг халан тэлж харанхуйд хоёр хурц цагираг болон аслаа.

- Юугаа гээчихсэн юм? Бильбо айснаа нуун зөрүүдлэн асуулаа.

Голлумын нүд ногоорон асч хоббитын биен дээгүүр гүйж эхэллээ. Голлумын завь эрэг өөд хар хурдаараа нисэж байлаа. Гээгдсэн бөгж, гэнэтийн сэжиг түүний хилэнг хөдөлгөж, түүнд ямар ч хутга мутга аймшигтай биш байлаа.

Энэ муухай амьтан гэнэт юундаа ингэж хилэгнэснийг Бильбо ойлгоогүй боловч өөрийг нь урж тасдахад бэлэн байгааг ухаарлаа. Бильбо үсрэн босч эргээд хонгилын зүг гүйлээ. Бильбо хананд наалдан зүүн гараараа тэмтчин дахиад л доош гулсаж гарлаа. Ард нь Голлум,

- Үүний хармаанд юу байна?

- Үнэхээр миний хармаанд тийм чухал юу байдаг билээ? Бильбо өөрөөсөө ингэж асуув.

Амьсгаадан бүдчин гүйж явахдаа Бильбо гараа хармаандаа шургуултал хүйтэн бөгж хуруунд нь орохыг мэдрэв.

Яг ард нь шуухитнав. Бильбо эргэж хартал Голлумын хоёр ногоон сар мэт нүд анивчин байхыг олж үзлээ. Айж цочирдсон Бильбо урагш ухасхийгээд үндсэнд тээглэн хутгаа тэврэн хүйтэн чулуун шалан дээр тэрийн унав.

Тэр хоромд Голлум түүнийг гүйцэж ирэв. Гэхдээ Бильбо хөдөлж хутгаа шүүрч авахаас өмнө Голлум ямар ч хоббит ерөөсөө байхгүй юм шиг хажуугаар нь хараал зүхэл болон гүйж өнгөрлөө.

- Энэ чинь юу гэсэн үг вэ? Голлум харанхуйд маш сайн хардаг. Тэр ч байтугай хажуугаар нь өнгөрсөн Голлумын хойноос харахад, хонгилын ханан дээгүүр гулгах хурц нүдний туяа хоббитод үзэгдэж байгаа юм чинь. Бильбо өвдсөндөө үрчийн ярвайн босоод, аажуудаа халж эхэлж байгаа хутгаа хэтэнд нь засаж хийгээд, Голлумын араас гүйв. Өөр арга зам байсангүй. Аюултай нуур тийш буцалтай биш. Голлумын араас урагшаа явсан нь дээр. Голлум өөрөө мэдэлгүй түүнийг гадагш гаргачих ч юм билүү.

- Зэвхий. Зэвхий. Зэвхий. Зэвхий Бэггинс. Миний юм алга болчихсон. Түүний хармаанд юу байгаа юм бэ? Оо, би мэдлээ. Хонгор минь, бид хоёр тааварлаж байна. Яг, яг шүү. Энэ муу миний төрсөн өдрийн бэлгийг олчихжээ. Аа, энэ олоод авчихжээ.

Бильбо сайн чагнав. Эцэст нь Бильбо учрыг нь ойлгох шиг боллоо. Бильбо урагш алхан Голлумд бараг тулж ирэв. Голлум эргэн тойрноо нэвт шувт ширтэн хонгилын гүн тийш урагшаа алхаж байлаа.

- Төрсөн өдрийн бэлэг. Ээ гай, гай. Хонгор минь хоёулаа үнэхээр түүнийгээ алдлаа гэж үү? Яахаараа ингэдэг билээ? Ойлголоо, ойлголоо. Тэр муу чарлаа турсагыг чирч явахад ойчоод

өнхөрчихөж дээ. Хичнээн жил үнэнч шударгаар хань болсон билээ, гэтэл одоо биднийг хаяад өнхрөөд явчихлаа гэж үү? Үгүй ээ, түүнийг минь хулгайлчихаж. Голл-голл. Голлум ийнхүү энгэнэн уйлагнав.

Гэнэт газар савж ойчоод, эхэр татан уйлж гарлаа. Голлумын ийнхүү чарлахыг сонсоход зэвүүн муухай байлаа. Бильбо хонгилын хананд наалдан хөшин зогсоно. Голлум жаахан тайтгарав. Тэгснээ дахиад л гэвтнөж гарав.

- Хаана гэж эрэх вэ? Хаагуур хаагуур явснаа яаж бүгдийг санах юм бэ? Тэр гээгдээгүй байхаа. Энэ муу Бэггинсийн хармаанд байх нь. Энэ муу амьтан олоод авчихаж. Биднийг хуурч чадахгүй дээ. Голлум ингэж өөрөө өөртэйгөө яриад,

- Хонгор минь, одоо бид ойлголоо. Энэ муу хулгайчийг барьж аваад хоолойг нь шахаж, хармааг нь нэгжье. Энэ бэлэг ямар ид шидтэйг тэр муу мэдэхгүй зүгээр л хармаалаад явж байгаа. Тэр муу хол яваагүй дээ, зам мэдэхгүй юм чинь. Өөрөө хэлсэн. Гэхдээ зальтай. Асуулт асуучихаад, хармаандаа юу байгааг хэлээгүй. Ээ, түүнд итгэж болохгүй. Тэр муу орох хаалга олсон юм чинь гарах хаалга олно шүү. Аа-ан, зөв зөв. Тэр муу арын хаалга уруу гүйж яваа. Яваг, яваг. Тэнд түүнийг гоблинууд бариад авна, ха ха. Хонгор минь тэр муу тэр замаар зугтаж чадахгүй. Аа ха ха, гоблинууд.

Хэрвээ гоблинууд түүнээс манай бэлгийг булааж аваад яаж чаддагийг нь мэдчихвэл яана аа. Тэгвэл бид хэзээ ч амар амгалан байж чадахгүй болно шүү. Хэзээ ч. Гоблинууд түүнийг зүүгээд харагдахгүй болчихно. Гоблин хажууд ирнэ, бид харахгүй, харж чадахгүй болно. Миний хурц нүд ч харж чадахгүй болно. Гоблинууд гэтэж ирээд бариад авна. Голл-голл. Хонгор минь бодох цаг алга. Яарах хэрэгтэй. Бэггинс тийшээ гүйсэн, бид хойноос нь харайя. Хурдал, хурдал.

Голлум сарвуун дээрээ тулж байгаад мэлхий мэт үсрэн урагш алхав. Бильбо ч араас нь чимээ гаргахгүй дагалаа. Хамгийн гол нь дахиад түүнийг мөргөж өөрийгөө илчлэхгүй байх. Гайхах, айх, сандрах, итгэл энэ бүхэн түүний толгойд багтаж ядна. Түүний олсон бөгж шидэт бөгж байх нь ээ. Энэ бөгжийг зүүхээр үзэгдэж харагдахгүй болдог байх нь. Хуучны үлгэр домогт ийм ид шидэт бөгж гарах нь зөндөө боловч энэ шидэт зүйл ингээд зүгээр хөл доор хэвтэж байна гэхэд нэн итгэмээргүй. Гэхдээ аргагүй үнэн. Голлум түүнийг харалгүй хажуугаар нь өнгөрөөд явчихсан шүү дээ.

Голлум уурлаж, уухилан урд нь алхаж байхад Бильбо араас нь зөвхөн хоббитууд л чадах маш чимээгүйгээр гэтэж явлаа. Удалгүй тэд хонгил хоёр салаалсан, Бильбо нуурын зүг эргэсэн тэр газар хүрээд ирлээ. Голлум гарц болгоныг тоолон хонгилын гүн уруу орно.

-Нэг нь ийшээ, зүүн тийшээ. Нөгөөх нь тийшээ, баруун тийшээ. Хоёр нь дахиад баруун тийшээ. Хоёр нь зүүн тийшээ...

Голлум цаашлах тусмаа удааширч хөлөө зөөж ядан итгэлгүй алхах боллоо. Голлум тал талаас нь түшиж байдаг уснаасаа холдох тусмаа дотор нь айдас төрнө. Гоблинууд хаанаас ч гараад ирэх боломжтой бөгөөд аврагч бөгж алдагдсан шүү дээ. Эцэст нь зүүн тийшээ дахин эргээд дугуй хаалганы өмнө очиж зогсов.

-Долоо дахь баруун талд. Тийм тийм. Зургаа дахь зүүн талд. Тийм тийм. Энэ энд. За тэр гарц энд байна. Голлум толгойгоо нүхэнд шургуулж харснаа гуйваад,

- Өө, хонгор минь тийшээ болохгүй. Аюултай. Тэнд гоблинууд байгаа. Үй түмэн гоблинууд байгаа. Бид үнэрээр нь мэдэж байна. За, одоо яах вэ? Тэд хоосон хоцрог. Жаахан сууя. Хүлээе хө, хонгор минь.

Ямар тэнэглэл вэ. Голлум түүнийг гарц дээр авчирсан боловч Бильбо гарч чадахгүй зогсоно.

Гүвтнэсэн улцгар амьтан гарцны үүдэн дээр том толгойгоо данхалзуулан нүдээ гялалзуулан сууна.

Бильбо яг л хулгана шиг чимээгүйгээр хана даган гүйчихэв. Голлум цочин өндөсхийн үнэртэн шиншилж нүд нь ногооноор гэрэлтлээ. Голлум аяархан заналтай исгэрэв. Тэр хоббитыг харахгүй байгаа боловч болгоомжлон сэртхийж, харанхуйд үнэрлэх, сонор соргог нь улам хурц мэдрэмжтэй болсон байлаа. Голлум өргөн савраараа газар тулан хэвтэв. Чулуун шаланд хамраараа шүргэх шахан нүдээ анин чимээгүй болов. Бильбо түүний хар дүрсийг арайхийн харж байгаа боловч Голлум татсан нум шиг хөвчрөн ямар ч хоромд чивчрэн үсрэхэд бэлэн байгааг мэдэрч байлаа. Бильбо амьсгаагаа хураан хөшиж цөхрөнгөө баран зогсож байлаа.

Одоохон хүч чадал байгаа дээр энэ үхээрийн хар харанхуй хонгилоос заавал гарах ёстой. Бууж өгч яасан ч болохгүй. Энэ муухай амьтан түүнийг алахаас өмнө Бильбо өөрөө түүнийг хутгалах ёстой. Үгүй, энэ шударга бус болно. Бильбо харагдаж үзэгдэхгүй, Голлум зэвсэггүй, тэгээд ч түүнийг алах гэж одоохондоо оролдоогүй байна.

Энэ Голлум аз жаргалгүй, ганцаардмал, бүгдэд хөөгдөж туугдсан амьтан. Бильбо өрөвдсөндөө зүрх нь зүсэгдэх шиг болов. Сайн сайхан амьдрах ямар ч найдваргүй уйтгар гунигт ганцаардмал өдрүүдийг Голлум яаж өнгөрөөдөг бол оо. Үг хэлгүй хад чулуу, түүхий загас, өөрөө өөртэйгөө ярьсан үл ойлгогдох гөвтнөө үүнээс өөр юмгүй Голлумын амьдралыг бодонгуутаа Бильбо жихүүцэх мэт хамаг бие нь ирвэгнэв. Бильбо гэнэт санаа аван үсэрч орхилоо.

Ийм харанхуйд зөвхөн хоббит л ингэж өндөр, ийм сүртэй сайхан үсэрч чадах байхаа. Бильбо Голлумын толгой дээгүүр сүнгэнэн үсэрлээ. Ямар мундаг үсэрсэн гэж бодно. Өндрөөшөө нэг метр уртаашаа хоёр метр үсэрсэн шүү. Хэрвээ дахиад жаахан өндөр үсэрсэн бол чулуун таазанд толгойгоо бутлах байсан биз ээ.

Голлум сөрвөлзөн босч дээгүүр нь сүнгэнэн өнгөрч байгаа хоббитыг барьж авах гэсэн боловч чадсангүй хоосон агаар базлан үлдэв. Бильбо чийрэг хоёр хөл дээрээ тапхийтэл газардаад цааш гүйлээ. Голлум араас нь хөөж байна уу, үгүй юу гэдгийг харах ч сөгөөгүй Бильбо хар хурдаараа гүйж байхдаа ард нь амьсгаадан шал пал дуугаран хөөж байгааг сонслоо. Гэхдээ дуу чимээ удалгүй намдав.

Гэнэт Бильбод судсан дахь цус царцам аймшигтай хилэнтэйгээр орилох сонсогдлоо. Голлум хожигдсоноо ухаарчээ. Тэр цаашаа гүйхээс айж байлаа. Голлум бүгдийг алджээ. Тэр олзоо,

дээр нь цорын ганц хамгийн үнэт эрдэнээ алджээ. Голлумын чарлах дуунаас Бильбогийн зүрх хагарчих шахаж байсан ч тэрээр цаашаа гүйсээр байв. Түүний араас хонгилын гүнээс хилэн хорслоор дүүрэн цуурай мэт дуу гарсаар хоцров.

- Хул-хулгайч. Хулл-лл-гайч. Хулгайч Бэггинс. Хараал идмэр. Хараал идмэр, насаараа хараал ид,

Тэгснээ таг чиг чимээгүй боллоо. Энэ аниргүй байдал заналхийлэх мэт.

Хэрвээ Голлум гоблинуудыг мэдэрч байгаа бол тэд, энд ойрхон байгаа гэж Бильбо бодов. Хөлийн чимээ дуулчихаж магад, ихэд болгоомжтой байхгүй бол замынхаа төгсгөлд үхчихнэ шүү.

Бүдүүлэг хийцийн чулуун ханатай хонгил намхан нарийхан болж байлаа. Хоббитод бол хонгил тийм ч бачуу биш боловч тэвдсэндээ тэрээр хэд хэдэн удаа бүдэрч чулуун шалны өргөр сөргөрт хөлөө цохисоор явлаа.

Энэ гоблинуудад намдах газар байна гэж Бильбо бодлоо. Бильбо энэ газар доорх хонгилд амьдрагч гоблинууд дөрвөн хөллөн гүйж чаддагийг мэдэхгүй байлаа.

Удалгүй уруудсан зам дуусаж, хонгил улам дээшлэн дээшлэн өгсүүр болов. Өөдөөгөө Бильбо тийм сайн гүйж чадахгүй. Өгсүүр зам төгсөж булан тойроод хонгил дахин уруудав. Бильбо дараагийн булан хүртэл гүйв. Хонгилын үзүүрт бүдэгхэн гэрэл үзэгдэв. Түүдэг гал юм уу, бамбарын гэрлээс гардаг улаан туяа биш жинхэнэ өдрийн гэрлийн туяа үзэгдэж байлаа. Бильбо алхаагаа хурдасгав. Бильбо хар хурдаараа гүйсээр дахин нэг булан тойрч өнгөрөөд түүнд санагдсанаар нар мэлтийтэл туссан задгай талбай дээр гарч ирлээ. Газар доорх түнэр харанхуйгаас гарч ирсэн болохоор Бильбо андуурчээ. Энэ нь дэлгээтэй байгаа том чулуун хаалгаар туссан гэрлийн өргөн зурвас ажээ.

Бильбо нүдээ нээтэл өмнө нь гоблинууд харагдах нь тэр. Гоблинууд яг хаалганы хажууд илдээ сугалчихсан, хөөрхий хоббитыг хүлээж байсан мэт чимээ чагнан, сонор соргог сууцгааж байлаа. Бильбо гоблинуудыг харахаас өмнө тэд түүнийг харчихлаа. Гоблинууд түүнийг түрүүлээд харчихлаа. Түүний бөгж хуруундаа алга байв. Бөгж санаандгүй алга болчихов уу, эсвэл шинэ эзнээрээ хорлонт тохуу хийхээр шийдэв үү? Гоблинууд ялан дийлэгчийн сүр дуулиантайгаар хашхиралдан Бильбо уруу харайлдав.

Одоо Бильбо түрүүний Голлумын адил гэнэтийн алдаандаа гомдох, цөхрөхийг биеэрээ мэдэрлээ. Бильбо хутгаа шүүрч авахын оронд яагаад ч юм хармаануудаа ухаж гарлаа.

- Өө, ямар аз вэ. Бөгж зүүн хармаанд байж өөрөө шахуу хуруунд нь углагдлаа. Гайхсан гоблинууд зогтусацгаав. Тэд юу ч ойлгосонгүй. Бильбо сая энд байсан одоо алга. Дахиад л орилоон хашхираан болов. Гэхдээ энэ нь гайхаж цөхөрсөндөө чарласан дуу байлаа.

- Хаана байна? Зарим нь хашхирна.

- Буцаад хонгил уруу гүйчихэв үү? Зарим нь орилно.

- Наашаа, наашаа. Гурав дахь нь чарлана.

- Үгүй ээ, тийшээ. Дөрөв дэх нь чангаацалдана.

- Гадуур сайн эрцгээ. Гоблинуудын Толгойлогч архиран тушаалаа.

Гоблинууд харааж зүхэн зэр зэвсгээ хангинуулан ийшээ тийшээ гүйлдэв. Тэд нар мөргөлдөн унаж босон, сандралдан улам улмаар зэрлэгшин догширно. Зөвхөн орилох хашхирах, архирах, хахирах, ёолох л сонсогдоно.

Бильбо хэдийгээр айж хөдөлж чадахгүй зогсож байгаа ч түүнийг санамсаргүй бариад авчих, гишгээд хаячихаас өмнө амиа аврах ёстой гэдгийг ойлголоо. Бильбо хаалгач гоблинуудын сууж байсан том торхны араар гулгаж орлоо.

Үүд тийш дөхөх хэрэгтэй. Яаж ч байсан үүд уруу. Бильбо ингэж өөрийгөө шахаж байвч шийдэж чадахгүй зогсоно.

Яг нуугдаж тоглож байгаа юм шиг. Гэхдээ одоо бол амь наана там цаана тоглож байлаа. Энэ агуйгаар дүүрэн гоблинууд байх бөгөөд хөөрхий жижигхэн хоббит сарвайсан гарт баригдахгүй, хүнд хөлд гишгэгдэхгүй гэж наашаа цаашаа гүйнэ. Нэг гоблин түүнийг мөргөөд авснаа юу мөргөснөө ойлгосонгүй, ийш тийш сортолзов. Бильбо тэрийж унаад, Гоблины хөлийн дундуур мөлхөж гараад дахин босож хаалганы зүг харайлаа.

Хаалга нөгөө л янзаараа онгорхой байсан боловч нэг гоблин санаандгүй түлхэн хаачихав. Бильбо хаалгыг байдгаараа түлхсэн боловч онгойсонгүй. Тэр үлдсэн нарийхан завсраар шургаад гарах гэж оролдов. Гэтэл хагас бие нь ороод яг тээглээд зогсчихлоо. Аймшиг, ямар аймшиг вэ. Товчнууд нь хаалганы модонд тээглэн цаашаа ч үгүй, наашаа ч үгүй болов. Хаалганы нөгөө талд эрх чөлөө, аврал хайраас түүнийг өндөр уулсын дундуур жирийх нарийхан зөргийн хэдхэн гишгүүр зааглаж байгааг Бильбо харж амжлаа. Үүлний цаанаас нар хурцаар гэрэлтэнэ.

Гэтэл тэр хөдөлж ч чадахгүй. Ээ, гай гай. Гэнэт ард нь,

- Үүдэнд сүүдэр байна. Тэнд байна, тэнд.

Бильбогийн зүрх хагарчих шахлаа. Тэр байдаг хүчээрээ цааш зүтгэлээ. Товчнууд нь хэдэн тийшээ үсрэв. Хүрэм хантааз нь шархийн урагдана. Бильбо гадагш бултасхийн гараад ирлээ. Тэрээр чулуун гишгүүр дээгүүр янзага мэт дэгдэн одлоо. Мэл гайхсан гоблинууд эхлээд шалаар нэг тарсан зэс товчнуудыг түүхээр ухасхийцгээв.

Гоблинууд юу болсныг дорхноо ухааран, түүний араас хашхиран хөөлөө. Гэхдээ гоблинууд нарны гэрлээс айдаг, гэрэлд дургүй ажээ. Гоблинуудын хөл нь гуйвж, толгой нь эргэж эхэллээ. Харин үл үзэгдэх Бильбо моддын сүүдэр барьсхийн эргэж ч харалгүй гүйнэ. Удалгүй гоблинууд хоцорч үлдэв. Харааж зүхсээр тэд эргэж явлаа. Ингэж Бильбо аврагдлаа.

Зургадугаар бүлэг

Чонын амнаас гараад барын аманд

Ийнхүү Бильбо гоблинуудаас зугтаж амь гарсан хэдий ч одоо хаана байгаагаа мэдэхгүй байлаа. Түүнд юу ч байсангүй, малгайтай цамц, идэх уух юм, пони морь, товч, нөхөд ч үгүй хоцорчээ. Моддын урт сүүдэр зөргийг хөндөлдөн хучиж иртэл тэрээр таамгаар алхсаар байлаа. Бильбо орчин тойрноо эргэж харлаа. Нар баруунаа буужээ. Нар уулын цаагуур орж байв. Уулс аль хэдийнэ ард гарчээ. Хоббит урагш харан баярласандаа чичрэх шахан байлаа. Уулын эгц хэц толгойнууд, тэгш уужуу хөндий буюу моддын дундуур гэрэлтэн үзэгдэх ойн цоорхойнуудаар солигдлоо.

- Тэнгэр минь. Би Манант уулыг нэвтэлж нөгөө талд нь гарсан бололтой. Гэндальф, одойнууд хаана байгаа бол? Тэд гоблинуудад баригдчихаагүй байгаа даа.

Бильбо доошлон явсаар хэсэг уулын тэгш газрыг туулж гараад, тэр газрын ирмэг дээрээс дахин уруудлаа. Түүний толгойноос нөхөд минь хэцүүдэж байгаа байх гэсэн түгшүүрт бодол салсангүй. Шидэт бөгж зүүсэн тэр өөрөө бол аюулгүй байдалд байлаа. Нөхдөө эрэхийн тулд дахиад тэр зэвүүн харанхуй хонгил уруу буцдаг юм билүү? Айдсаа нуун, хоббит яг эргэж явахын даваан дээр хэн нэгний дуу сонсов.

Бильбо зогсон чагналаа. Үгүй ээ, гоблинууд биш шиг байна. Тэрээр болгоомжтой гэтэв. Түүний явж байсан уулын зөрөг зүүн талаасаа өндөр хадаар хашигджээ. Баруун талд нь бутас ургасан эгц хажуу газар цэлийж байлаа. Ойролцоох бутан дундаас яриа сонсогдоно.

Бильбо зөргийн ирмэг тийш мөлхөж очлоо. Гэнэт хоёр том хадан чулууны завсраар улаан малгай гялсхийв. Энэ бол харуулд зогсож байгаа Балинаас өөр хэн ч биш байв. Бильбо арай л алга ташин баярласандаа хашхирч орхисонгүй. Биеэ барилаа. Хүсэж хүлээлгээгүй, таатай бус уулзалт болохоос болгоомжлон одоохондоо бөгжөө аваагүй бөгөөд Балин түүнийг хоосон газар мэт нэвт ширтэж байгааг харав.

Одоо нэг сайхан тохуу хийгээтэхье хэмээн Бильбо бутан дундуур гэтэж явахдаа бодоод хөхрөв. Гэндальф одойнуудад нэг юм ярьж тайлбарлаж байлаа. Тэд газар доорх агуй хонгилуудаар явж төөрч, яаж гарч ирснээ ярьж цаашаагаа яах тухайгаа хэлэлцэж байв. Гэндальф одойнуудыг үглэн зэмлэж, Бильбо Бэггинсийг гоблинуудын гарт ингээд үлдээж болохгүй тухай ятгаж байлаа. Хэрвээ хоббит амьд бол түүнийг аврах ёстой гэнэ.

- Бильбо миний найз, тэгээд ч эрэлхэг, үнэнч. Би түүнийг ингээд орхичихож чадахгүй, та нарт ч түүнийг орхихыг зөвшөөрөхгүй.

- Ер нь түүнийг хэрэггүй авч гарч, биднийг дагаад яваад байж чадахгүй элдэв чирэгдэл болоод байх юм гэх мэтээр одойнууд Бильбогийн талаар шулганалдана. Гэндальф ч гэж Гэндальф. Нэртэйгээр нь өөр бүр инээдтэй амьтан олохгүй дээ.

- Одоо бол хоббитоос нэмэр биш нэмээс л гарч байна. Түүнээс болж тэр хараал идсэн хонгил

уруу дахиад орох гэж үү? Ёстой гайгүй байлгүй. Нэг одой ингэж хэлэх сонсдов. Гэндальф уурлан,

- Түүнийг би, бидэнтэй яваач гэж дуудсан. Би зүгээр нэг дэмий юм хийхгүй шүү дээ, үүнийг сайн тогтооцгоо. Та нар надад тусла, бүгдээрээ түүнийг эрцгээе, эсвэл би ганцаараа явж эрье, та нар үлдээд өөрсдөө цаашаа явцгаа. Би түүнийг олоод ирэхээр та нар хамгийн түрүүнд л баярлалаа гэнэ дээ. Дори, чи яагаад түүнийг орхиод зугтсан юм бэ?

- Би яаж ч чадаагүй. Гоблин намайг барьж аваад унагааж, өшиглөөд харанхуй уруу шидчихсэн юм чинь.

- Дараа нь чи яагаад түүнийг эрж олох гээгүй юм?

- Ээ, тэнгэр минь. Тэнд юу болж байсан гээч. Гоблинууд харанхуйд нүдэлдэж, цохилцож, хазалцаж, хэмнэлдэж нэг нэгийгээ өнхрүүлж нударгалцаж байсан шүү дээ!. Миний толгойг арай л тас цавчаагүй шүү. Дээр нь Торин Оркрисст сэлмээрээ тас тас цавчин саад болоод байсан. Гэнэт чи аянгын гэрлээрээ нүд гялбуулахад гоблинууд орилолдон тал тал тийшээ зугтсан. Миний араас гэж чамайг хашхирахад цөм чиний араас харайцгаасан биз дээ. Бид бүгдээрээ гүйлээ гэж бодсон. Тоолоод бүртгээд зогсох цаг ч байгаагүй. Үймээн дундуур бид дэлгээтэй хаалгаар, харуулын хажуугаар харайлдан гарч шууд наашаа зугтаа биз дээ. Ингээд бид энд ирчихээд байдаг, харин Түлхүүр-Чимхүүр алга байдаг.

Бильбо бутны цаанаас үсрэн гарч бөгжөө сугалаад,

- Түлхүүр-Чимхүүр би энд байна гэлээ.

Цөм үсрэн босоцгоолоо. Баярлаж гайхсан тэд зэрэг зэрэг хашхиралдав. Гэндальф бүхнээс илүү гайхаж, бүхнээс илүү баярласан биз ээ. Гэндальф Балиныг дуудан нүдний нь өмнүүр хаанаас хэн ч, юу ч гараад, ороод ирж болох харуул нэртэй мануухайн тухай юу бодож байгаагаа бүгдийг нь хэлжээ.

Энэ явдлаас хойш одойнууд хоббитыг хүндлэх болсон байна. Урьд нь одойнууд Бильбо бол бүгдээс илүү гэсэн Гандальфийн үгэнд итгэхгүй байсан юм. Түлхүүр-Чимхүүр үнэхээр мөн, хаалгыг түлхүүртэй мэт сайн онгойлгодог түүний авьяасанд хэн ч эргэлзэхгүй болов. Балин юу ч ойлгохгүй гайхаж, итгэж ядан байхад бусад одойнууд хоббитыг хурдан сэргэлэн гэж зөвшөөрцгөөв.

Бильбо магтаалд хайлах шахан байвч бөгжний тухай нэг ч үг хэлэхгүй гэж сэтгэлээ. Түүнээс яаж зугтаасан тухай асуухад тэрээр,

- Өө амархан. Маш болгоомжтой, харагдахгүй гэтсэн.

- Өөх, ямар сэргэлэн юм бэ? Миний хажуугаар харагдахгүйгээр хулгана ч өнгөрч чадахгүй дээ. Чамд малгайгаа аван мэхийе. Балин, таны мэдэлд. Балин ийнхүү Бэггинсэд мэхийхэд Бильбо ч,

- Бэггинс таны мэдэлд үнэнч гэж бөхөлзөн хариуллаа.

Дараа нь одойнууд Бильбогоос гээгдэж хоцорсны дараа юу болсныг асуулаа. Бильбо тавтайхан сууж, өөрт нь юу тохиолдсоныг бүгдийг ярьж өгөв. Ганцхан бөгжний тухай нэг ч үг цухуйлгасангүй, за дараа хэлье гэж шийджээ.

Одойнууд оньсого таалцсаныг сонсоод ихэд сонирхсон боловч Голлумын тухай яримагц айцгаав.

Голлум миний хажууд ирээд суухад толгой юу ч сэтгэхээ больж би зүгээр л миний хармаанд юу байна гээд хэлчихсэн. Голлум гурван удаа хэлээд таасангүй. Тэгэхэд нь би,

- Чи хожигдсон. Хэлсэн амандаа хүрч намайг эндээс гарга гэлээ. Харин Голлум над уруу дайрч намайг алах гэлээ. Би ч зугтаасан. Зугтааж байгаад гэнэт бүдэрч уналаа. Голлум харанхуйд намайг харалгүй хажуугаар өнгөрөөд гүйчихсэн. Би ч араас нь дагалаа. Тэр амандаа нэг юм үглээд байх юм. Намайг замаа өөрөө мэддэг гэж бодоод хаалга чиглэн гүйх нь тэр. Хаалганы дэргэд очоод суучихлаа. Би түүний толгой дээгүүр үсэрч гарсан. Тэгээд л зугтаачихсан...

- Харуул манаа. Хаалганы дэргэд харуул байгаагүй гэж үү? Одойнууд гайхан асуув.

- Зөндөө. Зөндөө. Би тэндээс бултаж зугтсан. Хаалганд хавчигдан гарч чадахгүй тээглэчихсэн. Бүх товчоо тасалсан. Гэхдээ л зугтаж бүгдийг давж гараад одоо энд сууж байна гэж Бильбо яриад өөрийнхөө урагдаж ханзарсан хувцсыг харлаа.

Одойнууд Бильбог харуул манаанаас яаж зугтсан, Голлумын толгойг яаж эргүүлсэн. Энэ бүгдийг шалмаг хурдан сэргэлэн амжуулсныг шагшин гайхаж барахгүй байв. Гэндальф инээмсэглэн,

- За тэр, би та нарт хэлсэн шүү дээ. Бильбо өөрийгөө үзүүлнэ гээ биз дээ.

Гэндальф ийнхүү хэлэхдээ саравчилсан өтгөн хөмсөгнийхөө доороос Бильбо уруу нэг л учиртай харлаа. Хоббит яриандаа нэг юм нууцлаад хэлээгүйг шидэт Гэндальф мэдчихэв үү дээ гэсэн бодол түүний толгойд гялсхийв.

Хоббит Гэндальфаас асуух юм зөндөө байлаа. Гэндальф одойнуудад тэднийг яаж газар доорх агуй хонгилоос аварч гаргасан, хаана ирээд байгааг тайлбарласан ч байж болох. Харин Бильбо энэ талаар мэдэхгүй байгаа шүү дээ.

Шидтэн яриандаа өөрийнхөө мэргэн цэцнийг хэлэх боломжийг ч алдсангүй. Элронд бид хоёр энэ ууланд хорлонт гоблинууд байдаг гэдгийг аль хэдийнээс мэдэж байсан гэж тэрээр Бильбод хүүрнээд,

-Гэхдээ урьд нь төв зам байсан тэр зүгт гол хаалга гарцтай байсан юм. Тэнд аяны улсыг отоход амар байжээ. Энэ зам эртнээс муу нэртэй болсон учраас гоблинууд түүнийг орхисон бололтой. Гоблинууд ууланд өөр зам гаргажээ. Харин одойнууд юу ч мэдэлгүй энэ замыг

аюулгүй гэж бодоод яг тэр замаар яваад ирсэн байна.

Өөр аюул багатай зам олоогүй юм чинь амь өрсөн тэмцэхээс өөр аргагүй болсон доо. Тэгээгүй бол бид энэ уулыг давж чадахгүй байхсан гэж Гэндалф ярилаа.

Гэндалф Бильбогийн орилохыг сонсмогцоо юу болж байгааг шууд ойлгожээ. Аянгын гэрлээр гоблинуудыг тас цохин цацаж хаяад, шидэт Гэндалф агуйн хана хөдлөхөөс өмнө завсраар нь гүйж гарч амжжээ. Хөөж байгаа гоблинууд хөөгдөж байгаа одойнуудын араас Гэндалф агуй хүртэл салахгүй дагаж явсан байна. Тэр үзэгдэхгүй болж байгаад хамгийн хачирхалтай ид шидээ тэнд гаргасан байна.

- Амь эрсэдсэн хэцүү ажил байсан. Ёстой үхлийн ирмэг дээр байсан шүү гэж Гэндалф ярилаа. Гэндалф аргагүй л олон жил гэрэл, галын ид шидийг туршсан шүү дээ. Зуны нар буцах өдрийн галын наадам гэрлэн буудлагыг хоббит мартаж чаддаггүй билээ. Цаашаа юу болсныг бид мэдэж байгаа. Харин гоблинууд доод хаалга гэж нэрлэдэг, Бильбо хамаг товчноосоо салсан арын үүдийг Гэндалф мэддэг байсныг л мэдээгүй. Гэндалф мэдэх ч яах вэ, мэддэг байсан гэхдээ өөр арга зам байхгүй юм чинь.

Гоблинууд энэ хаалгыг аль эрт хийсэн юм. Гоблинууд зугтах бултахдаа зориулан хийсэн бөгөөд харанхуйд аллага дээрэм хийхээр уулын нөгөө талд гарахад нь хамгийн ойр гарц болдог байна. Гоблинууд энэ хаалгыг өдөр шөнөгүй манадаг, энэ хаалгаар ямар ч амьтан зугтан гарч чадаагүй юм. Одоо бол бүр унтахгүй манаж байгаа гэж Гэндалф хэлээд инээмсэглэв.

Цөм дэмжин хөхрөлдөв. Тэд багагүй зовсон боловч нэлээд дайснаа устгасан, тэр ч байтугай Толгойлогч гоблинг алсан, харин өөрсдөө амьд мэнд үлдсэн. Энэ удаа тэднийг азын тэнгэр ивээсэн гэж хэлж болох байлаа.

Харин шидэт Гэндалф тэдний баяр хөөрийг жаахан намдаасан гэж хэлж болно.

- Амарч боллоо. Одоо цаашаа явахгүй бол болохгүй. Харцгааж байна уу? Сүүдэр уртаслаа. Удалгүй бидний хойноос хөөж эхэлнэ. Харанхуй болохоос өмнө аль болохоор хол явахгүй бол цаадуул чинь жигтэйхэн үнэрч амьтад шүү. Ашгүй сартай шөнө болох нь, зам сайхан харагдана гээд шидтэн Бильбо уруу харснаа,

- Тийм ээ, хонгорхон Бильбо минь. Гоблинууд биднийг дайрч бид зугтаж, энэ гурван хоногт уулыг нэвт хэдэн арван бээр туулсны эцэст уулынхаа нөгөө талд гарч ирчихээд байна. Харамсалтай нь, бид хэт хойгуур явсан бололтой, жаахан дээд талаар явсан бол аюулгүй газарт хүрэх ёстой байсан юм. За яах вэ, одоохон хөдөлцгөөе. Амжих байхаа. Хурдан доошоо бууцгаая гэлээ.

Бильбогийн хоосон ходоод хоржигнож эхэллээ. Арга ч үгүй биз ээ, бараг хоёр хоног үмх ч талх амандаа хийлгүй явна гэдэг хоббитын хувьд юу гэсэн үг вэ. Бильбогийн хөл нь гуйвж ходоод нь жигтэйхэн оволзож эхлэв.

- Ямар их өлсөж байна аа гээд Бильбо уртаар санаа алдлаа.

- Одоо тэвчинэ дээ, яая гэх вэ. Үгүй яах вэ, бүр тэвчишгүй бол буцаж очоод гоблинуудаас пони морио, ганзагатай идэх юмаа гуйвал өгөх байлгүй хэмээн Гэндальф тохуурхав.

- - Үгүй дээ, ер нь өлсөхөө больчихлоо гэж Бильбо ихэд дурамжхан дуугарахад Гэндальф,

- За тэгвэл бүсээ чангалаад, гоблинуудын өглөөний зоог болохоосоо өмнө эртхэн хөдөлье. Тэдний зоог болсноос өөрсдөө зооггүй явсан нь дээр гэлээ.

Тэд аян замдаа гарав. Бильбо арга ядан ийш тийш нүд хаялан жимс самар хайвч юу ч олсонгүй. Гэхдээ л жаахан хурган чих зажилж, уулын горхиноос ганц нэг балгасан болж, эрэг дээрээс гуравхан ширхэг гүзээлзгэнэ олж үмхэж амжлаа. Харин ч улам өлсөх мэт болов.

Тэд урагш явсаар байлаа. Овгор товгортой зөрөг зам дуусч, өндөр өвс өтгөн бутас үзэгдэхээ болив. Гоньд, шар дэр, шүүдэргэнэ ч үл харагдана. Тэдний өмнө хад чулуутай эгц өргөн эрэг тулаад ирэх нь тэр. Доошоо уруудтал, хөлийн аясаар чулуу өнхөрч, тун удалгүй жижиг хайрга биш бүр том хад асга мэт чулуу өнхөрч эхлэв. Цөм хөл алдан унаж, жалганы ёроол уруу өнхөрцгөөлөө. Хажуугаар нь аймшгийн том том чулуунууд бөмбөрч, харин азаар хэн ч гэмтсэнгүй.

Өндөр жалганы ёроолоос цаашаагаа өтгөн ой болон үргэлжилсэн хэсэг мод таараагүйсэн бол энэ явдал чухам юугаар дуусах байсныг тааж мэдэхийн аргагүй. Зарим нэг нь модны мөчрөөс зуурч, зарим нь мод тэврэн харин манай хоббит шиг сэргэлэн нь модны ард нуугдсан байлаа. Удалгүй аюул намжиж эргэн тойронд анир чимээ багадах аядаад, хааяа нэг бут сөөг нарсны дунд тээр доор бул чулуу пүдхийн унах сонсогдоно.

- Ашгүй нэг гайгүй өнгөрлөө. Хэрвээ гоблинууд мөрдөж байгаа бол тэд бас чимээ гаргана. Гэндальф ийнхүү үглэж байх хооронд одойнууд их л гутрангуй царйлчихаад чулуунд цохиулсан биеэ илэн сууцгаана.

- Муу санаат гоблинууд чулуу өнхрүүлж бидний дээрээс буулгах вий дээ гэж Бомбур болгоомжлонгуй хэлэхэд Гэндальф,

- За хурдалцгаая, энд удаж болохгүй. Тэр, хараач гээд урагшаа заав.

Нар хэдийнэ уулын цаагуур орж, сүүдэр харлан унасан байлаа. Гэлээ ч тэртээд харагдах модны завсраар энд тэнд гэрэл гялсхийн үзэгдэж, халуун хоол дулаан хөнжил нүдэнд харагдах шиг болно.

Цөм л ойгоос гарахыг яаран урд зүг тийш хөтлөх замыг даган Бильбогийн толгойноос өндөр өндөр ургасан бут, ургамал дундуур уруудан явлаа. Улам харанхуй болж, аниргүй орчин айдас төрүүлж мөчир ч үл хөдлөх салхигүй ой шугуй тэр чигээрээ гүн нойронд автсан мэт санагдана. Тэд газрыг битүү бүрсэн нарсны навчис дээгүүр алхаж байсан тул өмнөх хүний хөлийн чимээ хүртэл сонсогдохгүй байлаа.

- Хөл минь биеэ даахаа болилоо, сөхөрч унах нь. Жаахан амарцгаах уу? Гэдэс хоосон шуудай шиг л байна гэж Бильбо гонгинож эхэллээ. Хав харанхуйд өмнө нь явж байгаа Торины буурал

сахал сүүтэгнэн одойнуудын амьсгалах нь хүртэл аянга цахиж байгаа мэт санагдахаар нам гүм байлаа.

- Зорьсон газраа ч бараг ирлээ гэж Гэндальф гэвтнөв. Зуун жил өнгөрөх шиг болсны дараа гэнэт зам шувтарч, тэд сарны гэрэл туссан ойн цоорхойд гарч ирэхэд одойнууд, хөөрхий хоббит хичнээн их баярласан ч цаанаа л нэг хүйтэн салхи үлээх шиг сэтгэл тавгүйтээд явчихлаа.

Толгодын цаанаас дотор эвгүйцүүлсэн улих дуу сонсогдоно. Гэнэт баруунаас, зүүнээс чонын сүрэг бие биеэ дэмжин улилдсаар сарны туяанд гарч ирлээ.

Бильбогийн амьдарч байсан нүхний ойролцоо чоно ер үзэгдэж харагдаж байгаагүй ч үлгэр домгоос чонын тухай сонссон болохоор тэр муухай амьтны яаж ульдаг тухай мэдэж байлаа. Бас Бильбогийн үеэл ах (Тукийн удам, их олон газар явж юм үзэж нүд тайлсан эр) чоно шиг ульж хоббитыг айлгадаг байжээ. Гэлээ ч энэ бүхэн үлгэр домог тоглоом шоглоом байсан, харин одоо чоно хажууд нь сүрэглэчихээд жинхэнээр улилдан байх нь Бильбогийн хувьд арай дэндмээр. Ямар ч шидэт бөгж аврахгүй л болов уу. Гоблинуудтай харьцуулалтгүй үнэрч сонорч энэ чононууд олзоо эрж хайж үзэж, харах хэрэггүй үнэрлээд л үмхчихнэ.

- Одоо яана аа, яана аа!. Гоблинуудын савраас гараад чонын аманд орлоо гээч. Бильбогийн ийнхүү үглэж байсан нь хожим зүйр цэцэн үг болсон гэхэд хилсдэхгүй. Ялимгүй өөрчлөгдөж одоо бид чонын амнаас барын аманд гэж нэг аюулаас мултарч өөр нэг гайд учрахыг хэлдэг.

- Зугтаагаад мод уруу авираад. Гэндальфийг ийнхүү тушаахад бүгд ойр хавийнхаа мод уруу гүйлдэн доод мөчрүүдээс нь шүүрэн авч мөчийн төдийд оройд нь гарцгаав. Азаар мод элбэг байж, тун удалгүй цөм нэг нэг модон дээр гарч шомбойн сууцгаалаа. Мэдээж чадах чинээгээрээ дээшээ авиран мөчир дээрээ чичрэн суух сахалт одойнуудыг харсан бүхэн зөнөглөөд хүүхэд шиг болсон өвгөд дүрсгүйтэж байгаа мэт санагдаж инээд нь хүрэх байсан биз. Фили, Кили хоёр зул сарын гацуур мэт өтгөн өнгөлөг хар модны орой дээрээс зууран арай ядан тогтож байв. Дори, Нори, Ори, Ойн, Глойн нар харин өндөр том нарсны тэвхийсэн тэгш мөчрүүд дээр нэг нэгээрээ тухлан суусан харагдана. Бифур, Бофур, Бомбур, Торин нар хажуугийн модон дээр авирч Балин, Двалин хоёр гуалиг өндөр сийрэг мөчиртэй царсны орой уруу авчирч байгаа бололтой. Гэндальф хаачив гэтэл ойн цоорхойн зааг дээр ургасан одойнуудын авирч чадахааргүй нэлээн өндөр нарсны далбагар мөчрийн ард нуугдсан байв. Гэндальфийг үе үе толгойгоо цухуйлгах бүрт хоёр нүд нь сарны гэрэлд гялалзан харагдана.

Ингэхэд Бильбо хаачив? Нэг модноос нөгөө мод уруу дэмий л гүйж нохойд хөөгдсөн туулай мэт харагдана. Хоббитын нуруунд таарах намхан мөчир олдохгүй байлаа.

- Чи түүнийг дахиад л хаячихсан байна шүү дээ гэж Нори доош харангаа Дорид хэлэв.

- Чи өөрөө үүрээд явах чинь яасан юм бэ? Газар доогуур ч, дээгүүр ч би л дандаа үүрч байдаг. Би ер нь ачаа зөөх гэж яваагүй шүү гэж Дори хэдэрлэв. Хурдал, хурдал гэж Торин шамдуулаагүй бол Бильбо аюулд өртөх байлаа. Яг дэргэд нь чоно улина.

Дори үглэх дуртай ч гэсэн нөхрөө гайд хаях одой биш болохоор доошилж Бильбог татах

санаатай гараа сунгасан ч Бильбо үсрээд Доригийн гарт хүрч чадсангүй. Дори модноос буухаас өөр аргагүй болж үсрэн бууж Бильбог мөрөн дээрээ суулгав.

Яг энэ мөчид ойн цоорхойд чонын сүрэг архирсаар гарч ирлээ. Өлөн нүд нь гялалзсан өчнөөн олон чонын сүргийг харсан хэн ч ухаан алдам. Харин Дори сандарсангүй Бильбог мөчрөөс зүүгдэж дээш авиртал нь хүлээж дараа нь өөрөө үсэрч нэг мөчирт зүүгдэв. Улайрсан чоно хойноос нь үсэрсэн боловч азаар Доригийн гал улаан цувьг л зууж үлдэв. Удалгүй чонын сүрэг хэлээ унжуулан шүдээ ярзалзуулан модны ёроолд сууцгаав.

Хэдийгээр зэрлэг хязгаарын галзуурсан чононууд ч гэсэн модонд авирч чадахгүй нь сайхан. Хэсэг зуур ч гэсэн амьсгаа авахтайгаа болсон боловч модон дээр суух тийм ч амаргүй, бас осгом хүйтэн, дээр нь амдан отож байгаа олон чонын ам уруу шидэх нь холгүй хүчтэй салхи шуурвал яах билээ? Харин азаар энэ үед дулаахан, ямар ч салхигүй байлаа.

Ойн цоорхой тэдний цуглардаг газар бололтой, чонын сүрэг нэмэгдсээр байлаа. Бильбо, Дори хоёрын нуугдсан модны доор хэдэн чоно харуулдан үлдээд бусад нь моддыг үнэрлэн, үлдсэн одойнуудын нуугдсан газрыг дорхноо олов. Тэдний суусан мод болгоны доор хэд хэдэн чоно манаж зогсчихоод бусад үлдсэн нь (бараг мянгаад байхаа) аварга том сэгсгэр саарал толгойлогчоо тойрон суулаа. Саарал боохой өөрийнхөө аймшгийн хэлээр ярьж эхлэхэд ганц Гэндалф төдийгүй (учир нь Гэндалф тэдний хэлийг мэдэх тул) Бильбо хүртэл их л таагүй юмны тухай ярьж байгааг гадарлав. Чонын сүрэг толгойлогчдоо үнэнчээ илэрхийлэн хариу барин зэвүүнээр улих болгонд хоббит үхтлээ айн чичирч модноосоо унах шахан байв.

Чухам юун тухай ярьж байсан мөн Гэндалф юу ойлгосон тухай одоо та нарт хүргэе. Чонын сүрэг гоблинуудтай хамтарч цуст дээрэм тонуул хийх нь олонтаа. Гоблинууд голдуу ууландаа хоргоддог боловч хөөгдөж туугдсан үедээ шинэ оромжийн эрэлд гарна гэвэл өөрсдөө дайтаж гэр оромж эзлэн авдаг байна. Сүүлийн жилүүдэд харьцангуй тайван байж гоблинууд дайн дажин хийгээгүй юмсанж. Харин гоблинууд үе үе хоол хүнсээ базаах, зарц боолоо шинэчлэх гэж дээрэм тонуулд гарахдаа чонын сүргийг хамсаатан болгон дуудаж олзныхоо талыг өгдөг байна. Гоблинууд чоныг яг одойнууд пони морь унадаг шиг унаад давхих нь олонтаа. Энэ үдэш ойн цоорхойд уулзан дээрэмд гарахаар тохиролцсон боловч гоблинууд ирэхгүй удаад байсан байна. Гоблинуудын удирдагч алагдаж, бусад нь манай баатруудын тарьсан үймээнээс болж яахаа ч мэдэхгүй уймарч байгааг тэд хэрхэн яаж мэдэх билээ дээ.

Энэ хавийн нутаг орчны талаар муу муухай юм их сонсогдох боловч урд зүгээс нүүж ирсэн зоригт эрс юунаас ч айсангүй голын хөндийд байшингаа барьж суурьшсан гэдэг. Эдгээр зоригтнууд олуулаа, сайн зэвсэглэсэн байдаг тул чонын сүрэг хүртэл дайрч зүрхэлдэггүй аж. Харин өнөөдөр тэд гоблинуудтай нийлж ууланд ойр тосгонууд уруу дайрч тонон дээрэмдэхээр төлөвлөсөн байна. Тэдний санаагаар бол гоблинууд боолуудыг олзлон, шилж ялгаад уул уруу тууж, үлдсэн бүгдийг чононууд сөнөөн устгаж, өглөө гэхэд тосгонууд хоосорч нэг ч хүн амьд үлдэхгүй ёстой гэнэ.

Энэ тухай саарал толгойлогч улин дуулж, бусад нь түүнийг даган баясаж нэгэн дуугаар орилж байхыг ойлгосон Гэндалф айхтар аюул зөвхөн тосгоны зоригт ардуудад ч биш түүнд болон түүний нөхдөд заналхийлж байгааг маш сайн ойлгов. Гэндалф болон түүний андуудыг чононууд тосгоны туршуулууд гэж ойлгосон тул эднийг тавьж явуулбал тосгоныхонд хэл

хүргэж, хамаг төлөвлөгөөг нураана, нэгийг нь ч амьд гаргахгүй гэж уурлан архиран эргэлдэж байлаа.

Чононууд үүр цайтал эндээс холдохгүй гэж шийдсэн бололтой. Мэдээж тэд гоблинуудыг хурдан ирж мод уруу авирч олзлогдсодыг барьж авахыг тэсэн ядан хүлээж байв.

Муусайн чононуудын санаархлыг ойлгосон Гэндальф айж сандарсан нь гайхал үл төрүүлнэ. Амь тэмцэн ядаж, ийм ч оромж олох гэж хэмээн өөрийгөө зэмлэн зүхэж байснаа жинхэнэ шидтэн болохоороо доор нь зэрлэг хэрцгий амьтан амдаж байсан ч ухаанаа алдалгүй нэг арга олох шиг болов. Гэндальф модноос хэдэн боргоцой тасдан авч, доор эргэлдэх чоно уруу шидтэл боргоцой бүр тод хөх өнгөөр асч, оч цацруулан саарал чонын нуруун дээр тас хийтэл буув. Шатсан хярвас ханхалж, чонын орилох дуу тэр даяар цуурайтахад дараа дараагийн боргоцойнууд хойноосоо нисэн сүргийг бөмбөгдлөө.

Ойн цоорхой тэр чигээрээ галт наадмын талбай мэт улаан, хөх, ногоон өнгөөр цацрах гал дөлөөр гэрэлтэв.

Боргоцойнууд газар дээр унан, цацран, дэлбэрч утаа баагиулан эргэлдэж нэг нь бүр сүргийн толгойлогчийн хоншоор дээр уналаа. Айж цочсон толгойлогч хатгуулсан мэт огцом үсэрч, хажуу хавьд тааралдсанаа хазаж орчин тойрноо бусниулав. Энэ бүгдийг Бильбо болон одойнууд модон дээрээс харан их л баясаж суухдаа аймшгийн адгуусаас бараг айхгүй ч болох шиг. Чононуудын ганц айдаг зүйл бол гал. Гэтэл бүр ид шидтэй галаар шидэж довтлоод байвал ямар байх билээ дээ. Шидэт боргоцой бага гэлтгүй чононуудыг айлгаж нэлээн хэдэн чонын арьсыг шатааж амжив. Чононууд асаж байгаа амьд гал болж орилолдон давхиж, галыг унтраах гэж газраар өнхөрч бүгд айцгаан, зарим хэдэн чоно ойн цоорхойгоос зугтаж амжив.

Ихэнх чоно тэднийг отсоор байлаа.

- Энэ юун шуугиан бэ? Ойн зүгээс гарч байна уу? гэж өндөр нурууны зүүн хэсэгт, өнчин уулын орой дээр хар сүүдэр мэт суух Бүргэдийн Захирагч асуув.

- Чоно ульж байх чинь, муусайн гоблинууд дахиад л нэг муу юм сэдэж байна уу даа гээд тэнгэр өөд дүүлэн нисэхэд, хоёр үнэнч бүргэд хойноос нь даган хөөрөв. Тэд газраас асар өндөрт хөөрч, тээр доор тас харанхуйд сүүмийн харагдах ойн цоорхой дээгүүр эргэлдлээ. Бүргэдийн хурц хараа нүхнээс цухуйж буй туулайг хүртэл харах чадвартай билээ. Бүргэдийн Захирагч модны ард нуугдсан одойнуудыг харсангүй харин галзуурсан мэт давхилдах чононууд басхүү жад, дуулгаа сарны гэрэлд гялалзуулан эгнээ эгнээгээрээ доод хаалгаар гарч байгаа гоблинуудыг хараад амжив.

Бүргэд ч бас хүнтэй адил янз бүр аймхай, хэрцгий байдаг. Харин энэ бүргэдүүд хойд нутгийн уулнаас гаралтай, хүчтэй, бардам гэдгээрээ алдаршсан бүргэдийн омгуудын дунд хамгийн агуу эртний язгууртан удмын шувууд байлаа. Энэ бүргэдүүд гоблинуудыг үзэн яддаг. Энэ муухай ой гутмаар амьтдыг иддэггүй бүргэд бас байдаг. Гоблинуудыг дайралдвал дайран давшиж агуй уруу нь хөөж оруулдаг тул гоблинууд мөн адил бүргэдийг үзэн ядан, үүрийг нь бусниулж устгахыг хүсэн мөрөөддөг боловч хэт өндөр уулс өөд авирч чадахгүй тул хий дэмий л тэдэнд хорсон заналхийлнэ.

Бүргэдийн Захирагч доор чухам юу болоод байгааг, гоблинууд хаашаа дайтахаар явж байгааг ихэд сонирхон харж үнэнч хамтрагч нараа дуудан чонын сүргийн галзуурсан мэт бужигналдаж байгаа ойн цоорхой дээгүүр бага багаар тойрон эргэлдэн доошилж эхлэв.

Ойн цоорхойд чухам юу болж байгааг хэлэхэд хэцүү байлаа. Зуны дунд сар гарч байсан хэдий ч бороо огт ороогүй тул өчүүхэн чинээний оч унангуут ойд гал авалцан дүрэлзэнэ. Шарлаж хатсан зүлэг, нарс модны унасан навчны том том бухлууд, хуурай мөчир, үхмэл мод бут бүгд галд автан шатаж, ойн цоорхой тэр чигээрээ дүрэлзэн, галын бүслэлтэнд орох шиг болов. Улайрсан чононууд айхгүй, харин ч улам улангасан өөрсдийн адгийн хэлээр одойнуудыг хараан зүхэж, шүлсээ асгаруулан, цус хурсан нүдээ эргэлдүүлэн одойнуудын сууж буй мод бүрийг тойрон давхилдана.

Яг энэ үед гоблинууд муухай орилсоор ойн цоорхойд гарч ирэв. Тэд чонын сүрэг тосгоныхонтой уралцаж байна хэмээн ойлгож яаран иржээ. Тун удалгүй учрыг ойлгож элгээ хөштөл хөхөрч, жадны ишээр бамбайгаа балбан баахан баясацгаав. Галаас огт айдаггүй гоблинууд хоорондоо нэг мөр зөвлөлдөж одойнуудаас хүртсэн хохирол бас доромжлуулсан өшөөгөө нэгмөсөн авахаар шийдэв.

Зарим чононуудыг нэг тийш нь тууж зайлуулж, бусад нь асч байгаа галыг дэвсэж унтрааж эхлэв. Харин одойнуудын нуугдсан модны ойролцоо асах галыг унтраах байтугай хуурай мөчир, гишүү авчирч улам дүрэлзүүллээ. Одойнууд ч орох байх газраа олж ядан дүрэлзэн асах гал дунд аврал эрэн сандарцгааж байтал гал улам ойртож, нүд хорсож, тэсэхийн аргагүй халуун дүүглээ. Харин гоблинууд бөөн баяр болж үсэрч, дэвхрэн хүмүүс нар буцах баярыг тэмдэглэхдээ баясан цэнгэдгийн адил бүр тойрон бүжиглэн наадацгаав.

Галын бүслэлтийн цаад талд жад, сэлмээр зэвсэглэсэн гоблинууд эгнэн ярайж, тэд нараас холгүйхэн чонын сүрэг соргог манаанд сууж байлаа. Гоблинууд орилолдон ийнхүү дуулж байв.

Арван таван бялзуухай таван модон дээр сууна

Арван таван бялзуухай таван гал дээр сууна

Амьдаар нь шарж байгаад, тогоонд буцалгана даа

Ааг уурыг савсуулан ширээндээ тавина даа

Амттай сайхан зоогоо тамшааланхан зооглоно доо хэмээн дуулангаа тэд,

- Бялзуухайнууд минь нис, нис. Чадах юм бол нисээрэй. Хөөе, амьд уу? Амьдаараа шарагдаж байснаас наашаа буугаад ир.

- Мулгуу амьтад минь эндээс зайлцгаа. Хэн та нарыг галаар тоглоотох гэсэн юм бэ? Барьж аваад турсагыг чинь хуулна даа гэж Гэндалф хариуд нь хашхирав.

Ингэж сүрдүүлэн загнахдаа Гэндалф гоблинуудад айснаа харуулахгүйг хичээсэн боловч

гоблинууд ерөөсөө тоосонгүй. Дахин дуулж эхлэв.

Ас ас, дүрэлзэн ас, бүү унтар

Аранзал аранзал, дэвжин аранзал

Өдөр шиг гэрэлтэй, гал гал халуухан

Өө хө, өө хө, хө

Эргүүлж тойруулаад эднийг сайхан шарна даа

Үсийг нь хуйхлаад хамрыг нь шарлуулаад

Ха ха, ха ха, ха ха

Нүд нь бүлтрээд, өөх нь хайлаад

Арьс нь шарлаад, ай даа мөн ч гоё доо

Ай даа, мөн ч амттай даа

Асар тэнгэр өндөр дөө

Одойнууд ингээд устана даа

Гоблинууд бид бүжиглэнэ дээ

Го го го, ха ха ха

Ура ура, хурай

Гоё доо, гоё доо, гоё доо

Ийнхүү тэднийг дуулж дуусах үед Гэндалфийн сууж байсан мод, бусад одойнуудын суусан мод цөм галд автлаа. Модны холтос, доод хэсгийн мөчир тас тас хийн шатаж эхлэв. Гэндалф модны орой уруу авирахад шидэт таягнаас нь оч цацарна. Нэгэнт аврагдах найдвар тасарсан болохоор дайснуудынхаа дээрээс үсэрч аль болохоор олныг хөнөөж өөрөө баатарлагаар үхэхээр шийдсэн бололтой. Гэвч азаар энэ төлөвлөгөө бүтсэнгүй.

Гэндалфийг яг үсрэхээр зэхэж байтал Бүргэдийн Захирагч түүнийг шүүрэн авч тэнгэрт дүүлэн нисэв.

Уур хилэндээ шатсан гоблинууд дэмий л хашхирч орилсоор үлдэв. Гэндалф амийг нь аварсан бүргэдийн чихэнд нэг юм шивнэхэд Захирагч чанга дуугаар бусад бүргэдийг дуудав. Ойн цоорхой дээгүүр гэнэт сүүдэр татаж, том том бүргэдүүд хаанаас ч юм нисч ирэхэд, чонын сүрэг гаслан шүдээ хавиралдан гүйж, гоблинууд жадаараа тэнгэр өөд хоосон хатгаж

заналхийлнэ. Бүргэдүүд эдгээр адгуустай байлдаж байх хооронд хэдэн бүргэд муурч унах нь холгүй болсон одойнуудыг модон дээрээс шүүрэн авлаа. Бильбо дахиад л хоцорчих шахав. Аргагүй самбаатай тулдаа Доригийн хөлнөөс зууран зүүгдлээ.

Шувууд модны дээгүүр эргэлдэн цааш нисэхэд, Бильбо Доригийн шагайнаас салахын аргагүйгээр зуурч амь тэмцэн нисэж явлаа.

Тун удалгүй ой мод харагдахаа больж, тэртээ хол улалзан асах гал жижигхэн улаан цэг болон үлдэв. Бүргэдүүд тэнгэрт улам улам дээшлэн ниссээр.

- Ёо, ёо, ёо, миний гар тасрах нь ээ гэж Бильбо ёолно. Бильбо энэ нислэгийг насан туршдаа мартаж чаддаггүй билээ.

- Хөөе чи. Миний хөлийг. Өвдөж байна шүү дээ... гэж өөдөөс нь Дори орилж байв.

Бильбо өндрөөс айдаг, ялихгүй жоохон дээш гарангуутаа толгой нь эргэж дотор нь муухайрдаг аж. Мод уруу авирах байтугай (урьд өмнө чононоос зугтаж байсангүй) шатаар хүртэл өгсөх дургүй. Тэгтэл ийм өндөрт нисэж байх гэж. Бильбо доошоо хараад золтой л ухаан алдсангүй, хоёр хөл нь хий хоосон агаарт савчиж тээр доор сарны гэрэлд хад асга, гуу жалга, гол ус тун чиг хол харагдана. Өндөр уулсын орой ойртож хурц шовх асга харанхуйгаас гэнэт гарч ирэв.

Халуун зун байхад Бильбо голдоо ортлоо даарч нүдээ тас анилаа. Гар нь хөшчихөж. Тэсэлгүй гараа тавьчихвал юу болох бол гэж бодохоос Бильбо айж байлаа.

Тун удалгүй хөөрхий Бильбогийн гар мэдээгүй болов. Хоббит Доригийн хөлийг тавьж, санаа алдан хаясан чулуу мэт доошоо уналаа. Харин энэ үед нислэг ч дууссан бололтой мань эр бүргэдийн үүрний хатуу хучлага дээр газардав. Хөдлөх ч тэнхээгүй нэлээд удаан хэвтэв. Толгойд нь янз бүрийн бодол эргэлдэж, гоблинуудаас зугтсандаа баярлахын сацуу яаж энэ айхтар өндрөөс унахгүй байх билээ ч гэж айх шиг...

Дээр нь гурван хоног хоосон байсныг хэлэх үү, нэг мэдэхэд өөрөө өөртэйгөө ярьж байв.

- За хө, цээжний тарган махыг яг сайхан иддэг дээр нь хайруулын тавагнаас аваад эргээд хийхээр ямар байхыг ойлголоо.

-Тэр ч яах вэ, тэр махыг чинь дараа дахиад хайруул дээр тавиад идэх болно, харин бид үнэхээрийн азтай юм. Тэгээд ч бүргэдийн хумс хурц ч гэсэн ямар хэрчээд идэх гэж байгаа хутга сэрээ биш гэж Дори хажуунаас нь хэллээ.

- Нээрээ тийм шүү, зүйрлэх юм биш. Хоббит дэргэд суугаа бүргэд тийш харснаа хамаагүй буруу юм ярьж үүрний эзнийг гомдоох вий дээ, хүний үүрэнд ирчихээд дуугүй байхгүй гэж өөрийгөө зэмлэв.

Бүргэд огт тоосон шинжгүй тэднийг үл анзааран өдөө цэвэрлэж суулаа.

- Захирагч бүх олзлогдсон одойнуудыг Гол Хавцал дээр авчир гэж тушааж байна гэж

дамжуулаад цааш нисэв.

Бүргэд, Дориг шүүрэн авч Бильбог үүрэндээ орхин шөнийн харанхуйд уусан алга болов. Хоббит ганцаар үлдээд яагаад бид нарыг олзлогдсон гэж дуудав? Ер нь тэр Гол Хавцал гэдэг нь хоолны газар юм болов уу гэж бодлоо. Гэвч энэ үед бүргэд буцан ирж Бильбогийн бодлыг үймрүүлэв.

Бүргэд Бильбогийн цувнаас зуун дээш хөөрж, тун удалгүй өргөн чулуун тавцан дээр шидэж орхилоо.

Хоббит айсан шинжтэй чичирч, эргэн тойрныг харснаа эндээс зугтах гэж санасны ч хэрэггүй гэдгийг ойлгов. Тэд зөвхөн жигүүртэн шувуу гарч, бууж чадахаар тийм өндөр хавцал дээр байлаа. Яах вэ, нисэж үхье гэвэл үсэрч болох л юм. Эргээд хартал одойнууд бас Бүргэдийн Захирагчтай нэг юмны тухай ярьж байсан бололтой Гэндальфийг олж харан жаахан уужирлаа.

Удалгүй жижигхэн хоббитыг хэн ч зооглохгүй гэдэг нь ойлгомжтой болж, Гэндальф бүргэдийн Захирагчтай овоо найзалсан шинжтэй тухлан сууж байв. Ууланд байнга зочилдог Гэндальф урьд өмнө жадаар хатгуулсан Захирагчийн шархыг эдгээж өгсөн түүхийг хоббит яаж ч мэдэх билээ дээ. Олзлогсон гэдэг нь гоблинуудад баригдсан тэднийг хэлсэн болохоос өөр санаа бодол агуулаагүй юмсанж. Гэндальф Захирагч хоёрын ярьж байхыг сонссон Бильбо сая л нэг цус сорогч, ховдог амьтдаас аврагдсандаа итгэв.

Шидтэн тэд нарыг Их Голын цаана гаргаж өгөхийг хүсэн Захирагчийг ятгаж байлаа.

Бүргэдийн Захирагч хүмүүс амьдардаг газар бүргэд нисч очихгүй гээд нэлээн татгалзаж байгаа сонсогдоно.

- Тэр хүмүүс чинь бид нарыг харангуутаа нум сумаар харваж эхэлнэ. Ямар өөдөөс нь энэ удаа бид нар хонь, ямааг чинь шүүрэхгүй ээ, өөр зорилготой гэж хашхиралтай биш. Шидтэн танд бид үргэлж туслахад бэлэн гэхдээ умард зүгийн хөндий бидний нисч очоод байх газар биш дэгээ.

- Үгүй, заавал тийшээ гээгүй шүү дээ. Эндээс аль болохоор холдож байвал болох нь тэр. Бид юу гэж та нараас тийшээ хүргэж өг гэж тушааж зүрхлэх вэ дээ...

- Ингэхэд ямар их өлсөж байна аа? гэж Гэндальфийг хэлэхэд Бильбо,

- Би ч бараг өлсөөд үхсэнтэй адил байна гэж дуугарч үзсэн боловч түүнийг хэн ч сонссонгүй.

- Өө, одоохон арга хэмжээ аваатахъя гэж Захирагч хариулав.

Удалгүй хэдэн бүргэд хуурай мөчир авчирч дараа нь молтогчин туулай, хурга чирээд ирлээ. Одойнууд чулуун хавцал дээр гал асааж шүлс асгаруулсан сайхан үнэртэй мах шарж эхлэв. Бильбо дэндүү туйлдсан тул галын дэргэд хэвтэн дулаацахаас өөр юм хийсэнгүй.

Хоббит ямар амьтан өвчиж мах эвдэж чадах биш. Хоббитын амьдардаг газар бэлдсэн мах

зардаг тул худалдаж аваад л хайруулын таваг дээр шарна шүү дээ. Ойн, Глойн хоёр цахиураа гээчихсэн болохоор (Одойнууд одоо хэр нь шүдэнз хэрэглэдэггүй юм) түүдгийн хажуугаар хэвтээд өгөв.

Ийнхүү тэдний Манант Уулан дахь адал явдал дуусав. Гал дээр шарсан махны оронд нэг сайхан амттай цөцгийн тостой талх байсан бол мөн ч гоё доо гэж Бильбо мөрөөдсөн хэрнээ олдсон махыг олзуурхан гэдсээ цадтал идэж аваад түүдгийн хажууд эвхрэлдэн унтлаа. Энэ шөнө тэр зөөлөн гудсан дээр унтсанаас илүү ямар сайхан тайван унтсан гээч. Тэр нүхэн гэрийнхээ тамтаггүй олон өрөөг хэсэж нэг л юм хайж, хаана тавьснаа санахгүй байна гэж зүүдэлж байв.

Долдугаар бүлэг


Беорны гэрт зочилсон нь

Өглөөний нар гийн Бильбо сэрэв. Год харайн босч сурсан зангаараа цаг харж, кофе чанагчаа гал дээр тавих гэтэл гэнэт нүхэн гэр нь тэртээ хол хоцорсныг ухаарав. Шүдээ ч угааж чадсангүй (юугаар ч угаах билээ), амтат жигнэмэг, шарсан гахайн утсан мах, халуун цайны оронд хүйтэн хурганы бас туулайн мах (тус тус хоёр ширхэг) зооглов. Одоо яая гэх вэ, идэх юм олдсон нь их юм гэж дотроо бодон хурдан идэж, аян замдаа бэлдлээ.

Бүргэдийн нуруун дээр гарч суутал бүргэд далавчаа дэлгэн сүн хийтэл хавцал дээрээс нисэв. Чихэнд салхи исгэрэх шиг болоход хоббит айсандаа нүдээ тас анина. Бильбогийн хойноос одойнууд нэг, нэг бүргэд дээр суун нисэв. Тэд нисэхээсээ өмнө Захирагчид талархсанаа илэрхийлэн, боломж олдсон үед хариу тус хүргэхээ андгайлав. Сэрүүхэн өглөө болж тээр доор манан татаж уулсын орой хүртэл харагдахгүй мананд дарагджээ. Нар манхайн мандлаа. Хоббит нэг нүдээ хагас нээн харвал тэд асар өндөрт нисэж байв. Доош хартал газар харагдсангүй, харин Манант уулс улам холдоно. Хоббит дахин нүдээ тас аньж бүргэдийн хүзүүнээс чанга гэгч зуурав.

- Хөөе. Чи яаж байна гэж бүргэд дуу алдаад,

- Юунд ингэглээ чичирнэ вэ? Чи арай тэр туулайнуудын хамаатан биш биз? Ийм сайхан салхигүй өглөө хязгааргүй өндөрт дүүлэн нисэхийг юутай ч зүйрлэшгүй шүү. Халуун усанд хэвтэж дараа нь зүлгэн дээр өглөөний хоолоо идэхтэй зүйрлэж болно гэж хоббит хэлэх гэснээ амаа хамхин бүргэдийн хүзүүнээс зуурсан гараа сулав.



Нэлээн удаан ниссэний дараа бүргэдүүд хайж байсан газраа олсон янзтай (тэр өндрөөс яаж харж байна аа) алгуурхан эргэлдэн доошиллоо. Хоббит нүдээ нээтэл газар ойртож царс, хайлаас, мод нов ногоон хөндийг гатлан урсах гол зэрэг тодрон харагдав. Голын дунд нэгэн

аварга хүчтэн шидчихсэн юм шиг хавцгай харагдав. Хавцгай Манант Уулын зааг дээрх сүүлийн харуул мэт сүндэрлэн зогсох нь цаанаа л нэг сүртэй байлаа. Бүргэдүүд хойно хойноосоо хавцгай дээр бууж манай баатруудыг буулган,

- Сайн яваарай. Санасан бүхэн чинь бүтэх болтугай. Орон гэртээ эсэн мэнд очоорой хэмээн зэрэг зэрэг өөрсдийн заншлаар ерөөв.

- Та нарыг салхи ивээн, нар сар гэрэлтэх тэртээх алс уруу хүргэх болтугай гэж Гэндальф бүгдийг төлөөлөн хариуллаа. Магадгүй ганцхан Гэндальф л юу хэлэх ёстойг мэдэж байсан биз.

Ингээд бүргэдүүдээс салцгаав. Хожим Бүргэдийн Захирагч бүх шувуудын Хаанаар өргөмжлөгдөн, алтан титэм хүртэж харин арван таван үнэнч албатууд нь алтан гинжээр шагнуулсан билээ. (Үүнийг одойнууд бэлэглэсэн гэдэг) Харин Бильбо тэд нартай дахин уулзалдаагүй, гагцхүү Таван Армийн Байлдааны талбар дээгүүр нисэж байхыг нь ганц удаа харсан юм. Гэхдээ энэ бол огт өөр түүх юм. Одоо ярих арай эрт байна.

Хавцгайн орой тэгшхэн ширээ шиг хавтгай, түүний нэг ирмэгээр олны хөлд элэгдсэн шинжтэй гөлгөр чулуун шатаар уруудна. Шатаар бууж хэдэн том чулуун дундуур сүлжин гарам дээр гартал хажууд нь хайрга дэвссэн дулаахан жижиг агуй тааралдав. Бүгд тийш орон тухлан сууж цаашдаа яах талаар ярилцахаар шийдлээ.

- За би та нарт амласнаа биелүүлж Манант уулыг давахад чинь тусаллаа. Аз хийморь чинь ивээж, Элрондын болон бусад андуудын мэргэн ухаан та нарыг хөтлөн явсаар аюулгүй газарт хүргэлээ. Бид баруун зүгийг хэт барин явж замаас холдсон учраас яарахгүй бол болохгүй... Одоо би та нараас салж өөрийн ажлаа амжуулах цаг ирлээ. Та нар адал явдлаа үргэлжлүүлнэ гэхдээ бид дахин учирч хамтдаа явж ч магад гэж Гэндальф мэдэгдэв.

Энэ үгийг сонссон одойнууд сэтгэлээр унаж Бильбо бүр уйлсан гээч. Бүгд хамтдаа Ганцаардмал Уул хүртэл явж Гэндальф тэднийг аюул бүхнээс хамгаална хэмээн найдаж байсан юм...

Хоббитыг харсан Гэндальф,

- Битгий уйлаад бай. Би та нартай нэг хэсэгтээ хамт явна. Ганц хоёр хоног чадахаараа тусална, харин дараа нь та нар өөрсдөө учраа олцгооно шүү. Одоохондоо та нар хаана ирсэн, хаашаа явахаа мэдэхгүй бас хоол хүнсгүй учир би та нарт тусална. Муу санаат гоблинуудтай дайралдаагүй бол бидний явах ёстой зам маань эндээс хэдхэн бээрийн цаана байгаа юмсан... Энэ хавьд эзгүй хоосон газар гэхдээ юмыг яаж мэдэх вэ, би сүүлийн хоёр гурван жил энэ хавиар явсангүй.

Зөвхөн өөрсдөдөө найдаж, болгоомжтой байх хэрэгтэй. Миний нэг сайн танил ойр хавьд амьдардаг юм. Энэ шатыг тэрээр хад цохиж хийгээд хавцгайг Каррок гэж нэрлэсэн, харин түүнтэй энд өдрийн цагаар уулзана гэж байхгүй дээ. За яах вэ, өөрсдөө л хайж олохоос. Хэрвээ түүнийг олвол би та нарт саяны бүргэдүүдийн адил амжилт ерөөгөөд сална даа гэж Гэндальф өгүүлэв.

Одойнууд түүнийг үлдэхийг хичнээн гуйвч тэр зөвшөөрсөнгүй. Аргаа барсан тэд луугийн хамгаалж байгаа алт, мөнгө, эрдэнэсийн чулуунаас амласан ч бүтсэнгүй.

- Би бүгдийг урьдаас төлөвлөсөн учир та нар намайг битгий гуй. Харин алт мөнгөний тухайд гэвэл та нар эхлээд тэр их эрдэнэсийг өөрийн болгож авах хэрэгтэй. Тэгээд ч би өөрт оногдох хувиа хүртэхээр зүйлийг та нарын төлөө хийсэн шүү гээд тэдний горьдлогыг таслав.

Голын эрэг хавьцаа тунгалаг устай, гүнзгий биш байсан тул бүгдээрээ усанд сэлж хувцас хунараа угааж, наранд биеэ ээж алжаалаа тайлцгаалаа. Өлсгөлөн ч гэсэн голыг сэргэлэн цовоо нь аргагүй гаталж (хоббитыг бас үүрч гарав) урт сагсгар царс, гуалиг эрхэмсэг хайлаасны хажуугаар өндөр ургасан өвс ногоон дундуур Гэндальфийг даган алхацгаав.

- Таны танил тэр хавцгайг яагаад Каррок гэж нэрлэсэн юм бол гэж хоббит хажууд алхах Гэндальфаас асуув.

- Мэдэхгүй юм даа. Тэр бүх хавцгайг Каррок гэж нэрлэдэг юм, харин энэ нь түүний гэрт ойрхон учир Каррок гэж том үсгээр нэрлэсэн байх.

- Тэр юу хийж амьдардаг юм бол?

- Золиг гэж, мартахаа шахав. Та бүхэнд гэж хэлэхэд тэр маш чухал хүн шүү. Түүнтэй эелдэг, хүндэтгэлтэй харьцахгүй бол дараа нь юу болохыг таахын аргагүй. Уул нь их сайхан зантай гэхдээ маш амархан уурладаг, уурлахдаа танигдахын аргагүй болчихдог юм.

- Гэндальф чиний танилууд бүгдээрээ айлгаж сүрдүүлсэн дүр төрхтэй юм уу? Яаж харилцах талаар өчүүхэн бидэнд үл ялих тайлбарлаад өгдөг ч болоосой гэж түүний үгийг сонсохоор тойрон цугласан одойнууд дор дороо дурамжхан бувгнав.

- Үгүй, энэ чинь хичнээн тайлбарлах вэ дээ. Яах вэ, айлгаж сүрдүүлсэн дүр төрхтэй л биз, гэлээ гээд миний андуудын тухай муу юм та нар сонсохгүй. Энэ танилын маань нэр Беорн, тэр бол арьсаа сольдог юм.

- Арьсны худалдаачин юм уу? гэж Бильбо тодруулснаа,

- Аа, мэднэ, мэднэ. Нүд ирмэх зуур туулайн арьсыг хэрэмний арьс гээд зардаг нөхөд шүү дээ.

- Ноён Бэггинс та ярих юмаа бодож байж ярьж байвал аминд чинь өлзийтэй. Беорны дэргэд арьсны худалдаачны тухай байтугай хивс, бүтээлэг, ороолт, цув муvны тухай ярьж болохгүй шүү. Беорн бол хүссэн үедээ дүрээ хувиргаж нэг бол том хар баавгай эсвэл хар үстэй, урт сахалтай том гэгч хүн болж хувирна. Зарим нь түүнийг аварга амьтдаас өмнө энд амьдарч байсан эртний агуу баавгайнуудын удам гэдэг, зарим нь луугийн тухай сураг гараагүй байхад гоблинуудыг хойд зүгээс дүрвэж ирээгүй байхад энд амьдарч байсан хүмүүсийн удам гэдэг. Түүнээс элдэв бусын юм асууж, шалгааж болохгүй шүү.

Тэр шигүү ой дунд том модон байшинд амьдардаг. Хэн ч түүнийг илбэдэж чадахгүй. Мал маллаж, зөгий үржүүлж зөгийн бал, цөцгий иднэ. Түүний адуу нь гоц ухаантай бас хүний

хэлээр ярьж чадна. Беорн ан гөрөө хийдэггүй, мах иддэггүй харин баавгайн төрхдөө орж, энэ тэндгүй их тэнүүчилнэ. Нэг удаа би түүнийг Каррокийн орой дээр зогсоод, Манант уулын цаагуур орох сарыг ширтэн, би хэзээ нэгэн цагт гэртээ харина даа гээд амандаа бувтнаж байхыг харсан юм. Тэгэхэд би түүнийг ууланд төрж өссөн юм байна гэж ойлгосон.

Бильбо болон одойнууд бодож тунгаах зүйл ихтэй болсон тул Гэндальфаас дахин юу ч асуусангүй. Хүрэх газар нь хол байлаа, хотгор гүдгэр бүрийг давж нэг дээш гарч нэг доош уруудсаар явлаа. Халуун болж эхлэв. Модны сүүдэрт сууж амсхийн дахин аялалаа үргэлжлүүлэв. Хоббитын гэдэс хонхолзож ядаж модны шош олоод идчих санаатай хайсан боловч юу ч олсонгүй.

Үд дунд тэд нэлээн арчилж тордсон нуга талбайд гарч ирлээ.

Энд тэндгүй ердийн ягаан, улаан, цагаан бас тахиан загалмай хошоонгоруудыг төрөл төрлөөр нь тарьсан харагдана. Нуга дээгүүр зөгий дүнгэнэх сонсогдож удалгүй үй түмэн зөгий харагдлаа. Тэд ямар ер бусын зөгий байсан гэж санана! Бильбо амьдралдаа тийм зөгий үзээгүй ажээ. Хуруунаас урт, том шар зөгийнөөс хамаагүй том, нуруун дээрх хар зураасууд нь алтадсан юм шиг гялтганана. Ийм зөгийд нэг хатгуулах юм бол усан хавантсан юм шиг танигдахын аргагүй болно доо гэж бодогдоод явчихав.

- За, бид ч зорьсон газраа удахгүй хүрлээ дээ. Беорны зөгийн эдлэнгүүд эхэлж байна гэж Гэндальфийн хэлэх сонсогдов.

Тэнгэр тулам өндөр хэсэг хөгшин царс модны хажуу өнгөртөл хэн ч нэвтрэхээргүй шигүү ургасан бут, хашаа мэт зэрэгцэн эгнэж ургажээ. Давж гарах тухай санасны ч хэрэггүй нь ойлгомжтой байв.

- Та нар энд байж дуудахыг минь анхааралтай сонсож бай. Намайг шүгэлдэнгүүт таван хормын зайтай хоёр хоёроороо ирээрэй. Бомбур сондгойрох нь дээ, за зүгээр дээ, ийм тарган юм чинь хоёр хүний дайтай харагдана гэж Гэндальф зааварчлаад,

- Алив, ноён Бэггинс хоёулаа явна, энд нэг хаалга байх ёстой гэсээр айж сандарсан хоббитыг дагуулан явав.

Тун удалгүй өндөр бөгөөд өргөн хаалга олдлоо. Хаалганы цаана цэцэрлэг бас тэгшилж зүлгээгүй модоор хийж дэрсээр дээвэрлэсэн хэдэн модон оромж харагдав. Энэ нь амбаар, саравч, морины жүчээ зэрэг байжээ. Эдгээрээс зайдуухан намхан модон байшин байв. Хашааны өмнөх хэсгээр дэрсэн дээвэртэй зөгийн үүрүүдийг эгнээ эгнээгээр байрлуулсан байлаа. Тэр хавиас зөгийн дүнгэнэх дуу чимээ сонсогдож холоос хүртэл том том зөгийнүүд үүрэндээ орж гарч байгаа нь тод харагдана.

Шидтэн зоригтойгоор хаалгыг нээж чихран гарах дууг үл анзааран байшин уруу хөтлөх өргөн замаар алхлаа. Хоббит хойноос нь гүйх шахам дагав. Тэр хоёроос холгүй бэлчиж байсан хэдэн цатгалан морьд ухаантай нүдээр тэднийг цоо ширтсэнээ гэнэт нэгэн зэрэг зугтаад алга болов.

- Эзэндээ, урилгагүй зочдын тухай илтгэхээр давилаа гэж Гэндальф Бильбод тайлбарлалаа.

Байшинг тойртол ард нь байшингийн хойд хана бас өөр хоёр модон оромжийн дунд бий болох гурвалжин талбайн голд мөчрийг нь цавчсан том царсан мод хэвтэж байлаа. Гуалингийн хажууд хар сахалтай, хар үстэй, асар том гартай, булчинлаг хөлтэй өндөр хүн зогсож байв. Тэр өвдөг татсан ноосон өмсгөлтэй агаад аймшгийн том сүх тохойлдон зогсож, морьд нь түүний мөрийг үнэрлэж тойрно.

- Өө нөгөө гийчид чинь хүрээд ирлээ шүү дээ гээд нам баргил хоолойгоор морьд уруугаа харан хэлснээ,

- Сандарсны хэрэггүй ээ, одоо явцгаа гээд сүхээ шидчихээд ойртож ирэн,

- За хаанахын хүмүүс, хаа хүрэх вэ? гэж асуулаа. Өндөр эр Гэндальфаас хамаагүй өндөр байлаа. Харин Хоббит түүний хоёр хөлний дундуур гарахад лав халтар өмсгөлийн нь хормойг ч шүргэхээргүй аж.

- Миний нэр Гэндальф гэж шидтэн өөрийгөө танилцуулав.

- Урьд өмнө сонсож байгаагүй юм байна гэж өндөр эр хэлээд,

- Энэ бяцхан амьтан чинь юу вэ? гээд тонгойж өтгөн хар хөмсгөө зангидан Бильбог сонжин харав.

- Энэ бол ноён Бэггинс. Ёс төртэй, нэр хүнд нь сэвтээгүй гэр бүлээс гаралтай хоббит гэж Гэндальф хариулав.

Бильбо дуугүй мэхийв. Малгайгаа гээчихээгүй бол жинхэнээр мэхийх байлаа л даа... Дээр нь хүрэмний нь товч тасарсныг нь хэлэх үү, өөрийг нь арчаагүй салан задгай амьтан гэж бодох вий гэхээс Бильбо ихэд санаа зовсон янзтай зогсов.



- Би бол шидтэн. Чи миний тухай сонсоогүй ч би чиний тухай их зүйл сонссон. Миний төрөл садан Радагстыг таньж магадгүй. Тэр зэрлэг ойн өмнөд зааг орчим амьдардаг юм гэж шидтэн үргэлжлүүлэв.

- Танилгүй яах вэ. Шидтэй ч гэсэн гайгүй залуу шүү. Бид хоёр үе үе уулздаг юм. За яах вэ, та нарт итгэлээ гэж бодъё. Ямар хэргээр явж байгаа билээ?

- Үнэнийг хэлэхэд бид нар хамаг юмаа алдаад, төөрөөд тусламж хайж явна. Сайн зөвлөгөө өгвөл их тус болохоор байна. Үгүй юу л даа... Бид нар Манант Уулнаас явж байна, замдаа гоблинууд дайралдаагүй бол ч...

- Гоблинууд гэнэ ээ? Та нар уруу дайрсан юм уу? Та нар тэнд юу хийж байсан юм гэж асуухдаа том эрийн дуу арай л зөөлрөх шиг болов.

- Бид мөрөөрөө явж байтал гоблинууд отож байгаад гэнэт дайрсан. Бид баруун зүгээс явж байгаа юм л даа... Ярихад ч урт түүх дээ...

- За яах вэ, сонсьё доо. Алив наашаа ороод ир гээд гэртээ оров. Хоёр гийчин эзнийг даган гэрт нь орлоо. Хэдийгээр зун боловч үүдний цэлгэр том өрөөний голд гал асаж, утаа нь дээшээ харласан багана уруу савсаж, дээвэр дэх гэрэл тусаж буй цоорхойгоор гарч байлаа. Намхан хаалгаар өрөөнөөс гартал царс модоор хийсэн баганад дээр барьсан өргөн дэвсгэг дээр гарч ирэв. Умард зүг өөд харуулж барьсан тул хэдийгээр орой болсон ч дэвсгэг дээр нар тусаж түүний цаана өнгө өнгийн нэрлэж таашгүй олон цэцэгс алаглан дэлгэсэн хивс шиг цэцэрлэг харагдана.

Жаргаж байгаа нар тусах модон вандан дээр сууцгаав. Гэндальфийг ярьж байх зуур хоббит хөлөө савчин цэцэрлэгийн цэцгүүдийг тааж ядан суув. Ихэнх нь огт үзээгүй цэцгүүд байлаа.

- Хэдэн найзынхаа хамт уулыг давтал... гэж Гэндальфийг ярьж эхэлтэл эзэн,

- За байз, тийм хэдүүлээ байсан юм бол тэд чинь хаачсан юм? Энд нэг л найз чинь байгаа юм биш үү? гэхэд Гэндальф,

- Чамд төвөг учруулна гээд би дагуулж ирээгүй юм. Чи дургүйцэхгүй бол би дуудчих уу? гэхэд,

- Тэг ээ, тэг гэж эзэн зөвшөөрөв.

Гэндальф шүгэлдэнгүүт, хэдэн хормын дараа Торин, Дори хоёр хүрч ирлээ.

Өндөр эрийн өмнө очоод ёс төртэй нь аргагүй бөхөлзөв.

- Хачин юм. Энэ чинь хоббитууд биш байна шүү дээ, одойнууд уу?

- Царсан Бамбай Торин, танд зүтгэхэд бэлэн.

- Би бол Дори, танд зүтгэе гэсээр одойнууд дахин мэхийв.

- Баярлалаа, гэвч та нарын зүтгэл надад хэрэггүй, харин би л та нарт хэрэг болж байх шиг байна. Одойнууд надад огт таалагддаггүй, гэхдээ хэрэв чи Трорын хүү Трайны хүү мөн бол, энэ чиний анд мөн бол, гоблины дайсан бас манай нутагт муу санаа өвөрлөөгүй ирсэн бол... Ингэхэд та нар яаж яваад энд ирэв?

- Эдний өвөг дээдсийн нутаг нь зэрлэг ойн баруун зүгт байдаг юм. Одойнууд тийшээ явж байгаа. Харин золгүй тохиолдлоор бид энд учирлаа. Таны эдлэнгээс зайдуу дээд замаар явж гол зам уруу гарах гэж байтал муу санаат гоблинууд дайраад... Би танд хэлсэн шүү дээ гэж Гэндалф одойнуудын өмнөөс тайлбарлан учирлахад гэрийн эзэн,

- Хамаагүй ээ, эхнээс нь ярь, хэл чинь хатчихгүй байлгүй гэж өөрийн бүдүүлгээ харуулаад амжив.

- Айхтар дуу цахилгаантай бороо орж, чулуун аваргууд хоорондоо том том чулуу, хад асгаар шидэлцэж эхэлсэн. Бид ч айж агуй хайж, хэсэг нөхдийнхөө хамт нуугдаж амжсан...

- Хэсэг нөхөд өө? Энд чинь хоёрхон одой байна шүү дээ?

- Өө нээрээ тийм, уул нь ч бид олуулаа л даа гэж Гэндалф үнэнээ хэллээ.

- Тэгээд тэд хаачив? Үхсэн үү, эсвэл гоблинуудад баригдсан уу? Аль эсвэл буцчихаа юу?

- Үгүй дээ, энэ хавьд байгаа. Олуулаа ирэхээс эмээгээд...

- Дууд, дууд. Хоёр одой дахиад хоёр нэмэгдэхэд тээр болох биш. Яриа маань ч удах шинжтэй.

Гэндалфийг шүгэлдэнгүүт Нори, Ори хоёр газар доороос мэт гэнэтхэн гарч ирэв. (Шидтэний тушаасан дагуу одойнууд тав таван хормын зайтай ирж байлаа).

- Ямар шаламгай юм бэ? За, зальт этгээдүүд минь наашаа сууцгаа.

- Нори танд зүтгэхэд бэлэн.

- Ори... гэж одойнуудыг ёсорхож эхэлтэл Беорн тэдэнд,

- За, наад үгээ больцгоо, хэрэг гарвал би өөрөө та нарыг дуудна. Алив, шидтэн минь үргэлжлүүл, тэгэхгүй бол мөддөө оройн хоол идэхгүй нь шүү.

- Бид нар нэг агуй олж хоргодоод дөнгөж зүүрмэглэж байтал гэнэт агуйны хана нээгдэж, гоблинууд үсрэн гарч ирж, биднийг бариад авах нь тэр. Бас бидэнд арваад пони морь байсан.

- Арваад пони морь оо? Та нар чинь явуулын цирк ажиллуулж байсан юм уу? Эсвэл тийм их ачаатай явж байна уу?

- Үгүй ээ, бид нар чинь олуулаа байсан юм. Дахиад хоёр, энэ ирж байна. Энэ үед Балин, Двалин хоёр цэцэрлэгээс гарч ирэн сахлаараа газар шүүрдэх нь холгүй Беорнд мэхийв. Беорн нэг уурлах гэснээ айж сандарсан одойнуудыг харж, тэдний малгайгаа ийш тийш даллан

бөхөлзөн тонголзохыг харснаа өөрийн эрхгүй инээд алдав.

- Яасан марзан нөхөд вэ, за орцгоо, орцгоо. Нэр алдар хэн билээ?

- Намайг Балин гэдэг, харин энэ бол Двалин. Бид танд...

- За тэр зүтгэлээ орхицгоо. Тонголзохоо ч боль, наашаа суу гэж Беорн уриалгахан хэллээ.

Балин, Двалин хоёр гайхшран дэвсэг дээр гарч суув. Беорн Гэндалф уруу эргэн харж,

- За тэгээд, цааш нь гэж тушаав.

- За байз, юун дээр зогслоо доо... Аа тийм, тэгээд надаас бусдыг, бүгдийг бариад авлаа. Би ч цаг алдалгүй хэдэн гоблинуудыг аянгаар зад ниргээд, хананд гарсан хаалга уруу хаагдахаас нь өмнө шургаад гарчихсан.

- Ид шидээ хааяа ч гэсэн ашигламаар юм даа гэж Беорн үг хавчуулав.

- Тэгээд гоблинуудын ухсан хонгилоор явж байтал гоблинуудын Дэд удирдагчийн агуйд ирэв. Тэр хаан ширээн дээр гуч, дөч орчим гоблинуудаа тойруулан сууж байлаа. Миний найз нарыг барьж аваад, гар хөлийг нь гавлаагүй байсан чиг арван хоёрхон одой, дөчин гоблиныг яагаад ч дийлэхгүй юм байна гэж бодоод...

- Арван хоёр оо? Найман одой л байна. Чи арай үлдсэн хэдийг нь өвөртөө нуусан юм биш биз?

- Тийм ч байж магад. Тэр нуугдаж байгаа хоёрыг Фили, Кили гэдэг юм. Гэндалфийг хэлж амжаагүй байтал дээр дурдсан хоёр одой Беорны өмнө ирчихсэн бөхөлзөж байлаа.

- За сууцгаа, нэг ч үг дуугарахгүй шүү гэж Беорн тушаав.

Шидтэн цааш ярьж, хонгилд байлдсан тухай, доод хаалга хүртэл яаж хөглөж байж очсон, ноён Бэггинсийг алдсанаа мэдээд үнхэлцгээ хагартлаа айсан тухай дэлгэрэнгүй ярив.

- Бид доод хаалган дээр ирэнгүүтээ тоогоо авлаа. Тэгтэл бид зөвхөн арван дөрвүүлээ байлаа. Ингээд хоббит алга болсныг мэдсэн юм...

- Арваас нэгийг хасахад арван дөрөв болдог юм уу? Хариу нь ес байх ёстой. Чи бас дахиад хэдийг нуугаад байна уу?

- Чи нээрээ Ойн, Глойн хоёрыг хараагүй юм байна. Өө тэр, хүрээд ирлээ. Оруулж болох уу? гэж Гэндалф Беорныг гэнэдүүлэв.

- Оруул, оруул. Сууцгаа. Ингэхэд чиний ярьж байгааг нэг л сайн ойлгохгүй байна. Хоббит та хоёр, дээр нь арван одой нийлээд арван хоёр л болж байна. Гэтэл чи арван дөрөв гээд байх юм. Шидтэнгүүдийн тоо бидний мэддэг тооноос өөр юм уу? За тэр ч яах вэ, цааш нь ярь.

Беорн ихэд сонирхож байгаа боловч түүнийгээ мэдэгдэхгүйг хичээн сууна. Гэндальфийн өгүүлж байгаа уулын хэсгийг тэр сайн мэддэг байв. Шидтэн цааш нь хоббит хэрхэн буцаж ирсэн тухай ярихад, Беорн сайшаасан байдалтай толгой дохилоо. Гэндальф үргэлжлүүлэн, чулуунд цохиулж алуулахаа дөхсөн, чононуудад бүслэгдсэн тухай, одойнууд айж мод уруу авирч, мөчир дээр суусан зэргээ ярихад, гэрийн эзэн үсрэн босч гараа савчин дэвсэг тойрон гүйж,

- Би тэнд байсан бол үзүүлээд өгөх байсан даа. Арьсыг нь шатаагаад ч зогсохгүй шүү гэж халаглав.

- Яах вэ, цөмөөрөө чадах чадахаараа л зүтгэсэн дээ гэж Гэндальф даруухан зан гаргав. Беорныг адал явдлыг нь сонирхож эхэлсэнд баярласан тэр урам орж яриагаа үргэлжлүүлэн,

- Бид ч амжиж модон дээр гараад сууж байхад доор, чононууд архирч дэвхрээд. Тэгтэл гал гарч ой шатаж эхэлсэн. Удалгүй гоблинууд ирж чононуудтай нийлцгээв. Тэд биднийг шоолж бүр дуу зохиож “Арван таван бялзуухай” гээд л...

- Шидтэн та дахиад л арван тав гэлээ. Гоблинууд хэдийгээр тэнэг ч гэсэн тоо мэднэ, тэд арван хоёрыг арван тав гэж андуурахгүй шүү гэж Беорн тэсэлгүй орилж гарлаа.

- Би ч андуурахгүй. Ингэхэд та Бифур, Бофуртай танилцаагүй байгаа...

- Бас надтай танилцаагүй гэсээр Бомбур дээрх хоёрын араас амьсгаадан гарч ирэв.

Тэрээр ганцаардан, таван хором хүлээж тэсэлгүй Гэндальфийн тушаалыг зөрчин гарч ирж байгаа нь энэ.

- За байз, нээрээ арван тавуулаа байна шүү. Гоблинууд ч тоолж чаддаг юм байна. Модон дээр сууж байсан нөхөд бүгд цугласан байх шив. Одоо ч яриан дундуур орж үймүүлэх хүнгүй боллоо гэж Беорн тайвширсан шинжтэй тэднийг тойруулан харав.

Бильбо Гэндальфийн ухааныг биширч суулаа. Шидтэн зөв тооцоолж сонирхолтой яриагаараа Беорны анхаарлыг сарниулж санасандаа хүрлээ. Дээрээс нь яриагаа байн байн тасалдуулсан нь гэрийн эзний сонирхолыг улам ихэсгэж харин ч тус боллоо. Тэгээгүй бол зочин урьж залах дургүй Беорн тэднийг гэрийнхээ босго ч алхуулахгүй байлаа. Ер нь ч цөөн хэдхэн найз нөхөд нь хол амьдардаг тул Беорн тэднийг урилаа гэхэд ганц хоёроор нь урьдаг, гэтэл өнөөдөр түүний гэрт бүр арван таван гийчин сууж байгаа нь хачирхалтай яа.

Шидтэн яриагаа дуусган бүргэдүүд тэднийг аварч, Каррок хавцгай хүргэн өгч, тэд гол гаталж ирсэн тухай өгүүлэв. Нар жаргаж Манант уулын цаагуур ороход бүрэнхий болж цэцэрлэгт урт хар сүүдэр уналаа.

- Сайхан түүх байлаа. Ойрд ийм сонирхолтой зүйл сонссонгүй гэж Беорн шидтэнг магтаж,

- Гэхдээ ойр хавийн гуйлгачин бүр иймэрхүү үлгэр ярьж ирэх юм бол би ч хоосрох юм байна. Та нар худлаа ярьж, намайг уяраахыг оролдсон ч юм билүү. Гэхдээ уран үлгэр зохиосны чинь

төлөө та нарыг хооллохоос доо. Татгалзахгүй биз?

- Яалаа гэж дээ? Танд маш их баярлалаа гэж одойнууд хоббитын хамт нэгэн зэрэг хашхиралдлаа.

Байшин дотор харанхуй, гэрэл муутай байлаа. Беорныг алга ташихад илбэдсэн юм шиг дөрвөн цагаан пони морь, том саарал ноход гарч ирэв. Гэрийн эзэн тэдний хэлээр ярьдаг бололтой нэг юм хэлэв. Амьтад алга болсноо тун удалгүй ассан бамбар авчран, гал тойрсон багануудад зоов. Ноход хойд хөлөн дээрээ сургуультай юм шиг явж, урд хөлөө гар шиг ашиглан юм зөөж байв. Гал тойруулан модон хөлөн дээр банз тавин ширээ болгов. Бильбод хүртэл суухад намдахаар тийм ширээ болсон тул амьтдын суудаг ширээ болов уу гэж одойнууд таамаглав.

Хонь майлах сонсогдон хар ухнаар түүчээлүүлсэн цав цагаан өнгийн хэдэн хонь орж ирлээ. Бусад нь аяга, таваг, модон халбага, хутга өрсөн цар барин ирэв. Ноход царыг авч ширээн дээр бүгдийг өрнө. Гэндальф, Торин хоёрт зориулж сүлжсэн зэгсээр хийсэн түшлэгтэй, богино хөлтэй хоёр намхан сандал авчирч өгөв. Гэрийн эзэн том хар түшлэгтэй сандал дээр сууж хөлөө жийн ширээний толгойд тухаллаа. Өөр тавилга харагдсангүй. Хоббит, одойнууд хоолоо зогсож идэх нь дээ гэж бодож амжаагүй байтал зүлгэсэн юм шиг гялтганасан хэдэн модны тайрдас өнхрүүлсээр оруулж ирэв. Бүгд ширээний ард сууцгаан хооллоцгоов.

Элрондтой салах ёс гүйцэтгэж, Найрсаг Оромжийг орхин аян замд гарснаас хойш анх удаа ийнхүү тансаг, халуун хоол зооглов. Бамбарын дүнсгэр гэрэл, шажигнан асах галын дөл, ширээн дээрх час улаан хоёр урт лаа өрөөг гэрэлтүүлэхээс гадна зөөлөн уур амьсгал төрүүлж байв. Хоол идэх зуур Беорн эртний домог туульс ярьж, уулын цаана орших онгон зэрлэг газар нутгийн тухай бас зэрлэг ой хэмээх хойд зүгээс умард зүг хүртэл орших харанхуй, аюул дүүрэн уулын тухай олон удаа дурдав. Энэ муу уулс дорнод уруу явах замыг хаадаг. Харин Беорны гэрээс тэр ой хүртэл нэг өдөржин мориор явах аж.

Одойнууд толгой сэгсрэн анхааралтай сонсож суув. Манант уулын дараах Зэрлэг ой бол Ганцаардмал Уул хүрэх замд таарах хамгийн аймшигт бөгөөд хамгийн аюултай ой гэдгийг бүгдээрээ ойлголоо. Нэлээн ярьж идэж уусны дараа Беорн ядарсан бололтой зүүрмэглэж эхлэхэд одойнууд харин эргүүлэн олж авах алт, мөнгө, эрдэнэсийн тухай, уран дархчуудын нарийн арга чаргын талаар ярьцгаав. Беорн энэ яриаг сонирхохгүй байсан биз. Түүний гэрт алт мөнгө байтугай хутганаас өөр төмөр эдлэл огт харагдсангүй.

Ширээ тойрон хорвоо дэлхийн сонин хачинг ярьж том аяганаас зөгийн бал шимэн шөнө дөл хүртэл сууцгаав. Галд мод нэмж хийлээ. Бамбарууд унтрав. Галын дөлөнд баганууд өндөр амьд мод шиг харагдаж, Бильбо ойд очсон юм шиг санагдан шар шувуу орилох, салхи исгэрэх шиг болов.

Хоббит зүүрмэглэж одойнуудын яриа холдож эхэлтэл хаалга чанга хаагдах чимээ гарав. Сэрж хартал Беорн алга. Одойнууд ширээний араас босож гал тойрон сууцгаав. Тэд нарын дуулсан олон дуунаас нэгийг нь та нарт сонирхууля.

Аясын салхиар өвс найгана.

Аниргүй навчис нэвсийнэ

Ойд сүүдэр өдөр шөнөгүй хар

Оргүй ч биш дээ, тэнд амьтад байгаа

Хүйтэн уулын хормойноос салхи

Хөндий тал уруу урсан сийгнэ

Шуугин сүнгэнэнэ, мөчирс бөхөлзөнө

Шуухитнаж ёолно, моддын найрал

Өрнөөс Дорно уруу салхи үлээнэ

Өлөн шуурга өрвөлзөн шуурна

Алтаа даран унтаж байгаа луутай

Аймшигт уулын зүг салхи

Тэнгисийн дээгүүр тэнгэрийн доогуур

Тэмүүлэн тэмүүлэн үлээнэ.

Бильбо дахин зүүрмэглэв. Гэндальф гэнэт босож,

- Одоо унтацгаая. Бид энд аюулгүй гэхдээ гэрийн эзний хэлснийг санахад илүүдэхгүй. Беорн илүү юм ярихгүй тул нар мандтал гэрээс гараад хэрэггүй гэж анхааруулав. Тэдэнд өрөөний нэг буланд модон багана хана хоёрын хооронд ор засаж бэлдсэн байв. Бильбо дэрсэн гудсан дээр хэвтэж, ноосон хөнжлийг дуртайяа нөмрөн нэг мэдэхэд нам унтжээ. Гал ч унтарч.

Шөнө дунд Бильбо юунаас ч юм цочсон юм шиг сэрдхийн сэрэв. Өндийж хартал гал бүр мөсөн унтарч, Гэндальф одойнуудын хамт тайван унтаж, дээвэр дээрх цоорхойгоор сарны гэрэл тусаж байв. Хаалгыг нэг том аварга амьтан маажих шиг болсноо дараа нь архирах дуулав. “Энэ юу болов? Арай Беорн баавгай болж хувиран наашаа орж ирж биднийг самрах вий дээ” гэсэн түгшүүртэй бодол төрлөө. Ямар ч байсан толгой дээгүүрээ хөнжлөө нөмөрч хэвтгэл идсэн хоол, ядарсандаа болоод буцаад нам унтав.

Өглөө унтаж байгаа Бильбогийн дээгүүр Бофур гарах гэж байгаад бүдэрч унаж бөөн дуу чимээ гарахад Бильбо сэрлээ.

- Хөөе, хэвтээ залхуу минь босооч, хоолгүй хоцорлоо шүү гэж Бофурыг хэлэхэд,

- Өглөөний хоол уу? Алив, хаана байна гээд Бильбо харайн босов.

- Бид нарын хоол гэдсэнд байна. Харин чинийх чамайг хүлээж байгаа гэж одойнууд тохуурхаад Беорн алга болчихлоо. Нар мандсанаас хойш түүнийг хайгаад олсонгүй. Өглөөний хоол харин бэлдүүлсэн байна гэцгээлээ.

- Гэндальф хаачив? гэж Бильбо асуунгаа гүйн гарав.

- Ирэхээр нь асуугаарай даа гэж одойнууд хойноос нь хэлэх дуулдав.

Шидэт Гэндальф харин орой болох үед хүрч ирэв. Нар жаргах алдад шидтэн байшинд орж ирэн, оройн хоол идэж байсан нөхөдтэйгөө цуг суулаа. Хоолыг нөгөө л чамин элдэвтэй амьтад зөөж авчрав. Харин гэрийн эзний тухай сураг чимээ гарсангүй.

- Хаагуур явж байгаад ирэв? Беорн хаана байна, түүнтэй тааралдсан уу? гээд одойнууд тал талаас нь лавлахад тэр,

- Та нар байзна, би эхлээд хоолоо идээтэхье. Өглөөнөөс хойш ус ч балгасангүй.

Хоёр ширхэг бүтэн талх цөцгийн тос, өрөмтэй хольж идээд, хэдэн аяга зөгийн бал уусны дараа Гэндальф цадсан шинжтэй хоосон тавгаа түлхэн гаансаа гарган тухаллаа.

- Эхлээд хоёр дахь асуултанд хариулъя. Ингэхэд энэ өрөө ямар өндөр таазтайг та нар анзаарсан уу? Тамхины утааны цагираг гаргахад тун догь юмдаг гээд нэг хэсэг дуугүй болов. Тэр гаансаа сорж утаа цагираглуулан наадаж суув. Цагирагнууд багана ороож, төрөл бүрийн хэлбэр дүрст хувиран, өнгө өнгөөр алаглан дээвэр дэх цоорхойгоор гарч алга болно. Гаднаас харсан бол тун чиг хачирхалтай харагдах байсан байх даа. Хөх, мөнгөлөг, шар, цагаан өнгөтэй том жижиг цагирагнууд дээвэр дээгүүр хөвөн нэг нийлж, нэг салж агаар мандалд уусаад л.

- Би баавгайн мөрийг дагаж явлаа. Зарим нь Беорны, зарим нь өөр баавгайн мөр байсан. Урьд шөнө бидний унтаж байсан гэрийн гадаа хойд, дорнод, умард зүгээс цугласан том жижиг түмэн олон баавгайн чуулган болсон бололтой. Дараа нь тэд бүгдээрээ өрнөд зүг явсан бололтой. Харин тийш хөтөлсөн баавгайн мөр байгаа боловч буцаж ирсэн мөр ер олдсонгүй. Би мөрийг даган Каррок хүртэл явгал тэрнээс цааш мөр тасарсан. Каррокоос цааш гол их гүнзгий, ширүүн урсгалтай, сэлж гарахын ч аргагүй. Тиймээс гол дагаж гарам хайж нэлээн явж дараа нь бас тэр замаараа буцаж ирэх гэж нэлээд цаг алдлаа... Товчхон хэлэхэд баавгайн мөр бид нарын байсан ойн цоорхой хавьд алга болсон. Миний мэдэж олсон зүйл ийм л байна даа. За та нарын асуултанд хариулав уу?

Шидтэн ярьж дууссан бололтой. Бильбо түүний юу гэж хэлэх гэж байсныг гэнэт ойлгосон бололтой.

- Беорн гоблинуудыг чонын сүрэгтэй дагуулаад ирвэл бид нар үхдэл болно. Та нар гэрийн эзэн чоныг үзэн яддаг гэж ярьсан чинь яасан бэ?

- Тэр ч үнэн бололтой. Бильбо, тэнэглэхээ боль, наад толгой чинь ийм юм ойлгодоггүй юм бол очоод унтаж бай.

Бильбо сэтгэлээр унав. Орой болсон тул хийх юм ч олдсонгүй. Бильбо дэрсэн гудсан дээр хэвтэж, одойнуудын дуулахыг сонсож байснаа нэг мэдэхэд унтжээ. Түүний зүүдэнд том том хар баавгайнууд байшингийн гадаа сарны гэрэлд хүнд биеэ дааж ядан бүжиглэнэ. Бильбо сэрээд хартал бусад нь тайван унтаж байлаа. Харин гэрийн гаднаас урьд шөнө сонссон хачин дуу чимээ дахин гарлаа.

Өглөө тэднийг Беорн сэрээв.

- За залуучууд яаж шуухан байв даа? гэж асуун хоббитыг дээш өргөн,

- За та нар чинь гоблинууд, чононуудаас бас аймшгийн баавгайнуудаас аль алинаас нь зугтсан байх нь ээ? гээд ноён Бэггинсийн өмдний мөрөвчнөөс нь татаад авав.

- Пөөх, энэ нөхөр чинь нэлээн зузаарч. За алив явцгаая, өглөөний хоол хөрөх нь.

Бүгдээрээ хоол идэхээр хамтдаа гарцгаав. Беорн одойнуудыг шоолон алиалж хөөр баяр болж жигтэйхэн сайхан ааштай байлаа. Гэрийн эзэн хаагуур явж түүнд юу тохиолдсоныг нь шалгаах хэрэг гарсангүй. Беорн өөрөө бүгдийг ярив.

Тэр орой гэрээс гараад шөнө дунд гэхэд гол гатлан ууланд гарчээ. Тэр хол газрыг ийм хурдан хугацаанд гаталсныг бодоход мань хүн лав баавгайн дүрд хувирч давхисан байх. Тун удалгүй ойн цоорхойд ирж ойр хавийг сонжин эргэлдэж байгаад нэг чоно, гоблин хоёртой таарч барьж авчээ. Тэр хоёрын ярьсныг сонсож, Гэндальф болон одойнуудын үнэн ярьсныг ойлгов. Одойнуудыг алдсандаа хорссон гоблинууд чонын сүрэгтэй хамтран тэднийг хайж, өш хонзонгоо авах бодолтой байгааг мэджээ. Тэд одойнуудыг үзэн ядаж уур хилэндээ бачуурцгаана. Муусайн одойнууд гоблинуудын удирдагчийг алж, чонын сүргийн толгойлогчийн хамрыг түлж, бас хэд хэдэн чоныг амьдаар нь шатаасан гэнэ.

Мэдээж баригдсан гоблин, чоно хоёр бүгдийг ярьж өгөөгүй ч гэсэн Беорн тэдний ярианаас хорон санаатнууд ойр хавийн тосгоныг дээрэмдэхээр төлөвлөж байгааг ойлгожээ. Гоблинууд чонын сүрэгтэй ойр хавийн тосгонуудыг хүйс тэмтэрч, Дэд удирдагчийг нь хөнөөсөн одойнуудыг олж бас тэднийг орогнуулж байгаа хүмүүс болон амьтдад нэг сайн сургамж өгөхөөр хатуу шийдсэн бололтой.

- Та нарын ярьсан түүх их сонирхолтой байсан ч, үнэн гэдэг нь нотлогдмогц бүр ч таатай байлаа. Та нарт итгэхгүй байсныг минь уучилна биз. Манай энэ хавьд Зэрлэг ойн зааг дээр амьдрахад таван хуруу шигээ мэддэг нэгэндээ л итгэхгүй бол маш амархан занганд орно шүү. Ингээд олж мэдэх гэсэн зүйлээ мэдэнгүүт би буцаж яаран ирлээ. Та нарыг ямар шуухан байгаа бол гэж санаа зовж, миний чадаж туслах зүйл байвал туслая гэж бодоод. Үнэнийг хэлэхэд одойнуудыг өнөөдрөөс эхлэн хүндлэх болсон шүү. Гоблинуудын удирдагчийг ална гэдэг чинь тун догь шүү гээд Беорн хэрцгийгээр хөхрөв.

- Та тэр муухай гоблин, чоно хоёрыг яасан бэ? гэж Бильбог асуухад Беорн,

- Өө нээрээ гадаа байгаа, очоод үз гэв.

Гадаа гартал гоблины толгойг гадсанд өлгөж, цаана нь чонын арьсыг модон дээр дэлгэж тохсон харагдав. “Ийм дайсантай болвол ч хэцүүднэ шүү. Ашгүй манай талд байгаа нь яамай даа” гэж бодогджээ.

Нэгэнт Беорн тэдний талд байгааг ойлгосон Гэндалф аялалын гол утга учраа дэлгэж тусламж хүсэхээр шийдэв.

Беорн ч хүн бүрт нэг, нэг пони харин Гэндалфд морь өгч, дээрээс нь хоол хүнс самар, гурил, хатаасан жимс, зөгийн бал бас маш амттай хэдэн хоног ч хадгалахад мууддаггүй боов зэргийг өгөхөөр амлав. Ганц Беорн л хийж чаддаг энэ боовноос багахныг идэхэд л бүтэн өдөр өлсөхгүй явна. Тэрээр гуриландаа зөгийн бал хийж зуурдаг байна.

Хоол хүнсээ авч явахад төвөггүй болгож эвтэйхэн боож баглав. Харин гол горхи гээд л замд бишгүй тааралдана. Уух усны талаар санаа зоволтгүй гэж гэрийн эзэн санууллаа.

- Зэрлэг ой уруу оронгуут байдал өөр болно шүү. Тэнд хоол хүнс байтугай уух ус хүртэл ховор, самарнаас өөр идэх юм олдохгүй. Өдийд самар болоогүй, түүхий байгаа. Гэхдээ та нарыг очих гэсээр байтал самар бүрэн болж бараг ялзарч магадгүй. Би та нарт нум сум өгнө, замд их муухай хорлон санаат амьтад таарна. Базааж авсан усаа хянамгай, бодолтой зарцуулаарай. Ой дундуур нэг зам бий, түүнээс хазайж нэг сөөм ч хажуу тийш алхаж болохгүй. Хар гол тааралдана, уснаас нь ууж, усанд нь орж хэрхэвч болохгүй. Хар голын ус хүнийг мансууруулан унтуулж, ой санааг нь алга болгоно. Нум сумыг өөрсдийгөө хамгаалахад хэрэглээрэй. Замаас гарч огт болохгүй шүү. Сайн ойлгосон биз.

- За миний тусалж чадах зүйл энэ л байна даа. Ойн зах хүрэнгүүтээ та нар зөвхөн өөрсдийн авхаалж самбаа, аз хийморьт найдах хэрэгтэй. Тэгээд морь, пони морьдыг буцаана шүү. За азын тэнгэр та нарыг ивээх болтугай. Энэ замаар буцах бол манайхаар морилон гараарай.

Цөмөөрөө гэрийн эзэнд талархаж, малгайгаа аван мэхийн ёсолж, “Танд зүтгэхэд хэзээд бэлэн” хэмээн бие биенээсээ өрсөн амлацгаав. Хүн болгоны сэтгэл санаа түгшүүртэй болж, хэдийгээр аялал адал явдалтай ч эрдэнэсийг олж авахын тулд амь насаараа дэнчин тавих нь тодорхой боллоо.

Өглөөгүүр эртлэн босож, бэлтгэлээ базаасаар байтал үд болов. Үдийн хоолыг зочломтгой гэрийн эзэнтэй хамт идээд, пони мориндоо мордоцгоон салах ёс гүйцэтгэн аян замдаа гарав.

Өндөр хашааны хаалгаар гараад хойд зүгийг чиглэцгээлээ. Беорны зөвлөж хэлснийг санан, төв замаас зайдуу, холуур явцгаав. Өмнө нь төөрч будилаагүй бол тэд Манант уулыг даваад Агуу Гол цутгалтайгаа нийлж буй газар, Каррок хавцгайгаас нэлээн урдуур гарч ирэх байлаа. Голыг гаталж гарахдаа ойн дундуур явсан хуучин зам бий. Гэхдээ Беорны ярьснаар тэр замаар сүүлийн үед гоблинууд холхилдож хүн амьтныг айлгадаг болсноос хойш зам бүдгэрч зэрлэг ногоо ургаж явахын аргагүй болсон гэнэ. Тэгээд ч тэр зам туулж гарахааргүй гүнзгий намаг уруу хөтлөн очихоос гадна Ганцаардмал уулнаас холдуулж урьд зүгт хөтөлдөг гэнэ. Харин Каррокийн хойгуур явбал Зэрлэг ой, Агуу голын эрэгт ойрхон гарч ирэх тул тэр зүг уруу явахыг Беорн зөвлөсөн юм. Тэндээс Ганцаардмал уул уруу шууд хүргэх, Зэрлэг ойг гэтлэх бараг хэн ч мэдэхгүй зам байдаг гэсэн.

- Манайхтай ойрхон болохоор гоблинууд энэ талаар голыг гаталж, Каррокийг хойд талаар нь тойрохоосоо айдаг юм. Гэвч та нар яарахгүй бол болохгүй. Хэрвээ гоблинууд дайтахаар шийдсэн бол тэд голыг урдуур нь гатлаад, ойр хавийн ойг самнаж, та нарын хүрэх ёстой ойн захыг хүртэл онгичиж орхино шүү. Чоно понигоос хурдан давхидаг гэдгийг мартаж болохгүй шүү. Хойд зүгээ бариад яв. Гоблинууд та нарыг буцаад ирнэ гэж бодохгүй байгаа. Уул ч ойрхон болно. Сайн давхидаг юм шүү гэж захиж байв.

Нэг хэсэг дуугүй явцгааж чадлынхаа хэрээр давхицгаалаа. Зүүн талаас хар уулс хүрээлэн тээр хол мяралзан харагдах голын зурвас аажмаар ойртон голын эргээр ургасан мод харагдлаа. Хурц нар ээж, нам гүм тайван байсан тул удалгүй гоблинуудын тухай бодохоо болив. Одойнууд хоорондоо элдвийг ярьж зарим нь дуулцгаана. Орой болж уулын орой жаргах нарны туяанд асаж байгаа мэт гэрэлтэх үед морьдоо зогсоож буудаллах газраа сонгон харуул манаа гаргаж унтахыг завдав. Энэ шөнө бараг бүгдээрээ чоно ульж гоблинууд орилолдохыг зүүдэлсэн байхаа.

Маргааш тэднийг маш сайхан өглөө угтлаа. Намар болсон юм шиг газар дээгүүр цагаан манан бууж сэрүү татна. Удалгүй нар үүлэн цаанаас мандахад дулаахан болж манан ч арилав. Манай хэд манан арилахаас өмнө цааш хөдөллөө. Дахиад бүтэн хоёр өдөр явахад замд шувуу, хэдэн бугын сүрэг, өндөр ургасан зүлэг ногоо цэцэгнээс өөр юм тааралдсангүй. Бильбо анхандаа бугын сөргөр эврийг бут гэж андуурснаа тун удалгүй ялгаж сурав. Гурав дахь өдөр бараг зогссонгүй. Беорны хэлснээр бол тэд ойн зам дээр дөрөв дэх өдрийнхөө өглөө хүрэх ёстой байлаа. Цаг алдахгүйг хичээж шөнөжингөө сарны гэрэл барин явав. Хоббит ийш тийшээ харахад түүнд модны цаагуур тэднийг дагаж байгаа том баавгайн дүрс жирс жирс харагдах шиг болов. Энэ тухай Гэндальфд хэлэхэд цаадах нь дэмий юм битгий бод гэсэн тул дорхноо мартав.

Шөнө дунд түр буудаллаж амарч аваад дахиад л цааш явав. Нар мандахад аймшгийн ой харагдлаа. Шигүү ургасан мод өндөр хар хана шиг сүндэрлэнэ. Зам өгсүүр болж ойр хавьд нам гүм. Буга, туулай бүгд гэнэт алга болжээ. Үд хавьд ойн зааг хүрч амрахаар тохиров. Энэ хавийн моднууд бүдүүн өтгөн ногоон урт навч, мөлхөө ургамалаар ороогдсон муруй саруй ургасан аж.

- За Зэрлэг ой гэдэг чинь энэ дээ. Хойд зүгийн ойнуудаас хамгийн агуу нь. Харахад айдас төрүүлэхээр сүртэй байгаа биз? За хэдүүлээ пони морьдоо буцаая.

Одойнууд дурамжхан эсэргүүцэх санаатай бувтнаж эхэлтэл шидтэн тэднийг дорхноо номхруулан,

- Яасан дүүрсэн амьтад вэ. Беорноос их хол үлдсэн гэж бодож байна уу? Арай түүнтэй дайсан болох гээгүй биз дээ? Ноён Бэггинс гэхэд л биднийг дагаж амгалан нойрыг хамгаалж явсан том баавгайг хараад амжсан байна. Харин тэр баавгай та нараас илүүтэйгээр өөрийн хайртай пони морьдоо хамгаалж байсныг ойлгохгүй байна уу? Та нар нэг л юмыг сайн ойлго. Хэдий найз болсон ч гэсэн Беорн өөрийн морьдоо хүүхэд шигээ хайрладаг юм шүү. Харин яаж та нарт пони морьдоо өгч унуулсан нь гайхалтай. Тэгээд ийм хүний морьдыг ой уруу авч явбал юу болохыг төсөөлж байна уу?

- За, за одоо болно. Бүр айлгачихлаа. Ингэхэд наад морио яах гэж байна? Лав л буцааж өгөхгүй биз? гэж Торин дурамжхан асуув.

- Тэр ч тийм шүү, буцаахгүй.

- Чи бас адилхан буцаана гэж амласан биз дээ?

- Тэгсэн, гэхдээ энэ морь надад бас хэрэг болно. Би өөрөө Беорнтой учраа олно гэж Гэндальфийг хэлэхэд тэднийг орхиж явах нь гэдгийг одойнууд сая ухаарав. Аймшигт ой уруу орох гэж байхад тэднийг орхиод явах гэж байдаг. Шидтэнг хичнээн гуйж гувшивч тэр бодлоо өөрчилсөнгүй.

- Би бүгдийг та нарт Каррокт байхдаа ярьж өгсөн. Одоо болно. Та нарыг гэсээр би бүр хоцорлоо. Надад урд зүгт хийж дуусгах зөндөө ажил байна. Та нарыг уулнаас бууж ирэхэд таарч магад, үгүй ч байж магад. Энэ бол та нараас хамаарна. Аян замын аз хийморь ноён Бэггинсийн самбаанаас хамаарна даа. Түүнд итгэж болно. Цагаа тулахаар та нарт тун ч их хэрэг болж ихийг бүтээж өгнө дөө. Бильбо, чи битгий уруу царайлаад бай. Ноён Торин, та толгойгоо дээш өргө, битгий уйтгарла. Ингэхэд энэ чинь, та нарын аялал мөн үү? Эрдэнэсийн тухай бодоцгоо. Зэрлэг ой... за тэгээд бусад муу муухай юмыг түр ч гэсэн март. Өглөө болтол толгойгоо зовоогоод хэрэггүй.

Маргааш өглөө Гэндальф хэлснээ давтав. Пони морьдыг суллаж эмээл, ачаагаа авч, хоорондоо эвтэй нь аргагүй хувааж үүрч явахаар болов. Бильбод хамгийн хүнд ачаа таарсан бололтой их л ууртай байлаа. Ийм жижигхэн байж яаж ийм их юм үүрч явах билээ дээ гэж ундууцав.

- Сэтгэлээр унасны хэрэггүй дээ. Энэ хүнд ачаа яагаад ийм хурдан хөнгөн болов гэж халаглах үе тун удахгүй ирнэ гэж Торин өгүүллээ.

Ойролцоох горхиноос усны саваа дүүргэж, пони морьдыг суллахад морьд баярласан мэт давхин алга болов. Бильбо модны цаанаас том баавгай гарч ирэн пони морьдын хойноос алгуурхан гүйснийг харсан гэдэгтээ тун итгэлтэй байлаа.

Гэндальф салах ёс гүйцэтгэв. Бильбо газар сууж сэтгэлээр унан бодлогоширно. Болдогсон бол эд нарыг орхиод шидтэнг дагаад явахсан. Тэрээр өглөөгүүр нэг жаахан юм идэж ходоодоо хуураад аймшгийн ой тийш ширтэхэд өөдөөс нь тас харанхуй айдас үлээж байлаа.

- Хэн нэгэн чамайг харж тагнаад байгаа ч юм шиг гэж амандаа үглэв.

- За баяртай гэж Гэндальф Торинд хэлээд бусад одойнуудад хандан,

- За бүгдээрээ баяртай. Та нар энэ замаар ой дундуур явна. Замаас гарч ерөөсөө болохгүй. Хэрвээ нэг алхам ч гэсэн замаас гарч холдох юм бол ойд төөрч, буцах замгүй болно шүү. Харин би та нартай дахин уулзах хүсэлтэй байгаа шүү.

- Заавал энэ ой дундуур явах ёстой юм уу? Өөр зам байдаггүй юм уу? гэж Бильбо санаа алдан асуухад,

- Өөр зам байхгүй гэж хариулаад,

- Эсвэл энэ замаар явж эр зоригоороо гарна, эсвэл буцаад гэртээ харьж болно. Ноён Бильбо та ичээч. Та эдгээр одойнуудыг хариуцаж яваа шүү, эд нарын амь нас танаас хамаарна. Ойлгов уу? гэлээ.

- Ойлгож л байна. Өөр зам байдагсан бол...

- Тойруу зам байгаа л даа. Хоёр зуу гаруй бээр явж зэрлэг ойг тойрон гарч болно. Өмнүүр тойрох бол бүр их явна. Аль замаар ч явсан аюултай гэдгийг чи мэдэж байгаа. Юу ч тохиолдож болно. Хойд зүгт гоблинууд бас аймшгийн Оркууд байдаг. Урд зүгт Некромантын мэдлийн газрууд бий. Түүний тухай чи сонссон байх. Тэр тэнгэрт тулсан өндөр цамхагт амьдарч дээрээс бүгдийг харж хянаж байдаг хорон санаат түүний гарт орох хүсэл чамд байхгүй биз дээ? Олон юм бодолгүй энэ ойн замаар явсан чинь дээр. Сэтгэл санаагаар уналгүй, замаасаа хазайхгүй бас дотроо залбирч явбал аз чинь таарч ойгоос эсэн мэнд гарах найдвар байгаа шүү. Ойгоос гарсан даруйд Урт Намаг харагдана. Түүний цаана өрнөд зүгт хөгшин Тортогийн хоргодон хэвтээ Ганцаардмал Уулын орой харагдана. Та нарыг ийш явж байгааг мэдээгүй байгаасай гэж найдаж байна.

- Ярихад амархан л даа. За шидтэн минь баяртай. Нэгэнт явах учир олон таван юм яриад яах вэ. Сайн яваарай гэж Торин дурамжхан нь аргагүй дуугарав.

- Та нар сайн яваарай гээд Гэндалф морио шавхуурдан өрнө зүг чиглэн давхив. Гэсэн ч тэссэнгүй хэсэг давхиснаа эргэн харж сүүлчийн удаа захиасаа хэлэх мэт хашхирав.

- Баяртай. Азын тэнгэр ивээх болтугай. Замаас гарч болохгүй шүү.

Тун удахгүй Гэндалф харагдахаа болив.

- Энэ бид хоёр явна л биз гэж хэн нэгэн уцаарлангуй хэлэв. Бүгд яахаа мэдэхгүй сандарсан болохоор уцаараа гаргахад бэлэн байлаа.

Нэгэнт ой уруу орохоос өөр замгүй тул ачаагаа бас нэг нэг шуудай усаа үүрч аваад, ноён Бильбог даган Зэрлэг ой уруу орж явцгаав.

Наймдугаар бүлэг

Аалз ба ялаанууд

Тэд цувран явсаар мөлхөө навч, хөвдөнд дарагдсан, бие биеэ налан түших мэт ургасан яг арк мэт санагдах хоёр том модны дундуурх харанхуй агуй шиг ой уруу орцгоов. Ойн хаалганаас нарийхан махиралдсан жим эхэлнэ. Ойр орчимд дэндүү нам гүм тул тэдний алхаа хүртэл чихэнд цуурайтан маш тод сонсогдож Зэрлэг ой тэр чигээрээ тэднийг тандан чагнаж байгаа юм шиг санагдана.

Аажмаар нүд харанхуйд дасаж эхлэхэд нарийхан муруй жимийг бүдэгхэн гэрэл гэрэлтүүлж байхыг анзаарав. Зарим үед завсаргүй мушгирч ургасан мөчирс, зузаан навчин дундаас төөрч ээдрэлгүй нэвглэн гийх нарны туяа алтан урсгал шиг гялтганана. Ойн гүн цаашлах тутам улам харанхуй болж байлаа.

Тэдний хажуугаар хэрэм модны мөчир дээгүүр ганц хоёр удаа жирсхийн гүйлдэн өнгөрөхийг хурц хараатай Бильбо хараад амжив. Хоббит модон доор овоорсон хөлмөг навчис дунд юу түжигнээд байгааг олж харах гэж толгойгоо бөндөгнүүлэн эрсэн боловч юу ч олж харсангүй. Моддын хоорондуур торлон татсан аалзны шүлс нүд эрээлжлүүлэн нэг л зэвүүн харагдана. Аалзны шүлс жимийг тойрон хажуугаар ургах мод бүрийг битүү бүрхсэнээс жим уруу ороогүй байх бөгөөд жим тусгай хамгаалалттай мэт санагдана. Тун удалгүй хүн бүхэн Зэрлэг ойг Гоблинуудын агуйгаас илүүтэй үзэн ядаж эхлэв.

Энд гоблинуудын харанхуй агуйгаас зэвүүн харанхуй байлаа. Нар ч үгүй, тэнгэр ч харагдахгүй, салхи ч үлээхгүй.. энэ ойг мөнхийн харанхуй, уйтгарт бөгчим нөмөрсөн мэт. Харанхуйд удаан байж сурсан одойнууд хүртэл бачимдан зовж байхад хоббит яаж тэсэх вэ дээ. Тэрээр гэрэл гэгээ үгүйлэн шаналж хором хормоор амьсгаадах нь нэмэгдэж амь нь тэмцэж байлаа.

Шөнөдөө бүр ч хэцүү байлаа. Нүхэнд орсон мэт хав харанхуй. Бильбо нэг удаа нүднийхээ өмнүүр гараа хөдөлгөсөн боловч юу ч харсангүй. Шөнө болохоор даарсандаа биш урилгагүй зочдоос болгоомжлон бие биенээ налж бүгд хамт унтана. Хоббит нэг биш удаа харуулд гарч ойн амьтдын энд тэнд асч унтрах улаан, шар нүдийг харж дотор нь эвгүйцсэн билээ. Энэ нүднүүд гялс гялс хийн анивчин заримдаа бүр унтаж байгаа одойнуудын толгой дээр асна гээч. Хамгийн аймшигтай нь цэхэр ногоон өнгийн сонгино шиг хэлбэртэй томоос том нүд. Хоббит энэ нүдийг хараад үхтэлээ айж билээ. “Лав шавьжны нүд байна гэхдээ нүд нь ийм юм чинь уг амьтан нь ямар бол?” гэж бодохоос аймшгийн.

Эхний хэдэн шөнө түүдэг асаав. Гэтэл ойн амьтад тэр аяараа гэрлийн зүг тэмүүлж түүдгийн гэрэл тойрон шавж, томоос том зарим нь хүний гарын дайтай ялаа шумуул дүнгэнэж аварга сарьсан багваахайнууд эргэлдэх болов. Ингээд түүдэг асаахаа түр хойшлуулсан аж.

Аймшигт ой дундуур бараг л зуун жил алхаж байгаа юм шиг хоббитод санагдав. Өдөр өдрөөр солигдовч эргэн тойронд юу ч өөрчлөгдөхгүй байхад сэтгэл санаа түгшиж эхэллээ. Учир нь хэдийгээр машхэмнэлттэй хооллож, бараг хагас өлсгөлөнгийн байдалд явж байсан ч хоол

хүнс нь өдрөөс өдөрт багассаар л байв. Нэг өдөр хар хэрэм агнах гэж баахан сум үрж үрж арайхийн онож бөөн баяр болж шарж идэх гэтэл учиргүй амтгүй байсан тул дахин ан гөрөө хийсэнгүй. Өлсөхийн зэрэгцээ харангадах шахаж байцгаалаа. Үүрч яваа ус нь дуусах гэж байдаг гэтэл тэдний явж байгаа жим дагуу горхи байтугай шалбааг ч таарсангүй.

Зэрлэг ойн дундуур явсан хэд дэх өдөр ч юм дээ, гэнэт тэдний замнаж яваа жимийг огтлон жижиг мөртлөө түргэн урсгалт уулын горхи тааралдав. Ойн харанхуйд горхи хав хар өнгөтэй харагдав, магадгүй угаас тийм өнгөтэй ч байсан юм уу. Беорны тэдэнд сэрэмжлүүлэн хэлснийг санаагүй бол тэд аль хэдийнэ горхины уснаас ууж, сав суулгаа дүүргэх байлаа. Харин захиасыг нь санан горхийг хэрхэн яаж гатлах тухай хэлэлцэв. Горхи дээгүүр барьсан гүүр аль хэдийнэ нурж ёрдойсон хэдхэн тулгуурууд үлдсэн харагдана.

Усны захад зогсож байсан Бильбо гэнэт уулга алдан хашхирав.

- Тэнд нэг завь байна, нээрээ завь байна гэлээ.

- Хэр зэрэг хол байна? гэж Торин асуув (Одойнууд Бильбог илүү хурц хараатай гэдгийг аль хэдийнэ зөвшөөрсөн бөгөөд одоо зөвхөн хоббитын нүдэнд итгэх болсон билээ).

- За байз, арван алхам болов уу даа.

- Уул нь цаад талын эрэг хүртэл бараг гучаад алхам баймаар... За миний нүд ч дээ, залуугийнхтайгаа адилгүй. Тэгээд ч гуч байна уу, арван хоёр байна уу, ялгаа юу байх вэ. Үсрээд гарна л гэж байхгүй дэг. Бас сэлж болохгүй гэсэн.

- Юмаар тээглүүлж байгаад татвал яах бол?

- Тэгээд яах юм? Тээглүүлээд татсан чинь цаанаа юмнаас уяатай бол яах вэ?

- Ноён Торин, та андуурч байна. Тэр завийг эрэг дээр зүгээр гаргаад хаячихсан юм шиг харагдаад байна. Гэхдээ ийм харанхуй байгаа юм чинь уясан олс нь харагдахгүй байж болох л юм.

- За байз. Бидний дунд Дори хамгийн чадалтай нь, харин Фили хамгийн залуу бөгөөд хурц хараатай. Алив, Фили нааш ир. Чи тэр завийг харж байна уу?

- Харж байна гэж Фили хариулав. Одойнууд шуудайнуудаа ухаж хэд хэдэн ороосон олс олж авчран, хамгийн урт олсны үзүүрт төмөр дэгээ зангидаж бэхлэв. Жижиг сажиг хэрэгтэй зүйл тэдэнд хүрэлцээтэй байлаа. Фили олсыг авч цаад эргийг онилон онилон байж шидлээ. Дэгээ усанд пүлхийтэл унах сонсогдлоо.

- Дутуу шидчих шиг боллоо. Дахиад хүчтэй шид. За юундаа айсан юм. Бид нарыг усанд орж болохгүй, уснаас ууж болохгүй гэсэн болохоос нойтон олс барьж болохгүй гэж хэлээгүй шүү гэж Бильбо Филийг тайвшруулав.

Фили эргэлзсэн бололтой олсыг болгоомжтой татан авч дахин нэлээн удаан онилж байгаад шидлээ.

- Оночихлоо. Бараг оночихлоо. Гэхдээ ялигүй давуулчихав уу даа. Алив аажуухан тат, тээглэж юу магад. Яг боллоо. Одоо маш болгоомжтой татна шүү.

Олс хөвчрөн чангарлаа. Фили яавч ганцаараа дийлэхээргүй тул Кили, дараа нь Ойн, Глойн нар ирж туслав. Хүчээ нийлүүлэн татахад завь усанд пал хийтэл орж бүгд өнхөрч унав. Азаар Бильбо олсны үзүүрээс барьж амжин татаж модны мөчрөөр тогтоож авангаа,

- Туслаарай гэж хашхирахад Балин гүйн ирж тэр хоёр хамжин завийг дээр гаргав.

- Уул нь уяатай л байж дээ гэж Балин завины хамар дээрээс унжих оосрын үзүүрийг заав.

- Бид нар ч аргагүй хүчтэй юмаа. Сайн олс байсан байна шүү.

- За хэн эхэлж явах вэ? гэж Бильбо асуув.

- Би Фили, Балин бас Бильбо нарыг аваад явъя. Бид нарын араас Кили, Ойн, Глойн, Дори, Ори, Нори, Бифур, Бофур нар явна. Хамгийн сүүлд Двалин, Бомбур хоёр голыг гатлах болно.

- Би дандаа сүүлд нь. Цөхөрлөө, одоо боллоо биз дээ. Ер нь яахлаараа би сүүл мушгиж байдаг юм Бомбур нэлээн дургүйцэн үглэв.

- Чи хамгийн бүдүүн юм чинь. Харин хөөрхий Двалин хамгийн хөнгөхөн нь тиймээс та хоёр яг таарна. Одоо маргалдахаа больцгооё. Үглээд байвал үнэхээр нэг гай гараад ирнэ шүү гэж Торин санууллаа.

- Хүүе, энэ чинь сэлүүр байхгүй байна шүү дээ гэж Бильбо гэнэт уулгалан,

- Бид чинь яаж хөвөх юм бэ? Сэлүүргүй... гэлээ.

- Алив, олс өгөөтөх гэж Фили хэлээд олсны үзүүрт дахиад өөр дэгээ уяж бэхлээд цаад эрэг тийш шидлээ. Дуу чимээ гараагүй тул дэгээ модны мөчирт орооцолдсон бололтой. Сайтар татахад олс ер хөдөлсөнгүй.

- За одоо завиндаа суугаад олсноосоо татаад цаад эрэгт гарна шүү. Харин үлдсэн хүмүүс завийг түрүүчийн олсоор татаж буцааж авчраад сууж байна гэж тэрээр тайлбарлав.

Тун удалгүй бүгд горхины нөгөө талд гарцгаалаа. Хамгийн сүүлд Двалин, Бомбур хөвж, Двалин олсны үзүүрийг барьсаар завинаас буув. Харин Бомбур амандаа нэг юм үглэсээр Двалины араас дагатал гэнэт хачин аймшигтай юм болох нь тэр. Энэ үед гэнэт туурайн чимээ сонсогдож ой дотроос буга үсрэн гарч ирж сандарсан одойнуудыг нэг мөргөөд юу ч ойлгосонгүй цааш давхиж нүд ирмэх зуур горхины цаад эрэгт үсрэн гарч алга болов.

Энэ хооронд ганцаараа сандарч самгардаагүй Торин бугыг шархдуулав. Буга бүдэрч харанхуйд харагдахгүй болсон хэдий ч туурайн чимээ жигд тод биш болоод явчихав. Хөл нь гуйвж байгаа бололтой. Одойнууд Ториныг мэргэн харвасанд талархаж эхэлтэл гэнэт Бильбо,

- Бомбур усанд уначихлаа та минь! гэж муухай орилох дуулав.

Бомбурыг завинаас бууж амжаагүй байхад буга ойгоос гарч ирэн горхин дээгүүр үсрэхдээ туурайгаараа түүнийг цохиод амжиж. Бомбур тэнцүүрээ алдаж, завь ч дайвалзан, эргээс холдож, урсгал даган урсжээ. Бүдүүн Бомбур усанд тэр чигтээ унаж эрэг хавийн мод мөчрөөс зүүгдэн ядан амь тэмцэж байхад нь завь урсаад явчихжээ.

Бомбурын малгайн орой харагдах газар уруу олс шидтэл ашгүй Бомбур шүүрээд авав. Түүнийг эрэг дээр хурдхан гаргацгаалаа. Мэдээж, тэрээр голдоо ортол норсон боловч муу юм болсноос дээр байв. Бомбур гэнэт бөх гэгч унтаад өгөхөд одойнууд ямар ч арга хэрэглээд түүнийг сэрээж дийлсэнгүй.

Бүгд Бомбурын бүтэлгүйг дуудаж түүнд уураа гаргав. Завь байхгүй, одоо яаж нөгөө эрэгт гарч бугыг олох билээ (Бугын шинэхэн мах оройн хоолондоо зооглоно хэмээн горьдож байсныг хэлэх үү). Тэгтэл нохойн дуу, ангын бүрээ сонсогдоод явчихав. Хойд зүгээс жим чиглэн ан хийж байгаа анчид ойртож байгаа бололтой. Одойнууд болгоомжлон чимээ чагнан цөм дуугүй болов.

Гэтэл харанхуйгаас гэнэт цав цагаан согоо хэдэн тугалаа дагуулан үсрэн гарч ирэв. Тэд ямар нэгэн гэрлээр цацарч, гэрэлтэж байгаа юм шиг харагдана.

Торин амаа ангайж ч амжаагүй байтал гурван одой нум сумаа шүүрэн авлаа.

Хачирхалтай нь, нэг ч сум амьтдыг оносонгүй. Амьтад гэнэт гарч ирсэн шигээ гэнэт алга болов. Харин шаралхаж ундууцсан одойнууд харвасаар байлаа.

- Больцгоо. Одоо болно гэж Торин хашхирахад бүгд сумаа аль хэдийнэ дууссан байлаа. Беорны бэлэглэсэн юм ийнхүү огт хэрэггүй болов.

Өдрөөс өдөрт улам харанхуй болсоор байлаа. Горхи тээр ард үлдэж, нөгөө л уйтгар гуниг төрүүлсэн ой мод өмнөх өдрүүд адил жимийн хажуугаар сүглийсээр. Зэрлэг ой хэзээ ч дуусахгүй нь гэсэн бодол дахин төрөв. Хэрвээ одойнууд энэ ойн тухай яльгүй жаахан мэддэг байсан бол бас буга согоо гэнэт гарч ирсний учрыг тунгаан бодсон бол удалгүй нар гарч, дорнод хавьд байрлах ойн цоорхой маш ойрхон гэдгийг ойлгох байсан сан. Гагцхүү тэнд хүрэхийн тулд тэднээс ихээхэн тэвчээр хатуужил шаардах байлаа.

Харин тэд энэ тухай бодохтой мантай, Бомбурыг ээлжлэн үүрч, туйлдан ядарч явлаа. Бүдүүн Бомбур хүнд гэж жигтэйхэн учир дөрөв дөрвөөрөө ээлжлэн үүрч бусад нь шуудайнуудаа чирсээр жим даган сэтгэл дундуур гэлдэрч байлаа. Уух идэх зүйл багасаж, шуудайнууд хөнгөрсөн ч үүнд олзуурхан баярлах хүн байсангүй. Зэрлэг ойд идчихээр юм ургадаггүй бололтой. Нүд халтирмаар муухай өнгөтэй мөөг, эвгүй үнэр ханхлуулсан ургамалаас өөр юу ч харагдсангүй.

Горхи гаталснаас хойш дөрвөн өдрийн дараа шигүү ой уруу орцгоов. Модны цаанаас бага зэрэг ч гэсэн нар цухуйн харагдаж, нарны туяанд жим сүүмийж гэрэлтэхэд эхлээд цөм баярлацгааж тайвшрав. Гэтэл удалгүй хоорондоо тун адилхан хязгааргүй үргэлжлэх саарал модны эгнээнүүд илүү уйтгар, гуниг төрүүлэх шиг болов. Салхи намуухан сэвэлзэж хөлийн доор навчис хөглөрөх нь намар ойртож буйг сануулна. Хөлмөгт хөл живж, зузаан хивсэн

дээгүүр гишгэж байгаа мэт санагдана.

Бомбур унтсаар байхад нөхөд нь цөхөрч аажмаар сэтгэл санаагаар унаж эхлэв. Заримдаа энд тэндээс инээлдэх, дуулах сонсогдоно. Чагнаад байхад гоблинуудын дуу лав биш, үл танигдах айдас төрүүлэм дуу байлаа. Үнэнийг хэлэхэд Зэрлэг ойд бүх л юмс айдас төрүүлнэ.

Дахиад хоёр өдөр өнгөрөв. Удалгүй жим уруудаж тэд аварга том царс модод ургасан хотгорт хүрцгээлээ.

- Бид арай нөгөө ойн цоорхойд ирээгүй байгаа? Алив, хэн нэг нь тэр модны оройд гараад орчин тойронг ажиглаатах, золигийн ой дуусах дөхсөн байлгүй дээ гэж Торин тушаав.

Мэдээж хэн нэг гэдэг нь Бильбог хэлсэн нь мэдээж. Хоббит хамгийн хөнгөн, хөнгөхөн гэгддэг Двалинаас хөнгөхөн боловч модонд авирч ер чадахгүй аж. Одойнууд түүнийг яг жим дээр ургасан бүдүүн царсны хамгийн доод талын мөчир дээр өргөж гаргав. Бильбо авирч гарлаа. Модны гишүү мөчир нүүр амыг нь шавхуурдаж хэд хэдэн удаа хөл нь халтирч унахаа дөхсөн боловч бяртай хоёр гар нь аварч байлаа. Бильбогийн хувцас, нүүр гар модны холтосны хүрэн, навчисны ногоон өнгөнд будагдсан юм шиг болов. Дээшээ авирах тусам өөдөөс нөгөө том аалзнуудын нэг нь гараад ирэх вий гэсэн айдас ихсэж байлаа. Ашгүй аалз таарсангүй, гэлээ ч яаж дахиад доошоо бууна гэж бодохоос зүрх нь халширч байв. Бильбо модны оройд гарч навчсыг яран толгойгоо цухуйлган харваас жижигхэн аалзнууд энд тэндгүй гүйлдэж, сэтгэл нь хэсэгхэн зуур болтугай амсхийв.

Нарны гэрэл нүд сохлом гялалзаж байв. Тээр доор одойнууд нэг юм хэлэн хашхирсан боловч Бильбо хариулсангүй, хамаг юмыг мартсан мэт боллоо. Нүд нь нарны хурц гэрэлд дасмагц эргэн тойронд эцэс төгсгөлгүй ногоон далай цэлийж, моддын орой давалгаа мэт долгиотон харагдлаа. Ой дээгүүр агч модны эрвээхэйнүүд эргэлдэнэ. Эндхийн эрвээхэйнүүд тас хар өнгөтэй аж.

Хоббит цэвэр агаар амьсгалж эрвээхэйнүүдийг харж мэлрэн удсанаа мэдсэнгүй. Нэг сонсох нь ээ, одойнууд доор орилолдож байлаа. Одойнууд тэвчээр алдсан бололтой дэвхцэцгээнэ. Бильбо эргэн тойронг дахин харж, хязгааргүй ойг дахин нэг ширтээд санаа алдан модноос буув.

Тэдний очих ёстой ойн цоорхой тун ойр байлаа. Бильбо жаахан эргэцүүлэн бодсон бол түүний авирч гарсан мод намдуу газар байгаа тул ойн цоорхой харагдахгүй байна гэдгийг ойлгож болох байв. Даанч сэтгэлээр унасан хоббитын толгойд тийм бодол огт орж ирсэнгүй.

Хөлс нь гоожиж, энд тэндгүй шалбарсан тэрээр одойнуудад олж харсан зүйлийнхээ тухай ярьж өгөв.

- Эргэн тойрон битүү ой мод. Одоо бид нар яана аа? Хоббитыг юманд явуулах ийм л байгаа юм даа гээд л нөгөөдүүл дуу дуугаа авалцан хашхирцгаав. Бараг л энэ бүх зүйлийн буруутан нь Бильбо болох шиг болов. Одойнууд эрвээхэйнүүдийг огт сонирхсонгүй тэгээд ч хоббит зөөлөн сэвэлзүүр салхины тухай ярьж тэдний эгдүүг хүргэв. Одойнууд бахим жин ихтэй тул мод уруу авирч гарч чадахгүй тэгтэл энэ хоббит салхи энэ тэр яриад байхдаа яадаг юм.

Орой унтахаас өмнө үлдсэн хоол хүнсхэнээ идэж дуусгаад, өглөөгүүр гэдэс нь хонхолзсон, өлсгөлөн сэрцгээлээ. Бороо орж модны битүү бүрсэн навчсыг бөмбөр шиг түжигнүүлж эхлэв. Тэдний ам их цангаж байлаа. Дээшээ харж амаа ангайж борооны дусал унахыг хүлээж зогсолтой биш. Гэхдээ энэ өглөө тийм ч муу биш байлаа. Нэг олз нь Бомбур нойрноос сэрлээ.

Тэр гэнэт сэрж, босож сууснаа дагзаа баахан маажив. Тэрээр өөрт тохиолдсон бүх зүйлийг мартжээ, зөвхөн хоббитын гэрт хооллож байсныг л санаж байв. Нөхөд нь түүнд бүгдийг ярьж өгч тайлбарлахыг хичээсэн боловч тэр зөрүүд зан гарган юунд ч итгэхийг хүссэнгүй.

Хоол хүнс дууссан гэдгийг сонсоод бүр уйлсан гээч. Ихэд сульдсан Бомбур хоолгүй олон хоносноос болж хөл нь гуйвж байлаа.

- Яах гэж сэрэв ээ. Ямар гоё зүүд зүүдэлж байсан гээч. Энэ ойтой адилхан гэхдээ арай өөр ой дундуур явж байсан. Мод болгон дээр нь бамбар, дэнлүү зоосон, энд тэнд түүдэг асаад л. Дараа нь би ойн хаантай хамт зоог барьж найрлаад л, дуу дуулаад л ямар сайхан байсан гээч гээд санаа алдав.

- За чи битгий сэтгэл үймүүлээд бай. Ер нь тэгээд дуугүй байхгүй бол би биеэ барьж дийлэхгүй нь шүү. Тэр гайтай горхиноос чамайг гаргаж авснаас хойш олигтой ч хооллосонгүй өдий хүртэл чамайг удаан үүрч явсныг чи ер ойлгож байна уу? Чи бидэнд маш их өртэй болсон шүү гэж Торин уцаарлав.

Нэгэнт идэх хоол байхгүй тул бүгд бүсээ чангалж, хоосон шахуу шуудайнуудаа үүрэн, гунигтай нь аргагүй гэлдэрцгээв. Өдөржингөө явах шиг болов.

Бомбур байнга гонгиносоор байлаа...

- Би хөлөө даахаа болилоо. Жаахан унтмаар байна... гэнэ.

- Чи дахиад унтах юм бол бид нар чамайг орхиод явна шүү. Дахиж л лав үүрч явахгүй гэж бусад нь түүнийг айлгасан боловч Бомбур удалгүй унаад өгөв.

- За та нар явж бай. Би хэвтээд амраатахъя. Юмыг яаж мэдэх вэ, дахиад хоол зүүдлэх ч юм билүү. Ер нь шал дэмий сэрсэн байна.

- Хүүе, тэр. Гэрэл гарч байна гэж хамгийн түрүүнд явж байсан Балин гэнэт дуу алдав.

Нээрээ л ойн гүнд жимийн зүүн талд тод гэрэл гарч байлаа. Хажууд нь дахиад нэг, дараа нь бас нэг гэрэл хойно хойноосоо гялсхийв. Бомбур босон харайж, цөм асаж байгаа галын зүг гүйцгээв. Хэн ч гоблинуудын эсвэл Тролл нарын асаасан гэрэл байх вий гэж болгоомжилсонгүй.

- Миний зүүд ч биелэх нь ээ гэж аахилж уухилсан Бомбур жимээс гарч гал уруу тэмүүллээ. Азаар бусад одойнууд Беорн, Гэндалф нарын захиасыг мартаагүй тул түүнийг татан авч хориглов.

- Тийшээ явбал жимээс гарна. Энэ ойгоос гарч чадахгүй бол-чихвол хоол ундны ямар ашиг байх вэ? гэж Торин бас чиг бодохоор зүйл хэлэхэд,

- Энэ ойгоос гарч чадалгүй байсаар бид өлсөж үхнэ гэж Бомбур хариулав.

Бильбо түүнтэй санаа нийлж байлаа. Ингээд бүгдээрээ баахан маргалдсаны эцэст хоёрыгоо тагнуулаар явуулахаар болцгоов. Гэтэл тагнуулд явах зоригтон олдсонгүй. Бүгд энэ аймшгийн ойд төөрөхөөс айцгааж байлаа. Тэгтэл Бомбур дахиад л зүүдэндээ идэж ууж байснаа яриад эхлэв. Маш их өлсөж байсныг ч хэлэх үү, бүгд санаа шулуудан, хамтдаа гэрлийн зүгт явахаар боллоо.

Жимээс гарангуутаа болгоомжлон газар хэвтэж мөлхөцгөөв. Удалгүй ойн цоорхой дунд асаж буй түүдэг харагдав. Түүдэг тойрсон моднууд дээр бамбар зоосон байлаа. Эдгээр бамбарын гэрлийг тэд харсан байж. Их л сонин, хачин амьтад түүдэг тойрон модны хожуулууд дээр сууж байв. Тэд ногоон хүрэн өнгийн өмсгөлтэй их л гоёсон байдалтай найрлаж байгаа бололтой идэж ууж, дуулж байв. Эд нар ойн эльфүүд байлаа.

Гал дээр шарж байгаа махны амт тэвчихийн аргагүй үнэртэхэд, одойнууд ганц ч гэсэн хэрчим мах олоод идчих санаатай түүдгийн зүг ухасхийцгээв. Гэвч ойн цоорхой уруу тэднийг нэг алхав уу, үгүй юу бүх гэрэл унтарчихлаа. Тас харанхуйд одойнууд бие биенээ хайж эхлэв. Энд тэнд тэмтчиж унаж мод мөргөн бараг бүх ойг сэрээх шахам орилон байж арайхийж бие биенээ олцгоож бүгд бүрэн бүтнээрээ байгаагаа мэдэцгээлээ.

Мэдээж энэ үед жим аль зүгт байгаа эсэхийг тэд тас мартсан байлаа. Нэгэнт төөрсөн нь ойлгомжтой болсон тул ямар ч байсан өглөө хүртэл ойн цоорхойгоос холдолгүй эндээ хоноглохоор болов.

Бильбо дөнгөж зүүрмэглэж эхэлтэл харуулд гарсан Дори,

- Дахиад гэрэл гарлаа, бүр ч илүү хурц гэрэл байна гэж чанга шивэгнэх сонсогдлоо. Бүгд босон харайцгаав. Нээрээ л гэрэл маш ойр харагдаж инээх, ярих, дуулах сонсогдов. Манай хэд нэг нэгнийхээ мөрөн дээр гараа тавин, шилээ даран асаж байгаа гэрлийн зүг хөдөлцгөөв.

- Одоо ухаантай байцгаана шүү гэж Торин сануулаад,

- Эхлээд ноён Бэггинсийг явуулъя. Түүнээс лав айхгүй байх. (Над шиг ийм жижигхэн амьтнаас хэн ч айх билээ дээ гэж Бильбо дотроо бодов) Түүнд муу юм хийж чадахгүй гэлээ.

Бильбог бөгжөө зүүж амжаагүй байтал хэн нэгэн араас нь түлхсэн бололтой. Тэрээр хар эрчээрээ урагшаа унаж ойн цоорхойд асаж байсан бүх гэрэл нэгэн зэрэг унтарлаа.

Дахиад хашхиралдаж, бие биенээ тоолтол хоббит байхгүй байв. Дахиад тооллоо. Бас л арван дөрөв байх ёстой байтал арван гурав болоод байлаа.

-Бильбо Бэггинс. Хүүе хоббит оо чи хаачив? Хараал идмэр, чи хаана байна аа? гэх мэтээр одойнууд уцаарлан харанхуйд тэмтчин эргэлдэнэ.

Хоббит ул мөргүй алга болов. Одойнууд түүнийг олохоосоо өнгөрлөө хэмээн бодож байтал Дори нэг юманд тээглээтэхэв. Модны хожуул байх гэж бодтол хожуул биш харин эвхрэлдэн унтаж байгаа ноён Бильбо байлаа. Одойнууд тал талаас нь чангааж түүнийг сэрээв.

- Яагаад намайг сэрээв? Би хачин гоё зүүд зүүдэлж байхад гэж тэрээр уцаарлав.

- Ээ тэнгэр минь. Бас нэг Бомбур гарч ирэх нь. Үгүй тэр, идэж болохгүй хоол зүүдлэх ямар хэрэг байна?

- Гэлээ ч гэсэн сэтгэл өег яг л жинхэнээсээ юм идсэн шиг болдог юм гэсээр Бильбо одойнуудын хажуугаар хэвтэв.

Гэвч унтаж чадсангүй. Дөнгөж хэвтгэл дахиад л энд тэнд гэрэл асаж Кили нөхдөө сэрээн,

- Гэрэл. Гэрэл гарлаа гэв.

Тэд дуу чимээ хэсэг чагнаснаа бас л тэвчсэнгүй гэрэл тийш явахаар болов. Харин азын тэнгэр тэд нараас зугтаж одсон бололтой.

Ойн цоорхойд бас л эльфүүд найрлаж байв. Гэхдээ энэ удаа идээ будаа гэж гайхмаар тансаг байлаа. Ширээний хойморт ойн хаан залран сууж байгаа харагдана. Түүний алтан шаргал үсийг навчаар сүлжсэн титэм чимж, Бомбурын зүүдэнд орж ирсэн хаантай маш адилхан байв. Эльфүүд аяга дүүрэн дарс дамжуулж, зарим нь арфа хөгжим тоглож, зарим нь дуулж байв. Тэдний өмсгөлийн зах болон ханцуйны уяас дээр шигтгэсэн эрдэнэс гэрэлтэн цацарна. Үсэндээ өнгө өнгийн цэцэг сүлжиж хийсэн тэд бүгдээрээ инээлдэж баясан хөгжилдөцгөөнө. Яг энэ үед эльфүүдийн хөгжмийн аясаар ойн цоорхойд Царсан Бамбай Торин гарч ирлээ.

Хөгжим огцом зогсож, бамбарууд бөхөж, түүдэг хүртэл хар утаа баагиулан шажигнан унтрав. Одойнуудын нүүр өөд үнс нурам пурхийн цацагдаж, тэд нар орилолдон гүйлдэв.

Бильбо ч одойнуудын адил айсандаа баахан ийш тийш гүйж, одойнуудыг нэрээр нь дуудаж байснаа гэнэт ойн цоорхойг тойрон гүйж байгаагаа анзаарлаа. Харин одойнууд түүний нэрийг дуудсаар бүр холдох шиг болов. Хэн нэг нь тусламж гуйж байгаа аятай баахан хашхирч байгаа юм шиг чимээ гарснаа алга болов. Бильбо орь ганцаархнаа харанхуй ойд үлдэх нь тэр.

Хоббит хэцүү хүнд байдалд орчих нь тэр. Тэглээ ч тэрээр үүр цайхаас наана одойнуудыг хайхын хэрэггүй гэж өөрийгөө тайвшруулахыг оролдов. Хоббит нэг модны ёроолд очиж налан суугаад, өөрийнхөө тухлаг сайхан дүүрэн хоол хүнстэй нүхэн гэрээ санагалзав. Үхрийн цээжний мах, шарсан өндөг, маслотай талх зэрэг амттай бүхнээ дурсан санаа алдав. Гарт нь нэг юм хүрэх шиг болохоор нь ухасхийн босох гэтэл хөлийг нь бас нэг юмаар ороосон тул тэрийгээд уналаа.

Томоос том аалз хоббит уруу дайрав. Аалз Бильбог модон доор сууж байхад нь чимээгүй ойртсон бололтой. Аалз харанхуйд харагдахгүй байсан ч Бильбо түүний цэнхэр ногоон нүдийг тод харж байлаа. Бас сэжиг хүрмээр, үстэй хөл нь үе үе Бильбогийн биеийг тэмтэрч

байв. Бильбо цагаа олж ухасхийсэн байж. Яльгүй удсан бол тэрээр хөдөлж чадахгүй болтлоо аалзны торонд ороогдох байлаа. Хоббит байдаг чадлаараа гар хөлөөрөө савчиж өшиглөж гарав. Аалз ч мөчөөгөө өгөлгүй хазах гэж дайран хоёул амь өрсөн тэмцэлдэв.



Ингэж нэлээн удаан үзэлцсэний дараа хоббит гэнэт хутгаа саналаа. Бильбо хутгаа хуйнаас нь сугалангуут аймшгийн аалз шууд ухарчээ. Бильбо хөлөө ороосон торыг хутгаараа зүсэн босон харайж, зориг орж аалзны хойноос гүйв. Аалз урьд өмнө хутга гялалзуулсан этгээдүүдтэй ер байлдаж байгаагүй бололтой хэсэг зуур алмайрчихлаа. Бильбо ч энэ мөчид яг нүд өөд нь хутгаа зоогоод амжив. Аалз галзуурсан мэт чичирч гэдрэгээ харан хөлөө тийчлэн унав. Хоббит гүйж очоод дахиад нэг хатгахад аалз сүүлчийн удаа бололтой нэг татганаснаа хөдөлгөөнгүй болов.

Бильбо ч бас ухаан алдан унажээ. Өглөөгүүр ухаан орж, эргэн тойрноо хартал хажууд нь айхтар том хар аалз хэвтэж байв. Хутга нь юу нь мэдэгдэхгүй хар шингэнд нэлээд будагдсан бололтой. Аймшгийн аалзыг ганцаараа эр зориг гаргаж дийлсэндээ хоббит ихэд зоригжив. Хутгаа навчаар арчих зуур юунаас ч айхгүй байгаагаа мэдэрч дахиад хэд л бол хэд хамаагүй аалзтай байлдахад бэлэн байлаа.

- Би чамайг хатгуур гэж нэрлэе гэсээр шинэхэн нэрлэсэн хутгаа хуйнд нь хийлээ. Ингээд хатан зоригт хоббит маань тагнуул хийхээр аян замдаа мордлоо. Ой хав харанхуй, чив чимээгүй. Ойр хавьд одойнууд ер үзэгдсэнгүй. Эльфүүдэд баригдсан юм болов уу. Бүр айхтар амьтдын гарт орсон бол яана? Одойнуудыг дуудаж хашхирах хэрэггүй л болов уу гэж бодсоноо аль замаар явахаа мэдэхгүй бодолд орон зогсов.

- Беорн, Гэндальф нар байн байн сануулаад байхад үгэнд нь орох минь яалаа гэж өөрийгөө зэмлэн,

- Би одоо энэ аймшгийн ойд гав ганцаар үлдлээ. Би ч өнгөрч дээ гэж өөрийгөө өрөвдөөд амжив.

Нэлээн бодож, тээнэгэлзсэний эцэст ерөөс шөнө дунд тусламж гуйн хэн нэгэн хашхирах шиг болсон тэр зүг явахаар шийдлээ. Азаар зөв чиглэлээ сонгосон байлаа.

Бильбо бөгжөө зүүж сонгосон зүг тийшээ гэтлээ. Хоббитууд хүссэн үедээ маш чимээгүй явж чаддагийг та нар мэднэ. Тэгээд ч муусайн аалзнууд түүний явж байгааг сонсоогүй биз дээ.

Гэнэт өөдөөс нь Зэрлэг ой хүртэл хөврөх, нүүгэлтсэн тас хар сүүдэр гараад ирэв. Ойртож харвал маш олон аалзнууд нэгэн зэрэг нэг том хар тор хэрсэн бололтой. Ойрмогхон байрлах моднууд дээр том том аалзнууд сууж байна. Бильбо бөгжөө зүүчихсэн юм чинь аалзнуудад харагдсангүй. Бөгжөө зүүгээгүй бол юу болох байсныг төсөөлөхийн аргагүй... Тэрээр модны цаагуур орж нуугдан муухай аалзнуудын яриаг чагнав. Аалзнууд ярих ч гэж дээ, дотор муухайруулам нарийхан, чихрах мэт дуугаар исгэрч байгаа юм шиг дуугаран ийнхүү ярьж байв.

- Хэцүүхэн тулаан боллоо. Гэхдээ тэр зузаан арьсны цаана амттайхан шүүс байгаа даа. Шүүсний төлөө байлдахаас өөр яах вэ, гэж нэг аалз хэлэв.

- Жаахан хүлээе. Сульдаад ирэхээр нь...

- Хэтрүүлж болохгүй шүү. Ер нь туранхайдуу, сайн хооллож байгаагүй юм шиг харагдсан шүү.

- Ер нь одоо шууд алахад юу нь болохгүй гэж. Тэгээд дараа нь сойж дүүжилвэл яасан юм? гэж нэг нь санаа алдав.

- Тэртэй тэргүй бараг үхсэн биз гэж эхний аалз хариулахад,

- Үгүй ээ, амьд байгаа. Нэг нь бүр ухаан орсон юм байлгүй савчиж байсан. Би өөрөө харсан...Тэр хараач гэсээр нэг нь хамгийн том ороомог уруу ойртон очоод цухуйж байгаа хамар уруу нь няслаад авав. Хөөрхий муу Бомбур байх даа гэж хоббит бодож амжаагүй байтал нөгөө ороомог орилонгуутаа самбаатай нь аргагүй хөлөөрөө тийрчихэв. Өшиглүүлсэн аалз модон дээрээс хий нь гарсан бөмбөг шиг өнхөрлөө. Бомбур ямар ч байсан амьд бололтой.

Аалзнууд бөөн хөөр болов.

- Чи үнэн хэлсэн байна шүү. Мах гэсэн чинь бүр амь орж өшиглөдөг байна шүү гэж бүтэлгүй аалзаараа тохуурхав. За би чамд үзүүлээд өгнө өө, гайгүй гэсээр унасан аалз мод өөд авирлаа.

Ямар нэгэн юм яаралтай хийхгүй бол болохгүй нь гэдгийг Бильбо ойлгож байлаа. Даанч ганцаараа сүрэг аалз уруу дайраад яах ч билээ. Эргэн тойрныг сайн ажвал хатсан горхины горилд хэсэг чулуу харагдав. Хоббит багаасаа үеийнхэн дундаа мэргэн буудагч хэмээн алдаршсанаар барахгүй туулай, хэрэм түүнийг харангуутаа л тал тийш бутран зугтдаг байв. Хэдийгээр том болсон ч гэсэн дуртай заншлаа гээлгүй нум сум харваж, жад шидэж, ер нь л хараа сайжруулах дасгал байнга хийдэг байлаа. Тэрээр олон зүйл сайн хийж чадна л даа, ер нь түүний тухай тодорхой өгүүлэх гээд ер амжихгүй юм.

Манай хоббит чинь хоол сайн хийнэ, тамхины утаагаар цагариг гарамгай гаргана, маш олон

сонин таавар мэднэ, ер нь их авьяастай шүү. Ингээд Бильбо гарт эвтэйхэн, мөлгөр чулуу сонгож аваад, хөгийн аалзыг яг Бомбурт дөхөж очингуут нь хамаг хүчээрээ шидээд авав. Чулуу аалзны яг нүдэнд онож аалз ухаан алдан үхэтхийн газар унав.

Дараагийн чулуу шигүү торны дунд ноёрхон сууж байсан том аалзыг бут цохиж торыг цооллоо. Аалзнууд сандарцгааж ийш тийш мөлхөн одойнуудыг хэсэг зуур орхив. Тэд нар Бильбог харахгүй ч гэсэн чулуу нисэн ирж байгаа зүг чиглэн, наалдамхай шүлсээ савируулан тэр хавийг торлож эхлэв. Бильбо хурдхан байраа сольж, муусайн аалзнуудыг аль болохоор одойнуудаас холдуулахаар шийдэв. Мань хүний нуугдаж байсан модны орчим бараг тавь шахам аалз цугларав Бильбо тэднийг баахан чулуугаар нүүлгэж, дараа нь уурыг нь хүргэх гэж бүр дуулж, бүжиглэж эхлэв.

Хөөе, хөгшин тарган аалз минь

Үхсэн ялаа барихаа болиоч

Арзгар аалз. Арзгар аалз.

Арзгар торонд чинь би орохгүй.

Тэнэг хөгшин аалз минь

Тэнтэгнэж ирээд намайг бариач

Сачий чинь хүрвэл бариад аваач

Арзгар аалз. Арзгар аалз

Тэнэг аалз, тэнэг аалз

Сачий чинь хүрвэл модноос дүүжлээч.

Мэдээж үүнийг сонссон хэн ч эв хавгүйхэн дуу болж гэх байх, гэхдээ хөөрхий Бильбо ийм түгшүүрт байдалд өөрөө зохиосон гэхэд бас ч яах вэ. Ямар ч байсан тэрээр ингэж дуулж бүжиглэснээр аалзнуудыг уурлуулж амжив.

Зарим нь газар үсрэн бууж зарим нь модноос мод уруу үсрэн цавуу шиг шүлсээ энэ тэнд савируулсаар түүний хойноос ухасхийв. Аалзнууд Бильбогийн санаснаас илүү хурдан урхинд орж, уур хилэндээ баригдан байж ядан байв. Чулуугаар баахан нүүлгүүлж, дээрээс нь тэнэг бүдүүнээрээ дуудуулах ямар таатай байв гэж.

Бильбо цааш нааш нэлээн гүйв. Удалгүй аалзнууд ойн цоорхойг тэр чигт нь аалзны тороор бүрхэх гэсэн мэт энд тэндгүй тор хатгаж эхлэв. Ингэвэл хүссэн хүсээгүй ч дайснаа торонд оруулж авна гэж тооцоолжээ. Бильбо гэнэт зориг орон нэгэн дуу зохиов.

Эргүү мангарууд аа

Тороор барихаар шийдэв үү?

Тэдний тор нь даанч сийрэг.

Тэгтэл би чинь хачин амттай

Алив, мангуунууд аа

Юундаа удаад байна вэ?

Баригдашгүй намайг

Барьж чадахгүй дээ!

Хоббит дуугаа дуулсаар эргэн хартал гарцгүй битүү тор сүлжжээ. Азаар ердөө л хоёр гуравхан утсаар сүлжсэн сийрэг газар харагдав. Бильбо түүнийг хутгаараа цавчин, ойн цоорхойгоос дуугаа дуулсаар зугтлаа.

Аалзнууд хутгыг харсан боловч юу байсныг нь сайн ойлгоогүй бололтой хойноос нь хуйлран гүйлдэв. Арзайсан муухай үстэй хар хөлөөрөө энд тэнд гишгэн, эрүү шүдээ ярзалзуулан, нүд нь уур бухимдлаар дүүрэн эргэлдэх аалзнууд газар дээгүүр, модон дээгүүр хаа сайгүй хөглөрөн гүйлдэж байлаа. Харин хоббит сэмээрхэн буцаад ойн цоорхой уруу гүйв. Аалзнууд түүнийг нэг хэсэгтээ л зэрлэг ойд хайх биз.

Шаламгай хөдлөхгүй бол аалзнууд буцаад ирнэ. Ямар ч байсан одойнуудыг маш хурдан суллах хэрэгтэй. Тэд нарыг ороомог болгон дүүжилсэн мод уруу авирч гарах гэж нэлээд зовлоо. Аалзны бөх торнууд дэм болж, түүгээр дамжин мод өөд авирав. Аалзнууд хөгшин, уур уцаартай нэгнийгээ харуулд орхисон байлаа. Тэрээр ганцаар үлдсэндээ олзуурхан одойнуудын хамгийн шимтэйг нь сонгож зооглохоор шийдсэн бололтой ороомгуудыг нэг нэгээр нь шинжин тэмтэрч байлаа. Манаач аалзанд сэхэл өгөлгүй хутгаараа нэг сайн хатгаад авав. Аалз модноос унаж нам болов.

Бильбо одойнуудыг яаж суллах талаар бодлоо. Хутгаараа цавчвал хөөрхий одойнууд тэр чигээрээ газар унаж бэртэнэ. Хоббит болгоомжтой нь аргагүй модны мөчир даган мөлхөж ороомгууд уруу дөхөв. Хөдлөх болгонд мөчир нахилзаж ороомгууд найгана. Хамгийн ойр байгаа ороомогт ойртож очлоо.

Энэ цухуйж байгаа цэнхэр малгай, энэ их урт хамрыг харахад... лав Фили, Кили хоёрын аль нэг бололтой. Ийм урт хамар ч Филигийнх байх даа хэмээн таамаглаад хэд эвхрэлдэн байж аалзны шүлсийг хутгаараа эвгэйхэн огтоллоо. Тэгтэл Фили ч цухуйж, чадах ядахаараа тийчигнэсээр торноос мултров. Хөшиж, мэдрэлгүй шахуу болсон гар хөлөө хөдөлгөж байгаа түүнийг харсан Бильбо тэвчилгүй инээд алдав. Тэр хоёр хамтран бусад одойнуудыг суллахаар шамдацгаав. Гагцхүү аалзны шүлсэнд хордсон Филигийн хөдөлгөөн удаан төдийлэн сайн тусалж чадахгүйгээр барахгүй хөмсгөн дээрээ наалдсан аалзны шүлснээс салах гэж будилж, сахлынхаа шүлсийг салгах гэж байгаад хамаг сахлаа хэрчээд хаячихлаа.

Тэглээ ч гэсэн тун удалгүй ихэнх одойнуудыг торноос гаргав. Одойнууд хөл дээрээ арай ядан тогтож, зарим нь туйлдсанаас болж зарим нэг нь аалзны хорыг их хэмжээгээр хүртсэн бололтой.

Ингээд Кили, Бифур, Бофур, Бомбур, Дори болон Нори нарыг суллалаа. Хөөрхий муу Бомбурыг аалзнууд ихэд хордуулсан бололтой, тэрээр модны ёроолд овоолсон навчис дээр сэхэхгүй унаад өгөв.

Үлдсэн тавыг суллах гэж байтал аалзнууд уур хилэнгээ оволзуулсаар буцаж ирлээ. Бильбо эхний хэдэн аалзыг хутгалан унатал цохив. Филиг торноос гаргаж авах үед бөгжөө сугалж авчихаад, эргүүлж зүүж амжаагүй байсан учраас аалзнууд өстөн дайснаа сайн гэгч харж авлаа.

- Өө, энэ муу хог чинь ийм оодой амьтан байсан юм уу. За гайгүй ээ, чамайг одоохон барьж аваад хоёр хоног дүүжлэхэд яаж дуулахыг чинь харъя даа, хутга чинь чамд нэмэр болохгүй гэсээр аалзнууд дайрцгаав. Энэ хооронд одойнууд бусдыгаа суллаж амжжээ. Байдал хэцүү байгааг бүгд ойлгож байлаа. Гэхдээ урьд шөнө аалзнууд гэнэгүй байхад дайрсныг бодвол гэрэлтэй гэгээтэй байлдахад бас учиртай байлаа.

Гэнэт Бильбо хөөрхий Бомбурыг хэдэн аалз тойрон шүлсээрээ ороож байхыг харав. Хоббит чанга орилон аалзнууд уруу үсэрлээ. Замд өртсөн хэдэн аалз үсрээд явчихав. Бильбо ч Бомбурыг тойрон эргэлдэж байгаа аалзнууд уруу дайрч хутгаа гялалзуулан эргүүлсээр, аалзнуудтай ёстой нэг байлдах шиг байлдлаа. Ихэнх аалзыг алсны дараа бусад нь тэсэлгүй зугтав.

- Хөөе, доошоо бууцгаа. Цаанаас чинь аалзнууд ойртож байна гэж одойнуудад хамаандлав. Нээрээ ч хөл дээрээ дэнжигнэж байгаа тэдний араас баахан аалз мөлхөн ойртож байгааг азаар харлаа.

Одойнууд түүний үгэнд орж чадах чинээгээрээ хурдалж, зарим нь модноос үсэрч, зарим нь бараг шууд унаж байгаа харагдав. Аалзных нь хор гартал тэд нараас тусламж хүлээх хэрэггүй гэдэг нь тодорхой боллоо. Бифур, Бофур хоёр Бомбурыг босгоод хоёр талаас нь түшин зогсов. Бильбо ийш тийш үсчин тэднийг бүсчлэн ойртох аалзнуудыг хутгалсаар байлаа.

Одойнуудад аалзанд баригдан олзлогдох, эсвэл амь тэмцэн байлдаж ялахаас өөр сонголт байсангүй. Одойнууд хутга, модоор зэвсэглэж бас гарамгай нь аргагүй чулуу нүүлгэж эхлэв. Бильбо кинжал хутгаа гялалзуулсаар, аймшиггүй дайрсаар байлаа. Аалзнууд олноороо алуулж байсан ч дайрсаар. Бильбо туйлдан ядарч эхлэв. Одойнуудаас зөвхөн дөрөв нь л байлдах тэнхээтэй байлаа. Аалзнууд тэдний ядарсныг мэдэрч удахгүй ялна гэдгээ ойлгосон бололтой тороо нэхэж эхлэв.

Хоббит одойнуудад бөгжний нууцыг нээхээр шийдэв.

- За, би одоо нэг хэсэгтээ харагдахгүй болно. Тэгээд аалзнуудыг аль болохоор хол авч явж төөрүүлэхийг бодъё. Харин та нар эсрэг зүг уруу зугтаарай. Хамгийн сүүлд, жимийн зүүн талд эльфүүдийн түүдгийг харсан биз дээ тэр зүгт гүйх нь зөв байх гэж одойнуудад

тайлбарлан зөвлөв.

Аалзны шүлсний хоронд мансуурч дээрээс нь туйлдан ядарсан одойнууд юу яриад байгааг ч сайн ойлгож байгаа шинж алга. Бильбод удаан тайлбарлах цаг зав байхгүй тул бөгжөө зүүв. Одойнууд мэл гайхсан янзтай үлдлээ.

Удалгүй Бильбогийн цоглог дуу дуулдав. Аалзнууд уур хилэндээ автан тэр зүг ухасхийв. Яг энэ үед хамгийн гайгүй хордсон Балин, Бильбогийн юу хэлснийг санан чулуу шидэх дохио өгөв. Одойнууд аалзнуудыг чулуугаар нүүлгэн жаахан завсраар нь бултацгаан бүслэлтээс гарч амжив.

Аалзнууд мэхлэгдсэнээ ойлгож, Бильбог орхин одойнуудын хойноос гүйлдэв. Бильбо ч тэр үед дуулахаа больсон байв. Мансуурсан одойнууд хурдан гүйж чадахгүй учраас аалзнууд гүйцээд ирэв. Зарим нэг нь хэт даварсан аалзнуудтай чадах чинээгээрээ байлдана. Хэдэн аалз ойрын мод уруу авирч дээрээс шүлсээ цацан татаж эхлэв.

Энэ үед Бильбо гэнэт аалзнуудын ар талд үсрэн гарч алмайрсан аалзнууд уруу дайрлаа.

- Зугтаагаарай Би эд нарыг жаал хатгаатахъя гэж хашхирав.

Хоббит хэлсэндээ хүрч, энд тэнд үсрэн гарч ирж, аалзнуудын нүдийг сохолж, гэдсийг нь хатгаж, хөл, гар, торыг нь тас тас цавчиж байв. Тэрээр үе үе алга болж, аалзнуудын уур хилэнг улам хүргэсээр. Аалзнууд хэдийгээр аймшигтай нь аргагүй уурлан исгэрч шүлсэндээ хахаж цацан, харааж зүхэж байсан ч Бильбогийн хутганаас айсан бололтой давшлахаа зогслоо. Одойнууд аажмаар холдож байлаа. Энэхүү тулаан нэг хоёр цагаар тогтолгүй маш удаан үргэлжлэв. Бильбогийн гар цуцаж аргагүй болох тэр үед аалзнууд бууж өгсөн бололтой ухарч, үүр өөдөө буцаж эхлэв.

Энэ үед Бильбо одойнуудтай урьд шөнө эльфүүдийн түүдэг түлж байсан ойн цоорхойд гарч ирсэн байлаа. Энэхүү ойн цоорхой ид шидтэй, эерэг энергиэр дүүрэн ч юм шиг. Магадгүй аалзнууд үүнээс эмээн зайлсхийв үү? Ямар ч байсан ойн энэ хэсэгт амрах завшаан олдсонд олзуурхан, бүгд газар үг хэлэх ч тэнхээгүй унаад өгөв. Амарцгаасны дараа одойнууд Бильбог шаналгаж эхэллээ. Тэд нар бөгж хаанаас олсон тухай дэлгэрэнгүй ярьж өгөхийг хүсэв. Харин Балин хоббитыг Голлумын тухай, бас оньсого таалцсан тухай дахин ярьж өгөхийг шаардлаа.

Ашгүй бүрэнхий болж одойнууд Бильбог шалгаахаа больж, өөрсдийн өрөвдөлтэй байдлын тухай бөөн бодол болцгоов. Замаа хэрхэн яаж эрэх, хоол хаанаас олох тухай, бас Зэрлэг ойгоос яаж гарах гээд өчнөөн олон сэтгэл зовоосон асуудал байгаа юм чинь. Одойнууд эдгээр асуултаа жижигхэн хоббитоос хэд хэдэн удаа асууна. Гэндальфийн хэлж байсны дагуу ноён Бэггинсийн тухай одойнуудын сэтгэгдэл нэлээд өөрчлөгдөв. Одойнууд Бильбог тэднийг аврах ид шидтэй, мундаг төлөвлөгөө гаргаад ирнэ хэмээн найдаж байгаа нь илт байлаа.

Баярлаж талархсанаа олон удаа байн байн илэрхийлж, зарим нь бүр мэхийн ёслох гэж оролдсон боловч толгойгоо даалгүй унаад өгөв. Бөгжний тухай үнэнээ ярьсан ч Бильбогийн нэр хүнд асар өндөр хэвээр байлаа. Бөгж ч яах вэ дээ, ид шидтэй л юм байгаа биз, харин тийм юмыг бас зөв эзэмшихэд уран ухаан шаардагдана шүү дээ.

Магтаалд умбасан Бильбо өөрийгөө бараг л хорвоо дэлхийд байхгүй адал явдлын ангууч хэмээн бодож эхэлтэл даанч хоосон ходоод нь түүнийг илүү мөрөөдөлд автуулсангүй. Төөрч гарсан жим уруугаа яаж буцаж орох тухай байнга сануулна. Өлсөж байгааг ч хэлэх үү, хоолноос өөр юм толгойд нь үл орно. Бодолд автсан Бильбо арга чарга бодсоор, өвс ширтсээр нэг мэдэх нь ээ ядарсандаа зүүрмэглэжээ. Түүнийг дагаад одойнууд хойно, хойноосоо “давсанд” явцгаав.

Харин Балин унтаж чадахгүй, үе үе инээж, өөрөө өөртэйгөө ярьсаар байв.

- Тийм байх аа. Би харалгүй хажуугаараа гаргасан юм байна. Би гэж нэг эргүү толгой тэрийг анзаардаггүй. Бас Голлумыг мадлаад авсан. Их зальтай, адтай эр байх нь ээ. Товчнуудаа гээсэн гэлүү? Үгүй ер, сайхан мадлав аа аа аа... гэсээр арайхийж нэг юм унтав.

Бүгд тайван унтаж нэг хэсэгтээ л нам жим. Гэнэт Двалин өндийж эргэн тойрноо харснаа,

- Торин хаачив? гэлээ.

Аймаар юм. Тоолтол бүгд нийлээд арван хоёр одой, нэг хоббит байлаа. Гэтэл нийлээд арван дөрөв байх ёстой. Ингэхэд Торин хаачив, ямар золгүй явдал түүнд тохиолдов оо! Болсон явдлуудыг эргэн санаж, хоорондоо удаан ярилцлаа. Удалгүй нойрондоо дийлдэн буцаад унтацгаав. Цөмөөрөө аймшгийн зүүд зүүдэлнэ.

Туйлдаж ядарсандаа харуул, манаа гаргалгүй унтацгаасан тэднийг одоохондоо ойн цоорхойд унтаж байгаагаар нь орхиод урьд өмнө юу болсныг эргэн санацгаая.

Торин нэлээн өмнө, сүүлийн үйл явдал өрнөхөөс өмнө баригдсан билээ. Эхлээд Бильбо эльфүүдийн тойрон сууж байсан түүдэгний гэрэлд оронгуугаа нам унтсаныг санаж байна уу? Түүний дараа Торин өөрөө ярилцахаар шийдэн алхаж дараагийн түүдгийн гэрэлд орж бас мансууран унтжээ. Тиймээс Торин аалзнуудтай хийсэн тулаан, одойнуудын орилж хашхирах зэргийг огт сонсоогүй байна. Дараа нь түүнийг ойн эльфүүд олж аваад агуй уруугаа аваад явсан байна.

Тэр шөнө энд тэнд найрлаж байсан амьтад бол ойн эльфүүд байсан нь үнэн. Угаас ид шидтэй тэд хэнээс ч айдаггүй, бас хорт санаа тээдэггүй гэлээ ч танихгүй бүхэнд маш болгоомжтой хандана. Дээд эльфүүдтэй ургийн холбоотой боловч тэдний цэцэн мэргэн ухааныг арай гүйцэхгүй. Ойн эльфүүд эртний удам судартай бөгөөд тэд нарын өвөг дээдэс дундаж Дэлхийг хэзээ ч орхиж явж байгаагүй. Бусад эльфүүд алс хол, баруун зүгт орших үзэсгэлэнт сайхан орныг зорин явж, тэнд очоод эльфүүдийн гурван омог (Цайвар арьстай эльфүүд, газар доор амьдардаг эльфүүд мөн далайн эльфүүд) болон суурьшин амьдарсан гэдэг. Эдгээр омгууд хэдэн үеэрээ өөрсдийн ид шидийг хөгжүүлэн, улам цэцэн мэргэн болж, сайн сайхан зүйлсийг хийж бүтээхийг эрмэлзэн амьдардаг.

Хэсэг хугацааны дараа зарим эльфүүд буцаад дундаж Дэлхийдээ эргэж иржээ. Харин ойн эльфүүд хэзээ ч ойгоо орхиж байгаагүй. Тэднийг нар сар ивээдэг ч тэд өөрсдөө од гаригийг биширч, шөнө дундуур ойгоор зугаалан тэнгэр дэх ойн гүн уруу орно. Хүмүүс ой уруу ойртож амьдардаг болсноос хойш эльфүүд модны гүн уруу нүүх болсон гэдэг. Ямар ч гэсэн эльфүүд

ямар ч үед хэвээрээ үлдэж, хэнд ч хэзээ ч муу юм хийж байгаагүй юм.

Зэрлэг ойн баруун талд байрлах ойн цоорхойгоос хэдэн бээрийн цаана том агуйд ойн эльфүүдийн хаан амьдарна. Агуйн том чулуун хаалганы өмнүүр хойд зүгийн хотгороос эхэлж, намаг уруу цутгадаг гол урсана. Асар том агуй газар доогуур олон хэсэг болон салаалж, түүнийг эльфүүд хэд хэдэн том заал болгон хуваажээ. Эдгээр заалууд нь уужуу өргөн, өндөр таазтай. Гоблинуудын аймшгийн агуйтай зүйрлэхийн аргагүй. Агуйд зөвхөн эльфүүдийн хаан амьдарна. Эльфүүд цуглуулсан алт, эрдэнэсээ хадгална. Жирийн ард эльфүүд ойн оромжиндоо эсвэл модон дээр амьдарна.

Хааны амьдрах агуйд бас шорон байдаг. Баригдсан Ториныг энэ шоронд оруулав. Эльфүүд одойнуудад төдийлэн дуртай биш болохоор ноён Торинтой боловсон эелдэгээр харьцсангүй. Учир нь урьд өмнө эльфүүд одойнуудыг эрдэнэсийг нь хулгайлдаг хэмээн хардаж тэдэнтэй нэг бус удаа дайтаж байжээ.

Харин одойнууд болохоор танай хаан өчнөөн юм захиалчихаад төлбөрөө төлөхгүй юм чинь бид нар авах ёстой юмаа л авсан гэнэ. Дашрамд хэлэхэд, эльфийн хаан янз бүрийн эрдэнэс тэр тусмаа мөнгөн эдлэл, үнэт чулуунд ухаангүй дуртай. Эрт дээр үед эльфийн хаад ноёд тоолж баршгүй их эрдэнэстэй байсныг мэдэх тул тийм хэмжээний эрдэнэс цуглуулахыг мөрөөддөг гэнэ. Харин одойнууд эльфүүдийг дэмий цаг үрж, зугаа цэнгэл хөөх дуртайг нь сайн мэднэ. Тэд эльфүүдийг эрдэнэс олох гэж зовдоггүй, худалдаа наймаа хийдэггүй, газар тариалан эрхэлдэггүй гэж байнга зэмлэнэ.

Торин энэ бүгдийг мэдэж байсан хэрнээ түүнийг нэг муу халаасны хулгайчтай адил хандана гэж даанч төсөөлсөнгүй. Царсан Бамбай Торины өвөг дээдэс хэзээ ч эльфүүдтэй байлдаж байгаагүй болохоор эрэмбийн дагуу хүндлэн хүлээн авах байх хэмээн горьдож байсан нь талаар болов. Тиймээс тэрээр ихэд уурлаж, ямар ч асуултанд хариулахгүй гэж шийдэв. Ингэснээр бас эльфийн хаанаас аялалын зорилгоо нууцлахад амар юм.

Ториныг хаан дээр авчрахад хаан нэлээн ширүүн харж хэдэн юм асуулаа. Торин асуулт болгонд өлсөж үхэх гэж байгаа тухайгаа л ярих.

- Яагаад чи хамсаатнуудтайгаа биднийг дайрдаг билээ гэхэд,

- Бид өлсөж үхэх гээд та нараас багахан хоол хүнс гуйх гэсэн юм.

- Одоо тэгээд найз нар чинь хаана байна?

- Мэдэхгүй, аягүй бол ойд хаа нэг газар өлсөж үхэх гэж байгаа байлгүй.

- Та нар манай ойд юу хийж байгаа юм бэ?

- Бид өлсөж цангаад хоол хайж явсан юм.

- Ер нь яах гэж манай ойд ирсэн юм гэхэд Торин хариулсангүй.

- За яах вэ. Наадахыгаа харанхуй гянданд хийгээд орхи. Удаан суухаараа ухаан сууж хэл ам нь

нээгдэх байхаа. Чи ч зөрүүд юмаа, бид ч гэсэн дутахгүй байж чадна шүү.

Ийнхүү Ториныг гавлаж, хамгийн доод агуйд хаяж, бат бөх модон хаалгыг дангинатал хааж түгжлээ. Гэхдээ түүнийг хооллож ундлав. Эльфүүд олзлогсодтойгоо сайн харьцдаг. Ямар гоблинууд биш дээ! Харин атгаалжин том аалзнуудыг хайр найргүй устгадаг юм. Ингээд Торин хааны шоронд орох нь тэр. Өгсөн талх махыг нь идэж, усыг нь уугаад гялайснаа илэрхийлсний дараа тэрээр анд нөхдөө санан хэрхэн яаж байгаа бол хэмээн санаа зовж суув. Тун удалгүй бүх юмны учир тайлагдаж, Торин юу болсон тухай цөмийг мэдэж авлаа. Гэхдээ энэ тухай дараагийн бүлэгт өгүүлнэ. Энэ бүлэгт бяцхан хоббит ямар их зүйл хийж чадахаа дахин баталсан шүү.

Есдүгээр бүлэг

Аврагч торхнууд

Маргааш өглөө нь аян замдаа эртхэн гарцгаалаа. Жимээ олохгүй бол өлсөж үхнэ гэдгийг арван хоёр одой, нэг хоббит сайн ойлгож байлаа. Тэдний найм нь жим тэр зүгт байгаа хэмээн таамагласны дагуу заасан зүгт гэлдрэхээр шийдэн хөдөлсөн боловч хол явж амжсангүй. Бүрэнхий болмогц энд тэнд бамбар дүрэлзэн асч, модны цаанаас жад, нум сумаар зэвсэглэсэн эльфүүд гараад ирэв. Тиймээс, зөв чигт явж байсан эсэхээ ч мэдэж амжсангүй.

Зогсохоос өөр аргагүй болов. Эргэцүүлэх гэж хэн ч оролдсонгүй, харин ядарч туйлдсандаа болоод тэр үү баригдсандаа бараг баярласан гэж хэлэхэд болно. Учир нь эльфүүд олзлогдсондойгоо эелдэг харьцдаг. Тэгээд ч одойнууд хэдэн хутга бариад эльфүүдийн нум сум, жадны эсрэг яаж байлдах билээ. Тиймээс тэд шууд буун өгч, эльфүүд тэднийг төвөггүй хүллээ. Харин Бильбо бөгжөө зүүгээд авлаа. Эльфүүд хэдийгээр харанхуйд сайн хардаг боловч хоббитыг харж амжсангүй.

Тэд одойнуудын нүдийг боож, ой дундуур туулаа. Одойнууд Зэрлэг ойн аль хэсэгт байгаагаа мэдэхгүй байгаа юм чинь ингэх хэрэг байгаагүй л дээ. Бильбо байдгаараа хурдлан бас бамбарын гэрэлд өртөхгүйг хичээн хойноос нь дагаж гүйнэ. Гэхдээ нэг хэсэгтээ хоцорч, үерлэн харлах голын дээгүүр гарч байхад нь арай ядан гүйцэж очив. Энэ гүүр нь эльфүүдийн хааны ордон уруу ордог ганц зам нь юм. Гүүрний нөгөө талд өндөр өндөр шигүү ургасан модтой хотгорын энгэрт нүсэр том хаалга дүнхийж харагдана. Энэ бол эльфүүдийн хааны ордны гол хаалга байлаа. Гүүрний наана бахь үндэс нь голоос ургаж гарсан модод харагдана.

Олзлогсодыг гүүрэн дээгүүр туув. Бильбо нүсэр том хаалгыг хараад бага зэрэг эвгүйрхэн зогслоо. Гоблинуудын аймшгийн агуйнуудаас ялгаагүй юм шиг санагдахад айдас төрөн аргагүйн эрхэнд нөхдийнхөө хойноос аварга том хаалга чихран хаагдахаас нь өмнө дотогш шургаж амжлаа.

Эльфүүд цуурай ихтэй олон салаа хонгилуудаар явахдаа дуулцгаав. Тэдний дуу цуурайтан улам чанга дуулдана. Гоблинуудын агуйг бодвол эльфүүдийн агуй уужим, дулаахан бас тухтай санагдав. Одойнуудыг туусаар чулуун баганаар гоёж чимсэн уужуу танхимд орууллаа. Танхимын голд байрлах уран сийлбэртэй хааны суудал дээр толгой дээрээ жимс, хүрэн улаан өнгийн навчсыг сүлжиж хийсэн титэмтэй, гартаа очир сийлбэртэй таяг барьсан, эльфүүдийн хаан сууж байлаа. (Титэмийг нь хараад намар болж байгааг бүгд ойлголоо, зундаа хааны титэмийг ойн цэцгээр сүлжиж хийдэг аж).

Хаан олзлогсодыг ихэд ширүүн харснаа хүлээсийг нь тайлахыг тушаав.

- Эд нар зугтаж чадахгүй. Хөл дээрээ зогсож чадахгүй, бараг унах гэж байгааг хараач. Манай шидэт хаалга эд нарыг хааш нь ч хөдөлгөхгүй.

Хаан тэднийг хэн болох, мөн хаашаа явж байгаа тухай нэлээн байцаасан боловч Торины хэлснээс өөр илүү зүйл мэдэж авсангүй. Одойнууд үнэхээрийн уурлаж үг хэлээ ч цэгнэх

ухаангүй хааны асуултанд түрэмгий, түрэмгий хариулав.

- Ойд төөрлөө гээд бид нарыг барьж байгаа юм уу? Эсвэл өлсөж үхэх дөхсөн нь буруу юу? Ингэхэд та нар тэр хараал идмээр аалзнуудыг бид нарын өөдөөс дайруулсан юм уу?

Хааны уурласныг хэлэх үү.

- Та нар миний зөвшөөрөлгүй орж ирчихээд юу, юу гэнэ ээ? Гол горхи, ой мод, зам бүгд минийх. Ичдэг ч болоосой. Бид нар биш харин та нар өчигдөр гурван ч удаа миний албатууд уруу дайрахыг завдсан. Та нарын гайгаар өчнөөн муухай атгаалжин аалзнууд нэг дор цугларсан. Зэрлэг ойн эзэн хааны хувьд та нар энд юу хийж байгааг чинь дахин асууж байна. Хариулцгаа. За яах вэ, хариулахгүй бол гяндан та нарыг сургаад өгнө өө, гайгүй. Та нараас илүү зөрүүд эрчүүдийг номхотгож, зөв боловсон харьцаатай болгож байлаа.

Хаан тэднийг хооллож ундалсны дараа харанхуй гянданд хорихыг тушаан, нэг нь ч гэсэн санал бодлоо өөрчилж “ухаантай” болохоос нааш гаргаж болохгүйг хатуу анхаарууллаа.

Энэ дашрамд хэлэхэд, хаан тэдэнд Царсан Бамбай Торин энд олзлогдоод байгаа тухай нэг ч үг унагаагүйг та анзаарсан болов уу? Одойнууд энэ тухай Бильбогийн ачаар тун удалгүй мэдсэн билээ.

Хөөрхий Бильбо яасан гээч. Тэрээр чимээ болгоноос айж цочин, орь ганцаараа өчнөөн олон хоног өнгөрөөж байлаа. Эльфүүдэд санаандгүй баригдчих вий гэхээс Бэггинс шөнө хүртэл унтаж үл чадна. Өдөр хоног ч өнгөрөхгүй бөгжөө ч авч болохгүй, ямар их шаналав аа. Одойнуудыг цөхөртлөө хайж хийх юмаа олж ядан агуйн хонгилуудаар хэсүүчлэн өдөр хоног өнгөрөөж байв. Хэдэн удаа бүр агуйгаас гарч үзлээ. Мэдээж түр зуур. Тэрээр одойнуудыг орхиж явах талаар огт бодоогүйгээр барахгүй өөрийн амьдралаа тэдэнгүйгээр төсөөлөхгүй болтлоо дасчээ.

Ордны хаалга ид шидтэй ч гэсэн эльфүүдийн хаан албатаа дагуулан үе үе анд, эсвэл өөр нэгэн аянд гарах үед нь хоббит амжиж араас нь шургаж гарч амждаг байв. Ингэх нь бас эрсдэл ихтэй. Учир нь хэн нэгэнтэй мөргөлдөхөөс болгоомжлон сүүл мушгиж явах тул хэд хэдэн удаа хаалганд бараг хавчуулагдахаа дөхсөн. Тэгээд ч ингэж гарч явах нь Бильбод төдийлөн сайхан санагдсангүй.

Эльфүүдийг дагаж явах гэж оролдсон боловч тэр нь талаар болов. Эльфүүд хурдан явахад Бильбо хоцорч төөрөн, ордны хаалгыг олох гэж баахан будилсан удаа бий. Ан хийж чадахгүй юм чинь, маш их өлсөж ядрав. Ордонд байх нь хоббиттод илүү өлзийтэй байлаа. Ядаж өлссөн үедээ зоориноос, заримдаа боломж олдвол бүр ширээн дээрээс идэх юм хулгайлах боломжтой. Өлсөнө гэж байхгүй.

“Би ч бүр хулгайч болж дууслаа л даа. Гэхдээ бүр барьцаалагдсан хулгайч шүү. Гадагшаа гарах гарцгүй, нэг байшингаа хэд дахин ухаад л... Амьдралдаа ийм гутамшиг үзсэнгүй. Би гэж тэнэг амьтан яах гэж тэр Гэндальфийн үгэнд орж энэ одойнуудыг дагаж гарав аа... Дулаан гэртээ галынхаа дэргэд сууж байхгүй” гэсээр өөрийгөө нэг өрөвдөж, нэг зэмлэж өдөр хоногийг өнгөрөөж байв. Уул нь Гэндальф гарцаагүй байдалд орсон тухайгаа дуулгахсан гэж

ихэд хүсэвч боломж байхгүй тул улам гутран суулаа. Иймээс, бяцхан хоббит зөвхөн өөртөө найдаж энэ хэцүүхэн байдлаас гарах зам олох хэрэгтэйг ойлголоо.

Бараг хоёр долоо хоног өнгөрсний эцэст Бильбо асар их ухаан зарцуулсан, бас айхтар болгоомжтой тагнуул хийсний ачаар одойнуудын хоригдож байгаа хонгилыг мэдэв. Арван хоёр одойнуудыг арван хоёр камерт нэг нэгээр нь хорьжээ. Нэг удаа эльфүүдийн яриаг санаандгүй сонстол дахиад нэг одойг хамгийн доод талын хонгилд хоригдож байгааг мэдэж авав. Тэр лав Торин гэдгийг ойлгосон хоббит хичнээн баярласан гээч. Тиймээс, хамгийн түрүүнд Торины хоригдож байгаа хонгилыг олж ойр хавьд нь хэн ч байхгүй үед түүнтэй хэдэн үг сольж амжив.

Энэ үед Торин сэтгэлээр уначихаад ерөөс эльфүүдийн хаанд аялалын жинхэнэ зорилгоо хэлэхээр шийдээд байлаа. Тэгтэл яг энэ үед Бильбогийн жонгиносон дуу гарахад бараг ухаан алдах дөхөв. Гэхдээ учрыг хурдан ойлгож, хаалга уруу ойртон ноён Бэггинстэй нэлээн удаан бөгөөд нухацтай ярилцав.

Бильбо цаг алдалгүй эльфүүдийн хаанд юу ч хэлж болохгүй гэсэн тушаалыг дамжуулав. Зориг орсон Царсан Бамбай Торин урьд нь бодож байсан бодлоо орхиж эльфүүдийн хаантай наймаа хийхээ болив. Уул нь тэрээр хаанд эрдэнэсээсээ амлан, эрх чөлөөгөө худалдан авах талаар бодол тээж байж. (Энүүхэндээ ярихад одойнууд луугийн хамгаалж байгаа эрдэнэсийг бараг л лууг ялаад, авчихсан юм шиг л ярьж байлаа.) Одоо харин шал өөр боллоо. Ноён Бэггинс баригдаагүй байхад юун наймаа ярих билээ? Одойнууд Бильбог ямар нэгэн юм заавал сэдэж олно гэдэгт бүрэн итгэлтэй байлаа.

Ер нь Гэндальфийн хэлж байснаар одойнууд Бильбог олж авсандаа хязгааргүй баяртай байв. Магадгүй шидтэн юу болохыг урьдчилан мэдэж байсан болохоор хоббитыг энэхүү нэр хүндийн өндөрлөгт хүрэхэд нь саад болохыг хүсээгүй ч юм билүү?

Харин Бильбо өөрөө одойнуудын итгэл найдварыг нь ойлгож түүнийг даах хүсэлгүй байлаа. Ингэхэд Бильбо ямар шидтэн биш дээ. Гэндальф энд байдагсан ч болоосой, даанч түүнийг хаанаас олох билээ дээ. Шидтэнгүүдэд ямар ажил мундах биш дээ, хаа нэгэн зүгт давхиж яваа биз. Ийнхүү олон юм бодсоор Бильбогийн толгой хагарахаа дөхөв. Тэгсэн хэрнээ олигтой, оновчтой санаа оноо ер олсонгүй. Мэдээж ид шидтэй бөгж түүнд асар их хэрэг болно, гэхдээ арван гурван одойнуудад арай багадаад байв. Хоббит бодох тусмаа л аргаа барна.

Уншигч та хоббитыг ямар нэгэн арга зам олж, нөхдөө аварна гэдэгт итгэж байсан биз? Яг л тийм юм болсон доо. Одоо энэ тухай тодорхой өгүүлье.

Хоббит одойнуудыг хайж эльфүүдийн хонгилуудаар хэрэн төөрч байхдаа агуйгаас гарах өөр нэг гарц олжээ. Уулын гол агуйн зүүн танхимаар шидэт хаалганы доогуур урсан гарах ажээ. Гэхдээ эльфүүд ямар нэгэн юм тээвэрлэхдээ ой дундуур зөөж явахын оронд гол ашиглан салаар урсгадаг байна.

Хэрвээ газар доорх урсгалыг даган харанхуй хонгилоор явбал хааны дарс хадгалдаг зоорь уруу очно. Хааны зооринд хэдэн зуу, бараг хэдэн мянга гэхэд хилсдэхгүй дарстай торх

хураалгаастай байдаг. Зөвхөн хаан ч биш, ер нь эльфүүд дарсанд дуртай гэж жигтэйхэн. Харамсалтай нь энэ хавьд усан үзэм тариалах боломжгүй тул дарсыг бусад хэрэгцээт зүйлсийн хамт өмнө зүгийн эльфүүдээс эсвэл хүмүүсээс худалдаж авдаг ажээ.

Бильбо нэг торхны ард тухлан сууж эльфүүдийн яриаг чагнав. Орж гарч байгаа эльфүүдийг сайн ажиглаж төмөр торыг яаж онгойлгохыг хараад авав. Бас хааны чалчаа албатын ярианаас дарсыг яаж агуй уруу тээвэрлэдгийг мэдлээ.

Эхлээд Удаан Нуурын орчим байдаг хүмүүсийн хотын зүг газраар эсвэл усаар тээвэрлэж аваачна. Хот тэр аяараа усан дээр, өндөр өндөр баганан дээр сүндэрлэдэг учир тийшээ ямар ч дайсан ялангуяа хорлон санаат Тортог хүртэл дайрч зүрхэлдэггүй байна. Тэндээс торхтой дарсыг уулын голоор урсгал сөрж салаар эсвэл хавтгай ёроолтой завиар зөөдөг аж. Хоосон торхнуудыг газар доорх урсгал уруу шидээд төмөр торыг нээхэд торхнууд урсаж Зэрлэг ойн баруун зүгт байрлах цоорхой хадтай тохойд цугларна. Эльфүүд урсаж ирсэн торхнуудыг хооронд нь холбон боож сал болгон Удаан Нуур орчим усан дээр байрлах Эсгарот хот уруу урсгана.

Байдлыг тал бүрээс нь бодож бодож эцэст нь Бильбо оргох төлөвлөгөө боловсруулав. Одоо зөвхөн боломжтой үеийг л тэвчээртэй хүлээх үлдлээ.

Нэг орой эльфүүд тогтсон дэглэмийн дагуу олзлогсдод хоол өгсний дараа бамбаруудыг аваад явцгаав. Хонгилд тас харанхуй болох үед хоббит хааны дарс хувиарлагч, харуулын даргатай ярьж байхыг сонсов.

- Хоёулаа явж шинэ ирсэн дарсны амтыг сонирхъё. Дөнгөж саявтар ирсэн хэдэн торх байгаа. Өнөөдөр зоорийг жаал цэвэрлэхгүй бол хоосон торхнууд хөглөрөөд зайгүй болж байна. Бага зэрэг дарс балгачихвал ажил хийхэд ч урамтай. За чи эс андах биш дээ.

- Тэгье, тэгье. Удахгүй том найр болох гэж байгаа. Наад шинэ дарс чинь хааны ширээнд тавьж болох ч юм билүү, үгүй ч юм уу шалгах хэрэгтэй дээ. Тааруухан бол хэн ч уухгүй шүү дээ гэж харуулын дарга уухайн тас зөвшөөрөв.

Үүнийг сонссон Бильбо ухаангүй баярлав. За яг одоо төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх цаг ирлээ. Тэрээр эльфүүдийг даган гэтэв. Нөгөө хоёр ч зоорины хажуудах жижиг өрөөнд очин тухлан сууж, инээд хөөр болсоор ширээн дээрх хоёр ваар дарснаас тамшаалан ууж гарлаа. Үүнийг харсан Бильбо бүр ч олзуурхав.

Учир нь хаанд ирүүлсэн дарс Дорвинион хэмээх газраас ирсэн бөгөөд жирийн албат, цэргүүдэд биш хааны найранд зориулсан байж. Тиймээс энэ дарсыг ваараар бус харин жижиг аягаар уух ёстой. Ойн эльфүүд нэлээд чанга дарсанд согтдог болохоор Бильбогийн баярлах нь аргагүй биз дээ.

Тун удахгүй харуулын дарга зүүрмэглэж, ширээн дээр толгойгоо унаган нам унтав. Хааны дарс хувиарлагч нэг хэсэг өөрөө өөртэйгөө ярьж байснаа бас л унтаад өгөв. Хоббит гэтсээр өрөөнд шургаж, харуулын даргаас багц түлхүүрийг сэмээрхэн мулталж аваад эргэж хар эрчээрээ камер тийшээ гүйв. Хоббит өөрөө харагдахгүй ч, хүнд түлхүүрүүд хөдлөх болгонд

нь хангинан жингэнэж, Бильбогийн зүрх айсандаа дэлбэрэх дөхөж байлаа. Хүйтэн хөлсөө асгаруулсаар одойнуудын хоригдож байгаа хонгилд ирэв.

Хамгийн түрүүнд Балиныг суллахад, нөгөөтөх нь жигтэйхэн гайхаж бөөн юм асууж сандаргав.

- За, за дараа тухтай ярьж өгнө, одоо бусдыгаа хурдхан гаргая. Намайг дагаад хоцрохгүйхэн шиг яваарай... Дахиж ийм боломж бид нарт олдохгүй. Хэрвээ эльфүүдийн хаан мэдчихвэл баларсан юм болно шүү. Бодохоос ч аймаар. Тиймээс одоо дуугүй хурдхан дагаад яв.

Бильбо хаалгануудыг нэг нэгээр нь онгойлгосоор удалгүй Ториноос бусдыг суллаж амжлаа. Тас харанхуйд одойнууд хоорондоо мөргөлдөн нэг нэгнийгээ гишгэж, тэр болгонд хараал урсган уцаарлан чанга чанга шивнэлдэнэ. Тэр болгонд хоббитын зүрх пал хийнэ. “Юун их чимээ гаргадаг амьтад вэ. Дуугүй байж чаддаггүй юм байх даа” гэсээр дотроо айж явлаа. Азаар нэг ч харуул тааралдсангүй.

Харуулын даргын хэлснээр тэдний хаан намрын сарын их найр наадам хийхээр цөм ой уруу явсан бололтой.

- Хөөх, за ёстой сонин юмаа. Гэндальфийн зөв байж дээ, бид танд төлж баршгүй өртэй боллоо шүү, ноён Бэггинс гэж мэл гайхсан Царсан Бамбай уулга алдсанаа,

- За, ингэхэд бид хаашаа явах вэ? гэлээ.

Бильбо одойнуудад оргох тухайгаа танилцуулахаар шийдэв. Одойнууд төдийлөн таашаахгүй болов уу гэж таамаглаж байсан нь зөв байжээ. Одойнууд түүнтэй хэрхэвч санаа нийлэхгүй гэдгээ илэрхийлэн, тэр ч байтугай болгоомжлохоо мартан дуу дуугаа авалцан маргаж эхэллээ.

- Бид хад мөргөж, живж үхнэ. Үгүй чамайг чинь овоо юм сэтгэчихлээ гэж бодсон чинь харин бүр бүтэшгүй зүйл ярьж байна гэсээр хоббит уруу дайрав.

- За тэгвэл тэр харанхуй хонгилдоо буцаж очоод, камертаа ороод хэрхэн яаж гарах талаар өөрсдөө бодоцгоо. Дараа нь надад дахиж түлхүүр олдохгүй ч байж магадгүй шүү.

Бильбог ийнхүү ухааруулахад одойнууд бодолд оров. Нээрээ ч бодох нь ээ өөр арга зам хайх хэцүү. Ид шидтэй хаалгаар гарч болохгүй, агуйд хэдий болтол нуугдах билээ, баригдаж л таарна. Буцах замгүй болсон одойнууд хоббитыг даган зоорь уруу бууцгаав. Замаараа хааны дарс хувиарлагч, харуулын дарга хоёрын хурхиран унтаж байгаа өчүүхэн өрөөний хажуугаар өнгөрлөө. Дорвинионы дарс таатай зүүд илгээсэн бололтой нөгөө хоёр тааламжтай инээмсэглэн унтаж байлаа.

Маргааш өглөө одойнуудыг оргосныг мэдмэгц харуулын даргын нүүр царай яаж өөрчлөгдөхийг ойлгосон Бильбо түүнийг өрөвдөн түлхүүрүүдийг буцааж тавилаа.

- Юу ч гэсэн ингэсэн нь дээр. Шоронгийн харуулын дарга муу биш эльф шүү. Баригдсан одойнуудыг гомдоогоогүй. Түүнийг хамаагүй хатуу битгий л шийтгээсэй дээ. Маргааш

аймаар юм болно доо. Бид нарыг гайхамшигт ид шидтэй гэж бодно доо. Бүгдээрээ нэгэн зэрэг оргоно гэдэг чинь... За алив түргэлээрэй, баригдахаасаа өмнө нуугдах хэрэгтэй.

Унтаж байгаа эльфүүдийг Балинаар мануулаад бүгд зоорь уруу оров. Цаг тун бага байлаа. Удахгүй хааны дарс хувиарлагчид хоосон торхнуудыг газар доорх урсгал уруу түлхэж оруулахад нь туслах гэж нэмэлт хүч ирэх ёстойг Бильбо сонсоод амжсан байлаа. Зоорины гол дунд дарсны хоосон торхнууд байсан ч онгойж өгөхгүй, онгойсон нэг нь хаагдахгүй тул тэд нарыг ашиглахгүй гэж шийдэв. Хажууд нь харин өөр том торхнууд харагдлаа. Эдгээрт хааны хэрэгцээний алим, цөцгийн тос бас бус нарийн нандин зүйлийг хийж авчирдаг байна.

Одойнууд багтах дайтай арван гурван торхыг шилж авав. Зарим нэг нь их уужуу байсанд одойнууд дургүйцэн, өнхрөх үед баахан нүдүүлэх нь хэмээн болгоомжлон ярьж байтал Бильбо хаанаас ч юм дэрс олоод ирэв. Одойнууд дэрсийг торхон дотроо дэвсэж, дотор нь орж хэвтэв. Ганц Торин л торхондоо багтахгүй ийш тийш хөрвөн учраа олохгүй нэг хэсэг түжигнэв. Арай хийж нэг, Торины учрыг олоод Балин торхыг нь хааж амжаагүй байхад цөмөөрөө бүтэж үхлээ хэмээн гонгинож эхэллээ. Бильбо ч хурдхан шиг бүх торхнуудыг хааж харагдсан нүх бүрийг битүүлэв. Тэгээд нэг амьсгаа авах зуураа мартсан зүйл байгаа эсэхийг дахин шалгав. Бүх зүйл бодсоны дагуу болсон юм шиг...

Хэдхэн хормын дараа хонгилд дуу шуугиан, гэрэл гэгээ гарч эльфүүд хоорондоо ярьж байгаа сонсогдох нь тэр. Хэдэн эльфүүд инээлдсээр зооринд орж ирэв. Тэд ажлаа аль болохоор хурдхан дуусгаж хөгжилтэй найрандаа буцаж очих гэж яарч байгаа нь илт.

- Хөгшин Гэлион хаачив аа? Найран дээр ер харагдсангүй гэж нэг нь чангаар хэлэхэд,

- Хөөе, хурдан гарч ирэхгүй бол би явлаа. Дээр хамаагүй хөгжилтэй шүү гэж нөгөө нь хариулав.

- Хөөе, хараач. Нөгөө хөгшин гайхал чинь энд харуулын даргатай тусгай найрласан бололтой. Хоёулаа ухаангүй согтуу унтаж байна гээч.

- Өө, наадахаа сэрээ, сэрээ. Унтах цагаа олов оо гэж бүгд тэвчээр алдсан бололтой хашхирцгаалаа.

Гэлион өөрийг нь сэрээхэд, бас тохуурхаж байгаад их л дургүйцсэн бололтой.

- Та нар чинь яасан уддаг юм бэ? Би бүр хүлээж хүлээж ядраад унтсан байна гэж ундууцав.

- Аргагүй ээ, бүтэн ваар дарс уусан юм чинь ядралгүй яах вэ гэж бусад нь дахин тохуурхав.

- Алив, тэр нойрны эмнээсээ багахан хийгээтэх. Ажиллахад урам орно. Харин наад найзыгаа сэрээгээд яах вэ. Унтаж байг.

Эльфүүд дарсыг нэг аягаар дамжуулан ууцгаав. Дарс таалагдсан бололтой улам их хөөрцгөөсөн боловч согтсонгүй.

- Хөөе, Гэлион оо, чи арай андуураагүй биз? Энэ торхнууд чинь ямар хүнд юм бэ? Дотор нь

юм байгаа юм биш үү?

- За битгий залхуурцгаагаад бай. Ажил хийхгүй байсаар бүр залхуу болсон гэдэг нь. Юуны чинь хүнд гэж, алив, хурдан ажиллацгаа гэж дарс хувиарлагч уурлав.

- За, өөрөө мэд. Ямар нэгэн юм болвол чи хариуцна шүү дээ. Хэрвээ хааны хүнс хүмүүст үнэгүй очих юм бол хаанд таалагдахгүй л байх гэсээр эльфүүд торхнуудыг ус уруу өнхрүүлж эхлэв.

Ус уруу, ус уруу. Пүл

Урсан өнхөр, өнхөр. Пүл

Бүү жив, өнхөр, өнхөр

Бүгдээрээ өнхөр, өнхөр

Тэд ийнхүү дуулсаар торхнуудыг харанхуй нүх уруу шидэцгээлээ. Торхнууд хавиралдан мөргөлдсөөр, хана мөргөсөөр хар нүхэнд унан газар доорх урсгал даган урсана.

Яг энэ үед хоббит гэнэт маш том алдаа хийснээ ухаарав. Уншигч та бараг таасан байлгүй дээ. Тэгээд ч дотроо инээд чинь хүрэн сууж байсан байх. Гэхдээ хөөрхий хоббитын оронд байсан бол та ч гэсэн алдаа хийлгүй бүгдийг тооцоолж чадах байсан болов уу? Ингээд хөөрхий хоббит зооринд үлдэж харин одойнууд бүгд урсаад аян замдаа гарч алга болов. (Гэхдээ үүнийг урьдчилан тооцоолсон байсан ч гэсэн хоббитыг торхонд орсны дараа хэн торхыг бөглөх вэ?) Энэ удаа ч Бильбо огт ганцаар үлдэх шиг болов. Ид шидтэй хаалгаар аргалаад гарлаа гэхэд тээр хол орших Удаан Нуурын дэргэдэх Эсгарот хотыг яаж олох билээ? Хүнд байдалд орсон нь тодорхой болов. Одойнууд ч гэсэн хоббитгүй баларна биз дээ?

Эльфүүд төмөр торыг нээхээр бэхэлсэн олсоо татаж эхлэв. Торхнууд тун удалгүй торноос гарч голд урсан ороход бэлэн болов. Эльфүүд их л баяр хөөртэй байгаа бололтой дуугаа дуулав.

Харанхуй урсгал та нарыг урсгаг, урсгаг

Хайрт нутагт чинь аваачиг, аваачиг

Хатуу, хойд нутгийн хавцлаас

Харь, газрын доорх хонгилоос

Өдөртөө өтгөн сүүдэртэй

Өргөн ойн цоорхой тийш

Шөнийн гол урсгаг, урсгаг

Салхины шивнээ, ойн дундуур

Голын тэртээ урсган аваачиг

Голын тэртээ нуга, намаг

Газраас одод хүртэл цагаан

Тэнд шөнөдөө хүйтэн, түнэр

Тэнгэрт ганцхан одод гялалзана

Эх дэлхийг туяаруулан

Их голын дээгүүр үүр цайхад

Өмнө зүг урсаарай, торхнууд

Ногоон нугын зүг урсаарай, урсаарай

Усны захад сүрэг бэлчинэ

Уул толгодоор модод цэцэглэнэ

Бөөр ягаан жимс улайрна

Бүр өндөрт наран гялалзана

Харанхуй урсгал та нарыг урсаг, урсаг

Хариас нутаг руу чинь аваачиг, аваачиг!

Хамгийн сүүлчийн торхыг нүх уруу өнхрүүлэх үед Бильбо тэр торхноос зүүгдэн пүл хийтэл мөс шиг хүйтэн усанд унав.

Усанд унангуутаа хоббит сэлж гарч ирээд, торхноос зууран дээр нь гарахыг оролдлоо. Гэвч хоосон торх нааш цааш бултан өнхөрч, усан дээр хөвөн эргэлдэж дээрээ мордуулсангүй. Эльфүүдийн дуулж хөөрөлдөх нэг хэсэгтээ сонсогдсоноо чимээгүй болж, Бильбо гав ганцаараа харанхуйд, усанд хоцров. Ядаж байхад нөхөд нь бүгдээрээ торхон дотор байж байдаг. Ямар ч нэмэр алга.

Торхнуудыг даган хэсэг хугацаанд сэлж байтал урд нь нэг саарал юм сүүмийж чихрах дуу чимээ гарлаа. Төмөр торон хаалга дээш өргөгдөн онгойж байв. Торхнууд хойно хойноосоо урсан ирж торон хашлаганд тулан бөөгнөрөв. Бильбо урсаж байгаа торхонд цохиулчихгүйн тулд үе үе усан доогуур шумбан орж байлаа. Ашгүй удалгүй торхнууд хойно хойноосоо уван цуван торон хаалганы доогуур гарах үед Бильбо санаандгүй дээш хараад зүрх нь хагарчих шахав. Төмөр хаалга торх хоёрын хооронд өрдөө зүү орох төдий зай харагдав. Хэрвээ хоббит торхны дээр гарсан бол ч хөөрхий амьд үлдэхгүй байж.

Торхнууд урсгалд хөөгдөн агуйгаас гарч голд ороод захалж ургасан хэдэн модны мөчир доор бөөгнөрөв. Одойнууд яаж байгаа бол, хэр зэрэг норсон бол гэх мэтээр Бильбо маш их санаа зовно. Хараад байхад зарим торх усанд нэлээн гүнзгий орсон харагдана. Хэн ч харсан дотор нь лав хоосон биш гэдэг нь тодорхой байлаа.

Голын ус мөс шиг хүйтэн. Бильбо чичрэн хамаг шүд нь тачигнаж юун одойнуудын тухай бодох мантай, өөрийгөө яая гэж байв. (Ер нь торхоо орхиод өөрөө сэлдэг ч юм билүү? Тэгтэл шөрмөс татвал яана? Эсвэл эрэг хүрэлгүй хөлдөж үхвэл яана?)

Хоббитод бас л аз тохиох шиг болов. Хэдэн торх эрэг орчмын хожуулд тээглэн эргэлдэхэд Бильбо энэ боломжийг ашиглан зуурч байсан торхон дээрээ авирч гаран гараа алдлан торхыг тэврэн хэвтэв. Харин торхон дээр тогтох тийм ч амар байсангүй. Хоббит унахгүйг хичээн дотроо залбирч явав. Торхнууд нэг хэсэг эргэлдэж байснаа хожуулаас салсан бололтой цааш урсав. Хоббит торхон дээрээ арай ядан тогтож байлаа. Бэггинс жин багатай басхүү торх нэлээн том байсан тулдаа л буцаад усанд унасангүй. Торхонд бага зэрэг ус шүүрэн орж усанд бага зэрэг суусан ч гэсэн яг л хазаар, оломгүй цүндгэр морь унаж нөгөөх нь зүлгэн дээр өнхөрч эрхлэх гээд байгаа юм шиг л санагдана.

Бага сагаар эрэг дагасан модны мөчир цөөрөн шингэрч, зарим үед тэнгэр харагдах болов. Урсгал гэнэт өргөсөж, хааны найр наадам хийх дуртай агуйн өмнүүр урсах их голтой нийлэв. Голын бүүдгэр толион дээр одод, үүлэн сүүдэр тусаж, бутран харагдана. Эргэн тойронд хад асга сүндэрлэнэ.

Эрэг дээр торхнуудыг хүлээж байсан эльфүүд шаламгай нь аргагүй бүх торхнуудыг ус багатай газар өнхрүүлэн аваачиж, нэг нэгээр нь тоолж хооронд нь холбож боогоод, өглөө болтол орхиод явав. Хөөрхий муу одойнууд. Харин Бильбо бага зэрэг ч гэсэн дулаацаж амжаад сундалсан “мориноос”- оо бууж ойр хавьд харагдах хэдэн байшинг чиглэн гэтлээ.

Тэрээр аймшигтай их өлссөн тул бараг л тааралдсан бүхнийг, хэний ч хамаагүй гэрээс хулгайлан идэхэд бэлэн байлаа. Магадгүй сүүлийн үед сурсан эрдэм нь нөлөөлсөн ч байх. Байшингуудын орчим түүдэг асаж харагдав. Хоббит олзуурхан норсон хувцсаа хатааж авахаар шийдэн зориг орон алхав.

Тэр шөнө Бильбод тохиолдсон адал явдлын талаар өгүүлэх хэрэггүй биз дээ. Ер нь энэхүү аялалын төгсгөл ойртож байгаа тул одойнууд Ганцаардмал Уул уруу хийсэн алдарт аян хэрхэн яаж дууссан тухай өгүүлэх нь чухал болов уу.

Товчхон хэлэхэд, хоббит бөгжний ачаар эхлээд хэнд ч харагдахгүй байж чадсан боловч мөдхөн шалан дээр үлдээсэн нойтон мөр бас хорьж дийлэлгүй найтааж эльфүүдэд сэжиг төрүүлэв. Тосгонд бөөн шуугиан дэгдлээ. Бильбо зугтаж амжаад шөнийн хулгайлсан талх, боов бас ширэн хүүдийтэй дарсаа зооглон ойд өнгөрөөв. Түүдэг хол байсан боловч дарсны ачаар бага зэрэг дулаацаж тэр ч байтугай модны унасан навчис цуглуулан дэвсээд нүдний хороо гаргав.

Үүрээр даарсандаа эрт сэрж өөрийн эрхгүй чангаас чанга найтаалаа.

Босоод хартал эрэг дээр эльфүүд бөөн хөөрөлдөөн болон торхнуудаар сал бэлтгэн Эсгарот

уруу сэлэхээр зэхэж байв. Бильбо хар эрчээрээ гол уруу гүйв. Тэд ажлаа түргэн амжуулах гэж яаран сандарч байх хооронд Бильбо амжиж хэнд ч харагдалгүй салан дээр гарлаа. Нар гараагүй байсан болохоор түүний сүүдэр гарахгүй дээрээс нь нөгөө айхтар найтаалгах нь зогсчээ.

Эльфүүд хүчээ нэгтгэн салыг эргээс холдуулахаар урт модон тулгууруудаар хөшиж түлхэнэ. Торхнууд эргээс холдох тун дургүй байгаа бололтой.

- Юун хүнд торхнууд вэ? Дотор нь амттан байгаа юм биш биз, үзэх үү? гэж нэг нь санал болгоход,

- Цаг алга, алив, хурдал. Нэг, хоёр, гурав аа гэж ахлах салчин тушаав. Удалгүй торхнууд эргээс холдон, хад асгыг тойрон (Хад асга дээр сал тээглэж зогсвол түлхэх үүрэгтэй урт модон тулгуур барьсан эльфүүд зогсож байлаа) хурдалсаар голын урсгалд орон Эсгарот хотыг чиглэлээ.

Яалтай ч одойнууд эльфийн шоронгоос зугтаж, Зэрлэг ойгоос гарч чадлаа. Харин тэдний амьд үхсэн эсэхийг зөвхөн бурхан тэнгэр л мэдэх байх даа.

Аравдугаар бүлэг

Найрсагаар угтаж авсан нь

Сал голын урсгал даган хөвсөөр хөвсөөр нэлээн хугацаа өнгөрч, үүр цайж дулаарч эхлэв. Гол зүүнтээ орших хавцлыг тойрч урсахад, давалгаа хавцлыг цохин мөргөж ёроол орчим өндөр өндөр усан оргил үүсгэнэ. Хавцал хойно хоцроход битүү ой модтой эрэг гэнэт алга болж, Бильбо нүдэндээ итгэлгүй золтой л дуу алдсангүй. Ямар үзэсгэлэнтэй газар харагдсан гээч.

Гол салаалж өчнөөн олон жижиг горхи, нуур, цөөрөм болж урсав. Энд тэнд жижиг жижиг олон салаа үүссэн харагдана. Голын хөндий хэдэн бээр газарт хязгааргүй үргэлжилж, тэртээх алсад тэнгэр тулам өндөр том хар уул сүндэрлэнэ. Ойр хавьд уул нуруугүй учраас тэрээр ганцаараа содон тод харагдана.

Аялалын гол зорилго Ганцаардмал уул гэдэг чинь энэ байна шүү дээ. Гэвч өчнөөн зовлон, саад тотгорыг даван туулж, зорьж явсан газартаа хүрсэндээ хоббит огт баярласангүй. Сэтгэлд нь зэвүүцэм таагүй мэдрэмж төрж, тэр уулыг бараг үзэн ядах шиг болов.

Салчин эльфүүдийн яриаг чагнах зуураа Ганцаардмал уулыг хол боловч ийнхүү зайнаас харж байгаадаа баярлах ёстойг Бильбо ярианаас нь мэдэж авав. Тэр ч байтугай хоббит, одойнууд тун азтай байна санж. Учир нь салчид Зэрлэг ойн зам, жимүүд бүдгэрэн устаж явахын аргагүй болсноос хойш хүн болгон голоор зорчдог болж, үүнээс үүдэн ойн эльфүүд, хүмүүсийн хооронд гол ашигласан татварын маргаан үүссэн тухай ярьцгаав.

Бас одойнууд Ганцаардмал уулын доор амьдрахаа больсноос хойш бүх зүйл өөрчлөгдсөн тухай дурдаад тэр цаг үе эмээ нарын ярьж өгдөг үлгэрт л үлдсэн бололтой хэмээцгээгээд санаа алдацгаана. Эдний ярианаас Гэндальфийн энэ нутгийн талаарх сонссон сүүлийн мэдээлэл нэлээн хоцрогдсоныг хоббит ойлгов.

Сүүлийн хэдэн жил газар хэд хэдэн удаа хөдөлж, хур бороо ихэд цутгаснаар гол булингартан эрэг хавийн намаг улам тэлж, ойн зам жимийг уусган арилгаж шинэ жим гаргаж нээхээр явсан явган, морьтон хэн бүхэн ор сураггүй алга болоод, ер нь нэг л биш ээ гэх мэтээр хоорондоо ярьж байв. Хүмүүс энэ бүх зүйлд Лууг буруутган түүний тухай ярих бүртээ уул уруу зэвүүцсэн байдалтай дохин харааж зүхэцгээнэ. Беорны зааж өгсөн жимээр одоо бараг хэн ч явдаггүй гэнэ. Зэрлэг ойгоос Ганцаардмал уулын хөндий хүрэх ганц аюулгүй үлдсэн зам нь гол байж. Тийм ч учраас эльфүүдийн хаан энэхүү цорын ганц гарцыг нүдний цөцгий мэт хамгаалдаг нь ийм учиртай байж.

Тэгэхлээр ноён Бэггинс өөрөө ч мэдэлгүй хамгийн аюул багатай цорын ганц замыг санаандгүй олоод авсан юм биш үү? Үүнийг Бильбо ухаарах тэнхээгүй, голдоо ортлоо даарч шүд ам нь тачигнан байж ядан сууж байлаа. Гэндальф түүний адал явдлын тухай сонсоод, бүх ажлаа яаран дуусгаж (Ямар ажил гэдгийг нь бид мэдэх онцын шаардлагагүй учраас энэ талаар тодорхой өгүүлсэнгүй) түүнд туслахаар яарч байгааг сонссон бол Бильбо бөөн баяр болох байсан даа. Даанч энэ тухай түүнд хэн дуулгах билээ дээ.

Бильбо маш их ядарч даарснаа л мэдэж байлаа. Гэтэл гол эцэс төгсгөлгүй мэт урсан үргэлжилж хүсэн мөрөөдөж буй хот харагдах ч үгүй... Ганцаардмал уул тээр хол айдас төрүүлэн сүндэрлэнэ. Тэгтэл гол ашгүй өмнө зүг рүү эргэн урсаж Уул бага зэрэг холдов.

Оройдоо горхинууд нэгэн хүчтэй урсгал болон нийлж огцом хад асга эгнэн сүндэрлэсэн эрэг дундуур хурдлан урсав.

Нар жаргах алдад голын урсгал зүүн тийшээ алгуурхан эргэж Урт нуурт цутгалаа. Нуурын аман хэсэгт уужуу, хажуу эргээр ёроолыг нь хайргаар бүрсэн нүсэр том чулуун хаалганууд харагдав. Урт нуур гэж энэ байх нь ээ. Бильбо түүнийг ийм далай шиг агуу гэдгийг төсөөлж ч байсангүй. Нуурын нөгөө тал бараг харагдахааргүй хол, хойд талын эрэг бол бүр ч харагдахгүй байлаа. Хоббит өмнө нь үзэж байсан газрын зургийг санах гэж оролдов. Нуурын усанд ойн тусаж байгаа Тэрэгний одод хавьд Түргэн гол нуурт цутгах аж. Түргэн гол өөр жижиг гол горхи цөм гүнзгий хавцалд үүссэн Урт нууранд цутган нуурыг амьдруулна. Нуурын ус өмнөд хэсгээр гадагшлан урсана. Оройн намуунд тэр зүгээс бөглүү сүрлэг чимээ гардаг нь хүрхрээ асарч буй нь энэ ажээ.

Түргэн голын амнаас холгүй усан тохойд, эргэн тойрондоо хад, хавцлаар хүрээлүүлсэн гайхамшигт сайхан хот оршино. Эльфийн хааны дарсны хонгилд нуугдаж байхдаа хоббит тэдний ярианаас энэ хотын тухай зөндөө ихийг сонссон билээ. Эрэг дээр хэдхэн байшин харагдана. Харин хот тэр чигээрээ нууран дээр модон тулгууртай асар том тавцан дээр байрлана. Асар том тавцангаас эрэг хүртэл урт гүүр татжээ. Энэ хотод эрэлхэг зоригтой хүмүүс аж төрдөг аж. Тэд луунаас айдаггүй, ойн эльфүүдтэй наймаа хийж, тэдэнд өмнө зүгээс тээвэрлэн авчирсан бараагаа зарна.

Урьд нь хойд зүгт оршин байсан баян чинээлэг Дол хот сүйрснээс болж сүүлийн үед наймаа мууджээ. Эрт дээр үед хөлөг онгоцнууд олноороо зарим нь цэрэг арми, зарим нь алт тээсээр усан дээрх хотод ирдэг байлаа. Тэр үеийн тухай, өрнөж байсан дайн дажингийн тухай өгүүлсэн үлгэр туульс зөндөө үлджээ. Алдарт Дол хот хожим сүйрч, одоо түүний байсан газар хуучин тавцангаас үлдсэн ялзарсан тулгуурууд л гантай үед ил гарч харагдана.

Өнөөгийн Эсгарот хотын иргэд энэ тухай төдийлэн санаж дурсдаггүй. Хааяа нэг Дарин омгийн Трор, Трайн хэмээх одойнуудын тухай, харгис Лууны тухай, сүйрч алга болсон алдарт Дол хотын тухай дуулах нь сонсогдоно. Зарим хүмүүс Трор, Трайн нарыг удалгүй эргэн ирж, чулуун хаалганууд нээгдэж, алт урсаж ирэх тухай, голын хөндийд хүмүүс эргэн суурьшиж, энх амгалан амьдрах тухай дуу зохионо. Эдгээр дуунууд сайхан боловч биелэшгүй хүсэл мөрөөдөл хэмээгээд хүмүүс нэг их ойшоодоггүй байв.

Хотоос сал ирж буйг харсан бололтой тал талаас жижигхэн завьтай хүмүүс ирж салчдын амар амгаланг асууна. Дараа нь салыг нуурын тохойд, усан онгоцны зогсоол уруу аваачив. Торхнуудын заримыг дорнодоос ирсэн хүмүүс авч явж харин үлдсэнийг нь уяж бэхэлсний дараа салчин эльфүүд хүмүүстэй нийлэн найрлахаар одов.

Тэднийг явсны дараа эрэг дээр юу болсныг харсан сан бол айдаггүй юмаа гэхэд лав маш их гайхах байсан болов уу? Бильбо усанд хамгийн гүнзгий суусан, нэлээн хүнд торхыг хамгийн түрүүнд ус багатай газарт чирэн аваачив. Торхон дотроос ёолох дуу сонсогдож тагийг нь

арайхийн онгойлготол туйлдан ядарсан одой өнхрөн уналаа. Нойтон дэрс сахалд нь шигдэн сахал нь тэр аяараа ширэлдэн харц нь зэрлэг гэж жигтэйхэн, яг л долоо хоног харанхуйд ганцаар хоригдсон нохойн нүд шиг эргэлдэнэ. Торин арай гэж хөл дээрээ босон салганан гэлдэрсээр эрэг унаад өгөв. Энэ бол Царсан Бамбай Торин байлаа.

Харин түүний, уул нь тэнгэрийн цэнхэр өнгөтэй боловч урагдаад танигдахын аргагүй халтар болсон мөнгөн цацагтай малгай бас алтан гинж нь байгаагүй бол түүнийг танихын аргагүй болжээ. Торхонд өнгөрөөсөн цаг мөчүүд түүнийг маш өөрчилж, танигдахааргүй болгосноос гадна тэнхээ тамиргүй сульдсандаа өмнөө хэн зогсож байгааг ч ойлгохгүй хараал зүхэл болоход Бильбо уурлаж,

- Ноён Торин гуай та чинь амьд уу, үгүй юу? гэлээ. Хоббит өөрөө жаахан ч гэсэн юм идэж цэвэр агаар хангалттай амьсгалж байснаараа мөн торхонд удаан суугаагүй хөл гар нь чилээгүй болохоороо хөөрхий одойнуудаас шал өөр байдалд байснаа мартсан бололтой.

- Бид эрх чөлөөтэй боллоо. Та чинь ойлгохгүй байна уу? Тэр хайгаад байгаа эрдэнэсээ олж авахыг хүсч байгаа бол хурдхан шиг гар хөлөө хөдөлгөөд бусдыгаа гаргаж авахад тусал. Хүн амьтанд баригдахаасаа өмнө хурдан хөдөлье хэмээн зандрав.

Бильбо хэрцгий ч гэсэн яах аргагүй үнэн юм хэлж байсан тул Торин үгэнд нь орж ёолон барин өндийж, нөхдөө суллахад туслав. Хоёул нийлж одойнуудын нуугдаж байгаа торхнуудыг хурдан хурдан оллоо. Зургаан ч одой гаднаас нь нүдэхэд хариу өгөв. Бильбо, Торин хоёр хүйтэн усанд үхтэлээ дааран бээрэн зургаан одойг гаргахад, нөгөөдүүл торхноос гарангуутаа л эргийн зүг унан босон мөлхөв. Ямар ч байсан аварсных нь төлөө нэг нь ч Бильбод талархсангүй.

Хамгийн их бэртэж гэмтсэн нь Балин, Двалин хоёр байсан тул тэр хоёрыг эрэг дээр орхилоо. Харин Бифур, Бофур хоёр арай гайгүй мөртөө тусалж нэмэр болохын оронд бас л эрэг дээр тэрийгээд өгөв. Азаар Фили, Кили хоёр залуу болоод ч тэр үү, ёолсон ч гэсэн инээж ханиах тэнхээтэй байлаа. Эсвэл тэр хоёрын торхонд дэрс өвс илүүтэй дэвссэн бололтой тэд ганц хоёр хөхөрч, хэдэн газар шалбарсныг эс тооцвол бараг гэмтээгүй харагдана.

- Миний торхонд лав алим зөөж байсан байхаа, надаас нэл алим үнэртэж байгаа биз? Өлсөж, даарч бас хөлөө ч тэнийлгэж чадахгүй ядаж байхад алим ханхлаад л. Ёстой тамтай юм. Би бараг амьдралдаа дахин алим идэх хүсэлгүй боллоо дог гэсээр Фили зовлонгоо тоочив.

Тэр хоёр Торин, Бильбо хоёрт тусалж, удалгүй үлдсэн зургаан одойнуудыг олов. Хөөрхий муу Бомбур үхсэн амьд нь ч мэдэгдэхгүй ухаангүй байв. Дори, Нори, Ори, Ойн, Глойн нар торхонд шүүрч орсон усанд золтой живсэнгүй харагдана. Тэд нарыг нэг нэгээр нь эрэг өөд зөөлөө.

- За ашгүй, бүгд амьд байна. Бид азтай юмаа. Бас ноён Бэггинсэд баярласнаа хэлэх хэрэгтэй. Бильбо байгаагүй бол бид хэцүүдэх байлаа... гэхдээ уул нь болдогсон бол өөр аргаар аялсан бол илүү их талархах байсан юм.

- За, маш их баярлалаа, ноён Бильбо. Бид таны төлөө зүтгэхэд хэзээд бэлэн байна. Харин одоо

нэг жаахан юм олоод идвэл зүгээрсэн... тэгээд нэг амсхийгээд авбал... Ингэхэд бид хаачих билээ?

- Хот орно, энд суугаад байлтай биш гэж Бильбо хариулав.

Ингээд Торин, Бильбо, Фили, Кили дөрөв хот орохоор болж бусад нь харин түр зуур ч гэсэн эрэг дээр хэвтэж амрахаар үлдлээ. Хот уруу орох гүүрний эхэнд харуулын байр байсан боловч дотроос нь хэн ч гарч ирсэнгүй. Хотыг хэн ч дайрах билээ. Хэдийгээр хэн нь хэндээ татвар төлөх вэ? хэмээн маргалддаг боловч хүмүүс ойн эльфүүдтэй эв найрамдалтай амьдарна.

Ойр хавьд өөр хүн амьтан байхгүй, айх юмгүй. Хэтэрхий амарлингуй амьдарч байсан болоод ч тэр үү, хотын зарим нэгэн цадиггүй залуус Луу ерөөс байхгүй, луугийн тухай яриа хөөрөө зохиомол үлгэр домог хэмээн маргалдана. Бас залуу зандан явахдаа Тортогтой тааралдсан гэх хэдэн хөгшчүүлээр доог хийнэ. Тиймээс, хийх юмгүй харуулууд байрандаа цэнгэж байсан тул одойнуудыг торхноос гарах байтугай гүүрэн дээр ирснийг ч анзаарсангүй. Торин харуулын байрны босгыг алхан ороход харуулууд бараг л ухаан алдахаа дөхөв.

- Ч-ч-чи чинь хэн бэ? Юу хийж байгаа юм? гэсээр сандран, буу зэвсгээ барьж авлаа.

- Би уулан доорх хаант улсын хаан Трорын хүү Трайны хүү байна. Үнэндээ халтар малгай, уранхай хувцастай ч гэсэн тэрээр үнэхээрийн хааны цусны удам гэхээр гэдийн сүртэй харагдана. Энгэр дээрх алтан гинж нь гялалзаж харц нь ширүүн яг л хаан шиг зогсоно.

- Би буцаж ирлээ. Одоо танай хотын захирагчтай уулзмаар байна гэж айлтгав.

Тэгж хэлэнгүүт юу болсон гэж санана. Харуулууд нааш цааш сандран гүйлдэж хамгийн ухаан муутайнууд нь гадагш гүйн гарч Ганцаардмал Уулыг ширтэж уулыг гэнэт алтаар гялалзаж эхлэх мэт хүлээн зогсов. Харуулын ахмад урагш гаран,

- Эд нар чинь тэгээд хэн юм? гэж Фили, Кили, Бильбо нарыг заан асуув.

- Миний эцгийн охины хүүхдүүд болох Дарин омгийн Фили, Кили хоёр. Харин энэ бол ноён Бэггинс. Бидэнтэй цуг баруун зүгээс хамт явж байгаа юм.

- Хэрэв та нар энхийг өвөрлөн ирсэн бол зэвсгээ энд орхиорой гэж ахмад тушаахад,

- Бид нарт зэвсэг байхгүй гэж Торин хариулав. Нээрээ ч бүх зэвсгийг нь эльфүүд хурааж авсан юм чинь. Харин Бильбо кинжалынхаа талаар юу ч дуугарахгүй гэж шийдэв.

- Бид нар дайсан биш, анд нөхрийн үүднээс та нар дээр ирсэн тул бид нарт зэвсэг хэрэггүй. Түүнээс гадна, бүхэл бүтэн хотын эсрэг яаж дайтах билээ? Одоо бид нарыг захирагч дээрээ хүргэж өг.

- Манай захирагч найрлаж байгаа гэж ахмад учирлахад,

- Тэгэх тусмаа бид нарыг аваач гэж ёсорхуу ярианаас залхсан Фили зандраад,

- Бид нар өлсөж цангаж өчнөөн хонов. Удахгүй унах гэж байна. Чи харахгүй байна уу? Эрэг дээр манай хэдэн нөхөд босч чадахгүй хэвтэж байна. Алив, түргэн захирагч дээрээ аваачиж өг, эс тэгвэл чамд муу юм болно шүү.

- За, намайг дагаад явцгаа гэж ахмад дуртай дургүй гөвтнөв. Модон тавцан дээрх байшингуудыг хагас дугуй маягаар барьж, байшингуудыг тойруулан усанд унахаас хамгаалсан бололтой модон хашлага хийжээ. Нэг байшингаас гэрэл цацарч, дотроос нь дуу шуугиан сонсогдоно. Харуулууд тэр байшинг чиглэн очиж дотогш оров. Одойнууд гэнэт гялбах хурц гэрэлд золтой л сохорчихсонгүй.

Торин ч цаг алдалгүй харуулын ахмадыг үг хэлэхээс өмнө өөрийгөө танилцуулаад авав.

- Би Уулан доорх хаант улсын хаан Трорын хүү байна. Би эргэж ирлээ гэж хашхирахад бүгд сандран суудал дээрээсээ үсэрцгээв. Хотын захирагч өөрийн сууж байсан агуу том суудлаасаа шалавхийлэн бослоо. Хамгийн ихээр гайхсан нь салчин эльфүүд байлаа. Тэд нэг нэгийгээ түлхэн хотын захирагч уруу яаран очиж чанга чанга дуугаар бие биенээсээ өрсөн ярьж байв.

- Эд нар чинь манай хааны олзлогсод байна. Эд нар манай ойгоор зөвшөөрөлгүй хэсүүчлэн, бидний амгалан тайван байдлыг алдагдуулсан тул эднийг шоронд хорьсон юм. Харин яаж шоронгоос оргож чадав аа?

- Энэ үнэн үү? гэж хотын захирагч Торианаас асуув. Хаанаас ч юм гарч ирсэн энэ Уулын доорх хаант улсын үе залгамжлагч гэж өөрийгөө нэрлээд байгаа амьтанд итгэснээс эльфүүдэд итгэх нь хотын захирагчид илүү амар байлаа. Тэгээд ч тэр үлгэр домогт гараад байдаг Уулын доорх хаант улс байсан ч юм уу, үгүй ч юм уу хэн мэдлээ.

- Бараг л үнэн гэхдээ эльфийн хаан биднийг огт үндэслэлгүй хорьсон. Харин шударга хэргийн төлөө явж байгаа бид нарыг төмөр тор, түгжээ энэ тэр зогсоохгүй гэдгийг мартсан бололтой. Би нэг юм ойлгохгүй байна. Ингэхэд эльфүүд хэдийнээс Урт Нуурын эзэд болсон юм? Би Эсгарот хотын захирагчтай ярьж байна. Эльфийн хааны албат, салчидтай яриагүй гэж Торин бардам нь аргагүй хариулав.

Хотын захирагч эргэлзсэн байдалтай эльфүүд өөд нэг, Торин өөд нэг харна. Тэрээр эльфийн хаантай муудалцахыг тун хүсэхгүй байлаа. Эльфийн хаан бол асар хүчтэй хаан. Захирагч ажил ихтэй чухал наймаа, татвар энэ тэр, өмнө зүгээс ирэх бараа таваар гээд зөндөө. Иймд одойнуудын тухай магтаал дуу домгийг сонсоогүй ажээ. Харин одойнууд эргэж ирсэн тухай мэдээг сонссон Эсгаротын иргэд шал өөр бодолтой байсан тул асуудал тун удалгүй Эсгаротын захирагчийн оролцоогүйгээр шийдэгдэв. Хотын иргэд бөөн хөөр баяр болж, гудамжинд цугларч, хаан буцаж ирсэн тухай эртний дууг хэн нэгэн дуулж эхлэв. Бараг л Трорын ач хүү биш Трор өөрөө ирсэн юм шиг л болов. Бусад хүмүүс дууг дэмжин дуулав.

Хууль ёсны хаан ирнэ

Мөнгөн оргилоос хаан

Алтан титмээ өмсөөд

Төр засгаа гардан авна

Алтран гялалзах ордондоо

Ятга хөгжмөө эгшиглүүлэн

Ариун тотгонд дуу хуур

Урьдын адил цуурайтна

Толгод гүвээгээр модод найгана

Өвс ногоо халиурна

Мөнгөөр оргилуур оргилно

Алтаар гол урсана

Уулнаас тэнгис хүртэлх

Газар нуга цэцэглэнэ.

Хаан ирэхэд

Хамаг зовлон арилна

Хотын иргэд хийл, босоо ятга тоглож, энэхүү урт дууг дуулж байлаа. Бүгд орилолдон хашхирч хөл толгойгоо олохгүй бужигнац-гаав. Эсгарот хотын хамгийн өндөр настай хэнбугай ч сүүлийн жилүүдэд ийм юм болж байсныг санахгүй байх. Баярлаж байгаа хүмүүсийг харсан ойн эльфүүд гайхахын зэрэгцээ бага зэрэг айх шиг болов. Ингэхэд эльфийн хаан үнэхээрийн андуурсан бол яана? Хотын захирагч ч гэсэн олны саналыг дагаж ард түмнээ дэмжиж, Торин үнэхээрийн алдарт одойнуудын хааны удам гэдэгт итгэж байгаа дүр үзүүлэхээр шийдлээ. Бильбо мөн адил тэр хавьд тухлаад авлаа. Хүмүүс харин түүний тухай энэ хоббит хаанаас гараад ирэв гэсэн утгатай зүйл асууж зовоосонгүй.

Хэсэг хугацааны дараа үлдсэн одойнуудыг авчрав. Тэд нарыг мөн адил баяр хөөр болон угтав. Одойнуудыг хооллон ундалж, шарх шалбархайг нь арчилж тос түрхэн, том байшинд оруулж амраалаа. Торин ба түүний андуудад зориулж байшингийн доор хэд хэдэн завь бэлтгэн сойж уяв. Өдөр шөнөгүй байшингийн доор хүмүүс цугларч, дуу дуулан инээд хөөр болцгооно. Одойнуудын хэн нэгэн цонхоор цухуйв уу, үгүй юу цонхон доор байгаа хүмүүс нэгэн дуугаар уухай хашхиран сүртэй юм болно гээч.

Эсгарот хотын хүмүүс одойнуудын тухай мэддэг дуунуудаа дуулахаас гадна олон шинэ дуу зохиожээ. Шинэ дуунууд бүгд лууг сөнөөсний дараа Уулын доорх Хаант улсын шинээр өргөмжлөгдсөн хааны илгээсэн эрдэнэсийн хөлөг онгоцнуудын тухай өгүүлнэ. Хотын

захирагчийн тушаалаар зохиож буй энэ дуунууд одойнуудад огт таалагдахгүй байлаа. Тэглээ гээд айлд байгаа улсууд тэвчихээс өөр яах вэ дээ. Ингэж айхтар хүндлүүлсний эцэст одойнууд овоо мариалан, хүч тэнхээ орж амарч амжив. Үс гээгээ янзлуулж, сахал самбаагаа самнаж, дуртай хувцсаа өнгө өнгөөр нь өмсөж бардам гэгч нь алхах болцгоов. Торин гэхэд л бараг аймшигт Тортог лууг ялаад алт эрдэнэсээ авсан юм шиг л хаахалзаж байлаа.

Одойнууд бяцхан хоббитыг мартсангүй. Өдөр бүр л түүний эрүүл мэндийн төлөө ууж найрсгаар хүндэлж, байнга л анхаарал тавина. Урьд өмнөх шигээ түүнийг загнаж үглэхээ больж, цөм хайрлан халамжилна. Харин Бильбо бусадтай адил баясаж чадахгүй нэг л дарамттай байв. Учир нь тэр муухай Уулыг бодохоор л дотор нь эвгүй оргино. Бас тэр уулын доор аймшигт луу хэвтэж байгаа гэхээс бүр айдас төрж чичирнэ гээч. Дээр нь бас ханиад хүрээд байшингаас бараг гурван хоног толгой цухуйлгасангүй. Одойнуудын магтаж байгааг сонсон талархсанаа хэдхэн үгээр илэрхийлсэн болоод өдөр хоногийг өнгөрөөж байв.

Энэ үеэр салчин эльфүүд, Зэрлэг ойд эргэн очиж хаандаа сонин хачин мэдээ дуулгав. Хааны ордонд юу болсон гэж санана. Хөөрхий харуулын дарга, дарс хувиарлагч хоёрыг лав хэзээ ч мартаггүйгээр шийтгэсэн байх. Одойнууд маш их болгоомжтой байж түлхүүр хулгайлсан, торхоор аялсан тухайгаа хэнд ч яриагүй. Хоббит ч бас хаширлан бөгжөө зүүсэнгүй. Эльфүүд янз бүрээр таамаглан одойнуудыг хэрхэн оргосон тухай толгойгоо ихэд гашилгасан боловч чухам яг юу болсныг баталгаатай мэдэж чадсангүй. Ямар ч байсан тэр нэг жижигхэн биетэй өөрийгөө ноён Бэггинс гэж нэрлээд байгаа “эрхэм” л одойнуудад тусалсан гэдгийг ойлгож байлаа. Эльфүүдийн хаан одойнуудын хаашаа ямар зорилготой явж байгааг мэдэж авав.

- За харж л байя, сайн л биз. Миний зөвшөөрөлгүйгээр ойгоор алт эрдэнэсээ авч явна гэж байхгүй. Тэгээд ч одойнууд эргэж ирэхгүй биз дээ. Луу гэдэг чинь аймаар амьтан. Эднийг үлдээлгүй залгиж орхино. Хохь чинь... гэх зэргээр дотроо эргэцүүлэн бодож суув. Эльфийн хаан одойнуудыг аймшигт луутай тулалдана гэдэгт огтхон ч итгэсэнгүй. Аягүй бол лууг дээрэмдэх санаа өвөрлөн явж байгаа биз, эсвэл нэг тиймэрхүү л үйлдэл хийх гэж байгаа байлгүй. Эльфүүд хэзээнээс хүмүүсээс илүү ухаантай болохоор яахыгаа ч нэг мэдэх байх аа (Уншигч та тун удалгүй эльфийн хаан тун их алдаж байж гэдгийг мэдэх болно) гэж эргэцүүлээд ойд энд тэндгүй тагнуул тавьж юу болохыг тайван хүлээхээр шийдлээ.

Одойнууд Эсгарот хотод бараг хоёр долоо хонов. Торин ч аялалаа үргэлжлүүлэхээр бодож эхлэв. Хотын иргэдийн хөөрсөн сэтгэл унтраагүй байхад нь тусламж гуйх хэрэгтэй гэдгийг ойлгож байлаа. Ингээд нэг өдөр боломжийг ашиглан хотын захирагч болон түүний зөвлөхүүдэд аян замдаа удахгүй гарах тухай хэлэв.

Хотын захирагч үүнд ихэд гайхаж, Ториныг үнэхээрийн тэр алдарт одойнуудын удам гэдэгт итгэж эхэллээ. Тэрээр одойнуудад огт итгэхгүй, тэднийг луйварчид гэж дотроо битүүхэн бодож байсан юм. Хэзээ нэгэн цагт өөрсдийгөө илрүүлэн баригдана даа, баригдана гэж бодсон аж. Хотын захирагч алджээ. Уншигч та Ториныг алдарт Трорын ач хүү гэдгийг сайн мэднэ. Харин тэр Ганцаардмал Уул уруу аялах болсон тухайд гэвэл ер нь байсан юмаа алдсан учраас дотроо шатаж өшөөгөө авахаар яваа одой юу хийж чадахыг хэн ч таашгүй.

Хотын захирагч одойнуудын явна гэдгийг сонсоод ер харамссангүй. Тэд нарыг хооллох, ундлах гэж бөөн зардал болсны дээр хотын иргэдийн амьдрал эд нарыг ирснээс хойш бөөн

найр наадам болж, ажил төрлөө орхисон билээ. Эд нар явлаа гэхэд сайн л биз. Харин хөгшин хар Тортог яаж хүлээж авах бол доо? хэмээн дотроо бодов.

- Трорын хүү Трайны хүү Торин та аян замдаа хөдлөлгүй яах вэ. Би таныг маш сайн ойлгож байна. Таны хэлж байгаагаар эртний зөн билэгтний зөгнөж хэлсэн үг биелэх цаг нь ирсэн бол бид танд чадах чинээгээрээ л туслая. Та ч удам даган ирдэг хаан суудал дээрээ суухдаа биднийг мартахгүй гэдэгт итгэж байна гэж хотын захирагч айлдав.

Намар ид дундаа орж, хавирга нэвт сүлбэх хүйтэн салхи үлээж байсан хэдий ч Эсгарот хотын иргэд гурван сэлүүрт хөлөг онгоц бэлдэж өглөө. Одойнууд Бильбогийн хамт онгоцонд сууцгаахад хүмүүс нэлээн хэмжээний хоол хүнс ачиж өгөв. Хэдэн хөтөч морь, бяцхан морьдыг унан гол даган хөдлөв. Тэдэнтэй болзсон газар уулзахаар тохиров. Хотын захирагч зөвлөхүүдийн хамт одойнуудад сайн явахын ерөөл дэвшүүлэн байшингийн үүдэн дээрээсээ үдэж гаргалаа. Хотын иргэд дуу дуулан гараа даллан үдэцгээв. Цагаан сэлүүрүүд усанд нэгэн зэрэг орж хөлөг онгоцнууд зогсоолоос аажмаар холдлоо. Ийнхүү Ганцаардмал Уул хүрэх урт аян замын сүүлчийн хэсэг эхлэв. Цөмөөрөө баярлан догдолж байхад ганц Бильбо л уйтгар гунигт автсан харагдана.

Арван нэгдүгээр бүлэг

Босгон дээр

Урт нуураар сэлсээр хоёр хоноход, нуурын урсгал Түргэн голтой нийлж, өөдөөс Ганцаардмал уул сүндэрлэн тодров. Гурав дахь өдрийн орой нь урсгал сөрж аль болохоор хол сэлэхийг хичээн голын баруун эрэг хавьд зогсоцгоов. Тохирсон дагуу хөтчүүд морьд, пони морьдыг хөтөлсөөр болзсон газраа хүлээж байв. Морьдоо хүлээн авч, хоол хүнсээ таллаж, нэг хэсгийг нь ачаад, үлдсэн хэсгийг нь эрэг дээр хам хум босгосон сүүдрэвч доор нууж орхихоор шийдлээ. Харин үлдсэн ачааг манах хүн олдсонгүй. Морьдыг авчирсан хотын иргэд бүгд ардаа ажилтай хэмээн яарцгаав.

Та нарын тухай зохиосон дуунууд сайхан, дуунд өгүүлдэг шиг та нарын үйлс бүтэж, бид удахгүй тавтай уулзацгаая гэсээр Ганцаардмал Уул уруу хялам хялам хийн хурдан эргэхийг завдав. Нээрээ ч ойр хавийг ажвал үлгэр домогт гардаг хааны удам залгамжлагчийг бодож байснаас Луунаас болгоомжилсон нь илүү бодитой байлаа.

Эргэн тойронд хүн амьтан амьдарч байсан шинжгүй, ойр орчим хаягдмал байдалтай. Ийм эзгүй газар үлдээсэн хоол хүнсийг хэн ч хулгайлах билээ...

Тэгээд ч одойнууд хотын иргэдийг яаран барин завиндаа суух нь сууж, явган явах нэг нь явган явж одсонд тэгтлээ их тоосонгүй.

Шөнө их хүйтэн хоносон тул манай аянчид ихэд даарч, зориг зүрх нь бага зэрэг мохов. Гэсэн ч өглөө эртлэн босож замдаа гарлаа. Бильбо, Балин хоёр цувааны сүүл мушгин хамаг ачааг тээсэн понийг дагасан шиг алхаж явлаа. Бусад одойнууд зам сонгохоор өмнө нь орж аль болох боломжийн жимээр явахыг хэлэлцэнэ. Эргээс ташуу, баруун хойд зүгт чиглэхэд тах мэт тэднийг угтах Ганцаардмал Уул аажмаар, өдрөөс өдөрт ойртсоор...

Өдөр хоног маш удаан өнгөрч байлаа. Тортог лууд ойртож байгаа учраас болгоомжлон дуу хуураа дуугаргалгүй инээх ханиахаа хүртэл хорьж явлаа. Эсгарот хотод бадарч байсан итгэл найдвар, өрнүүн сэтгэл тэр аяараа унтрав. Зорьсон газар нь ойртох тусам баярлахгүй харин ч эсрэгээр айдас хүйдэс эргэлзээ улам ихэснэ. Торины ярьж байгаагаар бол урьд өмнө энэ хавьд битүү ой мод, цэцэг навчис дэлгэрч байсан бол одоо мод байтугай, бут сөөг ч тааралдсангүй. Хааяа нэг өвс ногоо бас луугийн шатаасан модны хожуулууд л энэхүү гунигтай дүр зургийг арай өөр болгоно гээч. Иймэрхүү байдалтайгаар Луугийн эзэмшил ой уруу намрын сүүлийн өдрүүд дуусах үед орлоо.

Ямар нэгэн адал явдалд өртөлгүйгээр уулын энгэрт хүрэв. Луу үзэгдсэнгүй. Хар уул ойроос айдас төрүүлэх биш бүр аймшигтай харагдана. Уулын өмнөд хэсэгт хүрээд эхний буудаллах газраа сонгов. Газрын зураг дээр зааснаар энэ хэсгийн өндөрлөгийг Равен оргил гэж нэрлэх бөгөөд дээр үед орой дээр нь харуулын цамхаг босгосон боловч одоо хэн ч дээш гарах гэж зүрхэлсэнгүй. Учир нь уулын орой ил, нуугдах газаргүй бас Ёслолын Хаалга алган дээр байгаа юм шиг харагдана.

Торин хэдэн одойнуудыг Ёслолын Хаалга тйиш тагнуулд явуулав. Тагнуулд Балин, Фили, Кили бас Бильбо явав. Үүний дараа одойнуудын хамаг найдлага горьдлого болсон нууц хаалгыг хайж эхэллээ.

Тагнуулчид уйтгар гунигт саарал хад асгыг ардаа орхин Равен оргилын хормой өөд өгсөв. Тэндээс гол сайхан харагдана. Уулархаг хөндий өргөн тууз шиг ороон өмнө зүгт урсах Түргэн гол хад асгыг тойрон хөөсрөн шуугин Урт нуур уруу тэмүүлнэ. Бут сөөг ургасан огцом хадан эрэг дээрээс Ганцаардмал уулын хормойн тэнүүн хөндийд эртний цамхаг цайзат хотын балгас тодхон.

Эртний алдарт Дол хотоос ийм л юм үлдэж дээ. Урьд өмнө Дол хотын хонх хөндийг сэрээн хангинаж, ногоорон харагдах уулын энгэр хормой алаглан цэцэглэж нар цацарч хичнээн сайхан байсан гээч хэмээн Балин ярихдаа нүд нь харууслаар дүүрнэ. Луу үнсэн товрог болгож хаясан хотоо Торин тэр хоёр яаж ч чадахгүй, хий дэмий л уурлан хилэгнэж зогссоноо санасан бололтой.

Эрэг даган Ёслолын Хаалга хүртэл явах нь осолтой санагдсан тул уулын өмнөд хошуу хүрээд том чулууны ард нуугдав. Эндээс агуй тас хар нүх мэт тодоос тод харагдаж байлаа. Агуй дотроо уур утаа сагаж доороос нь Түргэн гол хөөсрөн урсана. Уул ихэмсгээр дүнхийж ямар нэгэн зүйлийг хүлээж байгаа ч юм шиг. Гол шаагин урсаж, хааяа нэг муу ёрын хар хэрээ дээгүүр нь эргэлдэнэ. Хэрээний гуаглах, усны шуугианаас өөр дуу чимээ үл сонсогдоно.

- За даа, буцацгаая. Энд бид юу ч хийж чадахгүй. Муусайн хэрээнүүдийг ээ. Тортог лууд бидний тухай ховлох вий дээ гэж Балин бие нь жихүүцсэн байдалтай өгүүлэв.

- Нөгөө Тортог луу чинь амьд байна... тэр гарч байгаа утааг хараач. Эрдэнэс тэврээд уулын ёроолд хэвтэж байгаа гэж хоббитыг хэлэхэд Балин,

- Чиний зөв, амьд байна. Шийд гаргах арай эртэднэ. Тэр муу луу өөр тийшээ нисэж очоод отоод хэвтэж байгаа ч юм билүү? Энэ агуйд насаараа хурхирсаар битүү утаа болгосон биз. За явцгаая гэлээ.

Тагнуулд явсан хэд хэрээний гуаглах муухай дуунд гуядуулан элдэв янзын муу юм бодсоор нөхөд дээрээ эргэж ирэв. Саяхан л зочломтгой Элрондын нутагт хичнээн сайхан дайлуулж цайлуулж байлаа. Гэтэл хэдхэн сарын дараа ийм байдалд орох гэж. Зорьсон газраа хүрсэн ч гэсэн зорилгодоо хүрэх тун ч хол байна даа. Гаднаас тусламж ирнэ гэж найдах юмгүй учир зөвхөн өөрсдийн авхаалж самбаа, чадалд итгэхээс өөр аргагүй. Гэтэл хүч тамир дуусч, эр зориг мохжээ.

Одойнуудтай харьцуулбал Бильбо сэтгэл санаагаар нэг их унасангүй. Хэдийгээр ядарсан ч гэсэн тэрээр Торины газрын зургийг судалж, эртний, сарны бичмэл, оньсого шиг үсгүүдийн утгыг тайлах гэж хичээнэ. Бильбогийн хүчин чармайлтаар одойнууд нууц хаалга байдгийг мэдэж, хайж эхлэв.

Үүний дараа буудаллах газраа сольж, Ёслолын Хаалганаас хойд зүг нэгэн хавчиг, хоёр талаасаа намхан нуруунуудаар хүрээлүүлсэн ам уруу нүүцгээлээ. Ам тойрсон нууруудын

зарим нь хөндий хүртэл үргэлжилнэ. Нууруудын баруун талыг Луу шатааж, үнс нурам болгоогүй болохоор зүлэг ногоо ургасан нь пони морьдоо тэжээх талаар санаа зоволтгүй болгов. Өдөр бүр хоёр гурваараа хуваагдан ургах нарнаас жаргах наран хүртэл, газрын зураг дээр заасан нууц хаалгыг хайсаар Уулыг тал талаас нь самнаж байв. Хоног хоногоор өнгөрсөөр харин нууц хаалга олдохгүй байсаар.

Горьдлого найдлага тасрахын даваан дээр аз дайрч, хаалга олдох сэжүүр гарав. Нэг өдөр Фили, Кили, Бильбо гурав уулын амны өмнүүр том том чулуу, хадтай газар хүрч ирцгээв. Үдийн хэрд Бильбо нэлээн өндөр, дээшээ гозойсон нэг их том чулууны ардуур явж байгаад элэгдэж үрэгдсэн хэдэн чулуун шат олов. Гурвуул шатаар яаран өгстөл өчнөөн жил хүн амьтны хөл хүрээгүйгээс бүдгэрч, алга болохоо дөхсөн нарийхан жим олдлоо.

Тэд жим даган явсаар уулын хөтөл өөд гарч, дараа нь уулын хойд энгэрт нарийхан хадан тавцанд хүрлээ. Энэхүү нарийн гэхэд хэцүү бас өргөн гэхэд хэцүү тавцан доор тэдний буудалласан газар алган дээр байгаа юм шиг харагдав. Гайхаж мэлэрсэн тэд дуугарах ч тэнхээгүй, сонирхолдоо хөтлөгдөн хад түшсээр цааш явав.

Мөр мөрөө даран цуварсаар явтал гэнэт хадан хавцал алга болж, өмнө нь тэрүүхэн хэсэгт зүлэг ногоо ургасан нар туссан тохитой хэсэгхэн газар гараад ирлээ. Энэ газар чулуун хананд тулсан бөгөөд хана нь хад боловч ёроолын хэсгээрээ ширхэг ч хагархайгүй, ан цавгүй, зүлгүүлж арчуулж байсан юм шиг толийно.

Хананд цоожны нүх сүв нугас, бариул гэхээр юм юу ч харагдахгүй боловч манай хэд энэ нь хаалга гэдэгт огт эргэлзсэнгүй.

Тэд хадан ханыг нүдэж, цохиж, түлхэж, өшиглөж, мэддэг хэдэн сургаал тарниа бүгдийг уншлаа. Нэмэр болсонгүй, хаалга хөдөлсөнгүй. Аргаа барсан гурав зүлгэн дээр жаал хэвтэж, амарч аваад үлдсэн одойнуудыг авчирч хаалгыг онгойлгохоор болж буудалласан газар уруугаа буцлаа.

Баяртай мэдээ дуулсан одойнууд шөнөжингөө унталгүй өглөө болохыг тэсч ядан хүлээв. Өглөөгүүр цөм аян замдаа хөдөлж, харин Бофур, Бомбур хоёр манаачаар үлдлээ.

Одойнууд нэг нэг ороосон олс тэвэрч хурдлан явсаар тун удалгүй зүлэг ногоон газар ирцгээв. Замдаа элдэв явдалгүй явсан боловч чулуун тавцан дээгүүр хойно хойноосоо гарахдаа бүгд эвгүйцэв. Доош харахад газар тээр хол бас хажуугаар нь хурц хад асга арзайж том том хадаас шиг аймаар харагдана.

Зорьсон газартаа хүрмэгц тухалж аваад доош олс буулган хоол хүнс, ачаа пүүгээгээ бага сагаар татаж гаргав. Хааяа дуулгавартай нэг нь (Кили) мэт юу болж байгааг мэдэх гэж эсвэл Бофурыг амрах гэж доош бууна. Харин Бомбур олсоор ч бай явганаар ч бай дээшээ гарч бусадтайгаа нийлэхээс эрс татгалзав.

- Ийм мундаг гэдэстэй юм чинь юун хад уулаар авирах. Аягүй бол сахалдаа тээглэж тэр чигээрээ доошоо нисэж үхэх биз. Та нар арван гурвуулаа болж үлдэнэ. Олс ч гэсэн... Над шиг бүдүүн амьтныг ямар олс дийлдэг билээ гэх мэтээр эсэргүүцсээр доор үлдэхээр болов.

Тун удалгүй түүний буруу байсан гэдэг нь нотлогдсон гэдгийг цухас дурдъя.

Орчин тойрныг сайтар судалснаар дээш явж байгаа жим олсон боловч түүгээр дээш гарах зоригтон олдсонгүй. Хаалга хажууд байхад буудалласан газраасаа холдох хүсэлтэн нэг ч байсангүй. Энд хэрээ гуаглах ч сонсогдохгүй зөвхөн салхи л исгэрнэ. Чулуу болгоны араас аюул осол заналхийлж байгаа юм шиг санагдах учраас одойнууд дуугаа намсган шивнэлдэн ярьж байлаа.

Одойнууд Эсгаротоос авч явсан төрөл бүрийн багажаараа хаалгыг онгойлгох гэж хичээн, их ноцолдсон боловч чадсангүй. Багажнуудын модон иш нь хугаран эвдэрч, одойнуудын гар нэл өргөс болж, ган төмөр багажнууд нь тугалгаар хийсэн юм шиг тахийж махийж зарим нь бүр ишнээсээ салаад унав. Нэг хэсэг нүдэж үзсэн боловч уул даяар цуурайтаж одойнууд Луут гараад ирэх вий гэж үхтэлээ айцгаалаа. Хаалганы доогуур ухах гэж оролдсоноо илбэдсэн хаалга юм чинь гүнзгий ухаад ч нэмэргүй гэдгийг азаар ухаарав.

Дотогш орох хүсэлдээ автан хэн ч газрын зураг дээр бичсэн зүйлс, сарны байршил цаг хугацааны талаар огт санасангүй.

Бильбо босгоны өмнө удаан суусандаа бүр залхаж байлаа. Босго ч гэж юу байх вэ дээ, нэг хадан өвс ногоо хоёрын дундах нарийхан зурвас газар, харин ийнхүү нэрлэх болсон нь одойнуудын нэг Бильбогийн өмнө хэлж байсныг санасантай холбоотой юм. Хоббитын нүхэн гэрт анх уулзахад Бильбо “Босгоны өмнө суугаад жаал бодох хэрэгтэй” гэж хэлж байсныг нь санасных биз. Ингээд, бүгд хаалгатай ноцолдоогүй, ойр хавиар дэмий хөлхөлдөөгүй үедээ босгон дээрээ сууцгаадаг болов. Өдөр өнгөрөх тутам дуу шуу багасаж сэтгэл санаагаар унацгаалаа.

Одойнуудын горьдлого тасраагүй арга зам хайсан хэвээр байсан ч хоббит бүр итгэл найдвараа алдаад байв. Бильбо өдөржингөө хад налан хөлөө хийж, баруун зүг ширтэн сууна. Заримдаа тэртээх хол Ганцаардмал уулын цаана Манант уул харагдах шиг санагдана. Одойнууд юу хийж байгааг нь асуухад Бильбо “Та нар чинь намайг бодох үүрэгтэй гэсэн биз дээ. Би бодоод л сууж байна” гэж эгдүүцэн хариулна.

Миний бодлоор ноён Бэггинс уулан доогуур явах нууц жимийн талаар бус харин огт өөр анир тайван зүлэг ногоо халиурсан Хоббитуудын өсөж өндийсөн тосгон, тохилог нүхэн гэрээ санагалзан суусан байхаа.

Заримдаа Бильбо холыг ширтэхээ больж, хаалганы өмнө хэвтэх томоос том саарал чулуу эсвэл хадаар мөлхөх тарган том дун хорхойнуудыг их л янзгүй байдалтай, муухай харж сууна.

- Маргааш намрын сүүлийн долоо хоног эхлэх нь ээ гэж Торин нэг өдөр хэлэхэд,

- Тэгээд өвөл болно доо гэж Бифур нэмэрлэв.

- Өвөл болоод Шинэ жил гарна. Ингэж суусаар байтал сахал самбаа маань ургаж бид сахалнаасаа зүүгдэн доошоо бууж болох нь дээ. Манай нөгөө алдарт аврагч маань бүр бууж өгчээ дээ. Ингэхэд ер нь тэр харагдуулдаггүй бөгж зүүгээд, Ёслолын Хаалга уруу очиж тэнд

юу болж байгааг мэдвэл яасан юм гэлээ.

Одойнууд түүнээс хоёрхон алхмын цаана сууж байсан тул Бильбо бүгдийг сонсоод золтой л ухаан алдсангүй. “Үгүй ер. Ийм найзууд байх гэж. Ер нь би яагаад эд нарт дандаа туслах ёстой юм? Би ид шидтэн юм уу? Одоо яана аа? Би бүр ийм юм болно гэж мэдрээд байсан юмаа. Намайг үнэхээрийн тэр уул уруу явуулбал би лав буцаж ирэхгүй байхаа” гэж Бильбод бодогдоод явчихав.

Тэрээр шөнөжингөө унтсангүй. Өглөөгүүр одойнуудын зарим доошоо бууж пони морьдоо услахаар, зарим нь ойр хавийг дахин самнахаар, зарим нь хаалгаар оролдохоор тал тал тийш тарцгаав. Бильбо сурсан зангаараа өдөржингөө цэнхэртэх алсыг ширтсээр, хааяа нэг том саарал чулууг харж суулаа. Яагаад ч юм нэгэн чухал үйл явдал болох юм шиг санагдав. “Арай Гэндальф ирж миний магнайг тэнийлгэх юм болов уу” гэж бодов.

Ингэж бодсоор толгойгоо өндийлгөн хартал нар жаргах дөхөж Зэрлэг ойн моддын дээгүүр нарны туяа ойж туяаран шаргалтана. Наран аажмаар доошилсоор Бильбогийн нүдний түвшинд ирэв. Хоббит босож чулуун тавцангийн ирмэг уруу ойртоход тэнгэрийн хаяанд шинийн сарны хавирган дүрс сүүмийн харагдана.

Гэнэт ард талд нь юм хугарах чимээ гарав. Хоббит эргэж хартал том хар хөх өнгөтэй, тод шар цээжин дээрээ хар цоохортой шувуу барьсан дун хорхойгоо хагалахаар чулуунд цохиж байв. Тас. Тас. Тас.

Бильбогийн толгойд таамаглал төрлөө. Луунаас айхаа ч мартан чулуун тавцан дээр гүйн гарч гараа даллан чанга хашхирав. Одойнууд юу болсныг тааж ядан гүйж ирцгээв. Доор үлдсэн хэд дээшээ гарахыг шаардаж хашхирлаа. Бомбур ганцаараа таатай нь аргагүй унтаж байлаа.

Бильбо бүгдийг тайлбарлах гэж яарав. Анир чимээгүй болов. Хоббит саарал чулууны хажууд хүлээзнэсхийн зогсоход одойнууд гайхшран толгой сэгсэрцгээн итгэж ядан зогсоно. Нар доошлох тусам бүгдийн тэвчээр алдарч эхлэв. Удалгүй нар бүр мөсөн жаргаж дүрэлзэх гал мэт улаан өнгөтэй сүүлчийн цацраг хаалганы тотгоны зүг долоовор хуруу шиг чиглэн тусахад үүнийг товч шиг нүдээрээ ажиглаж байсан хар шувуу чангаар орилов. Юм хугарах чимээ гарч хаалганы толигороос өчүүхэн хэсэг цууран унав. Цуурсан газар цоожны нүх онгойн харагдлаа.

Одойнууд нэгэн зэрэг хаалга руу гүйн очиж онгойлгох гэж үзэв. Нэмэр болсонгүй. Цаг өнгөрөөд байдаг. Бильбо гэнэт ухаан орж,

- Түлхүүр. Торин хаана байна? гэж хашхирлаа. Торин гүйж ирлээ.

- Гэндальф та нарт тэр газрын зургийн хамт түлхүүр өгсөн шүү дээ, тэр хаана байна? Хурдан хийгээд үз гэж хоббит түүнийг яаруулав.

Торин хүзүүнд зүүсэн түлхүүрийг аван цоожинд хийж эргүүлтэл “чаг” гэсэн дуу гарав.

Яг энэ үед нар жаргаж тэнгэрт сар ч харагдахгүй тас харанхуй болов. Бүгд хүчээ нэгтгэн

хаалгыг түлхлээ. Чулуун гадаргуу нь хага үсэрч бутарсаар, өндөр том хаалганы дүрс тодорч ирэв. Хаалга аажуухан дуу чимээгүй дотогш онгойв. Хаалганы цаана Уулын гүн тийш орох нууц зам нээгдэж, нүд сохлом харанхуй агуй дотроос гарч ирэх шиг болов.

Арван хоёрдугаар бүлэг

Гүний ертөнцөөс ирсэн мэдээ

Одойнууд хаалганы өмнө очоод харанхуйд нэлээд маргалдацгаалаа. Эцэст нь Торин,

- Бидний эрхэмсэг анд хүндэт Бэггинсийн чадлаа үзүүлэх цаг ирлээ. Энэхүү урт удаан аян замд найдвартай найз нөхөр байхын сацуу өөртөө ч баймгүй их хүч тэнхээтэй, ер бусын аз хийморьтой нэгэн гэдгээ харуулж чадлаа. Тийм учраас бидний үнэнч андын нэг байсны хувьд бид түүнд хүндэт даалгаврыг оноох цаг нь боллоо. Хувиа авахын тулд ажиллах ёстой биз дээ хэмээн хэлэв.

Та бүхэн Торины махруу ихэмсэг ярьдаг ялангуяа баяр ёслолын үед яаж төгөлдөр найруулга урсгадгийг мэднэ шүү дээ. Үнэхээр онцгой чухал үе байсан болохоор Торин их нухацтай итгэлтэйгээр үргэлжлүүлэн ярихад Бильбо юу хэлэх гээд байгааг нь ойлголоо.

- Энэ нууц хаалга уруу би эхлээд орох ёстой гэж та нар бүгдээрээ бодож байна уу? Трайний хүү Царсан Бамбай Торин таны сахал урд хожид байгаагүйгээр урт гэгч ургаг. Гэхдээ би энэ удаа татгалзаж болно биз дээ. Учир нь өөрт ноогдсон ажлаа хийснээр барахгүй хоёр ч удаагийн бэрхшээлээс та нарыг аварч гарсан. Аав минь гурав дахь удаагийн чармайлт ямагт ялалт дагуулдаг гэж хэлж сургадагсан. Азтай эзтэй ч гэнэ үү, хамаагүй. Би энэ харанхуй жим уруу орьё. Харин хэн хамт явах вэ?

Сайн дураараа явах одой байсангүйд тэр гомдсонгүй. Фили, Кили хоёр санаа зовсон шинжтэй хөлөө сэлгэн зогсоно. Хөгшин Балинаас бусад нь эмээсэн шинжтэй хөдөлсөнгүй. Хөгшин Балин түүнд талтай нэгэн бөгөөд,

- Би чамтай хамт явъя. Гэхдээ үүдний хавьд зогсож байгаад шаардлагатай үед тусламж үзүүлье хэмээв.

Одойнуудыг хэтэрхий битгий шүүмжлээрэй. Энэ үүргийг гүйцэтгэхэд Бильбо үнэхээр тохирсон нэгэн, үүргээ биелүүлж чадсан тохиолдолд одойнууд түүнийг сайшаан магтан дуулна, тэр ч байтугай аюул тохиох цагт ямагт тусална. Тийм ээ, одойнууд баатрууд биш ч тэд мөнгөний үнэ цэнийг үнэлж ойлгодог хүмүүс. Зарим нь алт эрдэнэсэд шунаж байхад ихэнх нь Торин болон түүний нөхөд шиг эрэлхэг зоригтой, хүндэтгэл хүлээм баатрууд билээ. Хамгийн гол нь одойнуудад өндөр шаардлага тулгаж болохгүй.

Бильбог нууц хаалганы гүн рүү ороход цайрах тэнгэрт одод түгсэн байлаа. Ингэж явах нь түүнд төсөөлж байснаас нь илүү хялбархан санагдав. Энэ чулуун орцыг одойнууд өөрсдийнхөө цэцэглэлтийн үед цохиж гаргасан бөгөөд ойн эльфүүд, гоблинуудын шидэт хаалга биш юм. Энэ шал, хана гөлгөр тэгш чулуун орц шулуухан явсаар уулын гүн тийш шууд хөтөлнө. Балин жаал явж байснаа Бильбод амжилт хүсээд хоцорлоо. Хоббит бөгжөө зүүн, хонгилын гүн харанхуй уруу одох нь тэр ээ.

Айснаасаа түүний царай цонхийсон авч, цэгц шийдэмгий харагдана. Өнөөдрийн Бильбо

нусныхаа алчуурыг ч авалгүй гүйж явсан хэдэн сарын өмнөх Бильбогоос тэс өөр байлаа. Тэрээр хутгаа гэрнээс нь суга татан гаргаж гартаа бариад, зоригоо чангалан цааш алхлаа.

- За Бильбо, өөрөө энэ явдалд орсон өөрөө л гарах хэрэгтэй. Тэр санаандгүй уулзалт дээр хэл амыг чинь татсан биш дээ. Өөрөө л явна, явна гэсэн.

- Ээ, тэнэг толгой. Тортог луу эрдэнэсийн агуйгаа энэ зуун дуустал манавал манаж л байг, надад ер нь ямар хамаа байна, надад бол хөөрхий муу гэртээ л харимаар байна. Бильбо улам цаашлан явсаар, явсаар.

Тун удалгүй хонгил уруу орж ирсэн амсар харагдахгүй болтлоо ахисан байлаа. Гэнэт хонгилд дулаахан болоод ирэв.

- Хөөш, гэрэл харагдав. Нүд нь түүнийг хуурсангүй. Хонгилын цаад үзүүрт улаан гэрэл гялалзав. Гэгээ өөд ойртох тусам гэрэл улам тодорч, халуун ч нэмэгдэв. Хоббит хөлөрчихлөө. Гал дээр асар том халуун тогоонд юм буцалж байгаа ч юм шиг эсвэл аварга муур хурхирч, архирч байгаа ч юм шиг хачин дуу доороос гарч, уур манан хөвөрч байлаа.

Энэ нь үнэхээр Уулын гүнд унтаж байгаа чөтгөр хурхирч байгаа нь удалгүй тодорхой боллоо.

Бильбо хөшин зогтусав. Дараагийн алхам нь түүний амьдралдаа хийсэн хамгийн том алхам байлаа. Үүний дараа болсон үйл явдлууд энэ алхамтай зүйрлэхэд юу ч биш байв. Хоббит агуйн харанхуйд өөрөө өөртэйгөө жинхэнэ тулаан, жинхэнэ тэмцэл хийж ялалт байгуулсан юм. Сэхээ авч зоригоо чангалан, цааш алхаж анх нууц хаалга уруу орохдоо харсан нүхтэй хэмжээ хэлбэрээр яг адилхан нүх олж харжээ. Тэр нүх уруу гэтэж очоод толгойгоо болгоомжтой гэгч нь шургуулан харахад өмнө нь томоо гэгч агуй цэлийж байв. Урьд нь энд одойнуудын дарсны агуулах эсвэл хорих шорон байсан бололтой. Агуйн хана тааз улбар гэрэлд харагдах төдий бөгөөд энэ улаан гэрэл Тортог луугаас гарч байв.

Хамраасаа утаа савсуулан зүүдэндээ бэдрэн буй асар том алтран улаарсан луу бөхөөс бөх унтаж байлаа. Далавчаа хумхиад хэвтэж байгаа нь зэвүүн сарьсан багваахайтай адилхан харагдана. Тортог луу энгэр дээрээ алт эрдэнэс овоолоод хоёр савраараа тэвэрчихсэн урт сүүлээ цагираглуулан дээгүүр нь даржээ. Агуйн шалан дээр эрдэнийн чулуу, алтан гоёл чимэглэл, мөнгөн урлал улааран ягааран асгарчээ.

Тортог луугийн цайран харагдах гүзээн дээр олон жил хэвтсэн алт эрдэнэс гүзээнд нь шигдэн ургасан байх аж. Луугийн ойролцоох хананд зэр зэвсэг, жад, сэлэм, сүх, төмөр бамбайнууд өлгөөтэй байх агаад ханын дагууд эрдэнэсээр дүүрэн торх савнууд зэрэгцэн харагдана.

Бильбо үг хэлэх тэнхээгүй алмайран зогслоо. Хоббитын гайхаж шагширсныг илэрхийлэх үг олдохгүй байна. (Яагаад гэвэл, гайхамшиг энгийн зүйл байсан өдрүүдэд эльфүүдээс сурсан тэр хэлийг хүмүүс одоо аль хэдийнэ мартжээ.)

Мэдээж, хоббит луугийн нууц эрдэнэсийн тухай үлгэр домог, дуу туульс олныг сонссон боловч ийм гайхамшиг, ийм тансаг гоё гэдгийг огтхон ч таамагласангүй. Толгой нь эргэн, урьд нь нэг бус одойг сөнөөсөн баялагт шунах хүсэл зүрхийг нь сүвлэн хатгалаа. Бильбо алт

эрдэнэсийг мэлрэн харж яах гэж ирснээ таг мартан, энэ дэлхийн хэдэн зуун луунаас ч айхаа больчихсон зогсож байлаа.

Зуун жил өнгөрөх шиг болов. Хоббит өөрийнхөө хүслээр биш ч юм нэлээн их дургүйхнээр хөшингө байдлаа орхин сэгсэрч хаячихаад агуйн шалан дээр гулган буулаа. Тэгээд хамгийн ойролцоо байгаа овоолттой эрдэнэс рүү гүйн очиж нэг том хүнд цом шүүрэн аваад зүүдэлж байхдаа хүртэл аймшигтай харагдах луугийн зүг хялам хяламхийн эргэж харайв. Тортог луу далавчаа хөдөлгөж хумстай сарвуугаа тэнийлгээд хурхирах нь аяархан болов.



Бильбо хар хурдаараа гүйв. Луу сэрэх янзгүй. Луу хулгай дээрэм, алаан тулаан зүүдэлж байх хооронд жижигхэн хоббит үүдний зүг сум шиг үсэрч байлаа. Бильбогийн зүрх хагартлаа цохилж, хөл нь арайхийн тогтож байсан хэдий ч тэрээр зогссонгүй, цомоо алдаж унагасан ч үгүй. Боллоо. Боллоо гэж Бэггинс баярлан хашхирлаа. “Намайг эрэлхэг баатар биш боовчинтой адил гэж хэн ярилаа. Одоо ёстой тэдний ам нь ангайхыг харна даа”

Хоббитыг харангуут Балин баярлаж цомыг нь үзээд, гайхаж шагшиж ханахгүй байлаа. Балин Бильбог шүүрэн тэвэрч аваад хоёулаа нууц хаалга чиглэн гүйлээ. Бэггинсийг яг л баатар мэт угтаж авлаа. Одойнууд түүнийг уралдан магтаж, дал мөрөн дээр нь алгадан бид чиний өмнө барагдашгүй их өртэй гэж ярьцгаана. Бильбо магтаал сайшаалыг чихнийхээ үзүүрээр сонсох төдийлөн нүдээ тас анин, шөнийн цэвэр агаар цээж дүүрэн амьсгалж газар тэврэн хэвтэж байлаа.

Одойнууд цомыг гар дамжуулан үзэн шогширч, алт эрдэнэсийн тухай ам өрсөлдөн ярилцаж байтал гэнэт аль эрт бөхөж унтарсан галт уул сэрсэн мэт асар их чимээ нүргэлэн дуугарч газар чичрэв. Ханан дахь хаалганы доор том чулуу ивсэн учраас бүрэн хаагдсангүй.

Нууц хонгилоос газар чичрүүлэн дэвслэх, архиран орилох муухай дуу сонсогдоно.

Юун алт эрдэнэс мантай. Одойнууд газар наалдан унацгаав. Өөрийнхөө амьд гэдгийг мартаж зүрхэлсэн ч зэвүүн амьтан гэдгээ сануулсаар Тортог луу сэрсэн нь энэ болой.

Луу гэдэг амьтад эд баялгийг ашигладаггүй хэдий ч олон жил эзэмшиж байгаа бол алт эрдэнэс болгоныг чулуун ширхэг бүрийг мэдэж тогтоосон байдаг. Тортог бусад луунуудтай адил ажээ.

Тортог хурц хутга барьсан эрэлхэг жижиг амьтантай байлдаж байна гэж эвгүй муухай зүүдэлсэн нойрноосоо сэрэнгүүтээ л үл мэдэх танихгүй үнэр авлаа. Хаанаас? Юун үнэр вэ? Тэр ханан дахь нүхнээс хачин дуу гарч байсан юм шиг санагдана. Надад зүгээр л тэгж санагдаад байгаа юм уу?... Луу хөдөлж, хүзүүгээ сунгаад гэнэт алтан цом алга болсныг мэдлээ.

- Хулгайч! Гал түймэр! Хөөш аллаа! Тэрээр Ууланд суурьшсанаас хойш ийм юм ер үзээгүй билээ. Тортог луугийн уур хилэнг бичих аргагүй. Өөрийнхөө эд баялагт дасаж ууссан баян хүн бараг хэрэглэдэггүй олон жилийн турш хүрдэг ч үгүй байсан юмаа алдсанаа гэнэт олж мэдээд, солиорон орилж байгаатай зүйрлэж болох юм. Тортог луу амнаасаа дөл улалзуулахад агуйд утаа тортог дүүрнэ. Уул тэр аяараа чичрэн доргиж байлаа. Луу хананы нүхэнд толгойгоо шургуулах гэж үзсэнээ нүх дэндүү жижигхэн болохоор дэлбэртлээ уурлав. Газар доор аянга цахилгаан цохих мэт болсноо хонгилоор цуурайтсаар Ёслолын Хаалга хүртэл дүнгэнэх нь тэр.

- Намайг дээрэмдлээ. Гайгүй ээ, та нарт үзүүлээд өгнө өө. Тортог луу ганцаардмал уулыг урвуулан эргүүлэн хогийн муу хулгайчийг хэдэн хэсэг тас татаж хаяя гэж шийдлээ. Хаалгаар нисэн гарах ус лууны улаан галан амьсгалын аясаар уур болон хувирав. Тортог тэнгэрт дүүлэн Уулын дээгүүр эргэлдсэнээ улбагар ногоон дөл өрвөлзүүлэн оргил дээр нь буулаа. Хилэнт луу харахгүй хажуугаар өнгөрнө гэж найдахдаа хөөрхий одойнууд том том чулууны ард нуугдацгаав.

Тэдний найдлага талаар болж хэрвээ ахиад Бильбо авраагүй бол тэд өнгөрөх байлаа.

- Дотогшоо орцгоо. Нууц хаалга уруу. Энд суугаад нэмэргүй гэж хоббит хашхирлаа. Бүгд нууц хаалга уруу харайтал гэнэт Бофур ориллоо.

- Хөөш, миний дүү нар! Бофур, Бомбур хоёр минь. Бид тэр хоёрыг бүр мартчихсан байна шүү. Тэд үхнэ шүү дээ.

- Пони морьдоо яах вэ? Идэх уух юм. Бид яаж ч чадахгүй нь ээ гэж бусад нь гонгинов.

- Зүгээр зүгээр гэж Торин эрэлхэг зангаараа бүгдийг тайвшруулаад,

- Бид тэднийг орхихгүй ээ. Бэггинс, Балин, Фили, Кили дотогш орцгоо. Муу юм боллоо гэхэд ядахнаа, дөрөв нь амьд үлдэнэ. Бусад нь миний араас.

Бүх байдал хутганы ирэн дээр байлаа. Архиран орилж байгаа хилэнт луу тэднийг хэзээ л бол хэзээ харчих боломжтой. Луу хэрвээ агаарт хөөрч, уулыг тойрон нисвэл одойнуудыг заавал харна. Торин нөхдийнхөө хамт олс уруу гүйн очиж татаж чангаалаа. Эхлээд Бофурыг амьд мэнд өргөж гаргалаа. Тэр ч байтугай, багаж хэрэгслээ, ганц хоёр пүүгээ, идэх уух юмтай уут саваа гаргацгаав. Гэтэл гэнэт...

Хөл доорх газар сэгсрэн чичирч, чулуун дээгүүр гал дөлийн хэл өрвөлзөв. Луу нисээд ирэв. Сүүлчийн одой пүүгээгээ чирсээр нууц газар гарч ирэхэд Тортог луу хойд зүгээс шуургалан нисэн ирж хөндий хэцийг галаар булав. Лууны далавч агаар тэнгэрийг шир ширхийн зүснэ. Лууны галан амьсгал чулуун ханан дахь хаалганы өмнөх өвс ногоог шатааж галын дөл хана хаалга хоёрын завсраар шурган цорволзоно. Хонгилын нууц орц уруу орж нуугдсан одойнуудыг долоов. Уяагаа тас татан мултран зугтах морьдын араар хөөн, луу нааш эргэж нисэхийг одойнууд харж амжлаа.

- Бид пони морьдгүй боллоо гэж Торин хэлээд,

- Хэрвээ Тортог хэн нэгнийг харсан бол хайрлахгүй байсан. За одоо, яая гэх вэ, суугаад хүлээхээс. Хэн нэг чинь гол руу явмаар байна уу?

Гол явах зоригтон олдсонгүй. Нууц хонгилын нэлээд гүн уруу орж шалан дээр суун хэдийгээр тэнд бөгчим халуун байсан ч одойнууд шүдээ хавиртал чичрэн сууж байлаа. Луу шөнөжингөө л Уулын дээгүүр хилэгнэн хүрхэрч хонов.

Луу тэдний буудаллаж байсан газрын ул мөрийг олж үзээд үл үзэгдэх хулгайчууд Урт нуурын зүгээс ирж пони морьд бэлчиж байсан энгэрээр Уул өөд гарсныг таамаглаад авав. Харин нууц орцыг олж харсангүй. Үүр цайхад луугийн уур хилэн жаал дарагдаад унтаж хүч юугаа сэлбэхээр өөрийнхөө алтан хэвтэр тийш буцлаа. Хулгайд юмаа алдсанаа тэрээр мартаагүй бөгөөд хэдэн жил ч хамаагүй отож хүлээхээр шийдлээ. Луугийн нас дэндүү урт, түүнд зуу, хоёр зуун жил юу ч биш ажээ. Луу үүр өөдөө удаан гэгч мөлхсөөр орж овоолттой алт эрдэнэс дээрээ элэглэн хэвтээд нүдээ анилаа.

Өглөө болоход одойнууд ч сэргэв. Шөнийн дайралт аюул осол намдаж байна шүү гэдгийг сануулж байсан ч тэд зорьсон хэргээсээ буцаж няцахгүй гэж шийдлээ. Морьд нь зугтсан уу, алагдсан уу, мэдэх аргагүй. Гадаа ер нь байдал ямар байгааг мэдэхгүй учраас жаахан харзнаж Тортог луу анхаарлаа сулруулахыг хүлээхийг Торин санал болгов. Азаар тэд нар идэш уушны нөөцөө дээш татаж авсан учраас өлсөж үхэхгүй нь магадтай.

Одойнууд юу хийх, яахыгаа удаан хэлэлцэв. Хилэнт уулнаас яаж зугтаж гарах арга ухааныг хэн ч мэдэхгүй байлаа. Энэ нь тэдний санасан бодсон бүхний хамгийн эмзэг газар байв. Одойнууд бүр учраа олохгүй будилцгаан Фили л Бильбог загнаж яах гэж цомыг нь авсан юм гэж дайрцгаав. Цомыг нь хулгайлаагүй бол луу одоо болтол унтаж л байхгүй юу. (Тэд цомыг үзэн шагшиж баярлаж байснаа таг мартжээ.)

- Би тэгээд өөр яах байсан юм бэ? гэж Бильбо хэдэрлээд,

- Би олж авчрагч мөн биз дээ? Луунууд алж хядаж байг, миний ажил бол хулгайлах. Намайг хулгайл гэж хөлслөө биз дээ. Иймд алтан цом эхний ээлжинд бага юм биш шүү. Та нар намайг алт эрдэнэсийг цөмийг нь үүрээд ирнэ гэж санаагүй биз дээ? Би та нарын оронд байсан бол дуугүй байх байсан даа. Тэр их алт эрдэнэсийг хулгайлахад бүтэн арми хэрэгтэй, гэтэл ганц надад тохчихоод. Тэнд тийм их, тийм их эрдэнэс байгаа гэдгийг урьдчилан хэлэхгүй яасан юм бэ? Та нарын ноён Трор хаан байсан л юм байгаа биз, үүнээс чинь надад хумсын чинээ нэмэр алга. Тортог луу туулай шиг номхон байсан ч тэр их алт эрдэнэсийг

ганцаараа зөөж гаргахад зуун жил хүрэлцэхгүй байх шүү.

Түүний эсэргүүцэл тэднийг ухааруулав бололтой одойнууд уучлал гуйн ийнхүү асуулаа.

- Ноён Бэггинс ямар арга санал болгож байна? гэж Торин асуухад,

- Ямар ч юм алга. Тортогийг сөнөөх эсэх явц байдлаас л болно. Би нэг арга бодож байна... Ай хө, гэртээ байсан болов уу гэлээ.

- Бид ч гэсэн гэртээ харимаар л байна. Одоо тэгээд, яах ч билээ дээ? гэж Торин гөвтнөв.

- Та нарт миний зөвлөгөө үнэхээр хэрэгтэй юу? Тэгвэл, дуугүй сууцгаа. Ийшээ тийшээ битгий гүйлдээд бай. Өдөр болохоор гадагшаа гарах учир олдоно биз. Хэн нэгнийгээ гол уруу нөөцөндөө явуулна. Орой болохоор дахиад нууц хонгилдоо нуугдана. Алт эрдэнэсийн хувьд бол... Би бөгжөө зүүгээд агуйд орж Тортог юу хийж байгааг шалгая. Муу аав минь “Эрвээхэй хүртэл эрээнтэй бараантай” гэж хэлдэгсэн.

Одойнууд хоббитын саналыг тааламжтай дэмжлээ. Урьд нь тэд хоббитыг хүндэлдэг төдий байсан бол одоо өөрсдийнхөө толгойлогчоо гэж хүлээн зөвшөөрөхөд ч бэлэн байлаа. Хоббитын толгойд асар том төлөвлөгөө эргэлдэж байв. Үд гэхэд Бильбо Уулын гүн уруу хоёр дахь удаагаа ороход бэлэн боллоо.

Мэдээж, хоббит тийш явахыг нэг их хүсэхгүй айж байсан ч айдас жихүүцэл нь урьдынхаасаа арай бага байлаа.

Хэрвээ Бильбо лууны зэрлэг авирыг жаахан илүүтэй гадарладаг байсан бол Тортогийг унтаж байгаа гэж нэг их найдахгүй байхсан. Хоббитыг замд гарахад гадаа наран аль хэдийнэ манджээ. Харин нууц хонгил харанхуй, аймшигтай байлаа.

Хаалга хана хоёрын завсраар шургах нарны гэрэл хонгилыг бүрэн гэрэлтүүлж чадахгүй байв. Тээр өмнө үл мэдэгдэм бүдэгхэн улбар гэрэл ёлтойно. Бильбо өөрийнхөө сүүхээтэйг шагшин өөрөөрөө бахархаж явлаа.

“Хөгшин Тортог ядарчихаад нам унтаж байгаа даа. Намайг харж ч чадахгүй, сонсож ч чадахгүй. Бильбо минь, толгойгоо өргөөд урагшаа алхаад марш” Бильбо ингэж бодлоо.

Луу ямар үнэрч амьтан гэдгийг Бильбо мартжээ, ер нь мэддэггүй байсан биз. Дээр нь луу ямар нэгэн юманд санаа зовсон үедээ нүдээ хагас анин унтдаг аж.

Хөөрхий Бильбо Тортог лууг нам унтаж байгаа гэж бодно. Тэр зэрлэг амьтан хөдөлгөөнгүй хэвтээд чимээгүй, нэгэн хэмээр амьсгалж байв. Бильбо нүхэнд агуй уруу үсрэх гэснээ гэнэт Тортог луугийн зүүн нүдний улаан цэгийг олж харлаа. Луу унтаж байгаа дүр үзүүлж байжээ. Тэрээр ханан дахь нүхийг ширтэн отож хэвтжээ. Бильбо зогтусав. Бөгжөө зүүсэн нь аз болжээ. Тортог луу яриа өдлөө.

- За, хулгайч гуай, ойртоод ир. Би чамайг үнэрээр чинь мэдэж байна. Би чиний амьсгалахыг хүртэл сонсож байна. Хар даа, энд хичнээн их алт эрдэнэс алаглаж байна, дуртайгаа ав.

Бильбо юунд гарамгай сайн бэ гэвэл, үнэхээр асар сэрэмж-тэйгээрээ гарамгай болохоор Тортог луу түүнийг хуурч чадсангүй.

- Үхээрийн хар Тортог чамд баярлалаа. Би алт эрдэнэс авах гэж ирээгүй. Чамайг нэг удаа харах л гэж ирсэн. Чи үлгэрт гардаг шигээ том амьтан гэдэгт чинь би итгэдэггүй юм.

- Одоо итгэв үү? гэж луу жаахан хөөрсөн шинжтэй болсон ч урьдынхаараа сэжиглэнгүй хэвээр асуухад Бильбо,

- Ямар ч үлгэр домогт гардагтай зүйрлэшгүй юм байна. Гайхамшгийн агуу их эзэн Тортог та амьдаараа сүрлэг амьтан юмаа гэж уулгаллаа.

- Хулгайч, худалч гэхэд чи чинь гайгүй боловсон харьцаатай юм гээч. Чи миний нэр усыг мэдэж байхад би чиний үнэрийг мэдэхгүй юм байна. Чи хаанаас яваа, хэн гэгч бэ?

- Өө бололгүй яах вэ, болно болно. Би эгц эргийн доороос ирсэн. Эгц хөндийг өгсөөд эрэг газраар давхиад ирлээ. Бас агаараар ниссэн. Би бол Үзэгдэхгүй Явагч, Харагдахгүй Харайгч.

- Өө, гайхалтай. Чиний жинхэнэ нэр чинь хэн юм бэ?

- Мөрийг мөрдөгч, Аалзны торыг Урагч, Ялааг Сүлбэгч. Энэ бүгд нийлээд Азын тооны эзэн.

- Өө, ямар олон нэр хочтой юм дээ гэж луу тохуурхан хөхрөөд,

- Далимд хэлэхэд азын тоо ч аз жаргал авчраад байдаггүй юм шүү.

- Би усанд живсэн нөхдөө үхлээ гэж бодогч, дараа нь тэднийг аврагч. Би уутны ёроолоос үсрэн гарагч, уутаа тэгээд хаягч.

- За, чи ч залж байна даа гэж луу мушилзав.

- Би Баавгайн Найз, Бүргэдийн Зочин, Бөгж ологч, Азын Эзэн, Торх унагч.

- Ингэвэл арай дээр юмаа. Гэхдээ хэтэрч болохгүй, үгэндээ бүдэрнэ шүү гэж Тортог луу дэмжин өгүүлэв.

Өөрийнхөө жинхэнэ нэр усыг мэдэгдүүлэхгүйн тулд луутай ингэж ярих нь зөв юм. Шууд нэрээ хэлэхээс татгалзвал уурлаж хилэгнэж магадгүй. Ямар ч луу жаахан үгээр тоглож оньсого таалцахаас буцахгүй шүү. Бильбогийн хэлнээс ихэнхийг нь Тортог ойлгосонгүй. (Хоббитын дурдсан бүгд та нарт илэрхий юм чинь та нар мэдэж ойлгоо биз дээ) Харин Тортог өөрөө болохоор боломжийн их мэдээлэл авлаа гэж боджээ.

“Ингэж бодсон юмаа” гэж луу мушилзаад, солигнууд энэ муусайн навтгар жижигхэн хүмүүсэрхүү амьтад оролцсон байна. Би ямар гүрвэл биш дээ, мэдээд байсан юмаа. Тэднийхээр ороогүй удсан юм байна шүү. Алдаагаа засахад ч амархан даа гэж бодов.

- Тун сайн байна. Торх унагч гуай торх гэж пони морьдын хамгийн тарганыг нь хэлж байгаа

биз дээ? Чи үзэгдэж харагдахгүй хичнээн ч хамаагүй явдаг л юм байгаа биз, харин гол уруу явган алхахдаа үлдээсэн мөрийг чинь үзэхэд мөн ч таатай байсан шүү. Чамд гэж хэлэхэд, би өчигдөр шөнө зургаан пони идсэн, үлдсэн хэд нь хаашаа ч алга болохгүй. Маш амттай байсан шүү. Амттай хоолоор дайлсны чинь хариуд би чамд нэг зөвлөмж хэлье. Чи одойнуудтай битгий хөл нийлүүлээд бай.

- Одойнуудтай юу? гэж гайхсан дүр үзүүлэн лавлав.

- Битгий яриа таслаад бай. Одойнуудыг би амт үнэрээр нь сайн мэднэ. Сайхан хоол. Одойнуудын үнэрийг мэдэхгүйгээр тэдний унаж явсан пони морьдыг идлээ гэж чи бодоогүй биз дээ. Хулгайч минь, чи тэдэнтэй нөхөрлөөд сайнаа үзэхгүй дээ. Тэд нартаа очиж хэлээрэй. Луу шинэ үнэр, хоббитын үнэр түүний сонирхлыг татаад байгааг ярьсангүй.

Миний алтан цомыг чи тэд нарт хэдээр өгсөн бэ? Хэдийг чамд төлөв? Юу ч өгөөгүй юу? Одойнууд ийм л амьтад даа, чи гав ганцаараа судас шөрмөсөө таслах шахан гүйж, гарт дайралдсанаа шүүрч явахад чинь тэд нар олзоо хүлээгээд гадаа салхилж суудаг. Ээ хөөрхий, чиний заяа чинь атаархал төрүүлэхгүй байна шүү. Их юм амласан уу? Бүү итгэ. Амьд үлдвэл их юм гэж бод.

Тортог луу ингэж ярихад Бильбо бүр шаналж орхив. Үзэгдэж харагдахгүй хулгайчаа цоо ширтэж байгаа Тортогийн цоргих харц түүн дээр тусахад Бильбо бөндөгнөн чичирч бөгжөө сугалж хаяад, Тортогийн өмнө хамаг түүхээ дэлгэмээр санагдаж байлаа. Луу ховсдож байгааг хоббит таамаглах ч үгүй байлаа.

Эр зоригоо чангалж байгаад Бильбо яриагаа үргэлжлүүлэв.

- Аугаа их Тортог гуай. Та их юм мэдэж байгаа ч бүгдийг мэдэхгүй байна. Бид ганц алт эрдэнэсийн төлөө ирээгүй шүү.

- Аа ха, баригдлаа даа гэж Тортог хөхрөөд,

- Азын тооны эзэн минь “Бид нар арван дөрвүүлээ” гэж яагаад хэлэхгүй байгаа юм? Миний алт эрдэнэсээс өөр юм та нарт хэрэгтэй болсонд би их баяртай байна шүү. Тэнэг толгой чи бүх алт эрдэнэсийг хулгайлна гэхэд зуун жил, зуугаас олон жил бөгтөгнөх болно. Хол ч явж чадахгүй. Ой тайгад та нарын хулгайлсан алт эрдэнсэд шунан дайрах шуналтан байхгүй гэж бодож байна уу? Ээх, усан толгой алт эрдэнэсээ та нар юугаараа зөөх юм? Хэн хамгаалж, хичнээн татвар төлнө гэж бодож байна? Чамайг одойнууд хуурахгүй гэж чи итгэж байна уу? Чиний хувь гэсэн чинь хумсын чинээ байвал яана?

Хэрцгий Тортог наг наг хөхөрнө.

Тэр өөрийнхөө үнэнд итгэж байлаа. Нуурын дээр амьдардаг хүмүүс энэ бүхэнд буруутай олз омгийн ихээхэн хэсэг Эсгаротод үлдэнэ гэж урьдынхаараа бодоод байв. Хөөрхий Бильбо, Тортог лууд итгэх шахсаныг яана. Бильбогийн толгойд Уулын гадагш яаж гарч, нууц хаалгыг яаж олъё доо гэдэг ганц бодол эргэлдээд байлаа. Алт эрдэнэсийг яаж зөөж нутаг усандаа аваачих талаар хоббит ер бодсонгүй.

Нээрээ, одойнууд эгэл Бэггинсийг одоо болтол шоолон хөхөрч, үнэхээр түүнийг хуурахаар шийдсэн бол яана аа, гэсэн аймаар эргэлзээ түүний толгойд төрөв. Үгүй ээ, үгүй байлгүй дээ. Одойнууд тун үнэнч нөхөд.

Лууны ховсдол үйлчилж эхэлжээ. Тэдний илбэн ховсдохыг эсэргүүцэж чадах хүн ховор байдаг.

- Алт эрдэнэс гол бишээ. Бид өшөөгөө авах гэж ирсэн юм. Бид эгц эрэг, хад хавцлаар явж, ус голыг гаталж, агаар тэнгэрээр нисэж ирсэн. Баян Тортог чамтай тооцоо хийх гэж зорьсон. Чамд цусан өшөөт дайсан байгаа гэдгийг чи мэдэж байгаа биз дээ?

Тортог луу дахиад л нуг нуг хөхрөв. Бильбо айсандаа нууц хонгилын ханыг нүдэхэд үүнийг сонссон одойнууд ноён Бэггинс зовж шаналан үхэж байна гэж бодоцгоолоо.

-Өшөөгөө авах гэнэ ээ гэж луу урхираад зовхио өргөхөд, түүний нүдний цөцгий чийдэн мэт гэрэлтэж, агуйн гүнийг гийгүүлэв. Тооцоо хийнэ гэнэ ээ, түүний өшөөг авах хамаатан садангууд нь хаа байна?

Дейлийн эзэн Гирион бас л үхэж үрэгдсэн. Түүний хүү, хүүгийн хүүхдүүд хаа байна? Өшөө хонзон авах хүүхдүүд нь хаа байна? Тэд надаас айж байна, мэдэв үү, хулгайч минь, айж байна. Би хаана ч хамаагүй хэнийг ч хамаагүй алж хяддаг болохоор намайг эсэргүүцэн босох амьтан байгаагүй юм. Би эртний эрэлхэг баатруудыг дарж устгаж байсан, одоогийн баатрууд гээд байгаа амьтад тэдний дэргэд юу ч биш.

Тэр үед би залуухан, боловсроогүй байсан даа. Одоо бол би хөгшин хүчирхэг, хүчирхэг, хүчирхэг дээ. За ийм байна даа, хулгайч минь. Миний хайрс хэдэн арван бамбайнаас ч зузаан, миний шүд сэлэм, миний хумс жад, миний сүүлний шарван гуядах цохилт аянгын нүргээн, далавч минь салхи шуурга дэгдээгч, улаан галан амьсгал минь үхэл, үхэл гэсэн үг.

- Би сонссон юм байна. Лууны гүзээ... э-э... энгэр дээр хайрсгүй гэдэг. Би л андуураагүй бол?

Луу хоббитын үгийг таслан,

- Чиний буруу, буруу. Хуучирсан үгс. Би дээгүүрээ хайрсаар бүрэгдсэн харин доороо элгээрээ чулуун, үнэт эрдэнийн чулуун хайрстай. Ямар ч жад сэлэм сүлбэж чадахгүй.

- Би таамаглах ёстой байж дээ. Нээрэн, нээрэн. Үл сүлбэгдэгч Тортогтой хэн зэрэгцэх билээ. Алт эрдэнэсийн хантаазтай байх ямар тааламжтай сайхан бол оо?

- Тэгэлгүй яах вэ гэж Тортог сэтгэл ханамжтай зөвшөөрөв. Хоббит түрүүнд ирэхдээ түүний чулуун гүзээг харж амжсан бөгөөд юу гэдгийг нь мэдэхгүй байлаа. Луу хажуулдан хэвтээд,

- Хар даа. Хэлэх үг байна уу? гэлээ.

- Зүйрлэшгүй, Гайхамшигтай, Итгэшгүй, Энгийн биш.

Бильбо шагшин уулгалан магтсан боловч дотроо “Хөгшин толгой. Зүүн энгэр дээр нь байгаа хонхорхой юу юм бол оо? Мөлчийсөн мөөм шиг юм...” гэж бодлоо.

Магтаал үгээ хэллээ, сайн гэгч харж авлаа гэж бодоод Бэггинс хурдхан зайлахаар шийдлээ.

- Эрхэмсэг эзэнтэн минь таныг дахин саатуулахаа больё. Та амар даа. Та пони морьд хөөгөөд ядарсан байлгүй. Бас хулгайчуудын хойноос элдээд.. гэж Бильбо хэлчихээд хонгилоор дээшээ өгсөн гүйлээ. Түүний сүүлчийн үг Тортогийн уур хилэнг хүргэв. Луу хүзүүгээ сунган чөтгөрийнх шиг хоншоороо агуйн ханан дахь нарийхан нүх уруу ойртуулаад улаан дөлөөр үлээв. Бильбо нэлээн холдож чадсан учраас азаар хорчийтлоо түлэгдсэнгүй. Лууг шоолж хөхрөх хэрэггүй байсан юм даа. Энэ алдаа аминд нь хүрэх шахлаа.

- Ээх Бильбо, мангар аа гэж хоббит өөрөө өөртөө хэлээд,

- Хэзээ ч амьд лууг бүү доромжил гэв. Энэ үг сүүлд нь “Юм төгсөх болоогүй байна шүү” гэдэг хэлц үг болсон юм. Адал явдал үнэхээр төгсөх болоогүй байлаа.

Бүр орой болсон хойно хоббит гадагшаа гарч чадлаа. Нууц хонгилоос гэнэт одойнуудын гар дээр унасан гэхэд болно. Нөхөд нь түлэгдсэн шархнуудад нь анагаах тос түрхлээ. Бильбогийн толгойных нь арьсандаа наалдаж хайлсан гээг үс, мөн хөлийн улных нь арьс дахин төлжтөлөө их удсан билээ. Одойнууд түүнийг байдгаараа л хөгжөөн сэргээхийг оролдож луугийн оромжинд юу болсон, яагаад түжигнэн хүжигнээд байсан тухай сонсохыг тэвчиж ядан хүлээж байв.

Хоббит дуртай дургүйхэн ганц хоёр үг унагаж байлаа. Хоббит луунд илүү олон юм хэлчихсэнээ ойлгож одойнуудаас зэмлэл хэмлэл сонсох хүсэлгүй байлаа. Өөрөө өөрийгөө адгийн муугаар хараагаад сууж байхад боллоо юм биш үү.

Эцэст нь Бильбо тэссэнгүй.

Том саарал чулуун дээр яриа сонсоод сууж байгаа шувууг хоббит чулуугаар шидлээ. Шувуу нисэж хэдэн алхам холдсоноо дахин хуучин газраа эргэн ирж суулаа.

- Өгөр шувуу чинь гэж Бильбо уурлаад,

- Энэ ер нь яриа чагнаад байна. Ямар зэвүүн шувуу вэ гэж хараалаа.

- За, дэмий донгосоод яах вэ... их сайн санаатай, нөхөрсөг шувуу шүү. Миний өвөг дээдэс гарнаасаа тэжээж байсан сүргийн нэг ч байж магад... энэ шувууны хэлийг сурчихаад, Эсгарот хот уруу юмуу өөр орон газарт элчээр илгээж байсан гэдэг гэж Торин ярилаа.

- За тэгвэл, та нар Эсгарот хотынханд мэдээ илгээх гэж байгаа бол яах вэ сонсож л байг.

Одоо шувууны хэл мэддэг хүн байхгүй л болов уу гэж хоббит хэллээ.

- За тэгээд юу болсон бэ? Алив, ярь ярь гэж одойнууд хашхиралдахад Бильбо санаж байгаа бүхнээ яриад Тортог луу олон зүйлийг таамаглаад мэдчихсэнд сэтгэл зовниж байгаагаа

ХЭЛЛЭЭ.

- Тортог биднийг нуурын хотоос ирсэн тэр хотынхон бидэнд тусалсан гэдгийг таамаглаад мэдчихсэн. Луу тийшээ нисэх байх гэж би айж байна. Би ямар мангар толгой вэ? Би яах гэж торх унагч гэж өөрийгөө нэрлэв дээ. Эсгарот хотынхон тусалсан гэж тэнэг хүн ч ойлгоно шүү дээ.

- Өөрийгөө битгий буруутга. Хэлсэн л бол хэлсэн биз. Лууны өмнө ам алдахгүй байх хэцүү гэж би сонссон юм байна.

- Харин чи луунаас чухал зүйл хулгайлаад амьд мэнд гараад ирдэг ёстой сайн эр гэж би бодож байна. Лууны савраас мултарна гэдэг амар зүйл биш. Хөгшин толгой луугийн биенд нэг сул тал болох гүзээн дээрх гөлчгөр нүх байгааг мэдээд авлаа. Энэ чинь хамгийн гол зүйл гэж Балин аргадлаа. Луунуудтай ямар ямар жад сэлмээр хэн хэн дайтан байлдаж дийлж байсан тухай одойнууд дурсан ярьцгаалаа.

Үнэн баримтат, эргэлзээтэй, зохиомол зэрэг олон тохиолдлыг санацгаав. Яаж цохивол оновчтой, ямар арга барил зөв найдвартайг зөвлөлдөн хэлэлцсэний дараа ийнхүү шийдэв. Лууны алмайрч тайвширсан үеийг хүлээнэ гэдэг боломжгүй, унтаж байхад нь дайрна гэдэг өөрсдийгөө алж устгана гэсэн үг. Иймээс шууд эгц өөдөөс нь дайрч байлдах нь зөв гэгцгээв. Тэдний яриаг шувуу анхааралтай сонсож байснаа тэнгэрт одод түгэх үед чулуун дээрээс нисэн одов.

Одойнууд ам өрсөлдөн ярилцсаар байлаа. Бильбо энэ үед суух газраа олж ядан сэтгэл санаа нь үймэрч айж түгшиж байв.

- Алив, сонсоцгоо гэж хоббит тэдний ярианд оролцож,

- Нуугдацгаая тэгэх үү, аан? Өвс ногоо шатсан, газар хүйтэн, орой ч болчихож. Луу дахиад ийшээ нисэж ирнэ гэж би бүр бүх биеэрээ мэдрээд байна. Намайг яаж агуйд орсныг одоо тэр мэдэж байгаа, тэгээд дээрх бүхнийг олоод харчихна. Хэрвээ догширч хилэгнээд хүсэх л юм бол Уулын хэцийг бут цохино. Бид нар чулууны бутархайнуудтай цуг будаа шиг цацагдана. Энэ бол Тортогт юу ч биш гэв.

- Ноён Бэггинс та нэг л гутрангүй байх чинь. Тортог тэр ханын нүхийг бөглөхөд юу байх вэ дээ, тэгэхэд яарахгүй байх юм. Чив чимээгүй байна, сонсож байна уу? гэж Ториныг эсэргүүцэхэд Бильбо ийнхүү өгүүлэв.

- Аах, мэдэхгүй мэдэхгүй... Намайг эргэж ирнэ гээд хүлээж байгаа ч юм билүү. Эсвэл үүрэндээ ямар нэг юм өөрчлөхийг хүсэхгүй байгаа ч юм билүү. Надтай бүү марга, битгий намайг ятга. Тортог одоохон гараад ирнэ дээ. Нууц хонгилд нуугдаад үүдээ хаачихья.

Хоббитыг ийнхүү айхтар их сандрахад одойнууд үгэнд нь орцгоолоо. Гэхдээ үүдээ хаасангүй. Дараа нь онгойлгож чадах ч юмуу үгүй ч юмуу хэн мэдэх вэ? Сүүлд нь лууны бэлэн хоол болно шүү дээ. Ямар ч аниргүй байлаа. Нууц хонгилын хагас дэлгээстэй хаалганы дэргэд одойнууд яриагаа үргэлжлүүлэн удаан сууцгаав.

Одойнууд хоббитыг хуурч байна гэсэн Тортог лууны үг бүгдийн сэтгэлийг үймүүлчихэв. Бильбо ийм үг сонссондоо гутарч харамсаж байлаа. Энэ муу үг элэг зүрхэнд эргэлзээ төрүүлнэ. Хоббит бол нөхөд нь түүнийг хуураагүй гэдэгт л итгэхийг хүснэ.

- Бидэнд алт эрдэнэсээ л олж авах чухал. Дараа нь яахыгаа шийдэцгээе. Алаагүй үнэгний арьсыг хуваана гэгчээр одоо юу ярих юм бэ? Ноён Бэггинсийн хувьд бид танд гүн ихээр талархаж баярлаж байна. Эндхийн газар нутаг зэрлэг аймшигтай юм чинь таны хувийг Хоббитын улсад чинь хүргэж өгч туслахыг бодно. Ноён Бэггинс та итгэвэл итгэ, өөрөө мэд дээ гэж Торин өгүүллээ.

Дахиад л Тортог лууны үүрэнд байгаа алт эрдэнэсийн тухай хөөрцгөөв. Торин, Балин хоёр тэдний мэдэх зүйлсээс бүрэн бүтэн үлдсэн болов уу, яагаа бол гэж ярилцаж байлаа. Одойнууд агуу их хаан Бладортийн армид зориулж хийсэн алтаар чимсэн гурван үзүүртэй жаднууд, аль дэвин галвын үед нас эцэслэсэн цэргүүдийн бамбай, Трорын хоёр бариултай томоо алтан цом зэрэг яасан бол? Энэ Трорын алтан цом дээр эрдэнийн чулуун нүдтэй шувуунууд бас үнэт чулуун навчтай цэцэгс зэргийг гоёмсог сайхнаар сийлсэн байдагсан. Мөн нов ногоон өвс шиг өнгөтэй таван зуун маргад сүвлэсэн, Гирионы зүүлт (Гирион Дейлын эзэн хаан байсан) байгаа болов уу? Гирион энэ зүүлтээ гангаас хатуугаараа гурав дахин бөх цэвэр мөнгөөр одойнуудын хийсэн торлог хуяг цамцны хамт том хүүдээ бэлэглэсэн юм. Ийм хуяг цамц өөр хаана ч байхгүй, байх ч ёсгүй шүү. Бас одойнуудын Уулын гүн зүрхнээс олсон том алмааз ямар гайхалтай гоё билээ. Мөн ч гоё шүү. Энэ чинь Трайны алмааз шүү дээ.

- Алмааз чулуу, алмааз чулуу гэж Торин солиорон зүүрмэглэж байгаа юм шиг үглэн эрүүгээ өвдгөөрөө тулан гөлийж суулаа.

- Алмааз чулуу мянган талт бөмбөлөг, галд хаясан мөнгө шиг гэрэлтдэг, наран дээрх ус шиг, оддын доорх цасан ширхэг, сарны туяан дахь бороон дусал л гэсэн үг.

Хаалга манан суугаа Бильбод юун алт эрдэнэс мантай. Хоббит тэдний ярианд үл оролцон, гаднаас ямар нэг хачин жигтэй өчүүхэн дуу чимээ гарахыг сонсохгүй өнгөрчих вий гэж хичээнгүйлэн чагнаж суулаа.

Улам харанхуй болсоор хоббитын сэтгэл түгшсээр.

- Үүдээ хаагаарай гэж хоббит одойнуудаас гуйв. Энэ өгөр луу юу ч хийж магад. Би айж байна. Тортог муухай юм сэдэж байгаа байхаа. Өчигдрийнх шигээ архиран түрхрэн шуугьж байсан бол бараг дээр байж дээ. Оройтоогүй дээрээ одоохон үүдээ хаагаач. Хоббитыг ийнхүү хэлэхэд Торин түүнийг цоо ширтсэнээ дуугүйхэн босож хаалга тулж байсан чулууг авч хаялаа. Хаалга хаагдаж тэд нууц хонгилд түгжигдэн үлдлээ.

Яг амжжээ. Тэднийг хонгилын гүн уруу жаахан холдтол ямар нэг аварга амьтан мөргөлдөх мэт Уул нэлдээ доргин чичирлээ. Нууц хонгилын хана хагарч цууран толгой дээрээс чулуу асгарна. Хэрвээ хаалга онгойвол яана аа.

Пүү, бодохоос аймаар юм. Одойнууд зугтан гүйж, гадаа Тортог лууны хилэгнэн орилох сонсогдоно.

Аварга урт сүүлээрээ шарван гуядаж, хад чулууг бут ниргэнэ. Шатсан зүлэг ногоо, шувуу сууж байсан том хадан чулуу, чулуун хана, хадан хясааны нарийхан ирмэг цөм галт уулын лавайд дарагдсан овоолттой балгас мэт боллоо.

Тортог луу муухай хараал идмээр хулгайчдыг гэнэдүүлэн дайръя гэж боджээ. Луу үүрнээсээ чимээгүйхэн гарч Уулын баруун энгэр өөд нисэн нууц хонгилын дээрх гарцыг олох, далимд нь одойнуудыг амтархан идье гэж зорьжээ. Одойнууд жаахан л удсан бол Тортог луу зорьсондоо хүрэх байв. Харин одоо луу юу ч, хэнийг ч олоогүйдээ улангасан уурлан архирч байлаа.

Тортог луу чулуун шуурга буусан хотгор дээгүүр эргэлдэнэ. Энд одоохондоо түүний хилэнг дэгдээх юм харагдсангүй. Өөр ажлаа амжуулж болно шүү дээ.

- Торх унагч... гэнэ ээ гэж Тортог уухилав. Чи уснаас ирсэн, ус чамайг авчирсан гэнэ ээ. Чиний үнэрийг л би нэг мэдэхгүй байгаа юм даа, яах вэ. Чи нууран дээр амьдардаггүй юм бол тэд нар чамд тусалсан байж таарах нь ээ. Тэдэнд Уулын доорх Хаан хэн болохыг сануулах цаг ирлээ дээ!

Тортог луу агаарт дүүлэн гарч улаан галан дөл өрвөлзүүлсээр Урт нуурын зүг өмнө тийш нисэн одов оо.

Арван гуравдугаар бүлэг

Гэрт гадаа хоёрт

Нууц хонгилд шивнэн ярихад чанга хашхирч байгаа юм шиг санагдахаар чимээгүй харанхуй байлаа. Жаал зуул юм идсэн болцгоогоод унтахаар хэвтэцгээв. Зүүрмэглээд байн байн сэрж харцгаахад, эргэн тойронд нөгөө л тас харанхуй, анир чимээгүй нөмөрч байв. Бүтэн хоног лав өнгөрсөн байхаа, хэдэн цаг болсныг хэн ч мэдэхгүй байлаа. Иймэрхүү байдалд удахгүй бүтэж үхнэ, эсвэл солиорох бизээ. Эрүүл агаараар нэг ч болсон амьсгалахсан! Луу өөрийнхөө хэвтэрт эргэж ирсэн бол дээр байхгүй юу, энд хажууханд байна гэж мэдэж байхсан, харин энэ чимээгүй орчин түгшүүр төрүүлж, Тортог хаа нэг газар ойрхон нуугдчихаад аймшигт дайралт хийхээр бэлдэж байгаа ч юм билүү. Эцэст нь тэдний тэвчээр алдагдлаа.

- Хаалга руу! гэж Торин тушаагаад,

- Үхэхийнхээ өмнө цэвэр агаараар амьсгалаад авъя. Ингэж харанхуйд бүтэж үхэхээр Тортог луутай тулалдаж байгаад өнгөрсөн нь дээр.

Хэдэн одой хонгилоор өгсөн алхацгаав. Тэд аргагүй мухардалд оржээ. Нууц хонгил дээрээсээ нурж хаалга хүрэх аргагүй, зам хаагджээ.

- Бид хашигдчихлаа! Бид үхлээ, үхлээ! Эндээс гаралтгүй! гэж одойнууд хашхирав.

Тэд үглэн уйлж үс гэзгээ урж тасдах нь холгүй сандарцгаана. Гэнэт Бильбогийн сэтгэл учиргүй тайвширч хүзүүн дээрээс нь чулуу аваад хаячихсан юм шиг болов.

- За тайвширцгаа! Амьд байхад арга олдоно гэж аав минь хэлдэгсэн. Би луугийн өргөөнд хоёр удаа зочилсон, одоо дахиад нэг явъя. Тэнгэр ивээж эзэн луу байхгүй ч байж магадгүй. Өөр арга алга. Энэ удаа эрхэмсэг нөхөд минь та нар надтай цуг явна шүү гэж хоббитыг өгүүлэхэд цөхөрсөн одойнууд зөвшөөрцгөөлөө.

- Одоо чимээгүй болцгоо! гэж хоббит хажуудаа яваа Торинд шивнэлээ.

- Тортог луу агуйдаа байхгүй байхаа, гэхдээ юмыг яаж мэдэх вэ, эрсдэж болохгүй.

Тэд тэмтрэн тэмцчин цааш уруудлаа. Бильбо байсхийгээд л зогсон чимээ чагнана.

Одойнууд амьсгаадан хөлөө чирэн явахад хонгилд цуурайтан сонсогдоно. Одойнууд хоббит шиг анир чимээгүй явж чадахгүй юм чинь. Харин доороос торхийх чимээ ч үл гарна. Бильбо агуйн хажууд бараг ирлээ гэж бодоод бөгжөө зүүлээ. Нүд сохлом харанхуйд ямар нэг юм олж харахын аргагүй байхад ингэж болгоомжлох нь илүүц мэт. Хоббит гараа сунган ойр орчноо тэмтэрснээ гэнэт гар нь хоосон нүхэнд орчих мэт болсноо хөл дээрээ тогтож чадалгүй тонгорон өнхөрч агуйн шалан дээр унав.

Хоббит нүүрээрээ шал арчин арайхийн амьсгалж ядан хэвлээ. Түүнд хэн ч хүрсэнгүй, түүнтэй хэн ч ярьсангүй. Тэрээр толгойгоо аяархан өргөлөө. Агуйд харанхуй байх агаад тээр

хол лууны улаан дөлөн нүдний цөцгийтэй огт адилгүй бүдэг гэрэл сүүмэлзэнэ. Энэ нь Тортогийн агуй мөнөөсөө мөн байлаа. Лууны эхүүн үнэр ханхийж утаа тортог амтагдана.

Бэггинс тэсгэлгүй уулга алдлаа.

- Тортог! Чи муу хараал идсэн хорхой, нуугдахаа боль. Исгэрээд гараад ирээч. Намайг барьж чаддаг юм бол базаад идээч!

Агуй цуурайтан түүний дуу өөрт нь сонсогдов. Бильбо өндийж босоод нууц гарц аль талд байгааг мэдэхээ болив.

- Тортог яах гэж байгааг мэдэх юмсан. Өнөө орой (Гадаа өдөр ч болж байгаа юм билүү?) луу зугаалахаар гарсан бололтой. Ямар сайн юм бэ? Жаахан гэрэлтэй ч болоосой. Ойн, Глойн хоёр Эсгаротод галтай хайрцгаа гээгээгүй бол одоо аштай байхсан. Хөөе, хэн нэг нь гэрэл гаргаатааач! гэж Бильбо хашхирлаа.

Бильбогийн сүр сархийн унахыг сонссон одойнууд мэдээж айсандаа хоббитын унасан нүхний аман дээр бөөгнөрөн зогсоцгоожээ.

Хоббитын дууг сонсонгуутаа,

- Чиш-шш! гэж шивнэлдэв. Тэдний дууг сонсоод Бильбо ямар ч гэсэн аль талд түүний унаж орсон нүх байгааг мэдэж авлаа. Одойнууд түүнд туслах гэж яарсангүй. Гэрэл! Гэрэл! гэж Бэггинсийг хөлөө дэвслэн чарлахад Торин сая нэг юм хоббитод туслахаар шийдлээ. Ойн, Глойн хоёрыг багаж зэвсэг авчруулахаар явуулав.

Тэр хоёр удахгүй ирлээ. Ойн гартаа асаж буй жижигхэн бамбар барьжээ. Бильбо нүхний зүг гүйн очиж бамбарыг шүүрэн авлаа.

Одойнууд айсан хэвээрээ байж бусад бамбаруудыг асаахаас болон хоббиттой нийлэхээр агуй уруу орохоос бүрмөсөн татгалзав. Бэггинс лууны саварт орохоор зүтгэвэл өөрөө л зүтгэнэ биз.

Энэ нь түүний хэрэг. Ер хоббит Түлхүүр -Чимхүүр. Бүх юмыг өөрөө л шийдэг. Ноён Бэггинс та яв, яв, бид энд суугаад хүлээж байя гэж Торин тов тодорхой хэлэв.

Хоббит ч тэднийг шахсангүй. Бамбараа толгой дээрээ өргөөд агуйг нэгжиж үзэхээр урагш алхлаа. Байсхийгээд л хангинах жингэнэх дуу гарахыг одойнууд сонсож байгаа нь Бильбо дахин ямар нэг алтан мөнгөн эдлэлд бүдэрч байгаа нь тэр. Хоббит цаашаа явсаар байв. Бүрэг харанхуйд бараг харагдахгүй байсан бамбарын улаан гэрэл гэнэтхэн дээшлээд ирлээ. Бильбо овоолттой эрдэнэс дээр авирч гараад ямар нэг юм харан тонгойв.

Энэ нь Алмааз чулуу байлаа. Торины нөгөө яриад байсан чулуу яг дүрээрээ. Ганцаардмал уулын голт зүрх байсан чулуу. Энэ чулуутай адил чулуу өөр байхгүй учраас Бильбо мянган чулуун дотроос ч энэ чулууг таних байлаа. Агуйн бүрэнхийд алмааз чулуу бүдэгхэн гэрэлтэнэ. Бильбо чулуунд ойртон хартал дотроосоо гэрэл цацруулсан бөмбөлөг байлаа. Чулууны гэрэл үй түмэн талстад хуваагдан гайхамшигтай олон өнгөөр туяарна. Хоббитын

зүрх дэлсээд ирэв. Алмааз оч цацруулан гялалзахад орчных нь тоо тоймшгүй алт эрдэнэс өнгө өнгөөр цацран туяарч гялтганана.

Бильбо чулуу уруу гараа өөрийн мэдэлгүй сунгав. Алмаазыг атгаж авах гэтэл хоббитын алга дэндүү багадаад байлаа. Бильбо нүдээ аньж байгаад хоёр гараараа чулууг өргөн хамгийн гүнзгий халаасандаа шургууллаа.

“Би ч одоо жинхэнэ хулгайч боллоо. Одойнуудад дараа нь хэлнэ. Тэд намайг өөрийнхөө хувийг өөрөө сонгоорой гэсэн биз дээ. Би энэ алмаазыг авна бусдыг нь тэд аваг” гэж Бэггинс бодож амжив.

Хоббит хэдийгээр ийнхүү бодсон ч энэ сонголтыг одойнууд дэмжихгүй гэж таамаглан эргэлзэж байв.

Бильбо цааш явж овоолттой эрдэнэс дээрээс буулаа. Одойнуудад Бильбогийн бамбарын гэрэл үзэгдэхээ болив. Тэгснээ гэрэл дахин харагдав. Бильбо агуйг хөндлөн гарч явлаа. Бильбог цаад хананы буланд том хатавчны дэргэд очиход гаднаас үлээх сэвшээ салхи бамбарыг нь унтраачих шахав. Хоббит хатавчны цаагуур шагайгаад авав. Харанхуйд өргөн өргөн хонгил цэлийх агаад дээшээ өгсөх шатны доод гишгүүрүүд харагдав.

Тортог луу хаа ч алга байлаа. Одоо буцахгүй бол болохгүй. Бильбо эргээд алхтал толгой дээгүүр нь хар сүүдэр шуугин өнгөрч, ямар нэг юм нүүрэнд нь хүрэх шиг болов. Бамбар нь унаж унтрав.

Бильбо хурдхан сэхээ авч, “Сарьсан багваахай байхаа” гэж өөрөө өөртөө хэлэв.

- За байз, байз! Одоо яах вэ? Хойно, урд, баруун, зүүнээ яаж олох вэ гэснээ,

- Хөөш, Торин! Балин! Ойн! Глойн! Фили! Кили! гэж орилов. Асар том агуйд түүний хашхирах яг л шивэгнэж байгаа юм шиг дуулдана.

- Наашаа, хэн нэг нь ирж надад туслаач! Туслаач!

Хэдхэн хормын дотор эрэлхэг Бильбо ийнхүү өрөвдөлтэйгөөр орилон тусламж гуйж байлаа.

Одойнууд түүний дууг сонссон боловч тодорхой үгс ялгагдахгүй зөвхөн “туслаач” гэдгийг л ойлгоцгоов.

- Юу болов оо? Луу лав биш, луу ирсэн бол хоббит орилж ч амжихгүй! гэж Торин үглэв.

Жаахан хүлээзнэтэл ямар нэг сэжигтэй дуу чимээ гарсангүй зөвхөн Бильбо л авраарай, авраарай! гэж орилж байв.

- Бамбараа асаацгаа! гэж Торин тушаагаад,

- Одоо дайчин хоббитдоо туслах цаг боллоо гэхэд Балин,

- Тэгэлгүй яах вэ, одоо тусалцгаая. Бильбо бидэнд хичнээн олон удаа тус хүргэлээ дээ, одоо бидний ээлж болсон. Тэгээд ч биднийг аюул осол амдаагүй бололтой гэлээ.

Глойн бамбаруудаа асаалаа. Одойнууд агуй уруу нэг нэгээрээ цувран бууж хоббитын дууг баримжаалан тэр зүг яарцгаав. Хол явцгаасангүй. Бильбо тэдний гэрлийг хараад өөдөөс нь гүйлээ.

-Сарьсан багваахай нисээд бамбар унтарчихлаа гэж одойнуудын асуултанд Бильбо өөрийгөө зөвтгөн гүвтнэнэ. Чамайг хэрчиж байгаа юм шиг л юундаа орилсон юм, гэж одойнууд түүнийг зэмлэсэн ч үгүй. Юу гэвэл, тэд нар алт эрдэнэсийн дэргэд зогсоод өөр юу ч бодох тэнхээгүй болчихоод байлаа.

Хамгийн сэрэмжтэй одой ч гэсэн алт эрдэнэс хараад эрэлхэг зоригтой, догшин дайчин болж ямар ч аюул түүнийг айлгаж чадахгүй болдог аж. Одойнууд хэрвээ хоббитын халаасанд алмааз чулуу байгааг мэдсэн бол юу болох байсан бол?!

Тэд Тортог луу байхгүй боломжийг ашиглан агуйг нэгжихээр нэгэн зэрэг ухасхийв. Бамбаруудаа шүүрэн авч аюул ослыг умартан зүг зүг уруу гүйлдлээ. Чанга чанга ярин, бие биеэ дуудаж, шалан дээрээс алт эрдэнэс шүүрэн түүцгээж хананд байгаа зэр зэвсгийг авч эргүүлэн тойруулан үзэж, илж нэг бараг л долоох нь холгүй шагширцгаана.

Фили, Кили хоёр мөнгөн утастай алтан ятга олонгуутаа тэсвэр алдан хөөрцгөөж шууд тоглож эхэлцгээв. Луу хөгжим сонирхохгүй болохоор ятганд хүрээгүй байна. Ятга өнгө хөгөө алдаагүй байлаа. Бүүдгэр агуйд эртний аялгуу цуурайтав. Бусад нь алт эрдэнэсээр халаас бүхнээ дүүргэж багтахгүй байгааг нь санаа алдан эргүүлж тавина. Торин агуйг нэлд нь нэгжиж нэг л онцгой юм хайгаад байв. (Мэдээж Алмааз чулууг эрсэн биз).

Дараа нь одойнууд зэр зэвсгээс авцгаав. Торин алтан торлог хуяг өмсөж, үнэт чулуу шигтгэсэн бүс бүсэлж, бүсэндээ мөнгөөр өнгөлсөн цавчуур хавчуулав. Хаан эзэн гэмээр харагдана.

- Ноён Бэггинс! Би танд анхны бэлэг өгье. Цуваа тайлаад, үүнийг өмс гэж Торин хоббитыг дуудлаа.

Тэрээр жижигхэн эльфэд зориулсан бололтой, хуучин цагийн хуяг цамц хоббитын мөрөнд өмсгөв. Эльфүүд лигфрил гэж нэрлэдэг үнэт гайхамшигтай сайн металлаар энэ цамцыг хийжээ. Цамцан дээр нь уулын болор, сувд шигтгэж оёсон бүс сайхан зохино. Ган цагаригуудыг ширээр бүрж хийсэн малгай нь бас л үнэт чулуун шигтгээгээр гялалзана. Хоббит энэ бүгдийг өмссөнийхөө дараа “Гоё, гоё!” гэснээ,

- Би эвгүй муухай харагдаж байна уу? Гэртээ байсан бол намайг шоолж инээлдэх байсан байхаа! Толинд харах юмсан гэв.

Одойнууд алт эрдэнэсийг ухсаар байлаа. Харин Бильбогийн бүр дургүй хүрчихэв. Тэрээр тэднээс холдон сууж юу хийх, яахыгаа бодож эхэллээ. “Энэ алтан цом цөмөөрөө хоосон юм чинь ямар хэрэг байна аа. Яг одоо Беорны аяганаас амтат бал уухсан даа” гэж шүүрс алдан

санаашрав. Бильбо,

- Торин! гэж дуудаад, одоо яах вэ? Тортог лууг ямар ч зэвсэг дийлэхгүй. Та нар энэ алт эрдэнэсийг март март! Бид ганцхан алтны төлөө ирээгүй шүү дээ. Аз эз гэдэг адтай эгзэгтэй байдаг.

Торин эрдэнэсийн гялбаанаас нүдээ арайхийн холдуулж,

- Нээрээ шүү. Одоо явах хэрэгтэй. Би замчилна аа! Энэ ордны хонгил гарц болгоныг би мянган жил болсон ч мартахгүй шүү!

Торин бусдыгаа дуудлаа. Тэд толгой дээрээ бамбараа өргөсөөр агуйг хөндлөн гарч асар том хаалганы доогуур гарлаа. Алт эрдэнэсийн бараа тасартал одойнууд харамссан нүдээр эргэн эргэн харж явлаа.

Эрдэнийн чулуу нь гялалзаж цацарсан хуяг бамбай цамц, дуулга тэргүүтнийхээ дээгүүр одойнууд шөвгөр оройт малгайтай цамцаа өмсөцгөөв. Ар араасаа цувралдан байсхийгээд л зогсон чагнан тун сэрэмжтэй явцгаалаа.

Уулын дотор босгосон одойнуудын эртний бэхлэлтүүд эвдэрч, зуун жил ч нурахааргүй байсан бүгдийг Тортог луу эвдэлж хаясан ч гэсэн Торин нөхдөө гарах гарц уруу итгэлтэй замчилж явлаа. Урт шатаар өгсөж гараад нэг их сунайсан хонгилоор явснаа дахин эргэж нэгэн хадан дээгүүр цохиж гаргасан гөлгөр шатаар өгслөө. Тэдний замд ганц ч амьд амьтан дайралдсангүй. Хааяа нэг тэдний гэрлийг алсаас харсан жижигхэн хар сүүдрүүд зайлан нисэж байв.

Хоббит цаашаа явах тэнхээ нь тасарч шатны гишгүүрүүд түүнд дэндүү өндөрдөж аргаа барсан яг тэр үед гэнэт агуйн тааз алга болчихлоо. Бамбарууд харанхуйг гэрэлтүүлж чадахаа болив. Хаанаас ч юм дээд талын нэг газраас бүдгэвтэр гэгээ тусаж агаар мэдэгдэхүйц цэвэршээд ирлээ. Өмнө талд нь мурийж тахийсан, түлэгдэж харласан, хаалганы том том даруулгууд харагдана.

- Энэ бол Трорын их танхим. Энд хаан зөвлөлөө цуглуулж, хүлээн авалт, найр наадмаа хийдэг байсан. Бид бараг гарцанд хүрээд ирлээ гэж Торин хэллээ.

Балгас болсон танхимыг өнгөрч явав. Эвдэрч түлэгдэж, тонгорчихсон ширээ, урт урт, мөн мухар сандлууд, үйрч яйрсан аяга таваг, яс үсэн дээгүүр зузаан тоос дарсан байлаа. Дахиад нэг хаалгаар гараад ус урсах чимээ сонсов. Гэрэлтэй болоод ирлээ.

- Түргэн голын эх булаг. Эндээс урсаад их Хаалга хүрдэг юм. Одоо голоо дагаад явна гэж Торин удирдав.

Чулуун ханан дээрх нүхнээс эртний мастеруудын хийсэн нарийхан, гүнзгий яг л сум шиг шулуухан суваг уруу эрчилсэн хүчтэй урсгал бууж байлаа. Эрэг даган хэд хэдэн цэргүүд зэрэгцээд багтаад явчихаар өргөн чулуун зам зурайна.

Одойнууд хадан цохиотой хошууг тойрч гүйтэл, тэдний өөдөөс өдрийн хурц гэрэл нүд гялбуулан туслаа. Тэдний өмнө хэсэг, хэсэг газартаа гал дөлөнд харласан хуучны сийлбэртэй том хаалга дүнхийж харагдав. Хаалганы цаана намрын утаан дунд Уулын гүвгэр дундаас нарны алтан цацраг үүдний чулуун өнгөн дээр гялалзан тусна.

Одойнууд дааман хаалга уруу алхацгаав. Луугийн гүзээнд гялалзталаа зүлгэгдсэн чулуун дээр хөл гулсана.

Бамбаруудаа шидчихээд, ийш тийш гүйлдэн ойр орчноо судлав. Холгүйхэн газар доороос горхи цоргин гарч, хөндийн зүг хөөсрөн урсана. Их Хаалганы цаанатайх тэгш хөндийд Дейл хотын нурманд дарагдсан балгас сааралтана.

- За тэр, би ч энэ хотыг харна гэж санаагүй шүү. Нар салхи үзээд ингэж их баярладаг гэж мэдэхгүй явлаа. Их хүйтэн байна шүү.

Үнэхээр хүйтэн салхи ясанд ортол үлээж, өвөл ойртсоныг сануулна. Салхины үзүүрээр тэд бүгдээрээ чичрэн даарч эхэллээ.

Бильбо зөвхөн даарсан төдийгүй өлссөнөө мэдрэв.

- Одоо бүр үд болчихсон байхаа. Жаахан юм идэцгээе. Идэх юм байна уу? Нэг аятайхан нөмөртэй газар олж сууцгаая гэлээ.

- Би нэг аятайхан газар мэднэ. Баруун урд гүвээн дээрх хуучин харуулын газар гэж Балиныг хэлэхэд Бильбо,

- Хол уу? гэж асуув.

- Таван цаг орчим явна. Нэлээн хэцүү зам даа. Тэр голын зүүн эрэг дээрх зам аль хэдийнэ баларчээ. Харин доошоо хараач. Тэр доор нурангийн тэндээс гол зүүн тийшээ эргэсэн байгаа биз? Тэнд хуучин гүүр байсан юм. Тэр гүүрнээс шатаар өгсөж улаан хошуут очих зам уруу гарна. Тэнд харуулын газар уруу шууд чиглэх зөрөг байгаа.

- Өөх, ямар аймаар юм бэ? Дахиад л явах, дахиад л авирах! Гэдэс хонхолзоод байхад шүү! Хичнээн цаг хоол ундгүй явж байна!

Хоббит цагийн тооцоогоо алджээ. Түүнд долоо хоног өнгөрсөн юм шиг санагдана. Уг нь нууц хонгил нурж, хоригдсоноос хойш ердөө л хоёр өдөр өнгөрч байгаа билээ.

- За явья, явья гэж сэтгэл хангалуун болсон Торин инээж хэлээд халаасандаа гараа шургуулаад эрдэнийн чулуугаа шарчигнуулав.

- Миний ордонг нүх гэж нэрлүүзэй! Гайгүй ээ, би чимэглээд өгнө өө хө!... гэж нэмэв.

- Эхлээд Тортог лууг дарах хэрэгтэй гэж Бильбо баргар царайлан татгалзаад,

- Ингэхэд, луу хаачив аа? Лууны хаана байгааг хэлсэн хүнд би идэх хоолоо өгнө. Луу биднийг

дээд тэнгэрээс ширтэж суугаагүй байлгүй дээ?

Одойнууд тэвдэцгээв. Бильбо, Балин хоёрын зөв гэж цөмөөрөө зөвшөөрлөө.

- Одоо хөдлөхгүй бол болохгүй. Намайг ямар нэг нүд ширтээд байгаа юм шиг санагдаад байна гэж Дори хэлэв.

-Энд хүйтэн хов хоосон. Ус байгаа ч идэх юмгүй газар байна. Иймээс ч луу цаг үргэлж өлсгөлөн... гэж Бомбур үглэж эхэлтэл бусад нь,

-За боллоо, боллоо! Балин замаа заагаарай! гэж орилцгоолоо.

Голын баруун эрэгт чулуун хана зам хаан сүндэрлэж байсан тул зүүн эргээр явцгаав. Уулын энэ хэсэг дэндүү сүйрч сүйтгэгдсэн байх нь. Алмааз чулууг санан дэмийрэх шахан явсан Ториныг хүртэл эрүүлжүүлчихэв. Балины яриад байсан гүүр аль хэдийнэ нуран унаж, уснаас зөвхөн тулгуурууд нь ёрдойж харагдана. Голын гармаар гаталж, эгц энгэр өөд өгсөн явсаар нэгэн тэгш тагтанд амран сууж зөөхий бингээ идэцгээв. Эсгарот хотынхон алс хол явахдаа ийм бин хийж авч явдаг бөгөөд удаан зажилж идэхэд их өл даадаг ажээ.

Одойнууд голоос баруун тийш уулын өмнөд хэц өөд бага багаар урагшилсаар байлаа. Харуулын газар уруу хөтлөх жимийг арайхийж олов. Шил шилээ даган цуварсаар, дээшээгээ удаан гэгч авирцгаав. Орой болж нар жаргах үед сая нэг юм уулын хэц дээр гарцгааж гурван талаасаа алсын бараатай тэгш талбайд хүрцгээлээ. Зөвхөн хойд талдаа салхинаас хамгаалсан мэт хадан хясаатай аж. Эндээс баруун, зүүн, өмнө зүгийн үзэмжтэй сайхан байгаль уулын орчин тойрон алган дээр юм шиг дэлгэгдэн харагдаж байлаа.

-Энд харуулууд гардаг байлаа гэж Балин тайлбарлаж эхлэв.

-Ийм харуулын цэгүүд Ганцаардмал ууланд хэд хэд бий. Бид тэр үед дэндүү тайвширч сэрэмж алдсан даа. Тортог лууг түрүүлж харсан болов уу? Бүх юм өөр байх байлаа даа. За яая гэх вэ. Эндээс бид хэнд ч харагдахгүйгээр их олон юм үзэж чадна даа.

-Тортог биднийг харсан бол нуугдаад ч нэмэргүй гэж Дори гөвтнөв. Уулын оргилд сууж байгаа лууг харах гэсэн юм шиг Дори оргил өөд байн байн хяламхийнэ.

-Биднийг хэн ч хараагүй байхаа гэж бодоцгооё. Өнөөдөртөө эндээс явахгүй ээ! гэж Торин зөвлөлөө.

-Ура! Ёстой үнэн, зөв үг байна гээд Бильбо газар лагхийтэл суулаа.

Энэ харуулын газар бараг зуугаад одой багтахаар том ажээ.

Гол танхимаас салсан дамждаг өрөөнд арай дулаахан байв. Энд зэрлэг амьтад ирж бүгээгүй бололтой, цэв цэвэрхэн ажээ. Ачаа пүүгээгээ буулгацгаан зарим одойнууд ядарсандаа унтаад өгөв. Зарим нь үүдний дэргэд суугаад яах ийхийгээ зөвлөлдөнө. Одоо бол тэд зөвхөн Тортог луу хаана байгаа бол? гэж ярилцаж байлаа. Баруун зүүн талд нисэж буй луутай төстэй юм юу ч харагдсангүй. Урд зүгт бөөн сүрэг шувууд харлан нисэх үзэгдэв. Юун сүрэг вэ? Ямар шувууд

вэ? Ярилцаад, ярилцаад, бодоод бодоод бодын шийр дөрөв гэгч болов. Тэнгэрт анхны одод түгж эхэллээ.

Арван дөрөвдүгээр бүлэг

Гал ус

Хэрвээ та нар одойнуудын адил Тортог луу хаачсаныг мэдэхсэн гэж байгаа бол хоёр өдрийн өмнө луу нууц хонгилын дээд нүхийг зад нурааж хаячихаад Эсгарот хотын зүг ниссэнийг санах хэрэгтэй.

Эсгарот хотынхон орон гэртээ сууцгаан, дорно зүгээс хүйтэн салхи шуугин үлээж байжээ. Оройн зугаалганд дуртай хэдхэн хүмүүс л тэнгэрийн оддыг ширтэн, усанд туссан анивчааг нь сонирхон эрэг хавиар зугаалж явлаа. Эсгарот хотоос Ганцаардмал уул харагдахгүй бөгөөд нуурын цаад үзүүр дахь толгодууд уулыг халхална. Гагцхүү цэлмэг өдөр зовлонт уулын оргил харагдах төдий цухалздаг байлаа. Одоо бол Ганцаардмал уул өтгөн бүрэнхийд дарагдаж байв.

Гэнэт уулын оргил харанхуй дундаас улаан дөлөөр ороогдсон мэт үзэгдсэнээ дахин алга болов.

-Хөөш, хараач! гэж хэн нэг нь уулга алдсанаа,

-Дахиад нөгөө улаан гал! Харуулынхан өнгөрсөн шөнө энэ гал үүр цайтал улалзсан гэсэн. Тэнд юу болж байна.

-Хаан буцаж ирээд алтаа ширгээж байна. Эзэн хаан хойд зүгт явснаас хойш хэдэн жил өнгөрөв өө. Одоо нэг эзэн нь юмаа мэдэх цаг болсон баймаар.

-Ямар юмны чинь хаан. Уулын жинхэнэ эзэн Тортог галзуурч байгааг чи харахгүй байна уу?

-Дандаа л муу амлаж байх юм! Чи дандаа замагт далай үертэй, загас жараахай хортой гэж дэмийрч байдаг. Эрүүл ухаанаар эвтэйхэн юм зохиож солиорооч!

Тэднийг ийнхүү маргаж байх хооронд толгодын дээгүүр дахин улаан гал өрвөлзөж, нуурын хойд хэсэг түр зуур алтран харагдав.

-Уулын хаан ирээд алтаа ширээж улаан дөл улалзуулан суугаа биш үү. Эртээ урьд цагт эндээс явсан хаан эргэж ирлээ гэдэг домог дууны биелэгдэх цаг болсон биш үү? Уулнаас алтан гол урсаж байна гэж хүмүүс уухайлан хашхирцгаав.

Цонх хаалгаа дэлгэцгээн Эсгарот хотынхон хүүхэд мэт хөөрөн баярлацгаав. Зөвхөн Тортог лууг уулын жинхэнэ эзэн гэсэн нэг л хүний толгой сав саруул байж, зөв сэтгэж байлаа. Тэрээр хотын дарга руу гүйн очоод хэлсэн нь,

-Тортог луу наашаа нисэж явна! Гүүрийг нураа, зэвсгээ, зэвсгээ барьцгаа!

Түргэний дохио, эвэр бүрээ хангинаж, хадат эргээр цуурай татлаа. Бүгдийн баяр хөөр үймээн дэгдээн болж хувирав. Луу хотынхныг гэнэт дайрч чадсангүй. Эсгаротынхон бэлдэж амжлаа.

Луу хотын зүг шунгинан ойртов. Алсаас жижигхэн оч шиг харагдсан Тортог лууны гэрэл улам улам томрон гялалзаж эхэллээ. Удалгүй хотынхны хүн болгонд уулын хаан биш, улаан галзуу Тортог луу ирж байгаа нь тодорхой боллоо. Хүмүүс хувин сав, торх бүхнээ усаар дүүргэж, хуяг дуулгаа өмсөж, зэр зэвсгээ шүүрэн авцгааж амжив. Тортог лууны далавчны хүчит салхи усыг урвуулан эргүүлэхээс өмнө, лууны хүрхрэх дуу ойртохоос өмнө хүмүүс хотыг эрэгтэй холбосон гүүрийг нурааж унагав.

Луу хүмүүсийн орилох, хашхирах чимээ барин гүүрний зүг эргэтэл гүүр нурсан байлаа. Түүнийг хуурсанд луу урьдынхаасаа илүү догшров. Эсгарот хотынхон арал дээр байгаа юм шиг нуугдаад авлаа. Одоо яах вэ гэж луу хилэгнэн “Нууранд орж болох юм, бөөн уур манан дэгдэнэ. Үүнийг далимдуулаад Эсгарот хот уруу харагдахгүй, үзэгдэхгүй дайрчихсаж болох юм. Тэгэхдээ нуур надаас асар том хүчирхэг, гүнзгий, харанхуй, хүйтэн шүү дээ. Би живчихвэл яана” гэж бодов.

Тортог луу хилэгнэн хотын зүг эргэж нислээ. Түүний өөдөөс хайрсыг нь бөмбөрдөн харваж хашхиран уухайлан дайрав. Нэг ч сум лууг шархдуулж чадсангүй. Сумны модон ишнүүд шатаж усанд шарчигнан унана. Ийм аймшигт галт тулалдааныг та нар лав үзээгүй байхаа. Уулынхны хашхираан, мөндөрлөн буух сум лууны уур хилэнг хүргэж галзууруулах шахав. Аль хэдийнээс хэн ч ингэж зэвүүнтэйгээр түүнийг эсэргүүцэн доромжилж байгаагүй билээ.

Үнэнийг хэлэхэд зэвсгээ, зэвсгээ барьцгаа гэж уриалан дуудсан тэр эрэлхэг эр байгаагүй бол Тортогийн эсрэг босох зоригтон энэ хотынхон дотор олдохгүй байсан буй заа. Тэр эрэлхэг эрийг Бард гэдэг. Бард бусдыгаа зогсолтгүй дэмжиж яаж овоо хараагаа чиглүүлэхийг харваачдад зөвлөж, сүүлчийн сумаа дуустал тэмцэлдэхийг хотын даргаас хүсэж байлаа.

Тортогийн амнаас улаан дөл өрвөлзөн унахад нуурын ус шөнийн тэнгэрийн доор хүрэнгэн ягаарч харагдана. Эхний тулалдаан дуусахад луу галан гэрлээ гялалзуулан хотын дээгүүр эргэлдэн нисэв. Эргийн модод алтадсан мэт гялтганан доогуур нь шөнийн сүүдэрт цусан улаан туяа урсах мэт тодорно. Хажуу бөөрнөөс нь ойж буух суман мөндрийг үл тоон луу гэнэт доошлон нисэж хотыг галдан шатаалаа.

Гал дээврээс дээвэрт үсчин өрвөлзөн асаж, байшингаас байшин дамжин дүрэлзэнэ. Хүмүүс түймрийг унтраах гэж зуу зуун хувин саваар ус цацаж байтал Тортог дахиад л дайрав. Аварга сүүлээрээ том ордны дээврийг зомгол болтол цохив. Гал түймэр дүрэлзэн авалцсаар. Тортог шархадсан ч үгүй, хилэгнэн догширсоор байв. Хүмүүсийн харвасан сум түүнд намгийн шумуул хазах төдий адил ажээ. Аймаар хилэнт луу үхэл зовлон, эвдрэл сүйрэл түгээсээр Эсгарот хотын дээгүүр ниссээр байв.

Хотынхон ус уруу үсэрцгээв. Хүүхэд эмэгтэйчүүдээ завинд суулгацгаалаа. Эрчүүд зэр зэвсгээ хаян харсан зүгтээ зугтаав. Уулын доорх хаант улсын эзэн хаан эргэж ирлээ гэж саяхан дуулж, хөөрч байсан эрэг хавиар хүмүүсийн орилох, уйлах, ёолох, гингэнэх дуу сонсогдоно. Ихэнх хүмүүс хотыг ийм аюулд учруулсан одойнуудыг үгийн муугаар харааж зүхнэ. Хотын дарга үймээний үеэр хэн ч харахгүй гэж бодоод, алтан завиндаа суун, өөрийнхөө сэлүүрдэгчдэд хурдан түргэн зугтаахыг тушаана.

Эсгарот хот үнс нурам болон хоосров.

Тортог луу тоглож байгаа нь энэ аж. Тэр бодсоноо биелүүлж санаа нь амарчээ. Энэ муусайн хүмүүс завиндаа сууж л байг! Тэдний араас луу хөөхөд юу болохыг харуулна даа. Завинд суугаагүй нь үнс нурам дотор өлсөж үхнэ биз. Завьтай хүмүүс эрэг дээр хэзээ ч гарч ирэхгүй шүү дээ. Хотыг түймэрдэж дуусаад Тортог луу эргийн ойролцоох ой мод, бэлчээр нуга хөндийг шатааж эхэллээ. Энэ муусайн хүмүүс одойнуудад тусалсныхаа горыг амсах ёстой.

Үлдсэн цөөн харваачид харвасаар байлаа. Тэдний нэг нь баргар ширүүн царайтай Бард. Тэрвээр гай гамшгийг урьдчилан хэлж чаддаг учраас нөхөд нь түүнийг “явдаг зовлон” гэж хочилдог аж. Ерөнхийдөө Бард эрэлхэг зоригтой, самбаа сүүхээтэй хүн гэдгийг бүгд мэддэг. Бард бол Дейл хотын эзэн хаан Гирионы холын удам ажээ. (Дол хотыг сөнөсний дараа эзэн хааны эхнэр хүүхдүүд Эсгарот хотод суурьшсан байна.) Бард харвасаар харвасаар ганцхан сумтай үлджээ.

Тэдний зүг гал дөл ойртоод ирлээ. Нөхөд нь нэг нэгнийхээ араас Бардыг орхин зугтан одов. Бард сүүлчийнхээ сумыг хийн онилон татах гэтэл шөнийн харанхуйгаас турлиах шувуу дэрхийн нисэн ирж мөрөн дээр нь суулаа. Турлиах шувуу хүнээс айдаггүй агаад Бардад нэг юм хэлэн шулганав. Бард шувууны хэл мэддэг учраас гайхан зогтусав.

-Хүлээ, хүлээ! Удахгүй сар гарна. Тортог лууны зүүн энгэр дээр нэг нүх байгаа. Шувуу ууланд байхдаа Бильбо болон одойнуудаас сонссон бүгдийгээ Бардад дамжуулж ярилаа.

Луу эргэж ирлээ. Тэгэхдээ түрүүчийнхээсээ доогуур нисэж ирэв. Үнс нурам болсон хотын дээгүүр Тортог лууг яг нисэж байхад нуурын зүүнтэйгээс лууны далавчийг мөнгөн өнгөөр туяаруулан сар мандав. Бард нумаа татлаа.

-Сум! Хар сум! Би чамайг хамгийн сүүлд харвахаар үлдээсэн юм. Чи надаас хэзээ ч урваж байгаагүй! Чамайг эцэг минь надад бэлэглэсэн, чи эцэгт минь өвөг дээдсээс уламжлагдсан. Үнэхээр чамайг уулын эзэнт улсын уран дарханы газар дархалсан юм бол заналт дайсныг дар, заавал онож буу!

Тортог луу хотын дээгүүр ниссээр. Түүний гүзээ сарны гэрэлд үнэт эрдэнэсийн чулуугаар гялалзан гялтганана. Зөвхөн зүүн энгэр дээр нь нэг хар толбо харагдана. Нумнаас тавьсан сум тас хийн дүүлсээр хар сум Тортог лууны энгэр дэх хар толбонд очиж зоогдлоо. Бардын харвасан хүчирхэг хар сум лууны биенд тэр чигээрээ гүнзгий шигдэн оржээ. Тортог лууны бүх бие татвалзан гүвэлзээд хүмүүсийг дүлийртэл, эргийн моддыг яйрч унатал, хад чулууг хагартал, Дейл хотыг сөнөтөл орилж чарласаар гэдсээ дээш харуулан унав. Усан дээр хотыг тогтоон түшиж байсан тулгуур модод лууны хүнд биеийг даалгүй хугарч уналаа. Нуурын ус буцалж, ийш тийш бургилан урсаж, нүд сохлом цагаан уур манан дэгдэн хөөрөв. Тэгснээ нам гүм боллоо. Ингэж Эсгарот хот сөнөж Тортог луу үхсэн билээ. Харин Бард амьд мэнд үлдсэн юм.

Шинийн сар дээр хөөрчээ. Салхи ширүүсэн үлээнэ. Нуурын дээрх уур манан салхинд хөөгдөн янз янзын хэлбэр дүрстэй болон эргэлдсээр зэрлэг ойн захад очин задран замхарна. Нуурын дээгүүр сандарч тэвдсэн хүмүүсийн дуу хадаж усан дээр үй түмэн завь холбилзоно. Эсгарот хотынхон үнс нурам болсон хотоо харан гашуудан уйлцгаана. Тэд бас ч гэж гай түйтгэр гайгүй өнгөрснийг ойлгоогүй байлаа. Ямар ч байсан хотын иргэдийн дөрөвний гурав нь амьд

үлдэж, завьнууд нь бүгд бүрэн бүтэн, түймэр ой тайга, малын бэлчээрт хүрээгүй байна. Хамгийн гол нь Тортог луу үхсэн! Хотынхон үүнийг арайхан бүрнээ ухаараагүй байлаа. Хүмүүс баруун эрэг дээр уван цуван цугларсаар байлаа. Хүйтэнд чичирч бөндөгнөсөн, амьд мэнд гарсан хүмүүсийн дунд хотын дарга байв. Хотынхоо иргэдийг гарзанд нь хаячихаад Эсгаротоос хамгийн түрүүнд шахуу амиа бодон зугтсан түүнийг ард түмэн дайран харааж загнав.

-Амиа бодогч, ард түмнээ хаягч! Хамгийн чухал үед хар толгойгоо хамгаалагч!

Хотынхон Тортог лууг мэргэн сумаараа ялсан Бардын эрэлхэг зоригийг магтан бахархан шагшицгаана.

-Хайран баатар эр үрэгдчихлээ. Бид хаанаа болгон өргөмжлөх байсан юм. Гирионы хааны үр удам, Тортог лууг устгагч Бард! Хаан эзэн Бард биднийг орхижээ. Бид гашуудан гасалж байна!

Гэнэт харанхуйн дундаас нэвт норсон өндөр хүн гараад ирэв. Духандаа наалдсан нойтон үснийхээ доороос нүд нь оч мэт гялалзана.

-Бард үхээгүй! Бард лууг алаад нуур уруу үсэрсэн. Би Гирион хаан эзний удам Бард байна. Би лууг алсан! гэж хэллээ.

-Хаан эзэн Бард! Хаан Бард мандтугай! гэж олон түмэн уухайлан уухайллаа. Хотын дарга шүдээ хавиран зогсоно.

-Гирион Дейлийн эзэн хаан байснаас Эсгарот хотын эзэн байгаагүй. Нуурын хотынхон бид мэргэн ухаантай ахмад хүнээ захирагчаараа сонгодог байсан. Та нарын хаан эзэн Бард өөрийнхөө эзэмшил газар Дейлдээ буцаг. Дейл хот айх аюулгүй, дайрах дайсангүй боллоо. Нуурын ногоон эргээс уулын сүүдрийн хүйтэн чулуу таалагдаж байвал тийшээ Бардтай цуг явж болно оо. Харин бид эндээ үлдээд гайхамшигт хотоо дахин сэргээн босгож энх тунх амьдарцгаана гэж хотын дарга өгүүлэв.

-Эзэн хаан Бард мандтугай! гэж хэн нэг нь хэлэв.

-Бидэнд хөгшин төгцөг, худалдаачин наймаачин хэрэггүй!

-Мэргэн харваач мандтугай! Мэргэн харваач мандтугай! Зузаан халаастнууд сөнөтүгэй!

Олон түмэн ийнхүү уухайлан хашхирсаар...

Хажуухандаа зогсож байгаа мэргэн харваач Бардын зүг хулчгардуухан харснаа хотын дарга ийнхүү өгүүлэв.

-Би Бардыг гомдоох гэж ерөөсөө бодоогүй. Мэргэн харваач олон хүний амийг аварсан, мэдээж түүний алдар гавьяаг бид магтан дуулах болно. Хотын дарга дуугаа чангалав.

-Яагаад? Яагаад намайг буруутгаад байгаа юм бэ? Би буруу юм юу хийсэн юм бэ? Би лууг

сэрээсэн биш үү? Бид хэнд тусалж, морьд хоол ундны нөөц өгсөн билээ? Хэн биднийг урьдын үлгэр домог үнэн бодит болно гэж итгүүлсэн билээ? Бидний зочломтгой сайхан сэтгэлийн ачаар хэн, хаана, хаашаа хүрлээ?

Одойнууд! Тэд бидний ачийг яаж хариулав? Алтаар уу, мөнгөөр үү? Горьдсоны гарз бизээ. Тэдний уршгаар Тортог луу Эсгарот хотыг маань маань дайрч устгалаа. Тэр одойнуудын харгаагаар зуу зуун хүн орон гэргүй үлдлээ. Хичнээн хүүхнүүд бэлэвсэрч, хичнээн хүүхдүүд өнчрөв? Хотын дарга яаж хотын дарга болсны учрыг та бүхэн ойлгов уу? Түүний залирхаг уран үгс хотынхны зүрхэнд сэжиг төрүүлж, тэд эзэн хаан Бардын тухай дорхноо мартан Торин болон бусад одойнуудыг харааж зүхэж эхэллээ. Ганцаардмал уулын хаан ирлээ гэж саяхан дуулж байсан хүмүүс гашуун гомдмоор үгс урсгаж, ерөөсөө одойнууд нуурын дээрх хотыг устгахын тулд лууг албаар хилэгнүүлсэн гэж нотолцгоов.

-Ээх мангарууд аа! гэж Бард дуу алдаад “Хэргийг хэнд тохохоо мөн олов оо! Хөөрхий тэр одойнууд хамгийн түрүүнд л толгойгүй болсон байлгүй дээ” гэснээ бодлогошров. Хэрвээ одойнууд сүйрсэн бол уулын доорх алт эрдэнэсийн санг харж манах амьтан байхгүй байгаа юм байна. Тэр алт эрдэнэсийг олборлоод хүмүүсийг цуг-луулаад удирдвал удахгүй их хотын хонх дахин цуурайтах болно...

Бард энэхүү бодлоо орхин хотын даргад хандан,

-Одоо маргалдах, зөрөлдөх цаг биш. Бидэнд өөр ажил их байна. Чиний хэлснээр болдог бол, хэрвээ хамт явахыг хүсэгчид байвал бид хойд зүг явцгаая гэлээ.

Бард ийнхүү хэлээд шархдагсдад зориулж асар майхан босгож байгаа газар уруу явлаа. Хотын дарга түүнийг баргар царайлан үдээд хэсэг зуур бодлогоширсноо хоол цай шаардаж гарлаа.

Бард хотын иргэдтэй ярилцангаа сул задгай үлдсэн эрдэнэсийн сангийн тухай мэдээ гал түймрээс илүү хурдтай тархаж байгааг ойлголоо. Тэдний зовлонд өртсөний өр төлөөс болох алт эрдэнэсийг олж аваад өмнө зүгээс ирэх бараа бүрийг авч юугаар ч дутахгүй амьдарцгаана гэж хүмүүс ярьж нүдэнд нь баярын оч гялалзаж байлаа. Өөр баярлаж хөөрөх зүйл байхгүй юм чинь. Шархадсан хүмүүсээ асар майханд оруулж хотын даргад нэг майхан тусгайлан гаргаж өгөв. Хоол хүнс тун бага, тэр ч байтугай хотын даргад хүртэл өчүүхэн хувь оногдлоо. Тэр хүйтэн шөнө олон хүн өвчилж зарим нь үхжээ. Луутай тэмцэлдэж амьд үлдчихээд, гал түймэрт шаталгүй бүрэн бүтэн гарчихаад, эцэст нь ханиад хүрч үхнэ гэдэг ямар вэ дээ?

Маргааш өдөр нь дээрдсэнгүй. Өвчтэй хүмүүс улам олшров. Дээр нь хоол хүнс хүрэлцэхгүй, өлсөцгөөнө.

Мэргэн харваач Бард хотын даргын нэрийн өмнөөс гэж хэлж байгаад олон ажил өөрийнхөө бодсоноор хийж амжлаа. Түүнд амаргүй байлаа. Орох орон, хоол хүнс, харуул манаа гээд яаралтай бүгдийг амжуулав. Эльфүүд туслаагүй бол Эсгарот хотын хуучин иргэдээс цөөхөн хүн өвлийн хүйтнийг даах байсан бизээ. Зэрлэг ой уруу Бардын явуулсан элч нар уулын голын эрэг дээр хороо цэрэгтэй таарсан гээд бод доо. Тортог луу үхээд дөнгөж гурав хонож байгаа шүү дээ. Ойн эльфүүдийн хаан нууран дээр болсон явдлын тухай өөрсдийнхөө тагнуул туршуул болон зэрлэг хязгаараар нэг Тортог лууны үхсэн тухай зарлан нисэх шувуудаас

мэджээ. Жигүүртэн шувууд үймэрч нисэлдээд амгалан байдлаа алджээ. Тэнгэрт шувууд сүрэг сүргээрээ цугларан ийшээ тийшээ хошууран шунгинана. Зэрлэг ой нуга, хөндийгөөр төсөөлөх аргагүй дуу чимээтэй байлаа. Моддын навчис шаржигнаж, ойн хамаг амьтад яг л чагнаж байгаа юм шиг чихээ соотойлгон сууцгаана. Тортог лууны үхэж сөнөсөн тухай мэдээг Беорн эльфийн хаанаас түрүүлж сонсчээ. Гоблинууд хүртэл агуйдаа яаралтай хуралджээ.

-Царсан Бамбай Торины тухай бид нар дахиад хэзээ ч дуулж сонсохгүй байхаа гэж эльфийн хаан ойр түшмэдүүддээ хэлээд “Би түүнийг бүү яар, манайд нэлээн бай гэсэн шүү дээ. За тэгээд одоо яах вэ” гэлээ.

Эльфийн хаан бас л Трорын алт эрдэнэсийн тухай саналаа. Тэгээд нумчин сумчин цэргүүдээ зэвсэглэн аян замд гаргасан нь Бардын элчүүдтэй тааралдсан болой. Саяхан болтол эндхийн хязгаар нутагт байн байн дэгддэг дайн дажин удахгүй, яг одоо эхлэх гээд байгааг мэдэрсэн мэт цусанд дуртай хэрээ шувууд тэнгэрт эргэлдэнэ.

Эсгарот хотынхны аймшигт аюулын тухай сонсоод эльфийн хаан Бардын гуйлтыг хүндлэн ёсоор болгож Ганцаардмал уулын зүг явж байснаа эргэж, Урт нуурын тийш яаран довтолголоо. Сал завь хэдхэн учраас цэргүүд эргээр уруудан, харин хоол хүнсний зүйлээ усаар явууллаа. Эльфүүд хөнгөн шингэн хөлтэй бөгөөд хэдийгээр ус намаг шалбаагтай газраар явж байсан ч гэсэн Тортогийг үхсэний тав дахь өдөр нуурын захад хүрч Эсгарот хотынхны асар майхнуудыг харлаа. Хотын даргаар толгойлуулсан хүмүүс ихэд баярлаж аврагчдаа юу ч хайрлахгүй шагнахад бэлэн байв.

Тэд төлөвлөгөө хурдан зохиоцгоолоо. Хотын дарга хүүхэд хөгшчүүл, өвчтэй зовлонтой хүмүүс, эмэгтэйчүүдтэй хамт тэндээ үлдэв. Тэдэнтэй хамт эльфийн хүмүүс бас хоцорлоо. Зарим нь мод унагааж, зарим нь голоор урсаж ирсэн гуалинг уснаас гарган авч байв. Ингээд өвөл болохоос урьтаж, эрэг дээр бүхэл бүтэн гацаа босгоод авлаа. Хотын даргын захирамжаар урьдынхаасаа сайхан том хотын суурийг тавьцгаав. Ёроолд нь үхсэн луу тэрийн хэвтэж байгаа нуурын дээр хэн ч амьдрахыг хүсээгүй тул уснаас хол жаахан хойд зүгт хотоо босгохоор шангаа тавив. Нуурын усны намхан газар Тортог луу яг л хөшөө мэт хэвтэнэ. Тэр уулын доорх үүрэндээ хэзээ ч эргэж очихгүй болжээ. Хэдэн зуун жилийн дараа Эсгарот хотын балгас дунд түүний ясыг нартай өдөр үзэж харж магадгүй л юм. Үхэж хөшсөн Тортог луу айдас төрүүлнэ. Түүний дээгүүр завиар хөвөх зоригтон тун цөөхөн байсан төдийгүй нуурын ёроолд асгарч унасан эрдэнийн чулууг авах гэж шумбах хүн бүр ч алга байлаа.

Ингээд хотын дарга үлдэж. Бардын цэргүүд эльфийн армитай хамтран уулын зүг аян замд гарлаа. Эсгарот хот сүйрснээс хойш арван нэг дэх өдөр эхний отряд толгодыг давж Түргэн гол урсах хавцлаар явсаар зорьсон газраа хүрлээ.

Арван тавдугаар бүлэг

Аянга цахилгааны өмнө

Бильбо болон одойнууд юу хийж байгаа бол? Тэд шөнөжин ээлжлэн харуулд гарсан боловч уулын дээгүүр шувууд сүрэглэн цуглан нисэхээс өөр онцгой зүйл ажигласангүй. Ууланд амьдрагч хэрээнүүд оргилын дээгүүр чанга чанга гуаглан нисэж, өмнө зүгээс өөр шувууд сүрэг сүргээрээ нэмэгдэж байв.

-Энэ нэг л бишээ. Намар дуусч байхад нүүдлийн шувууд аль хэдийнэ дулаан хязгаарт нисэн одох байсан. Гэтэл харахгүй юу? Эндээс холгүйхэн тулалдаан алаан хядаан болсон бололтой гэж Торины өгүүлэхэд Бильбо,

-Хөөш хараач! Тэр нөгөө шувуу! Тортог лууг хилэгнэж эхлэхэд нисээд алга болсон шувуу яг мөн байна. Одоо эргээд ирчихэж! Үүр нь шатчихаад өөрөө амьд үлдсэн байхаа гэж уулга алдав.

Хөгшин шувуу харуулын цамхагийн хаалганаас холгүйхэн чулуун дээр суугаад чагнаж тагнаж байгаа юм шиг толгойгоо гилжийлгэн жиргэж шулганаснаа дахин дуугүй болов.

-Энэ шувуу бидэнд нэг юм хэлэх гээд байна. Их тэвдэж сандраад байх юм. Би юу ч ойлгосонгүй. Бэггинс чи ойлгов уу? гэж Балин асуулаа.

-Тийм ээ, хэцүүвтэр юм гэж Бильбо шувууны хэл мэдэхгүй мөртөө нэрэлхэв.

-Улаан хошуут байсан ч болоосой гэж Балиныг шүүрс алдахад,

-Чи чинь хар шувуунд дургүй шүү дээ. Биднийг нааш явж байхад чи харааж зүхээд байсан шүү дээ.

-Тэр чинь хэрээнүүд байсан. Хэрээ зэрлэг зэвүүн, доорд амьтан. Улаан хошуут бол их өөр. Бүр Трорын үеэс улаан хошууттай нөхөрлөж ирсэн юм. Тэд алс нутгаас шинэ мэдээ авчирч дуулгаж, бид тэр шувуудад тэдний дуртай янз бүрийн гялтганасан юухан хээхэн бэлэглэдэг байсан. Улаан хошуут гэж хэрээтэй адил боловч арай жижгэвтэр, хар өнгөтэй гэхдээ улаан хошуутай шувуу байдаг юм. Тэр шувууд урт настай, ой сайтай, юм мартдаггүй, мэргэн ухаанаа удам дамжуулан үлдээдэг амьтан. Би олон улаан хошуутыг таньдаг мэддэг байсан. Энэ орчмыг яагаад улаан хошуут гэж нэрлэснийг мэдэж байна уу? Хөгшин Карк түүний эм хоёрын дурсгалд зориулж ингэж нэрлэсэн юм. Гайхалтай сайхан хос байсан даа. Тэр хоёртой дахиад нэг уулзах юм сан. Одоо ч амьд мэнд байхгүй байхаа даа. Хөгшин Карк тэр үед өвгөрчихсөн байсан юм чинь.

Балины үгийг сонссон турлиах чангаар гуаглаад агаарт хөөрөв.

-Бид хоёрын ярьсныг энэ шувуу ойлгох шиг боллоо. За мэдэхгүй, гэхдээ жаахан хүлээе гэж Балин хэллээ.

Удалгүй далавчны дэвэлт сонсогдов.

Турлиахтай цуг өрөөсөн нүд нь сохор, үс нь халцарсан хөгшин улаан хошуут ирлээ. Хөгшин улаан хошуут газарт арай хийн бууж далавчаа удаан гэгч эвхэж хумхиад Торин өөд хазганав.

-Оо, Торин! Трайны хүү. Оо Фундины хүү Балин! гэж гуаглав. (Бильбо улаан хошуутын хэлснийг ойлгож байлаа. Эсвэл тэр шувуу ерөнхий хэлээр ярьсан юм болов уу)

-Би та нарын үнэнч анд Каркын хүү Роэк байна. Карк нас барсан ч би түүний захиасыг мартаагүй. Зуун жил бас тавин гурвыг нэмээд зуун тавин гурван жилийн өмнө би өндөгнөөсөө хагарч гарсан. Одоо би сүргийн толгойлогч. Улаан хошуут бид цөөрч байгаа боловч Уулын аугаа их хаадыг сайн санаж байна. Та нар сонссон уу? Миний албатууд айхавтар сонин мэдээ авчирсан шүү! Ойлгож байна уу? Та нарт таалагдахгүй бол намайг бүү зэмлээрэй. Ойлгож байна уу? Шувууд уул уруу эргэж ирж байна. Өмнө зүгээс, дорно зүгээс, баруун зүгээс нисэн ирж хараал идсэн Тортог луу үхсэн гэдэг мэдээ дуулгаж байна.

-Үхсэн, үхсэн гэнэ ээ? гэж одойнууд баярлан хөөрцгөөв.

-Тэгэхээр одоо бид нуугдах хэрэггүй юм байна. Одоо бүх алт эрдэнэс биднийх! Ура, ура!

-Үхсэн! Тортог луу турлиахын нүдэн дээр үхсэн гэнэ. Энэ шувууны өд сөднөөс нэг ширхэг ч бүү унаг! Луу Эсгарот хот уруу гурван өдөр дайрч давшилж шатааж, алж хядаж байгаад мэргэн суманд оногдож үхсэн.

Одойнууд баярлан үсрэн дэвхцэж байв. Торин тэднийг тайвшруулах гэж нэлээд зовов.

Улаан хошуут Эсгарот хотынхны Тортог луутай хийсэн тулалдааны тухай одойнуудад яриад ийнхүү өгүүлэв.



-Царсан Бамбай Торин! Одоо баярлаач, хөөрөөч! Уулын бүх орд харш чинийх, алт эрдэнэс

чинийх! Уулын зүг зөвхөн шувууд биш өөр амьтад ирэх юм бол баярлах мантай болно шүү. Үхсэн луу, эзэнгүй эрдэнэсийн тухай эргэн тойрон шуугьж байна. Олон ч амьтад шүдээ хавиран шүлсээ гоожуулж байгаа шүү. Эльфийн цэргүүд замд гарчээ. Үхэл цус нөжинд шунагч махчин шувууд тэднийг дагалдан яваа гэнэ. Энэ бүхэнд одойнууд буруутай, одойнуудаас болж Тортог луу Эсгарот хотыг дайрч үнс нурам болтол устгаад хотынхныг орох орон, идэх хоолгүй болгосон гэж нуурын иргэдэд дөжиртөл нь донгоджээ. Та нар арван гурвуулхнаа ч гэсэн зөв мэргэн шийдвэр гаргаарай. Дээр үед Уулын доор амьдарч асан аугаа их омог Дарин овогтнуудаас одоо атганд багтам цөөхөн үлджээ. Та нар Эсгарот хотын даргал битгий итгээрэй. Миний үгэнд ор! Тортогийг харваж алсан хүнтэй ярь! Түүний нэрийг Бард гэдэг. Бард бол Дейлийн эзэн хаан Гирионы удам судрын хүн. Хоёр нүүргүй шулуун шударга хүн. Одойнууд, эльфүүд, хүмүүс хоорондоо найрамдан нөхөрлөвөл бүгдэд аз жаргал, баяр хөөр авчирна. Харин энэ аз жаргал, эв найрамдал Трор хааны эрдэнэсийн үнэтэй тэнцэх болов уу даа?

-Өөх, Каркын хүү Роэк чамд баярлан гялайлаа. Бид чиний ачийг мартахгүй. Биднийг амьд мэнд байгаа цагт бүдүүлэг зэрлэгчүүд бид-ний алт эрдэнэсээс хумсын чинээ ч авч чадахгүй! Эльфийн цэргүүдийн хэзээ ирэхийг бидэнд мэдээлэх юм бол бид танд бодитойгоор талархан баярлах болно шүү. Таны сүрэгт хүчит далавчтай залуу, улаан хошуут байвал хойд уулын зүг миний хамаатнуудад бидний тухай мэдээ хүргэхээр явуулна уу? Эхлээд Төмөр уулнаа суугч миний үеэл ах Дэйнд хэл хүргэмээр байна. Дэйн хамгийн ойрхон байгаа Дэйн эрэлхэг дайчин олон цэргүүдтэй. Түүнд элч шувуухайгаа түргэн шуурхай явуулахгүй юу?

-Чи зөв шийдсэн үү, үгүй юу би мэдэхгүй байна. Гэхдээ би чадах бүхнээ хийе дээ гэж хэлээд Роэк далавчаа дэлгэн нисэн одов.

-Төмөр уул шүү! Цаг хугацаа тун бага байна гэж Торин араас нь хашхирч амжив.

-Идэх юм бүр ч бага гэж Хоббит нэмлээ. Хоол ундтай бол хожим хойчийн ажил бүтнэ гэдэг биз дээ, хөөрхий Бэггинс! Тортог луу үхэж үрэгдсэн ингээд ажил дууслаа гэж тэрээр боджээ. Тэгсэн чинь үйл явдлын эцэс төгсгөл урьдын адил үл харагдана. Үнэнийг хэлэхэд хэнтэй ч байлдахгүй бүгд эвлэн найрамдахын төлөө өөрийнхөө авах эрдэнэсийн тал хувийг өгөхөд Бэггинс бэлэн байлаа.

-Уул уруу! Уул уруу! гэж одойнууд орилолдон Хоббитын үгийг анзаарсангүй. Бильбо аргагүйн эрхэнд одойнуудын араас даган агуйд эргэж ирэв.

Одойнуудад үнэхээр хугацаа бага хэдхэн өдөр үлджээ. Тэд нар агуйг нэгд нэгэнгүй нэгжиж үзээд агуйд гаднаас орох ганцхан зам бол их хаалга гэдгийг мэдэж авлаа. Бусад орох нүх сүв нурж унан дарагдсан учраас айж зовох юм үгүй болов. Хаалгаа бэхжүүлж басхүү зам тавих ажилд орцгоолоо. Агуйгаас дээр үеэс үлдсэн багаж зэвсэг олноор олдов. Одойнууд гар хумхилгүй ажиллаж байлаа. Энэ үед улаан хошуут шувууд дайсны цэргүүд ойртон ирж байгаа тухай мэдээ авчирсаар байв. Эльфийн хаан амсхийхээр нуурын зүг эргэснийг шувууд дуулгав. Бас гурван чоно луугаас зугтан ус уруу давхиад нөөцтэй уут сав, пүүгээ, шуудай байгаа эрэг дээр байгааг дуулгав. Фили, Кили хоёр хамгийн залуу хөл гар хурднаараа морьдыг авчрахаар явлаа.

Тэднийг дөрвөн өдрийн дараа эргэж ирэхэд нөхөд нь улаан хошуут шувуудын авчирсан шинэ мэдээ дуулгалаа. Эльфийн хааны цэргүүд хүмүүстэй хамт нуураас Уулын зүг хөдөлсөн гэнэ. Байдал бас тийм ч их аймаар хүнд биш байлаа. Хоол хүнс хүрэлцээтэй, агуй уруу орох хаалга өндөр, зузаан чулуун ханаар хаагдсан байгаа. Энэ хананд орчин тойрныг харах бас тэндээс харваж болох нүхэн дуран гаргасан байгаа. Хана хаалгагүй учраас шат тавьж дээш авирах бөгөөд ачаа барааг олсоор татаж гаргана. Гол урсан гардаг байсан хонгилыг битүүлсэн учраас Түргэн голын нарийхан урсгал чиглэлээ багахан өөрчилж, хана эрэг хоёрын дундуур өргөсөн урсав. Ингээд одоо бол хаалга уруу зөвхөн усаар дамжиж очихоос өөр аргагүй боллоо. Фили, Кили хоёрын авчирсан пони морьдыг хуучин гүүрийн эвдэрхий дээр угтаж тэднээс ачаа шуудайг нь аваад буцааж нутаг уруу нь өмнө зүг хөөв.

Нэгэн шөнө дунд Дейл галын гэрлээр гялалзаж, бамбарууд асаж түүдэг гал энд тэндгүй үрэлзэв.

-Ирчихэж! гэж Балин дуу алдав.

-Тэд хэдүүлээ бол? Харагдаж үзэгдэхгүй орж ирэх гэж албаар шөнийг хүлээсэн бизээ.

Тэр шөнө одойнууд нүд аньсангүй. Үүр дөнгөж цайнгуут дайсны цэргүүд лагериасаа гарлаа. Одойнууд тэдний хэсгүүд уулын гүвээн дундуур хөндий чиглэн ар араасаа цуврахыг харж байлаа. Удсан ч үгүй тодорхой харагдаад эхлэв. Хүмүүс дайнд бэлдэн зэр зэвсэг барьсан байх агаад өмнө талд нь нум сум агсаж урт жад барьсан эльфүүд явж байв. Тэдний эхний хэсэг эргийн ирмэгт тулж ирээд цаана нь өндөр хана сүндэрлэх өргөн нуурыг харан гайхаж мэлрэн зогтусацгаав.

Цэргүүд нуурыг нэг, ханыг нэг зааж хоорондоо ярьцгаана. Торин тэдэнд хандаж,

-Уулын доорх хаант улсын хаан Трайны хүү Торины их хаалганд зэвсэг барин ирсэн та бүхэн хэн бэ? Та нарт юу хэрэгтэй вэ? гэж тод чангаар асуув.

Түүнд хэн ч хариулсангүй. Цэргүүдийн хэсэг нь шууд буцаад явахад үлдсэн бусад нь жаахан харзнаж ийш тийш харж байснаа эргэж явлаа. Тэд голоос зүүн тийш уулын гүвээнүүдийн яг дунд байрлаж буудлалаа. Тэндээс уул ус олон жил сонсоогүй дуу хуур хангинана. Эльфүүдийн ятга хангинаж дуу хуур уянгалахад одойнуудад дулаан цаг ирчихсэн хаврын цэцэгсийн энхэр үнэр хаанаас ч юм үнэртэх шиг санагдав.

Бильбо бүр хөгжилдөн байгаа тэр газар өөд гүйж очмоор байлаа. Одойнуудаас ч гэсэн нэг хоёр нь мөн л тийшээ гүймээр байсан биз. Байлдаж тулалдаад хэрэггүй энхийн аргаар ярилцан тохирч болно гэж одойнууд шивэгнэлдэж байснаа Торины зангидсан хөмсгийг хараад амаа хамхиж суулаа.

Хааныг хөгжөөн баярлуулах зорилгоор ятга тэргүүтэн хөгжим авчирч дуулж бүжиглэцгээв. Гэхдээ л одойнуудын дуу хангалуун цэнгүүн эльфүүдийн дуутай тун адилгүй харин ч Бильбогийн тохилог нүхэн гэрт дуулж байсан дуутай дэндүү төстэй байлаа.

Эзэмшил газар уулын гүндээ

Эзэн хаан эргэж мориллоо

Зэрлэг Тортог үхэж хатлаа

Зэргийн дайсан яг ингэж сөнөнө!

Хурдан сум хурц сэлэмтэй

Хаалга үүд бөх бат

Хатан зоригт хааны алт эрдэнэс бүрэн

Одойнууд одоо юунаас ч айхгүй!

Эцэг өвгөд бидний дээдсүүд

Энд алтаа давгаж байсан

Уулын гүнд тэр цагаас хойш

Уран хонх жингэнэж байгаа мэтээ

Оддын гэрэл бөгж болно

Лууны гол титэм болно

Сарны туяа эрдэнэс болно

Сайхан хоолойт дуучин аялгуу урсгана

Ард олон хаанаа өргөмжиллөө!

Уулын доорх хааны суудалдаа

Эргэж суулаа, эзэн хаан!

Орчлонгийн бүх одойнуудаа

Баярлацгаа, хөөрцгөө, наашаа ирцгээ!

Эртний хотдоо ирээрэй одойнуудаа!

Элбэг баян, өгөөмөр хаан хүлээж байна

Эзэн хаан байсан, байх ч болно

Эргээд ирцгээ, одойнуудаа!

Эзэмшил газар уулын гүндээ

Эзэн хаан маань эргэж мориллоо

Зэрлэг Тортог үхэж хатлаа!

Зэргийн дайсан яг ингэж сөнөнө!

Торин инээмсэглэн суух нь түүнд энэ дуу таалагдсан бололтой. Тэрээр хэрвээ Дэйн мэдээ авангуутаа наашаа гарвал Төмөр уулнаасаа Ганцаардмал уул хүртэл хичнээн өдөр явж ирэх нь вэ? гэж тоолж тооцоолж гарав. Харин Бильбо гуниглаж эхэллээ. Одойнуудын дуу дэндүү дайнч дэндүү харгис санагдаж сайн юм болохгүй гэж мэдрэгдээд байлаа.

Үүр цүүрээр байрлаж буусан хэсэг цэргүүд хөндийг өгссөөр яг хананы өмнө ирж зогсов. Цэргүүд хоёр туг барьжээ. Нэг нь эльфийн хааны ногоон нөгөө нь Эсгарот хотын цэнхэр өнгөтэй ажээ.

Торин нөгөө асуултаа давтав.

-Уулын доорх хаант улсын хаан Трайны хүү Торины Их хаалганд зэвсэг барин ирсэн та бүхэн хэн бэ?

Энэ удаа түүнд хариуллаа. Хар үстэй, ширүүн царайтай өндөр хүн урагш алхан гарч ирлээ.

-Торин сайн байна уу? Агуулахаа сахисан худалдаачин шиг өндөр хананы цаана чи юунд нуугдана вэ? Бид ерөөсөө чиний дайсан биш! Та нарын амьд мэнд байгаад бид хэлж баршгүй баяртай байна. Бид амьд амьтан харна гэж бодоогүй шүү. Нэгэнт бид уулзсанаас хойш ярьж хэлэлцэлгүй яаж болох билээ?

-Эхлээд чи хэн гэдгээ хэл, дараа нь ярьцгаая!

-Миний нэр Бард. Би Тортог лууг алсан. Ингэхээр миний ачаар та нар алт эрдэнэсээ эргүүлж авсан шүү. Ингэхээр ярих юм байхгүй гэж үү? Түүнээс гадна би Дейлийн эзэн Гирионы үр удам. Чиний ордонд Тортог луу Дейл хотын болон өөр хотуудаас хулгайлсан баялаг их байгаа. Ингээд бас нэг ярих хэрэг гарч байна. Дээр нь Тортог луу үхэхдээ Эсгарот хотыг балгас болгосон. Олон хүн орох оронгүй болсон. Эсгарот хотын даргын өмнөөс чамайг өр төлөөсөө өгөхөд бэлэн үү гэж асуух гэсэн юм. Эсгарот хотынхон та нарт тусалсан, та нар өөрсдөө мэдэлгүй тэдэнд гай гамшиг учруулсан.

Бардын үг ихэмсэг, сүрлэг үнэн байсан болохоор Торин одоо бүгдийг нь зөвшөөрнө гэж Бильбо бодлоо. (Дашрамд хэлэхэд лууны гүзээн дээрх эмзэг газрыг хэн анх олж харсан билээ гэдгийг маргалдаж байгаа хоёр санасан ч болоосой. Тэдэнд энэ тухай санах сөхөө байсангүй) Эндээ гэж хэлэхэд лууны хүрсэн алт ямар их ид шидтэй болдгийг Хоббит мэдэхгүй байлаа.

Лууны хүрсэн алт ховсдолтой болж тэр алтанд хүрсэн болгоныг өөртөө захируулж чаддаг байна. Тийм алтанд хүрсэн одой тэр алтнаасаа салж чадахгүй болдог аж. Алт эрдэнэс Ториныг ховсдож чадаад Торин алтан дотроос алмааз чулууг эрсэн биш бүх эрдэнэс түүнд

адилхан үнэ цэнэтэй байсан бөгөөд одойнуудын овог омгийн аугаа их гунигт түүхийг түүнд санагдуулж тэрээр алт эрдэнэсээ үзэж харан цаг өнгөрөхийг мэдэхгүй суудаг болжээ.

-Чи үгээ юу юу гэж төгсгөнө гэнэ ээ? Чиний хэлснээр Тортогийн тарьсан гай гамшгийг бид хариуцаж төлөх юм гэж үү? Ямар учраас, яагаад? Бидэнд тусалсан ач тусыг бид цаг хугацаанд нь хариулна. Харин занаж зүхэж зэр зэвсгээр биднийг айлгаж чадахгүй шүү. Бид дайсан биш гэж чи хэлсэн шүү дээ? Анд нөхөд зуу зуун цэрэг зэвсэглэн авчирдаг юм уу? Чи миний нэг асуултанд хариулаач! Хэрвээ бид бүгдээрээ амь үрэгдсэн бол та нар уулыг эзлэн аваад бидний хамаатан төрөл саданд нэг ширхэг ч болтугай алт эрдэнэс өгөх байсан гэж үү?

-Би мэдэхгүй ээ гэж Бард үнэнээ хэлээд “Гэхдээ та нар азаар амьд мэнд байна. Бид та нартай дайсагнахыг хүсэхгүй байна шүү. Урьд нь та нарт тусалсан хүмүүс бидэнд туслаач гэж л гуйж, хүсэж байна. Чи ийм энэрлийн тусламж үзүүлэхгүй гэж үү? Эсвэл чи хаан Торин төмөр зүрхтэй чоно гэж дэлхий даяар яриг гэж бодож байна уу”

-Та нар зэр зэвсэг гартаа барьсан байхад би юу ч ярихгүй. Тэр тусмаа өөрийнхөө харанхуй нүхэнд намайг хорьсон эльфийн хаантай би ерөөсөө ярихгүй. Эльфийн хаан ямар нүүрээрээ юу шаардаж байгаа юм бэ? Бидний суманд өртөх гээгүй бол бушуухан буцацгаа! Эльфүүд өөрсдийнхөө ой тайгад буц, тэгсэн цагт бид бодно. Дараа зэр зэвсэггүй ирцгээ!

-Эльфийн хаан миний найз. Анд нөхрийн хувьд бидэнд туслах гэж Эльфийн хаан Эсгаротод уруу ирсэн. Торин чи юу ярьж байгаагаа бод. Хэлсэн үгэндээ харамсах цаг ирэх бий дээ! Бид удахгүй буцаж ирнэ. Бод, бод!

Ингэж хэлээд Бард эргэж буудалласан газрын зүг алхав. Хэдэн цаг өнгөрөв. Туг далбаагаа өргөсөөр бүрээ дунгаа үлээсээр тэд буцаж ирээд өндөр хананы дэргэд зэрэгцэн зогсож бүрээгээ хангинуулав.

-Уулын доорх хаант улсын хаан гэж өөрийгөө өргөмжилсөн Трайны хүү Царсан Бамбай Торин! Эсгарот хот болон ойн иргэдийн үгийг сонс! Алт эрдэнэсийнхээ арван хоёрны нэг хувийг чи Тортог лууг устгасан Гирионы өв залгамжлагч Бардад өгөх ёстой. Бард Эсгарот хотынхонд өөрийнхөө хувиас тусламж болгон өгөхөд бэлэн байна. Чи өвөг дээдсийнхээ адил хүндлүүлэхийг хүсэж байвал өөрөө Эсгарот хотыг сэргээн босгоход тусална биз. Бидний энэ нөхцөлийг чи хүлээн зөвшөөрөх үү?

Торин ойрхон байсан нэгэн нум сумыг шүүрэн авч харвалаа. Сум элчийн бамбайнд шигдээд тэр чигээрээ гозойсоор байв.

-Хэрвээ чи ийм хариу өгч байгаа бол бид чамтай дайтана гэж элч хашхирлаа.

-Та нар өөрсдөө найрамдах нөхөрлөхийг хүсэхээс нааш бид энэ Уулнаас та нарыг явуулахгүй. Бид та нар уруу дайрахгүй. Алтан дээрээ суугаад ам хамар уруу чинь ордог юм бол идэхгүй юу, уухгүй юу гэж нэмж хэллээ.

Элч хамгаалагчдынхаа хамт буцаж явлаа. Одойнууд яах тухайгаа хэлэлцэв. Торинтой ярилцах нь бүү хэл түүнийг харахад аймаар байлаа. Одойнуудын ихэнх нь түүнийг буруутгахгүй

хаантай санал нэг байв. Гагцхүү бүдүүн Бомбур, Фили, Кили гурав өөр бодолтой байлаа. Мэдээж Бильбод бол энэ уул дургүйг нь хүртэл гозойж байгаа бөгөөд дээр нь бас бүслэлтэнд орчих гэж! Нэг үгээр хэлэхэд аз нь хаяжээ.

-Өмхий, өмхий хангинаад. Энэ лууны тортогонд сүх өлгөсөн ч унахгүй байх шүү. Бас энэ бин, энэ бинг идсээр байгаад хахаж үхэх юм байна л даа гэж Бильбо хамар доороо гэвтнөв.

Арван зургадугаар бүлэг

Шөнийн явдал

Өдөр хоног тун алгуурхан өнгөрч байлаа. Одойнууд өглөөнөөс орой болтол алт эрдэнэсийг ухсаар...

Торин Алмааз чулууны тухай ярьж энэ чулууг эрж олохыг нөхдөөсөө гуйв.

-Алтаар урсах голоос ч үнэтэй гэж эцгийн минь ярьдаг байсан Алмааз чулуу надад үнэлж цэгнэшгүй эрдэнэ шүү. Бүх алт эрдэнэсээс би ганцхан түүнийг л авна. Алмааз чулуунд минь шунагч аз жаргал үзэхгүй дээ!

Бильбо айж орхив. Хэрвээ Торин болон одойнууд түүний дэрлэж унтдаг баадан дотор өнөөх Алмааз эрдэнэ нь байгааг олчихвол юу болох болоо. Гэхдээ л Бильбо нууцаа дэлгэсэнгүй. Тэр ч байтугай шал өөр төлөвлөгөө толгойд нь төрж эхэллээ.

Улаан хошуут шувууд шинэ мэдээ авчирлаа. Дэйн таван зуун одойнуудынхаа хамт Төмөр уулнаасаа гараад зүүн хойд зүгээс Уулын зүг ойртон Дейлээс ерөөсөө хоёр хоногийн газарт ирчихээд байгаа гэнэ. Тэд харагдахгүй орж ирж чадахгүй. Дайтах болно. Энэ ч зөв биш дээ. Дэйнний цэргүүд дайнд хатуужсан эрэлхэг зоригтой хэдий ч уулыг бүсэлж байгаа бүслэлтийг давж гарч чадахгүй. Тэд дийлж яллаа ч гэсэн та нарт баярлах юмгүй болно. Өвөл хаяанд ирчихээд байна. Тэсгим хүйтэн, цас шуурганд та нар гаднаас тусламж авахгүйгээр өвлийг давж чадахгүй. Тортог луу та нарыг сөнөөж чадаагүй ч алт эрдэнэс та нарыг сөнөөх юм байна гэж улаан хошуут Роэкийг хэлэхэд Торин өөрийнхөөрөө зүтгэлээ.

-Эльфүүд, хүмүүс ч гэсэн хүйтнийг давж гарна гэж үү? Бид агуйд байна. Тэд нар майхан асартаа амьдаараа хөлдөж үхнэ. Цас тэднийг жаахан ухааруулах болов уу? гэх мэтээр Торин ярив.

Энэ шөнө Бильбо эрс шийдвэр гаргалаа. Харанхуй болмогц хаалганы дэргэдэх хананд тулж очоод барьж явсан модон хувингаасаа дэгээ бүхий урт олс, даавуунд ороосон Алмааз чулуугаа шатаар дээш өргөн гаргаж авлаа. Хананд түшүүлсэн шатаар дээш өгсөж гарав. Ханын дээгүүр харуул Бомбур алхана. Гэнэтийн дайралтаас айж одойнууд шөнө болгон ээлжлэн жижүүр гаргадаг байлаа.

-Ямар хүйтэн юм бэ? гэж Бомбур гомдоллоод “Тэд дулаахан сууж байгаа бололтой. Хичнээн олон түүдэг байна аа” гэв.

-Агуйд ч эндээс дулаахан шүү гэж Бильбог сануулахад Бомбур,

-Би ч энд шөнө дунд болтол гозойно доо. Ямар ч азгүй амьтан бэ дээ би чинь! Торины сахал урт болог гэм, би түүнтэй маргахгүй л дээ. Гэхдээ дандаа зөрүүдэлдэг төмөр толгой гэж үглэв.

-Миний хөлнөөс л хатуугүй байх даа. Хөл минь энэ хатуу чулуун дунд хад боллоо, боллоо.

Зөөлхөн ногоон зүлгэн дээгүүр гүйхийн тулд би дэлхий дээр байгаа бүх юмыг өгөхөд ч бэлэн байна. Бильбог ийнхүү ярихад Бомбур,

-Би ч нэг сайхан хооллочихоод дулаахан хөнжилдөө шургамаар байна гэв.

-Бүслэлтээс гарсан цагт өдөн дэрэн дээр унтахгүй юу! Хэрвээ чи зөвшөөрвөл би чамайг орлоод үлдье л дээ. Би аль түрүүн жижүүрлэхсэн. Өнөө шөнө нэг л нойр хүрэхгүй байна.

-Өө яасан сайн юм, тохирлоо! Ямар нэг юм болвол намайг хамгийн түрүүнд сэрээгээрэй за юу? Би агуйн хаалганы зүүн талд хэвтэж байна шүү. Бэггинс чи тун сайн хүү шүү гэж Бомбур баярлалаа.

-За яв, яв. Би чамайг шөнө дунд сэрээнэ.

Бомбур агуйд орж үзэгдэхгүй болмогц Бильбо бөгжөө зүүгээд олсоо бэхлээд хананаас буулаа. Түүнд таван цаг байлаа. Бомбур лав хурхирч байгаа, Ториноор толгойлуулсан бусад одойнууд алт эрдэнэс дотор л ухаж суугаа байх. Хэн нэг нь тэр ч байтугай Фили, Кили хоёр ч гэсэн жижүүрлэхээсээ өмнө урьтаад хананд авирахгүй нь мэдээж.

Саргүй шөнө байсан боловч Бильбо өөрөө тавьж засахад нь тусалсан замаар явж байсандаа төөрсөнгүй. Удалгүй зам дуусч өмнө нь танихгүй газар гарч ирлээ. Хоббит явсаар явсаар Эсгаротын цэргүүдийн буусан газар руу эргэх уулзвар дээр очиж голоор гатлах хэрэг гарлаа. Намхан жижигхэн хэнд ч гэсэн гүехэн боловч өргөн голыг гатална гэдэг эгзэгтэй хүнд асуудал шүү. Ямар ч гэсэн Бильбо голыг гаталлаа. Гаталлаа ч гэж дээ яг эргийн дэргэд очоод хөл нь чулуун дээрээс халтиран их л дуу чимээтэйгээр ус уруу палхийн унав. Дараа нь босож хуурай газар гарч ирэхэд юу болсныг эрж хайсан эльфүүд дэнлүү барин энд тэндгүй гүйлдэж байв.

-Энэ лав загас биш! Дайсны тагнуул байх. Дэнлүүнүүдээ унтраа. Одойнуудын зарц нэг жижиг амьтан бол дэнлүүтэй дэнлүүгүй харагдахгүй.

Зарц гэнэ ээ гэж Бильбо мушилзсанаа найтаамаар болов. Хором өнгөрөхөд Хоббит чангаар найтаалаа. Эльфүүд чимээ гарсан зүг гүйцгээв.

-Сайн уу? Та нар намайг эрж байгаа бол би энд байна. Ингэж хэлээд тэрээр бөгжөө сугалан тэдний өөдөөс алхлаа.

Эльфүүд гайхан сандарснаа дорхноо сэхээ авч Хоббитыг хүрээлэн авлаа.

-Чи хэн бэ? Одойнуудын Хоббит уу? Чи энд юу хийж яваа юм бэ? Чи харуулын хаагуур нь гараад ирэв? Асуулт ар араасаа дарна.

-Ноён Бэггинс та нарт үйлчлэхэд бэлэн гэж Бильбо түвшин хэлээд “Хаан Торины анд. Танай хааныг би харсан. Тааралдахдаа намайг таньдаггүй юм. Харин Бард намайг санах байхаа, би түүнтэй уулзах гэж явна”

-Пөөх, ямар хэргээр яваа билээ?

-Сайн санаат эльфүүд минь, энэ хэрэг зөвхөн бид хоёрт л хамаатай. Хэрвээ та нар гэртээ, зэрлэг ойдоо буцах гэж хүсэж байгаа бол намайг Бардтай уулзуулаач... гэж Хоббит даарсандаа шүдээ тачигнуулан “Та нарын түүдэгт дулаацаж болох уу? Алив нөхөд минь хурдлаарай! Надад ердөө хоёрхон цаг үлдсэн” гэлээ.

Ингэж Уулын доороос гүйсэн Бильбо тун ч удалгүй хааны шатрын өмнө түүдгийн дэргэд зогсож байв. Түүдгийн дэргэд ойн эльфүүд мэргэн харваач Бардтай хамт шөнийн зочноо сонирхон харна. Тэд нар уранхай цуван доороо эльфийн баатрын хувцас хунар өмссөн Хоббитыг урьд өмнө нь харж байгаагүй билээ.

Бильбо байдаг чадлаараа ажил хэрэгч хоолой гарган ингэж ярив.

-Байдал маш хүнд байгааг та бүхэн мэдэж байгаа. Би энэ аян замд бүр ядарч цөхрөөд тухлаг тайван орон гэртээ баяртай нь аргагүй буцмаар байна. Гагцхүү энэ алт эрдэнэст хамаг учир байна. Надад хувь оногдоно, тодорхой хэлэх юм бол бүх баялгийн арван дөрөвний нэг хувь. Би гэрээ бичгээ хадгалсан нь зөв боллоо.

Бильбо түрүүчийн нэг удаа Торин чулуун тавиур дээр үлдээсэн үнгэгдсэн бичгийг хүрэмнийхээ халааснаас гаргаж ирлээ.

-Олзны хувь. Та нартай эхлээд тооцоо хийчихээд үлдсэнийг нь хуваахад би татгалзахгүй. Гэтэл Ториныг та нар мэдэж байгаа шүү дээ. Торин та нарыг энд байгаа цагт хэлтэрхийгээ хуваалцсанаас өлсөж үхсэн нь дээр гэх одой.

-Түүний өөрийнх нь сонгосон зам! Зөрүүдлээд өлсөж үхвэл үхэж л байг гэж Бард мухардуулав.

-Тийм нь ч тийм л дээ. Гэхдээ өвөл хаяанд ирчихээд байгааг мартаж болохгүй. Цас орж эхлэхээр зөвхөн одойнууд ч биш хүмүүс, эльфүүд өлсөж эхэлнэ. Төмөр Уулнаас Дэйний цэргүүд ирж явааг мэдэж байна уу?

-Мэдэлгүй яах вэ. Үүнээс бид айхгүй байна гэж эльфийн хаан хариулав.

-За, за ойлголоо, гэхдээ та нар бас бүгдийг мэдээгүй байна. Дэйн хоёрхон хоногийн газар ирчихээд байгаа. Түүнтэй хамт гоблинуудтай хийсэн зэрлэг ширүүн дайнд оролцсон эрэлхэг дайчин таван зуугаад цэрэг ирж яваа. Тэд ойртоод ирэхэд та нар сайнаа үзэхгүй шүү дээ.

-Чи юу ярих гээд байна? гэж Бард барайн асуугаад “Чи өөрийнхөө нөхдөөс урвах гээд байгаа юм уу? Эсвэл биднийг заналхийлэн сүрдүүлж байна уу? Би нэг л ойлгохгүй байна шүү” гэлээ.

-Хүндэт Бард минь, бүү яар! Бүгдийг бүх юманд сэжиглээд байдаг ямар хачин хүн бэ? Би та нарт нэг санал хэлэх гэж байна.

-За хэл, хэл гэж Бард хаантай цуг зөвшөөрөв.

-За харцгаа гэж Бильбо хэлээд халааснаасаа Алмааз чулууг гарган боолтыг нь авлаа.

Ордонд нь алт эрдэнэс дүүрэн байдаг эльфийн хаан хүртэл дуу алдан огло үсрэн бослоо. Бард мэлрэн дув дуугүй зогсоно. Сарны гэрлээр дүүрэн бөмбөлзөх бөөрөнхий чулуу аалзны шүлсний торон дээр дүүжлэгдээд оддын хүйтэн анивчаагаар нэхэгдсэн мэт гялтганана.

-Энэ чинь Алмааз чулуу. Трайны чулуу. Уулын зүрх-Торины зүрх. Торинд бол алтан голоос илүүтэй эрдэнэ. Би танд өгч байна. Ярилцаж тохироход дэмжлэг болж магадгүй.

Ингэж хэлээд Бильбо мэлрэн зогсоо Бардад чулуугаа ямар ч харамсалгүйгээр атгууллаа. Мэргэн харваач жаал сэхээ аван,

-Чи яаж олж авсан юм бэ?

-Өө их урт яриа болно. Ойлгож байна уу? Энэ чулуу урьдчилгаа болог! Одойнууд намайг олзлогч гэдэг гэхдээ би үнэнч шударгаар олзлогч л доо. За ийм байна. Одоо би буцъя, одойнууд намайг яавал ч яаг! Харин энэ чулуу та нарт хэрэг болно.

Эльфийн хаан Хоббитыг хүндэтгэн харж байснаа,

-Бильбо Бэггинс! Чи эльфийн баатрын хувцас өмсөх бүрэн эрхт хоббит юмаа. Чамд уртдаж байгаа нь ерөөсөө хамаагүй! Царсан Бамбай Торин чамайг дэмжих болов уу, яах бол? Бид одойнуудыг чамаас илүү мэднэ. Энд аюулгүй, чи бидэнтэй үлдэхгүй юм уу?

-Эзэн хаантан минь баярлалаа. Урьсанд тань баярлалаа. Би нөхдөө орхиж чадахгүй. Бид нар хичнээн олон адал явдал хичнээн урт замыг хамтдаа туулсан гээч. Би бас Бомбурыг сэрээнэ гэж амласан, уучлаарай би явахгүй бол болохгүй нь.

Бильботой маргах аргагүй байлаа. Бильбог эльфийн хаан, Бард хоёр гаргаж өгөхөөр болов. Гэнэт нэгэн түүдгийн дэргэд ээж суусан хар цувтай өвгөн түүнийг угтан босож ирлээ.

-Тун сайн байна, ноён Бэггинс. Чи намайг баярлуулж ханахгүй юмаа гээд хоббитыг тэврэн нуруун дээр нь алгадан магтлаа.

Энэ бол шидэт Гэндалф байв. Бильбо олон сарын туршид анх удаагаа үнэн сэтгэлээсээ баярлан догдлов. Шидтэнгээс асуух үй түмэн асуулт байвч цаг алга байлаа.

-Тэвч, тэвч. Удахгүй бүх юм төгсөнө гэж би итгэж байна. Чамайг нэлээн хэцүү шалгуур хүлээж байгаа гэхдээ чи өөдрөг байгаарай. Чи заавал дийлнэ. Улаан хошуут шувууны сонсоогүй зүйл болж магадгүй. За яв, яв! Сайхан нойрсоорой!

Гэндалфийн хэлсэн үгэнд бодлогоширсон ч хөгжилтэй болсон Бильбо цааш яаран явлаа. Түүнийг усны гарам хүртэл үдэв. Хоббит нэг ч удаа халтирсангүй голыг гаталж эльфүүдтэй салах ёс хийн гар даллаад үүдний зүг явлаа. Ямар ч байсан тэр шөнө дундаас өмнө амжиж түүний буусан, хананаас унжиж байгаа олсоор хана өөд авирч байлаа. Хоббит ханан дээр гараад олсыг тайлан хувиндаа нуугаад намайг яах бол гэж санаашран жаал суув.

Яг шөнө дунд амласан ёсоороо Бомбурыг сэрээж өөрийнх нь бодсоноор өөрт нь огт нийцэхгүй баярласан талархсаныг сонссон болоод унтахаар хэвтээд өгөв. Бильбо дөнгөж

хэвтэнгүүтээ л гүн нойронд дарагдлаа. Дашрамд хэлэхэд өндөгтэй шарсан өвчүүний өөх зүүдэлсээр байлаа.

Арван долдугаар бүлэг

Ганцаардмал уулын дээр

Маргааш өглөө нь эльфүүдийн байрласан газарт бүрээ хангинав. Удалгүй одойнууд нарийхан замаар хэн нэгэн явж байгааг харлаа. Хананаас нэлээд зайдуухан зогсоод одойнуудыг дуудав. Торин Бардтай ярилцах уу, үгүй юу? Байдал өөрчлөгдөж шинэ чухал мэдээ авсан тухай мэдээлэв.

-Дэйн ирнэ гэхээр эд нар айж байна. Түүний ойртож байгааг салхи дуулгаж гэж хэлээд “Би зөвшөөрч байна, зэвсэггүй ирнэ шүү” гэж хашхирлаа.

Өдөр дунд ханын дэргэд ойн эльфүүд болон Эсгаротын туг намирч байлаа. Хорин цэрэг нэг газар жад сэлмээ бөөгнүүлж тавиад цааш эргэлээ. Тэдний дунд Бард эльфийн хаан, малгайтай цуваар биеэ ороосон нэг өвгөн зогсоно. Өвгөн төмөр бүслүүртэй том сагс тэвэрчээ.

-Торин сайн байна уу? Чи хэлсэн үгээ мартаагүй биз? гэж Бард хэллээ.

-Чи намайг үдэш нэгийг бодоод өглөө өөрийг боддог гэж бодоогүй биз дээ гэж Торин ихэмсгээр үг хаяад “Чи тэнэг юм асуух гэж ирээ юу? Би эльфүүдгүй ирээрэй гэсэн биз дээ? Яагаад эльфүүд ирэв. Эльфүүд энд байхад би чамтай ярихгүй ээ”

-Чи алтаа яасан ч хэнтэй ч хуваалцахгүй юм уу?

-Чиний найз нар надад алтны оронд юу өгөх юм бэ?

-Трайны Алмааз чулууны талаар чи юу гэж бодож байна? гэж Бард асуув.

Энэ үед өвгөн сагсаа онгойлгон нүд сохлом гялтганасан Алмааз чулууг гаргаж ирлээ.

Торин гайхсандаа дуугүй болов. Удсан ч үгүй Торин уурлан хилэгнэн хашхирав.

-Энэ чулуу миний эцгийн өмч, одоо хууль ёсоор минийх. Яахаараа би өөрийнхөө хөрөнгийг өөрөө худалдаж авдаг билээ? Ер нь яагаад энэ чулуу та нарт байдаг билээ? Та нар яаж олж авсан бэ? Аа ойлголоо, хулгайчууд хэзээ ч хулгайч л байдаг шүү дээ!

-Бид нар хулгайч бишээ. Чиний хөрөнгийг бид солилцоход бэлэн байна.

-Яаж та нар олж авсан бэ? гэж Торин хилэгнэн орилов.

-Би, би өгсөн юм гэж Бильбо хананаас толгойгоо цухуйлган айсан дуугаар гонгинов.

-Чи, чи... гэж орилоод Торин хоббитын шилэн хүзүүн дээрээс хоёр гараараа шүүрэн авав.

-Аах чи муу хоббит чамайг алаад өгье! Олзлогч чамайг огтлоод хаяъя!

Торин хэлэх үгээ олж ядан уурлаж хөөрхий хоббитыг туулай шиг сэгсчив. Дарины сахлыг барьж тангараглая! Гэндальф энд байсан бол хэлээд өгөхсөн! Ямар амьтныг бидэнтэй явуулсан юм бэ, аан? Чамайг одоо хананд нялаад өгье гээд Торин Бильбог дээр гэгч нь өргөтөл,

-Боль! гэсэн ширүүн дуу гарлаа. Бардтай цуг ирсэн өвгөн сагсаа газар тавиад мөрнөөсөө цуваа мулталлаа.

-За би Гэндальф байна. Би яг цагаа олж иржээ. Миний найзыг битгий зэрэмдэглэ! Түүний хэлэхийг сонс гэлээ.

Торин Бильбог газар шидээд,

-Та нар ч гэсэн сонсоцгоо. Би үүнээс хойш түүнээс цааш ид шидтэнгүүдтэй тэдний найз нөхөдтэй орооцолдохгүй. За муу оготны зулзага минь ярь гэв.

-Аа ха ха! Ийм юм болсонд уучлаарай! Би өөрийнхөө хувийг өөрөө сонгон авч болно гэж чи хэлснээ санаж байна уу? Би хэлснийг шууд л ойлгосон шүү. Одойнууд үгэндээ эзэн болдог гэж би сонссон юм байна. Би юм юманд хэрэгтэй чухал болж байсан цаг бий шүү. Гэтэл одоо оготны зулзага гэнэ ээ? Насан туршид минь намайг хүндэлнэ, үргэлж тусалж тэтгэнэ гэж хэн ярьж тангараглаж байлаа? Нэг үгээр хэлэхэд би өөрийнхөө хувийг аваад өөрийнхөө дураар үрсэн.

-За тийм байна. Бид дахиад хэзээ ч тааралдахгүй гэж би найдаж байна гэж Торин гөвгнөснөө Бардап хандан,

-Надаас урвалаа. Би миний удам дамжсан өв хөрөнгө Алмааз чулуунаас татгалзахгүй гэдгийг та нар зөв тооцоолжээ. Энэ чулууны оронд би эрдэнэсийн сангийнхаа арван дөрөвний нэг хувийг өгье. Эрдэнийн чулуугаар биш алт мөнгөөр төлье. Энэ хувь бол тэр муу урвагчийн хувь. Хувиа аваад нүднээс далд орог. Та нар энэ урвагчийг аваад тонилцгоо! Чамайг явахгүй бол би чамайг аваад шидчихнэ шүү! Хурдал, хурдал, далд ор!

-Алт мөнгөө хэзээ өгөх юм бэ? гэж Бильбо асууж амжив.

-Дараа нь дараа нь. Цаг нь болохоор аваарай, далд ор!

-Миний алт мөнгийг өгтөл Алмааз чулуу бидэнд байх болно гэж Бильбо хананаас буухдаа мэдэгдэв.

-Чи ч их сайн хаан юм даа гэж Гэндальф Торинд хандан тохуурхан хэлээд бүх юм өөрчлөгдөж ч магадгүй шүү гэлээ.

-Магадгүй, магадгүй гэж Торин хариулаад яаж Дэйний тусламжтайгаар Алмааз чулууг эргүүлж авах , алт эрдэнэсийн сангаа бүрэн бүтнээр нь үлдээх тухай бодож эхэллээ.

Ингэж Бильбо ямар ч гавьяа шагналгүй эльфийн баатрын хувцаснаас өөр юмгүй уулыг орхиж явлаа. Түүний араас харж хоцорсон зарим одойнуудын зүрх нь шимширч, ичих шиг болж

байлаа.

-Баяртай, яаж мэдэх вэ дахиад уулзацгаах ч юм билүү гэж хоббит хашхирлаа.

-Зайл, зайл! Миний өвөг дээдсийн дархалж хийсэн бамбай цамц өмссөндөө баярла. Хэрвээ чи яараагүй бол майга хөлийг чинь газарт зоогоод өгье гэж Ториныг агсрахад Бард,

-Битгий халуур! Бид нар маргааш болтол хүлээнэ. Маргааш өдөр дунд Алмааз чулууны оронд өгөх алт мөнгөө авахаар ирнэ. Хэрвээ бүх хэлэлцээр тохироо үнэн шударгаар дуусвал бид буцна. Баяртай, Торин! гэлээ.

Тэднийг явсны дараа Торин Дэйнд бүх болсон явдлыг тоочиж түргэлэхийг гуйсан мэдээ Роэкоор дамжууллаа.

Нэг хоног өнгөрлөө. Өглөө баруун зүгээс хүйтэн салхи үлээж үүл хуралдав. Энэ нь Уулын зүүн хамар дээгүүр одойнуудын армийн эхний хэсэг харагдаж байна гэсэн мэдээ харуул авчирсных.

Дэйн ирлээ. Түүний цэргүүд шөнөжин амралтгүй явсаар хүлээсэн цагаас ийнхүү хурдан иржээ. Одойнууд өвдгөө хүрсэн хуяг нөмөрч жижигхэн нүхтэй төмөр оймс өмссөн байлаа. Ийм төмөр оймсыг зөвхөн Дэйний албатууд л нэхэж чаддаг ажээ.

Цэрэг бүхэн хоёр бариултай цавчуур сүхтэй, мөн өргөн иртэй богино жад бүсэндээ хавчуулжээ. Одойнууд бөөрөнхий бамбай нуруундаа үүрчээ. Өтгөн сахлуудаа бүсэндээ шургуулчихсан, дуулганых нь төмөр саравч хүрлэгэр нүүрийг нь бараг хаасан байлаа. Эльфүүд болон хүмүүсийг зэр зэвсгээ барьцгаа гэсэн бүрээ хангинав. Энэ үед одойнууд хөндийг өгсөн том том алхаж явлаа. Одойнуудын армийн үндсэн хэсэг зүүн гүвээ гол хоёрын дунд зогсож, зөвхөн цөөн цэргүүд голыг гаталж эльфүүд буудалласан зүг хөдлөв. Цэргүүд зогсож зэр зэвсгээ газарт тавиад энхийн зорилготой гэдгээ илчлэн гараа өргөцгөөлөө. Бард Бильботой цуг тэдний өөдөөс очив.

-Бид Найны хүү Дэйний элч нар. Бид эртний үндсэн нутаг орныхоо зүг ахан дүүсдээ туслахаар яарч явна. Та нар аль нутгийн ямар хүмүүс вэ? Яагаад Уулыг бидний бодсоноор бүслээд байгаа юм бэ? Ингэж тэд эртний маягаар хүндэтгэлтэйгээр асуулаа. Энгийн хэлээр бол “Энд та нар юу хийж байгаа юм бэ? Бидэнд зам тавиатах, эсвэл хүчээр дайраад гарна шүү” гэсэн үг байлаа.

Бард одойнуудыг нэвтрүүлэхийг эрс эсэргүүцэв. Бард Торинд итгэхгүй байсан учир Трайны Алмааз чулууны оронд өгөх алт мөнгийг эхлээд авах бодолтой байв. Яагаад гэвэл Торины арми нэмэгдэж хүчирхэг болно. Дэйний цэрэг бүр том шуудайтай хоол хүнс үүрч ирсэн байлаа. (Одойнууд ер нь хүнд ачаа үүрэх чадалтай байдаг)

Ууланд орох юм бол бүслэлт олон сараар үргэлжилж тэр хооронд Торины тоолж баршгүй ах дүү нараас ахиад хүрээд ирнэ. Тэгээд ч одойнууд ууланд нууц гарц хаана л бол хаана гаргах чадвартай. Гарц болгонд тавих харуул хамгаалалт гээд бүсэлж дийлэхгүй юм болно. Бидний хүч хүрэлцэхгүй.

Одойнууд яг ийм төлөвлөгөө зохиож байлаа. Харин Бард үүнийг эвдсэнд хоорондоо баахан маргалдаж маргалдаж эцэст нь Дэйний одойнууд хамар доороо хэлэхгүй үгийг хэлж хараасаар одсон болой. Бард хаалга уруу хэсэг явуултал тэнд тэднийг таагүй байдалтай угтлаа. Тэднийг харваж болох газар ойртож очих төдийд хананаас сум шунгинан ирнэ. Хүмүүс яаран буцав. Тэгээд байлдаанд бэлдэж эхлэхэд Дэйний одойнууд голын зүүн эргээр өгсөцгөөв.

-Ээ тэнэгүүд ээ! Би тэднийг арай ингэнэ гэж бодсонгүй. Одойнууд газар доор байлдаж чаддаг байж магадгүй юм. Харин газар дээрх дайн тулалдааны талаар юу ч мэддэггүй юм байна. Баруун талын хаданд манай харваачид, жадчид отоод сууж байгаа. Хэдийгээр одойнууд зузаан бөх хуяг цамцтай боловч их л сандрах болно доо. Одоо тэднийг амарч амжаагүй байхад нь хоёр талаас нь бут цохё! гэж Бардыг хэлэхэд эльфийн хаан,

-Би чиний оронд байсан бол яарахгүй л байх байсан. Тэд нар газар доогуур нүх ухдаггүй л юм бол тэртэй тэргүй бидэнтэй нүүр тулаад л ирнэ. Энхийн замаар эв зүйгээ ололцон хэлэлцэж тохирч магадгүй шүү. Эцсийн эцэст байлдлаа гэхэд бид хүний тоогоор их шүү дээ гэв.

Эльфийн хаан одойнуудад өөр төлөвлөгөө байж болох юм гэдгийг бодсонгүй. Трайны Алмааз чулууг гартаа авсан дайсандаа уурлан хилэгнэсэн одойнууд эльфүүд болон хүмүүс эргэлзэж байх хооронд цохилт өгөхөөр шийджээ.

Дохио чимээ ч үгүй тэд нар шууд л урагш давшицгаав. Нум сум шунгинаж илд жад шүнгэнэж гардан байлдахад тулаад байв. Яг тэр үед гэнэт газар дээр тас харанхуй боллоо. Хаанаас ч юм бүү мэд бөөн хар үүл гарч ирэн Уулыг нэлд нь нөмрөн хучсанаа аянга ниргэж үүлэн дундаас цахилгаан гялсхийн оргилд зоогдов. Хойд зүгээс далавчнуудынх нь хооронд зүү орох зайгүй зэрэгцэн нисэх асар олон шувууд сүрэглэн нисэж ирлээ.

-Зогсоорой, зогсоорой! гэж Гэндальф хашхирлаа. Тэр хаанаас ч юм гарч ирээд одойнуудын жагсаал Бардын цэргүүд хоёрын хооронд зогслоо.

-Больцгоо! гэж аянгын дуугаар хэлэхэд түүний таягнаас нүд гялбуулсан гал оч үсэрнэ. Та нарын жинхэнэ дайсан ирж явна. Гоблинууд ирж явна. Миний бодсоноос эрт ирчихлээ. Дэйний жаданд сүлбүүлсэн Азогийн хүү Болг тэднийг удирдаж явна. Харцгаа! Гоблинууд чоно хөлөглөн давхиж хойноос нь чонын сүрэг дагалджээ.

Байлдаж байсан хоёр тал үймэрч бүгд сандралдав. Гэндальф ярьж бөөн хар үүлс харанхуйлсаар байлаа. Одойнууд тэнгэр ширтэн хөдөлгөөнгүй зогсоно. Эльфийн дайчдын эгнээн дундуур их дуу хадсаар.

-Сонсоцгоо! Бид зөвлөлдөн хэлэлцэж амжина. Энэ хэлэлцээнд Найны хүү Дэйн бас оролцоно гэх шидтэний дуу цуурайтсаар.

Ингэж хэн ч хүлээгээгүй тулалдаан сүүлд нь Таван Армийн байлдаан гэж нэрлэгдсэн их тулалдаан эхэлсэн юм.

Зэрлэг ууланд Торин болоод түүний нөхөд Гоблинуудын толгойлогчийг алснаас хойш

гоблинууд одойнуудыг үнэн зүрхнээсээ үзэн яддаг болжээ. Хот, гацаа, цайз, цамхагийн дундуур өөрсдийнхөө элчийг тасралтгүй давхиулж одойнуудыг занан байж устгаад хойд зүгийн нутгийг тэр чигээр нь эзэмшихийг гоблинууд хатуу шийдсэн ажээ. Гоблинууд үйл явдлыг удаан тэвчээртэй мөрдөж хэл мэдээ цуглуулж байх хоорондоо харанхуй агуйдаа зэр зэвсгээ бэлдэж байжээ. Дараа нь тэдний гол хот Гандабадад цугларцгаажээ. Гандабадад гоблинуудын бүтэн арми зэр зэвсэгтэйгээ өмнө зүг аян замд гарахад бэлэн болоод байсан үедээ Тортог луу үхсэнийг сонсоод тэсэлгүй яаран давшлан гарчээ. Дэйн хааны цэргүүдийн өсгий даган давхисаар хойд зүгээс Уул уруу чиглэн амралтгүй шөнөжин өдөржин явжээ. Гоблины арми Ганцаардмал уулыг хойд нутгийн нууруудаас тусгаарлаж байдаг эзгүй газарт гарч ирэхээс өмнө улаан хошуут шувууд ч хараагүй байна. Гэндальф олон зүйл мэдэж сонссон боловч хэлэхэд хэцүү л дээ түүнд мэдээгүй зүйл их байлаа. Гоблинуудын арми гарч ирсэн нь түүний гайхлыг төрүүлсэн гэж өөрөө хэлсэн шүү дээ.

Гоблинууд нийтийн дайсан учраас эльфийн хаан, Бард, Дэйн нарын хэлэлцээр дээр одойнуудыг дуудах бөгөөд энэ үед хоорондын хэрүүл маргааныг тас мартах ёстой гэж шидэт Гэндальф төлөвлөжээ. Гоблинуудыг уулын гүвээнүүд дундах хөндийд шахаж аваад өөрсдөө өмнө болон зүүн зүгээс дайрах нь зөв. Гэхдээ гоблинууд тоогоороо илүү байж Уулыг бүсэлж аваад дайрах юм бол тэд хэцүүдэх юм. Цаг тун бага. Хэрвээ тусламж ирэхийг хүлээх юм бол хугацаа хүрэлцэхгүй.

Аянга нүргэлсээр зүүн өмнө зүг чимээгүй болмогц сарьсан багваахай сүргээрээ нисэж ирэв. Сарьсан багваахайн сүрэг зүрхэнд айдас хуруулан холбоотон цэргүүдийн дээгүүр эргэлдсээр Уулын гүвээн дундуур алга болов.

-Уул уруу, уул уруу! Биднийг бяцлаагүй байгаа дээр нэг гүвээн дээр гараад авъя гэж Бард уриаллаа.

Өмнөд гүвээ, доод хэц дээгүүр эльфүүд, зүүн гүвээнд одойнууд хүмүүс байрлацгаан Бард хэдэн гавшгай хүмүүстэй хамт дайснаа алсаас сайн харахын тулд зүүн овооны оройд гарч отоцгоолоо. Савнаасаа хальсан нуурын үерт уулын хойд хөндий автжээ. Хаашаа ч харсан эргэн тойронд гоблинууд, чонын сүрэг. Удалгүй дайсны түрүүчийн хэсгүүд гүвээний үзүүр тойрон гарч ирээд ура хашхиран Дейл уруу зүглэлээ.

Дайсны цэргүүд цөөн хэдэн хаалтыг хэмх унагааж улам цаашлан давшлаа. Гэндальфийн бодож байснаар гоблинууд гүвээн дундуур хөндий өөд өгсөв. Тэд улаан хар өнгөтэй олон туг намируулжээ. Гоблинууд айхыг үл мэдэгч хайрлахыг үл мэдэгч далайн давалгаа мэт хуйлран дайрч явав.

Энэ бол аймшигт тулалдаан болсон юм. Бильбо юу болсныг хэдийгээр олонтаа дурсан ярьж энэ дайнд оролцсондоо бахархдаг боловч үнэндээ энэ тулалдаан түүний ой тойнд хамгийн зэвүүн, аймаар дуртгал үлдээсэн байна. Харин би та нарт нууцлан хэлэхэд тулалдаан эхлэнгүүт Бильбо бөгжөө зүүж нүдэнд харагдахаа больжээ. Гэвч тэнэмэл сум жад илдэнд өртөхөөс бөгж хамгаалж чадахгүй болохоор аюул осол хажууд нь дагасаар байв. Гэхдээ Бильбо зэрлэг гоблины далайсан сэлэмд өртөхгүй зугтааж чадах нь мэдээж.

Эльфүүд анхны цохилтонд орлоо. Эльфүүд гоблинуудыг үхтэлээ үзэн яддаг. Тэд нарын жад

харанхуйд мөсөн дөл мэт гэрэлтэнэ. Дайсан хөндийд үзэгдэв үү, үгүй юү нумнаас тавьсан сум агаарт дүүлэн шунгинан гялалзан ниснэ. Нумчдын дараа жадчид орцгоов. Энд тэндгүй орилж чарлацгаан гоблинуудын цусанд хар чулуу улаан нялга болно. Гоблинууд түргэн сэхээ авч эльфийн дайралтанд дарагдаж эхлэхэд хөндийд эрэлхэг чанга дуу хадлаа.

“Мория! Дэйн, Дэйн!” гэсэн уриа хашхирсаар Төмөр Уулын одойнууд урт сэлэм барьсан хүмүүстэй мөр зэрэгцэн цавчуур сүхээ далайцгаан давшилтанд орлоо.

Гоблинууд тэвдэн бужигналдсанаа ухаан орцгоон дахин шинэ дайралтанд ортол тэднийг эльфүүд бут цохилоо. Ихэнх гоблинууд амиа авран эргэж гол руу харайтал саяхан нөхөд нь байсан чононууд тэднийг үхтэл нь хэмэлцгээлээ. Алсаас ирсэн дайснаа дарж ялалт яг л одоо ялалт гэж бодохын даваан дээр дээрээс дахиад дуу чимээ цуурайтав.

Энэ нь Уулыг тойрсон гоблинууд хаалганы дээрх хадан хавцалд гарсан байлаа. Үй түмэн одой цэргүүдийн арми олонх нь хавцал хаднаас муухай орилон гүвээ уруу унахыг үл хайхран ухаан жолоогүй уруудан байв. Гүвээн дээр давшилтыг сөрөх хүч маш сул байлаа. Ялалт найдваргүй болоод ирлээ. Доод хөндийд ялагдсан гоблинууд хар дайчдын дөнгөж эхний урсгал байжээ. Орой болж байлаа. Гоблинууд хөндийд дахиад дүүрээд ирэв. Тэр зүг шунаг сувдаг чонын сүрэг өндөр дэнхгэр гоблинуудтай хамт шууран давхилдана. Бага багаар харанхуй болоход сарьсан багваахайнууд эльфүүд болон хүмүүсийн толгой дээгүүр эргэлдэн үхдлийн цус сорно. Зүүн гүвээнд хамгаалж байсан Бард аажуухан ухарч байхад Улаан хошуут оргилын ойролцоох өмнө талын гүвээн дээр эльфийн хаан цэргийн дарга нар бөөгнөрөлдөн байлаа.

Гэнэт чанга хашхиралдах дуу гарч үүдний дэргэд эвэр бүрээ хангиналаа. Энэ нь бүгдийн мартсан Торин байлаа. Хананы хэсэг их дуу чимээ гарган нууранд уналаа. Хананд гарсан нүхнээс Уулын хаан андуудтайгаа гарч ирэв. Одойнууд нүд гялбуулсан хуяг дуулга өмссөн байлаа. Харанхуйн дунд шатаж дуусаж байгаа түүдгийн гэрэлд Торин цутгасан алт шиг харагдана. Гоблинуудын унагасан чулууд уулын энгэр даган өнхөрч ирэхэд одойнууд Дейл орох голын эрэг уруу эргэж тулалдаанд орлоо. Чонын сүрэг, чоно унасан гоблинууд тэдний цавчуур сүхний аясаар хядагдана. Торин цавчуур сүхээрээ сүртэй сүртэй далайн хэн ч эсэргүүцэж чадахгүй хүнд цохилтоор дайснаа дарж байлаа.

-Наашаа, наашаа! Эльфүүдээ, хүмүүс ээ! Наашаа, элгэн садангууд минь! гэж Торин цуурайтуулан хашхирахад түүний дуу газар тэнгэрт хадна. Дэйний цэргүүд хамгийн түрүүнд Торины зүг ухасхийлээ. Тэдний араас Бардын зогсоцгоо гэж гуйхыг үл тоосон хүмүүс нөгөө талаас жадчин эльфүүд хөдлөв. Гоблинууд хиаран унахад тэдний хүүр Дейлээр дүүрлээ. Чонын сүрэг дайран орлоо. Торин Болгийн цэргүүдийг сүйрүүлсэн ч гоблинуудын толгойлогчид хүрч чадсангүй. Торины ард гоблинуудтай хамт хүмүүс хөгжилтэй эльфүүд, одойнууд үхэтхийн унасан харагдана. Торины баг дэндүү цөөхүүлээ болохоор дайралт бут цохигдон Ториныг хэдэн талаас нь гоблинууд бас олз үнэртсэн чонын сүрэг хүрээлэн авав.

Болгийн хэсэг одойнууд уруу далайн давалгаа элсэн эргийг хумин авахтай адил өрвөлзөн орилолдож шуурлаа. Торины хэсэгт туслах аргагүй байв. Цавчуур сүх зогсоо зайгүй гялалзана. Хүмүүс эльфүүд хоёр талаас нь доош шахан хөөлөө.

Бильбо энэ бүхнийг хараад зүрх нь шимширч байлаа. Бильбод эцсийн эцэст хөгшин Тукийн

араншин тодорч ямар нэг юм болвол эльфийн хааныг эцсээ хүртэл хамгаалахаар хатуу шийдээд эльфүүдтэй цуг Улаан хошуут оргил дээр байж байв. Бас эндээс зугтахад амар аж. Гэндальф ч гэсэн энд байж сүүлчийн удаа ямар нэг ид шид үзүүлэх гэсэн мэт бодлогошрон суулаа.

Үхэл гарцаагүй ирэх болсон санагдана. Гоблинууд жалгыг эзлээд авна. Биднийг бүгдийг бут цохиж эсвэл олзлон авна. Яаж уйлж унжихгүй байх юм! Би бүх дайн дажин дууслаа гэж бодсон. Тортог луу амьд байсан бол энэ алт эрдэнэсийн төлөө ингэж үхэлдэхгүй байхсан. Хөөрхий Бомбур, хөөрхий Фили, Кили, Балин та нар минь дээ! Би ч гэсэн хөөрхий! Дайн тулааны тухай хичнээн дуу домог байдаг билээ, тэр үлгэр домогт ялагдал нь хүртэл ямар гоёор бичигдсэн байдаг билээ дээ? Гэтэл энийг хараа..... аах паах! Би ер нь юунд ороогдох нь энэ вэ? Бильбо ингэж бодоод шаналан сууж байв.

Салхи үүлсийг хөөн баруун зүгт шингэх нарны улаан гэрэл түрхэн зуур гялалзав. Бильбо тэр зүг ширтсэнээ зүрх нь бүлт үсрэх шахав. Баруун зүгээс шувууд нисэн ирж байлаа.

-Бүргэд, бүргэд! гэж хоббит чарлав. Бильбо тун хурц хараатай ажээ. Нэгэн хэмээр ихэмсэгхэн дэвсээр бүргэдийн сүрэг нисч байлаа. Бүргэдүүд хойд зүгийн үүр болгоноос Уулыг зорьжээ.

-Бүргэд, бүргэд! гэж хоббит гараа даллан хөөрч баярласандаа үсрэн дэвхэцнэ.

Эльфүүд Бильбог харж чадахгүй ч дууг нь сонсож байлаа. Эльфүүд бас л баярлан уухайлхад тэдний дуу хөндийгөөр нэг цуурайтлаа.

Байлдаж байсан цэргүүд зогтусацгаан тэнгэр ширтэнэ. Бүргэдүүдийг зөвхөн Уулын өмнөд гүвээн дээрээс л харж болох байлаа.

-Бүргэд, бүргэд гэж Бильбо дахин хашхиртал гэнэт толгой дээр нь том чулуу унаж хөөрхий Бильбо дуу тавин элэгдэн тэрийгээд ухаан алдлаа.

Арван наймдугаар бүлэг

Эргэж ирсэн нь

Бильбо ухаан орон сэргээд ийш тийш харвал эргэн тойронд нь хэн ч байхгүй гав ганцаараа Улаан хошуут оргилын бэлд хэвтэж байх нь тэр. Дээр нь үүлгүй тэнгэр цэлийнэ. Голдоо ортол даарч байсан ч дух нь халуун шатна.

-Би яачихав аа? гэж Бильбо гэвтнөөд, за яах вэ учир нь олдох байлгүй. Ямар ч гэсэн үхсэн баатрын тоонд ороогүйгээс хойш аргатай, аргатай.

Хоббит босож суугаад өвдсөндөө ярвайна. Хөндийн зүг ширтлээ. Хөндийгөөр дүүрэн овоолсон мэт үхсэн цэргүүдийн хүүрэн дунд эльфүүд яваад байх шиг харагдав. Бильбо нүдээ сайн гэгч арчаад хартал үнэхээр эльфүүд явж байв. Хөндийд эльфийн байр бүрэн бүтнээрээ байж байв. Үгүй ээ, тэр хаалганы тэнд юу гүйлдээд байна аа? Аан одойнууд ханаа сэргээн засаж байна. Яагаад чив чимээгүй болчихоо вэ? Яагаад баярлаж хашхирахгүй, яагаад дуулахгүй байгаа юм бэ? Уйтгар гунигтай хачин зэвүүн чимээ аниргүй байна вэ? Ямар ч байсан бид ялжээ гээд Бильбо толгойгоо тэмтрэн гэхдээ ямар үнээр ялсан гэдэг л гээд босонгуугаа нэг хүнийг олж харав.

-Хөөе, хөөе! Сонин мэдээ хэлээч гэж тасалданги цахирсан хоолойгоор дуудав.

-Энэ чулуун дотор юу чарлаад байна аа? гэж тэр хүн бараг Бильбогийн хажууд зогсоод ийш тийш харан эрэв. Бильбо бөгжөө саналаа. Өө хө, хүн болгон л муу зуршилтай шүү дээ. Бөгжөө зүүгээгүй байсан бол дулаахан хөнжилдөө унтаж байхгүй юу! Би, би Бильбо Бэггинс байна. Торины анд гэж хэлээд хоббит бөгжөө хуруунаасаа сугаллаа.

-Өө ямар сайн юм бэ, чи олдлоо. Чамайг ямар их эрэв ээ? Алагджээ гэж бодоцгоож байтал чиний дууг Улаан хошуут оргил дээр сүүлчийн удаа сонссон гэж шидтэн Гэндальф хэлсэн. Тэгээд чамайг дахиад нэг хайгаач гэж гуйсан юм. Чи шархадсан уу? гэж асуулаа.

-Толгой дундуур минь татаад хаясан шиг байна. Би дуулгатай байсан л даа. Миний толгой уг нь бөх шүү бөх! Харин энэ муу хөл хөдлөхгүй байх чинь гэж Бильбо учирлахад нөгөө хүн хоббитыг өргөж аваад “Би чамайг буудалласан газар хүргэж өгье” гэж хэллээ.

Тэр хүн итгэлтэй хурдан алхана. Бильбо хэдхэн хормын дотор Дейлд ирлээ. Майхны үүдэнд гараа боосон Гэндальф угтав. Тулалдааны гүнд байсан цэргүүдийг ярих юм биш, тэр ч байтугай шидтэн шархаджээ. Бильбог хараад Гэндальфийн царай гэрэлтэн тайвшрав.

-Бэггинс! Ээх, энэ газраа цөмрөөд орохсон. Амьд, амьд байна. Аз чинь ингээд хаячихдаг юм байх даа гэж янз янзаар л бодлоо шүү. Чамайг байхгүй байх хооронд энд юу юу болсон гээч! За яах вэ, сонин ярьж амжина. Алив явья, чамайг хүлээж байгаа.

Ингэж хэлээд шидтэн хоббитыг хөтлөн нэгэн майхны өмнө ирээд,

-Торин, би түүнийг аваад ирлээ! гэв.

Майханд Царсан Бамбай Торин бүх бие нь шархадчихсан хэвтэж байлаа. Түүний сэглүүлсэн хуяг дуулга, эмтэрч мохсон цавчуур сүх газарт хэвтэнэ. Бильбог ойртоход одой толгойгоо өргөлөө.

-Үүрд баяртай, аз эз, олзын эзэн минь! Би өвөг дээдсийнхээ хүлээж байгаа газар уруу явлаа. Энэ орчлон эргэж шинэчлэгдэхээр буцаж төрнө. Алт эрдэнэсээ аваад явахгүйгээс хойш би чамтай андын ёсоор салъя гэж бодсон юм. Өөрийн хэлсэн үгийн мууг буцаан авч өмнө чинь сөгдөн буруугаа хүлээе гэлээ.

Бильбо гуниглан өвдөг сөгдөв.

-Уулын хаан минь баяртай! Бидний аян дайн ийнхүү зовлонгоор төгсөж байна. Уул шиг алт байгаад ч энэ гарзыг нөхөж чадахгүй. Аюул зовлонг чамтай хамт амсаж эдэлж явсан минь Бэггинсийн удмынхны хэнд ч олдоогүй шагнал шүү.

-Илүү үгээр яах вэ. Баруун хязгаарын хоббит чи өөрийгөө мэдэхгүй байна. Чи эрэлхэг дайчин дээр нь энгүй их ухаалаг. Ухаан ур хоёрыг хослуулсан хоббит. Бид алт мөнгийг биш зөвхөн дуу хуурыг дээдлэн үнэлж байсан үед энэ хорвоо сайхан байжээ. Нүгэлт энэ орчлонг орхих цаг минь болжээ. Үүрд баяртай!

Бильбо асраас гараад пүүгээгээ олж хөнжлөөрөө толгойгоо хулдаад хэвтээд өглөө. Та нар итгэнэ үү байна уу, өөрсдөө л мэд. Бильбо хоолойгоо хатаж, нүдээ улайтал гашуудан уйлсаар байлаа. Жижигхэн Бэггинс зөөлөн сэтгэлтэй, ихэд дасамхай хоббит шүү. Хоббит жаал тайтгарч тоглоом шоглоомын үг хэлэхтэй болтол нэлээд хугацаа өнгөрсөн шүү.

Би яг цагаа олж ухаан оржээ. Тэгээгүй бол Торинтой амьдад нь уулзаж салах ёс хийж чадахгүй байх байсан даа гэж өөрийгөө тайвшруулна. Ториныг эргээд амьдруулахгүйгээс хойш яана гэх вэ? Харин анд нөхдийн ёсоор хагацсан минь золтой. Би ч гэж би. Ямар тэнэг толгой вэ? Яаж ч бодоод дайн байлдааныг өөрчлөх аргагүй, болдог юм болоод өнгөрчээ. Алмааз чулууг хулгайлахгүй байсан бол болох л байж. Ай хөөрхий, урьдчилаад мэдсэн ч болоосой гэж бодно.

Түүнийг ухаан алдаж ойчсоноос хойш болсон үйл явдлыг сонсоод Бильбо урьдынхаасаа илүү гуниглан шаналж гэртээ харимаар санагджээ.

Бильбо харих бэлтгэлээ хийж байх хооронд аймшигт тулалдаан яаж дууссаныг би та нарт ярьж өгье. Бүргэдүүд гоблинуудын араас мөр алдахгүй мөрдсөөр гэнэт гоблинууд сэжигтэй нь аргагүй шуугилдаад ирэхийг мэджээ. Ингэж мэдмэгцээ бүргэдүүд тэргүүлэгчээ даган зүүн хойд зүгийг барин нисчээ. Яг амжиж ирсэн байна. Асар том бүргэдүүд айж сандарсан гоблинуудыг Уулын өндөрлөгөөс доош шахан хөөж эльфүүдийн жад, хүмүүсийн сэлэмний ирэнд тулгажээ. Уулын хяр цэвэршиж эльфүүд хүмүүстэй хамт өөрсдийнхөө нөхдөд туслахаар хөндийг зорив.

Дайчин гоблинууд шоргоолж мэт олон. Бүргэдүүд хүртэл тэвдэж байхад Беорн баавгайн дүрээрээ хүрч ирлээ.

Беорн мянган бөмбөр дэлдэж маш чангаар урхиран хархиран гоблинууд, чонын сүрэг өөд дайран орж тэднийг бухал өвс овоолттой хог мэт ийш тийш хэмх шидэв. Беорн чих дүлийртэл орилж гоблинуудыг шидэлсээр тэдний бүслэлтийг задлан одойнуудад гарах боломж олгов.

Сумаар шивүүлсэн Ториныг өргөж тулалдааны талбараас гаргаж өвсөн дээр тавиад эргэн ирж улам их уурлан хилэгнэн дайрч оржээ. Болгийн гоблинууд түүнийг дийлсэнгүй. Болг баавгайн саварт гамбир болтлоо алгадуулан үхэв. Гоблинууд сандралдан ухарч зугтлаа. Хүмүүс эльфүүд одойнууд тэднийг голын зүг шахан хөөхөд гоблинуудын зарим нь өмнө зүг зугтан одсон бөгөөд заримыг нь зэрлэг ойд хүрэхээс өмнө барьж устгав. Тэр өдөр Ганцаардмал ууланд хойд нутгийн гоблинуудын дөрөвний нэг нь үрэгдсэн гэж өгүүлдэг ажээ. Ингэж Ууланд олон жилийн энх амгалан тогтжээ. Ялалт оройдоо бүрэн зарлагдсан бөгөөд Бильбог ирэхэд гоблинуудыг хөөж барихаар бүх хэсгүүд явсан байжээ. Иймээс байранд хүн цөөн зөвхөн хүнд шархтангууд л байсан юм.

-Бүргэд, бүргэдүүд хаана байна? гэж хоббит Гэндалфаас асуулаа.

-Нэг хэсэг нь дайсныг үлдэн хөөхөөр бусад нь үүрэндээ буцсан. Нар гармагц буцаж ниссэн. Дэйн бүргэдийн тэргүүнд алтан титэм бэлэглэж үүрд нөхөрлөнө гэж амласан.

-Өө, яасан харамсалтай юм бэ? Би тэдэнтэй уулзах гэсэн юм. За яах вэ, буцах замдаа уулзана аа. Би хэзээ буцаж болох вэ? гэж хоббит нойрмогхон асуухад Гэндалф,

-Хүссэн цагтаа явж болно гэлээ.

Бильбогийн хүссэн хүсэл биелтэл хэдэн хоног өнгөрөв. Ториныг Уулын бэлд агуй дотор оршуулахад Бард түүний цээжин дээр Алмааз чулууг тавилаа.

-Уул сүндэрлэж байгаа цагт үргэлж мөнх энх амар нойрсох болтугай. Энд ирж суурьших одой болгонд аз хийморь бэлэглэж байг гэж мэргэн харваач хэллээ.

Эльфийн хаан булшин дээр Гоблинуудыг номхотгогч сэлэм бас Торин олзлогдохдоо алдсан эльфүүдийн сэлмийг өрж тавив. Гоблинуудыг номхотгогч сэлэм ойртоход гэрэлтдэг тул одойнууд энэ сэлэмтэй байсан цагт тэднийг гэнэгүй байхад нь дайрч чадахгүй юм.

Найны хүү Дэйнйг уулын хаанаар тунхаглан зарлахад эртний омог отгийнхон тал бүрээс ирж өрх нэгдлээ. Ториныг дагалдаж явсан арван хоёр одойноос Фили, Кили хоёр алагдаж арав болжээ. Фили, Кили хоёр толгойлогчоо, ураг төрлийнхнийгөө хамгаалан тэмцсээр амь насаа алджээ. Торин тэр хоёрын ээжийн том ах нь байсан юм. Нэг үгээр хэлэхэд нагац ах нь байсан юм. Үлдсэн арван одой Дэинтэй нийлэв.

Уулын шинэ хаан алт эрдэнэсээ үнэнч шударгаар хуваалаа. Урьдын гэрээ одой болгоны бас Бильбогийн хувийн тухай хэн ч дурссангүй. Алт эрдэнэсийн арван дөрөвний нэг хувийг алт мөнгөөр Бардад өглөө.

-Бид бурхан болоочийнхоо амласныг биелүүлж байна. Тэр тусмаа Алмааз чулуу хаанд буцаж

ирсэн юм чинь!

Энэ арван дөрөвний нэг хувь гэдэг чинь урьд урьдын ямар ч хааны зүүдэнд оромгүй их баялаг байлаа. Бард Эсгарот хотын захирагчид алтаа явуулж өөрийн андууд болон хамтран тэмцэгчдээ элбэг дэлбэг шагнаж эльфийн хаанд Дэйний буцааж өгсөн Гирионы эрдэнэсийн зүүлтийг өргөн барьжээ. Бард Бильбод хандан хэлэв.

-Одоо бүх юм өөрчлөгдсөн юм чинь урьд хийсэн гэрээг мартах ёстой. Энэ эрдэнэс чинийх. Чи өөрийнхөө хувиас татгалзсан гэхдээ би Торин өөрөө хүртэл харамссан үг биелэлээ олохоос айж байна. Санаж байна уу? Чамайг амьд мэнд дээрээ зайл, тонил юуны чинь хувь гэсэн биз дээ? Харин би чамайг дээд зэргээр шагнаж байна. Чиний оронд хэн байсан ч би ингэж үнэнч шударгаар шагнах байсан.

-Гялайлаа, баярлалаа. Би одоо яахыгаа үнэндээ мэдэхгүй байна. Миний хөрөнгөнд шунах ангуучдаас өдөр шөнөгүй зугтан орон гэртээ очиж чадах уу, үгүй юу? Зовж зовж аваачлаа гэхэд би энэ их алт эрдэнэсээр юу хийхээ бас мэдэхгүй л байна. Харин та нарт үлдвэл дээр биш үү.

Эцэст нь хоббит нэг нь алттай, нөгөө нь мөнгөөр дүүрэн хоёр жижиг авдар авахаар тохирлоо.

Нэлээн чадалтай пони морь даахаар хэмжээний авдар байлаа.

-Надад энэ морь болно болно гэж Бильбо сэтгэл дүүрэн өгүүлэв.

Салах цаг боллоо.

-Баяртай Балин, Двалин, Дори, Нори, Ори, Ойн, Глойн, Бифур, Бофур, Бомбур! Санаа сэтгэл тань тайван амгалан сахал самбаа тань уртаас урт болог! гэж ерөөгөөд Уулын зүг эргэж харан Баяртай Торин! Царсан Бамбай Торин! Баяртай Фили, Кили хоёр минь баяртай. Та нарыгаа хэзээ ч мартахгүй!

Одойнууд гуниглан хэлэх үгээ олохгүй дэмий л газар шүргэх дөхөн бөхөлзөнө. Удаан дуугүй зогссоны дараа Балин,

-Сайн яваарай! Хаана ч байсан азтай одтой яваарай! Биднийг орон хотоо янзалж барьж босгосон хойно зочлон ирээрэй! Тэр цагт тэнгэрт тулсан найр хийнэ ээ.

-Та нар ч гэсэн манай нутгаар явахдаа ороорой. Би дөрвөн цагт цайгаа уудаг л даа, харин та нарыг хэдийд ч ирсэн баярлана. Ингэж хэлээд Бильбо хурдхан эргэж алхлаа.

Эльфийн цэргүүд ч буцах замдаа орлоо. Тэдний тоо цөөрсөн хэдий боловч олон жилийн дараа хойд нутагт баяр баясгалан эргэж ирсэн болохоор уйтгар шаналалаас хөөр хөгжөөн их байв. Лууг дарж гоблинуудыг зад устгасан эльфүүдийн элэг зүрх цэнгэл хөгжил цэнгүүн хаврыг хүсэж байлаа. Эльфийн хааны ард эхний эгнээнд Гэндалф Бильбо, хүнийхээ дүрд орсон Беорн инээж хөхрөн хүнгэнэн дуулна. Уулын гол өргөн талд цэлийн гарч ирсэн газраас нэлээд хойхно Зэрлэг ойн цоорхойд хүрэлцэн ирцгээв. Энд шидтэн хоббит хоёр ой уруу

орохоос, эльфийн хааны ордонд зочлохоос татгалзсан учраас жаал саатацгаав. Тэд төгөлийг хойноос нь тойрон гарч зэрлэг ой Саарал уул хоёрын дундуур зурайх эзгүй цөлөөр явахаар шийджээ. Энэ зам эвгүй, урт боловч Саарал ууланд гоблин бараг үлдээгүй ойн дундуурх аймшигтай жимээр явснаас дээр санагдсан байна. Беорн ч бас энэ замыг сонгов.

-Эльфийн хаан минь баяртай! Түнэр ногоон ой чинь урган өтгөрөг, түмэн олон ард чинь цэнгэн жаргаг! гэж Гэндалф хэллээ.

-Гэндалф баяртай! Чамайг хүсэж хүлээгээгүй байхад ч хамаагүй ирдэг зангаараа л ирж байгаарай. Чамайг ирэх болгонд чинь би үнэн сэтгэлээсээ баярлан баясах болно гэж эльфийн хаан хариулав.

-Эзэн хаан танд өчүүхэн бэлэг! гэж хоббит ээрсхийн хэлээд Дэйний өгсөн сувдтай мөнгөн зүүлтийг гар сунган барьлаа.

-Би ийм үнэтэй бэлэг авах юу хийсэн билээ? гэж хааныг гайхахад Бильбо,

-Хаан таны зочломтгой сайхан зан аашинд талархаж байна. Олзлогч дээрэмдэгчид л гэнэ, тэд чинь гайгүй үнэнч андууд шүү. Би чиний дарсыг мөн ч олон ууж мөн ч олон талхыг идсэн дээ гэв.

-Үнэн сэтгэлийн чинь бэлгийг хүлээн авъя. Энэ цагаас хойш чи эльфүүдийн үнэнч анд мөн шүү! Ажил төрөл чинь ашиг өгч, унасан сүүдэр чинь хүртэл тэнэсэн сумнаас хол байг, баяртай!

Эльфүүд ойн зүг хөдлөхөд Бильбо пони морио хойшоо заллаа.

Хоббит гэрийнхээ зүг осолтой адал явдал, олон олон хүнд хэцүү байдлыг даван туулсаар явлаа. Зэрлэг хязгаар тэр өдрүүдэд гоблинггүй ч зэрлэг хэвээрээ л байсан билээ. Түүнтэй цуг шидтэн Гэндалф, Беорн хоёр байсан юм чинь түүнийг сайтар хамгаалж халамжилж явсан болохоор тэрээр үнэнээсээ үнхэлцгээ хагартал айх аюултай тулгараагүй билээ. Өвлийн дунд сард ойг бүрэн тойрч гараад Беорны гэрт тулж очлоо. Беорн олон зочид дуудан өргөн найр хийлээ. Манант ууланд гоблинууд ганц хоёрхон үлдсэн, үлдсэн тэд үхтэлээ айн хамраа ч гадагш цухуйлгаж чадахгүй сууж байсан болохоор Беорны урилганд ойн амьтад дуртайяа ирцгээлээ. Чонын сүрэг бүр хулжжээ.

Тэр цагаас хойш Беорн манант уулаас зэрлэг ой хүрэх бүх газар нутгийн аугаа их хаан болсон бөгөөд түүний үр удмынхан олон үедээ баавгай болж хувирах чадвараа хадгалсаар байсан гэдэг. Тэдний зарим нь зэрлэг ширүүн уур хилэнтэй байсан гэдэг. Гэхдээ ихэнх нь бие хаа, хүч чадлаар биш гэхэд зөөлөн сэтгэлээрээ Беорнтой адилхан байсан гэнэ билээ. Тэр өр зөөлөн Беорны удмууд Манант уулаас сүүлчийн гоблинуудыг хөөн устгаж зэрлэг хязгаар нутагт тэр аяараа энх амгалан болсон гэнэ билээ.

Нар өндөрт гялалзсан гайхалтай сайхан хаврын нэг өдөр Бильбо Гэндалф хоёр Беорныхоос явлаа. Бильбо гэр өөдөө хэдий яарсан ч Беорны цэцэрлэгт цэцэгс зуныхаасаа илүү гоёмсог тансаг алаглахад өөрийн эрхгүй хоргодон Хүн баавгай Беорныхоос нэлээд гунигтай хөдөлсөн

байна. Тэд урт замыг туулж ядарч зүдэрсээр тэдний ирэх замд гоблинуудын дайрсан тэр газар хүрч ирлээ. Өглөөний нар мандаж байв. Алсад зэрлэг ой цэнхэртэн түүний наахна орших ойн цоорхой хавар болчихоод байхад харлан харагдана. Ойн цаанатай Ганцаардмал уул сүндэрлэнэ. Ганцаардмал уулын оргилд цагаан цас нарны гэрэлд гялалзана.

-Дайны гал дөл дүрэлзэж байсан газар цасанд дарагджээ. Аймшигт луу хүртэл үхэж үрэгддэг байна шүү гэж Бильбо өөрийнхөө адал явдалд оролцсон газрыг харж чадахгүй уйтгартай хэлэв.

Бильбогийн дотор нууцхан орших хөгшин Тукийн омголон зан бага багаар унтарсаар түүний хоёр дахь зан чанар давамгайлан сэргэж ирлээ.

-Аах тухлаг буйдандаа шигдэхсэн! гэж шүүрс алдлаа.

Арван есдүгээр бүлэг

Сүүлчийн алхам

Таван сарын нэгэнд аянчид сүүлчийн хавцалд хүрч ирлээ. Нар шингэж байлаа. Хөөрхий пони морьд хараажаар ядарчээ, ялангуяа алт мөнгөтэй авдар тохсон морь илэрхий цуцжээ. Зам уруудан явтал дуу хуур цуурайтан дуулдав. Тэнүүн талын эльфүүд түүнийг одойнуудтай энд байснаас хойш одоо болтол дуулсаар байгаа юм шиг Бильбод санагдана. Тэднийг явсаар нуга дээр гарч иртэл эльфүүд түрүүн дуулж байсантайгаа тун адилхан шинэ дуу хангинуулж эхэллээ.

Тортог луу - Тортог луу!

Тоос шороо болон бутарсан

Арьс ч үгүй яс ч үгүй

Алдар нэр ч үгүй, эрх дарх ч үгүй

Тортог луу - Тортог луу!

Тоос шороо болон бутарсан

Хатан сэлэм дэвтээд

Хаан ширээ хазайгаад байсан юм

Одоо эзэн хаан ирлээ!

Орон улсаа тохинуулна даа!

Хүмүүс итгэнэ найдна

Одойнууд алттай эрдэнэстэй

Юм юм урьдынхаараа болно

Хүн амьтан жаргалтай амьдарна

Тра ля - тра ля - ля, ля!

Тэнгэрийн одод ойрхон ойрхон

Тэргэл саран мөнгөн таваг

Алт алт бидний алт

Асан дүрэлзэх дөл дөл

Тра ля - тра ля, ля ля

Шөнийн оддын доогуур

Зорьсон газар хол уу?

Сэрүүхэн хөндийдөө эргэж ирлээ

Сэтгэл дотор уужирлаа

Тра ля - тра ля, ля ля ля

Эльфүүд тэднийг баярлан угтаж гол гарахад туслан Элрондынд хүргэж өглөө. Тэнүүн талын эзэн зочдоо элэгсэг дотно угтав. Ууланд юу болсныг сонсох гэж эльфүүд яарч байлаа. Гэндальф тодорхой сайхан ярьж байхад Бильбо зүүрмэглэн суув. Шидтэн эхлээд замдаа хоббитоос сонссон бүгдээ яриад дараа нь Беорны гэрт байснаа нэмж өгүүлэв. Сүүлд нь хоббитын мэдээгүй байсан сонин зүйл ярьж эхлэхэд Бильбо нүдээ нээн чагналаа.

Гэндальф Элронд хоёрын ярианаас шидтэн хаагуур хаагуур явж байсныг мэдэж авлаа.

Гэндальф одойнуудаас салж яваад мэргэн ухаант цагаан шидтэнгүүдийн их зөвлөлд оролцохоор шууд явжээ. Шидтэнгүүд зэрлэг ойн өмнө зүгт оршиж байсан Некромантыг хөөж чаджээ.

-Удахгүй ой тайга өөрчлөгдөнө. Бид хар хорын хүчийг удаан эргэж ховсдохгүй болтол хөөчихсөн. Ганцхан бүр мөсөн хөөж арилгаж чадаагүй.

-Энэ үеийнхэн дараа үеийнхэн ч бүр мөсөн хөөж чадахгүй байхаа гэж Элронд харамсав.

Гэндальфийг ярьж дуусахад эльфүүд цаг хугацаанд үл хуучирсан эртний дуу туульсийг санаж сэргээн шинэ үеийн дууг ч нэмж дуулсаар байлаа. Бильбо буланд шигдэн толгойгоо тонгойлгож суугаад зүүдлэн хурхирна.

Бильбо цасан цагаан хөнжил дотор сэрлээ. Дэлгээтэй цонхоор саран гэрэлтэнэ. Голын тэндээс эльфүүдийн чанга дуу тов тодорхой цангинана.

Цэнгэн хөгжилдөн бүгдээрээ хамт дуулцгаая!

Цэнгэг салхи бутсын дээгүүр моддын дундуур сүнгэнэнэ

Одод түгсэн тэнгэрт саран өндөрт хөөрчээ

Саран доорх хорвоо гэрэлтэй гэгээтэй

Цэнгэн хөгжилдөн бүгдээрээ хамтран дуулцгаая!

Цэгцрэн товшлон бүгдээрээ бүжиглэцгээе, эргэлдэцгээе.

Үелзэх гол мөнгөрөн мөнгөрөн гялалзана

Үүр цайтал дуулж хуурдя

Манай аянчин амгалан унтана

Бүүвэй бүүвэй намуухан дуулцгаая

Дулаахан хөнжилдөө зүүдлэн нойрсог!

Дуу хуураараа аядуухан бүүвэйлье

Агч мод, бургас, нарс, царс!

Аяар аяархан найгаарай, ганхаарай!

Тэргэл сар нуугдаач, голын шуугиан намсаач!

Бүүвэй, бүүвэй намуухан дуулцгаая!

Бильбо цонхоор цухуйн эльфүүдийг дуудан,

-Хөөе, хөгжилтэй андууд аа! Хэдэн цаг болж байгааг мэдэж байна уу? Та нарын дуу согтуу гоблинг ч сэрээх байх шүү! За яах вэ, яах вэ, баярлалаа баярлалаа гэж шулганав.

-Чиний хурхирахаас чулуун луу ч сэрнэ шүү гэж эльфүүд хөхрөлдсөнөө,

-Чамд бид гялайлаа. Өглөө болчихоод байхад чи унтсаар байх юм. За хөөрхий, аян замдаа ядарсан биз дээ гэцгээв.

-Элрондын гэрт унтана гэдэг эм тан л гэсэн үг. Сайхан нойрсоорой гэчихээд Бильбо хөнжилдөө шурган өглөө болтол унтав.

Сайхан амарч хүчээ сэлбэсэн Бильбо маргааш нь эльфүүдтэй цуг бүжиглэн дуулж инээж хөхөрч байв. Гэхдээ л гайхамшигтай сайхан тэнүүн нутаг ч түүний орон гэрээ санахыг болиулж чадсангүй. Долоо хоногийн дараа хоббит Элрондтой салах ёс гүйцэтгэж жижигхэн бэлэг өргөөд Гэндальфтай цуг цааш аян замынхаа мөрийг хөөлөө.

Тэднийг хөндийгөөс дөнгөж хөдөлтөл тэнгэр баруунаас харанхуйлж салхи нүүр нүдгүй гуядав.

- Хаврын тэнгэр ээ гэж!.. Гэрийнхээ зүг явж байгаа болохоор юу ч болж байсан сайхан байна. Гэрээс минь мэнд мэдэж байна гэж бодъё доо гэж Бильбо зоригоо нэмэв.

- Урт зам угтаж байна аа! гэж Гэндальфийг сануулахад Бильбо,

- Сүүлчийнх! гэж баяртай хариуллаа.

Зэрлэг хязгаарын хил болсон гол хүрч гармаар гарцгаалаа. Уулын цас хайлж өдөр болгон бороо цутгасанаас болж гол үерлэсэн боловч элдэв явдалгүйгээр голоо гаталсан бөгөөд цаашаа хоббитын нутаг уруу яаран давхицгаалаа.



Анд нөхөд нь үлдээд хоёулхнаа болсон болохоос бүх юм урьдынхаасаа тайван чимээгүй болж Троллууд дайралдсангүй. Бильбо өнгөрсөн жил юу ярьж яаж байцгаасныгаа санаж (Арван жил өнгөрсөн юм шиг санагдана) ус уруу унасан Том, Берт, Биллтэй тулсан газар зэргээ бүгдийг нь таньж зааж явлаа. Тэндээс холгүйхэн Троллуудын алт эрдэнэс булсан газраа бүрнээрээ байж байв. Гэндэльф тэр хоёр алтыг ухаж авсныхаа дараа Бильбо,

-Надад байгаа юм маань үхтэл минь хүрэлцээтэй. Чи үүнийг ав, чамд хэрэг болж магадгүй гэлээ.

-Хэрэг болохоор барах уу? Ямар ч юманд ам гарч болдоггүйг чи мэдэж байгаа... Миний бодлоор чамд удахгүй хэрэг болно гэв.

Алтаа уутлан тээсэн ачаанд тэртэй тэргүй түүртэн буй хөөрхий пони мориндоо ачаад өөрсдөө явган алхав. Эргэн тойрон ногоорсон өвс ногоо хоббитын толгойг далдартал халиурч нар хурцаар шарна. Бильбо байсхийгээд л амсхийн зогсож Элрондоос авсан улаан алчуураар нүүрээ арчина.

Энэ дэлхий дээр бүх юм дуусдаг төгсдөг хойно доо, бидний үлгэр ч бас адил. Зургаан сарын нэгэн сайхан өдөр Бильбогийн төрж өссөн газар, түүнд бол толгод бүр нь мод бүхэн нь таван хуруу шиг нь танил дасал болсон цэлгэр хязгаарт хүрч ирцгээлээ. Бяцхан довон дээр Бильбо гараад өөрийнхөө гэрийн хажуу дахь тойрог замыг хараад ийнхүү чангаар дууллаа.

Аяны зам, аяны зам

Уулын дээгүүр, ойн дундуур

Аймшигт харанхуй агуй хавцал

Асгаран эргэлдэх гол ус

Аяны зам аяны зам

Өвлийн хүйтэн, зуны халуун

Алтан нарны доор мөнгөн сарны доор

Үүлгүй тэнгэрийн доор

Аяны зам аяны зам

Алс холын хязгаар нутаг

Холын холоос эргэдэг

Хонгор нутагтаа тэмүүлдэг

Аяны зам, аяны зам

Дайны голомтоос ч эргэнэ

Гал уснаас ч гэрийн зүг

Төрөлх нуга төрсөн гацаандаа эргэнэ

-Хонгорхон Бильбо минь! Чи чинь яагаад хайлаад байна аа? Энэ чинь эрэлхэг хоббит чи юу? гэж Гэндальф өгүүлнэ.

Гүүрээр гарч тээрмийн хажуугаар өнгөрлөө. За энэ Бэггинсийн танил дасал болсон нүхэн гэр!

-Хөөе! Энд юу болоод байна аа? гэж хашхирав.

Гэрийнх нь үүдэнд янз янзын хүмүүс овооролдон ихэнх нь хаалгаар орсноо буцаж гарч ирнэ. Түүгээр ч барахгүй хэн ч хөлөө арчихгүй байна гээч!

Бильбо Бэггинс гайхахын ихээр гайхсан бол түүнийг харсан хоббитууд түүнээс илүү гайхан мэлэрчээ. Бильбо яг дуудлага худалдаа өрнөж байхад иржээ. Үүдэн дээр нь улаан хараар бичсэн том зарлал өлгөөстэй байлаа.

“Хоббитын улсын Торбе-Кручед дуудлага худалдаа болно. Ноён Бэггинсийн эд зүйлсийг ноён Грабл, Коланец хоёр дуудан худалдана. Худалдаа зургаан сарын хорин нэгэнд арван цагт болно” гэжээ.

Бараг үд болж байсан болохоор ихэнх эд юмыг нь хямдхан зарчихсан байлаа. Бильбогийн хамаатан Лякошель Бэггинсийнхэн өрөөнүүдийг нь нарийвчлан хэмжиж өөрсдийнх нь мебель багтах нь уу, үгүй юу гэж багцаалж байлаа. Товчоор хэлэхэд Бильбог хэл мэдээгүй алга болсонд тооцоод зарлачихсан байсан бөгөөд түүнийг ингээд гэнэтхэн буцаад ирсэнд баярлаагүй хоббитууд басхүү багагүй байлаа.

Бильбогийн буцаж ирсэн явдал бөөн шуугиан дэгдээв. Круче болон эрэг хавийнхан бараг арван өдөр зөвхөн Бэггинсийн тухай л ярьцгаав. Харин Бильбог албан ёсоор амьд гэдгийг нотлоход хэдэн жил болсныг дурдах ёстой. Эд хогшлын хувьд арай амархан арга эв нь олдлоо. Учирлаж гуйгаад болохгүй болохоор нь Бильбо өөрийнхөө мебель, гэр ахуйн эд зүйлсээ зүгээр л эргүүлэн худалдан авлаа. Харамсалтай нь мөнгөн халбаганууд эргэж олдсонгүй. Лякошель Бэггинсийнхэнд шингэчихлээ гэж Бильбо сэжиглэсэн боловч тэд нар Бэггинсийг мөн гэж хүлээн зөвшөөрөөгүйгээр үл барам гудамжинд тааралдахдаа нүүр буруулах болов. (Тэд нар Бильбогийн тохилог сайхан нүхэн гэрт нүүж орох гэж ихэд дурлажээ)

Бильбо зөвхөн цайны халбагануудаа биш нэр төрөө алдсанаа сүүлд нь ухаарав. Бильбогийн цонх гэрэлтэй байгааг ажигласан эльфүүд, одойнууд, ид шидтэнгүүд байнга зочлон орж ирдэг, түүнийг хүндэлдэг анд найз нартай болсон хэдий ч Хоббитын улсынхан түүнд өөрөөр ханддаг болжээ. Хөршүүд нь ноён Бэггинс жаахан гажигтай гэнэ. Тукийн удмын зээ, зээнцэрүүд нь түүнтэй аав ээжээсээ далдуур найзалж орж гарна. Аав ээж нь “Нөгөө Бэггинс” гэж түүнийг хайнгадуухан нэрлэнэ.

Хөршүүдийнх нь санал бодол Бильбог ёстой хумсын чинээ ч зовоохгүй байлаа. Бильбо амар тайван нэгэн хэмийн амарлингуй сайхан амьдарч санаандгүй уулзалтын өмнөх үеийнхээс улам ч илүү уянгатай сайхнаар тогоотой цай нь буцалж байх шиг санагдана. Бильбо сэлмээ чулуун тавиурын дээр өлгөж хуяг дуулгаа музейд өгсөн авай. Алт мөнгөө бэлгэнд өгсөөр ихэвчлэн зээ зээнцэр нартаа тараажээ. Харин бөгжөө хэнд ч үзүүлээгүй бөгөөд урилгагүй түрэмгий зочдоос нуугдах үедээ л зүүдэг ажээ.

Хөршүүд нь Бэггинсийг бүр галзуурчихаж гээд түүний адал явдалд хэн итгэдэг юм гэж толгой сэгсрэн ярилцана. Бильбо шүлэг дуу бичиж хааяа хөвгүүдтэй уулзан насан эцэстлээ жаргалтай сайхан амьдарчээ. Тэрээр их урт насалсан шүү.

Хэдэн жилийн дараа нэгэн намрын орой Бильбо өрөөндөө суугаад дурдатгалаа бичиж “Аян замаас буцаж ирсэн нь буюу Хоббитын явдал” гэж нэрлэхээр завдан байтал хаалга цохижээ. Энэ нь Гэндалф, Балин хоёр байлаа.

-Орцгоо, орцгоо! гэж Бильбо тэвдлээ. Тэд гал тойрон тухлан сууцгаана.

Ноён Бэггинсийн хантааз өргөн хэлхгэр болсон байхаас гадна цул алтан товчтой байхыг Балин ажиглаад авав. Одой Балины сахал самбаа нь урт болж эрдэнэсийн чулуун шигтгээтэй баялаг гоёмсог бүс бүсэлжээ. Аян замын адал явдалт өдрүүдээ санан дурсацгаав. Уулыг тойрсон газар нутаг одоо ямар болсон бол гэдгийг мэдэхсэн гэж Бильбо яарч байлаа. Тэнд бүх юм сайхан болсон. Бард шинэ хот босгож Эсгаротын хүмүүсээс олноороо Дейл хот руу нүүжээ. Дол хот урьдын адил баян тансаг, гоёмсог болж түмэн хэлийн шувууд жиргэж, буман

өнгийн цэцэгс дэлгэрч, намар цагт ургацаа хурааж найр наадам хийдэг болжээ. Голоор бараа, хүнс дүүрэн хөлөг онгоц хөвж эльфүүд, одойнууд хүмүүс эв найртай энх тунх амьдрах болсон байна. Хотын хуучин дарга муу муухайгаар үхжээ. Тэр Бардын Эсгаротыг сэргээн босгохоор өгсөн алтнаас хулгайлж аваад зугтсан байна. Ингэж зугтаж яваад элсэн цөлд өлсөж үхжээ.

-Шинэ дарга арай ухаантай, Эсгарот хотыг сэргээн босгоход хүч чадлаараа зүтгэсэн бөгөөд ард олон ч түүнийг хүндэлдэг. Манай гол горхи алтаар урсдаг тухай дууг хотынхон зохиосон гэж Балин ярив.

-Зөгнөл биелэлээ олжээ гэж Бильбо бодлогошрон хэллээ.

-Тэгэлгүй яах вэ. Яагаад биелэхгүй байх билээ? Чи өөрөө хүсэл мөрөөдөл биелүүлэхэд оролцчихоод одоо болохоор итгэхгүй байгаа юм уу? Хонгор Бильбо минь ингэж болохгүй шүү. Чи өөрийнхөө баялагийг зөвхөн азаар, аз завшаан тохиогоод л цуглуулсан гэж хэлэх гээгүй биз дээ! Ноён Бэггинс, чи бол эрэлхэг, эрхэмсэг эр шүү. Би чамаар бахархдаг, харж ханадаггүй шүү. Чи минь энэ асар том ертөнц дээрх жижигхээн золиг доо гэж Гэндальф батлан өгүүллээ.

-Боллоо боллоо гэж Бильбо инээмсэглэн хэлээд шидтэний тамхины хайрцаг уруу гараа сунгалаа.

Table of Contents

[Бяцхан хоббитын андуудад](#)

[Нэгдүгээр бүлэг](#)

[Хоёрдугаар бүлэг](#)

[Гуравдугаар бүлэг](#)

[Дөрөвдүгээр бүлэг](#)

[Тавдугаар бүлэг](#)

[Зургадугаар бүлэг](#)

[Долдугаар бүлэг](#)

[Наймдугаар бүлэг](#)

[Есдүгээр бүлэг](#)

[Аравдугаар бүлэг](#)

[Арван нэгдүгээр бүлэг](#)

[Арван хоёрдугаар бүлэг](#)

[Арван гуравдугаар бүлэг](#)

[Арван дөрөвдүгээр бүлэг](#)

[Арван тавдугаар бүлэг](#)

[Арван зургадугаар бүлэг](#)

[Арван долдугаар бүлэг](#)

[Арван наймдугаар бүлэг](#)

[Арван есдүгээр бүлэг](#)